2	1.1.2.үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно.	2021 - 2025	940.0, Улсын төсөв		"Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар батлуулсан 2024 оны эвентийн календарийн дагуу Олон улсын 78, үндэсний хэмжээний 47, Орон нутгийн хэмжээний 38 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан. Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилтын хүрээнд: - Архангай аймагт ""АРА фестиваль"", "Улаанбаатар олон улсын медиа урлагийн наадам", "Нүүдэлчин дэлхийн фестиваль", "Бүргэдийн баяр", "Бодибилдингийн фитнесийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээн", "Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам", "Хар хорин айс фестиваль" зэргийг дэмжин хамтран ажилласан. - Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд сур харвааны ажлын хэсэгтг ажиллахаас гадна жуулчдад зориулан наадмын нээлтийн арга хэмжээг орой тоглуулах арга хэмжээг зохион байгуулсан. - Монголын эдийн засгийн форумын ажлын хэсэгт орж "Аялал жуулчлалын салбар хуралдаан"-ы зохион байгуулалтыг хариуцан ажилласан."	ССАЖЗЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд зохих ажлууд хангалттай сайн хийгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.
3	1.1.3.төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааг үндэсний онцлогийг шингээсэн агуулгаар баяжуулна.	2021 - 2025			МУ-ын Ерөнхийлөгчийн 2015 оны 119 дүгээр зарлигаар “Төрийн ёслолын журам”-ын 3.4-т Үндэсний ёслол нь үндэсний уламжлалт ёс заншил, сонгодог ёс, шинэ хандлагыг хослуулан хэрэглэж боловсронгуй болгож байна гэж заасны дагуу МУ-ын хэмжээнд нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүд, төр, засгийн удирдагчид гадаад оронд айлчлах, гадаад дээд, өндөр хэмжээний зочид МУ-д айлчлах арга хэмжээнүүдийг үндэсний уламжлалт ёс заншил, соёл уламжлалын онцлогийг тусгаж зохион байгуулсан. Мөн “Төрийн ёслолын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан саналын төслийг нэгтгэн журмыг шинэчлэн батлуулахаар ЕТГ-т хүргүүлсэн байна.	ЗГХЭГ	50	50.0	
4	1.1.4.соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлнэ.	2021 - 2025			"1. Соёлын сайдын 2024 оны А/212 дугаар тушаалаар ""Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн чиглэл"" бодлогын баримт бичгийг баталсан. 2. Соёлын биет бус өвийг хамгаалах Засгийн газар хоорондын хорооны 19 дүгээр чуулганаар ""Монгол нүүдлийн зан үйл"", "Наурыз" өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэх тухай 8b49, 8b56 тоот урьдчилсан шийдвэрийг баталж, ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн жагсаалтад албан ёсоор бүртгэсэн. 3. ЮНЕСКО-ийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Ази-Нохон далайн бүсийн хорооны 10 дугаар Ерөнхий чуулганаар Монгол Улсаас нэр дэвшүүлсэн Монгол Улсад анх гүйлгээнд гаргасан шуудангийн “Элдэв-Очир” марк, “Халхын дөрвөг хааны гэрийн үеийн бичиг” 2 баримтат өв амжилттай бүртгэгдсэн. 4. Засгийн газрын 2024 оны “Фестиваль зохион байгуулах тухай” 41 дүгээр тогтоолын дагуу “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг 2024 оны 8 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Фестивальд 12 улсын 140 гаруй гадаад оролцогч, Монгол Улсын 21 аймаг, нийслэлээс 1000 орчим өвлөн уламжлагчид, салбарын 150 гаруй байгууллага оролцож, соёлын биет бус өвийн 7 ай савын 362 төрлөөр 780 хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулсан. Фестивалийг 169,000 хүн үзэж сонирхсон бөгөөд аймаг, нийслэлийн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид болон 40 гаруй хоол үйлдвэрлэгчид оролцож, 21,000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаж, нийт 2,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. 4. ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй байгуулсан СОЯ 24/132 гэрээний дагуу 2024 оны 9 дүгээр сарын 14-15-ны өдөр Архангай аймгийн Тариат сумын Мөрөн багийн нутагт “Суман голын хадны зураг” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. Тус хуралд Архангай аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга, мэргэжилтнүүд, Цэнхэр, Өндөр-Улаан сумын Соёлын төвийн дарга, музейн төлөөллүүд, Архангайн ТВ, 1-р 10 жил, Тариат, Чулуут, Хотонт, Түвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн багш нар зэрэг нийт 82 том хүн, 118 сурагч болон нутгийн ард иргэд оролцсон.	ССАЖЗЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд зохих ажлууд хангалттай сайн хийгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-р үнэлэв.
5	1.1.5.соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.	2021 - 2025			1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар Соёлын яамыг дахин байгуулсан. Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг 78 байхаар баталсан. Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болж, Засгийн газрын 2024 оны 18 дугаар тогтоолоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг 130 байхаар баталсан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хороо нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлыг хүрээнд хамаарах болсон. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад биеийн тамир спортын салбарын Биеийн тамир, спортын улсын хорооноос гадна Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв болон аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын 31 газрын 923 албан хаагчийн 23.9 тэрбум төгрөгийн цалин хөлс, нийгмийн даалгалын шимтгэлийн төсөв шилжин ирсэн. 2. Засгийн газрын 2021 оны 168 тогтоолоор аймгуудад "Соёлын хэлтэс"-ийг байгуулах шийдвэр гарч, Засгийн газрын 2021 оны 377 тогтоолоор Соёлын хэлтсийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Соёл, урлагийн газар болгон өөрчилсөн бүтэц батлагдсан. Засгийн газрын 2024 оны 06 дугаар тогтоолоор Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар гэж өөрчилсөн. 3. ЗГХА Соёл, урлагийн газар 17 орон тоотой байсныг нэмэгдүүлж 45, Хүүхэлдэйн театр 31 орон тоотой байсныг нэмэгдүүлж 41, Уран зургийн галерей 13 орон тоотой байсныг нэмэгдүүлж 33 болгосон. Монголын Үндэсний кино урлагийн зөвлөл 18, Чингис хаан Үндэсний музей 116, Хүүхэд залуучуудын театр 110 орон тоотойгоор шинээр байгуулагдсан.	ССАЖЗЯ	100	70.0	/Бүтэц зохион байгуулалтыг шийдсэн хэдий ч хүний нөөцийг хөгжүүлэх ажил хийгдээгүй байна./ Санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн. Журмын 6.2.2.2-р үнэлэв.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			78.0	
Нүүдлийн соёл иргэншилт Монгол									
Зорилт 1.2. Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.									
6	1.2.1.өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээл, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.	2021 - 2025	1,620.0, Улсын төсөв		Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд зорилтыг ханган ажилласан. Энэ хүрээнд Соёлын яамнаас Батлуулсан төлөвлөгөө 1, шинэчлэн батлуулсан стандарт-1, сургалтын агуулга хөтөлбөр-4, албан даалгавар 1, урлаг-2, үндэсний сургагч багш бэлтгэх сургалт-6, Үндэсний сургагч багш 456 бэлтгэгдсэн, Соёлын боловсролын богино сургалт 4, олон улсын форум-2, их семинар 1, олон улсын фестиваль 1, төндөр 1, нийгмийн соён гэгээрлийг дээшлүүлэх Соёлын сэргэлт-2023, 2024 нэгдсэн цогц арга хэмжээ-2, нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх сошиал нөлөөллийн аян-14, музейн боловсролын 70, бусад 100 гаруй соёлын боловсролын албан бус хөтөлбөр хэрэгжиж 90330 гаруй иргэн хамрагдсан, сургалт дугуйлан 2500 гаруй хичээллэж 26120 гаруй хүүхэд хамрагдсан, монгол хэл бичгийн цахим сургалт 10, танхим 2, цахим хэрэглэгдэхүүн 122, контент 16, цахим хуудас 1, IPTV 2, апп 3, эстүүл 3, тоглоом 1, VR үзэсгэлэн 6, нүүдлийн соёлын боловсрол олгох зуны зуслан 6 ажиллаж 200 гаруй хүүхэд хамрагдсан. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилт 16 үйл ажиллагаа 41 шалгуур үзүүлэлттэй батлагдаж, хамтарсан албан даалгавар батлуулан салбар дундын зохицуулалтыг ханган ажиллаж байна.Нийгмийн соёл, төлөвшлийн төлөө 20М дагагчтай пэйж хуудас 18М хүнд таалагдаж, 1.5 сая хүнд хүрч, ТВ 60М, Сонин 10М, ФМ радио 30М, вэбсайт 40М, автобусанд 1,05М, лифт 120М, автомашин 50М, постер 20М сувгуудаар түгээгдэж өссөн дүнгээр 3.1 сая хандалтад хүрсэн. СӨБ-ын 400 багш, ЕБС-ийн 360 багш, СХД-ийн 43 хороодын 215 хэсгийн ахлагч, анхан шатанд 426 нийт 1251 хүнийг богино хугацааны сургалтад хамруулав. “Соёлын эрхийн бичиг”-ийг хэрэгжүүлж 1156 соёл, урлагийн үйлчилгээнд 39664 хүүхдийг хамруулж, тандалт судалгаа хийгдсэн.Хүүхэд, залуучуудын бүтээлч идэвх, оролцоог нэмэгдүүлэх уралдаан, тэмцээн, үзэсгэлэн, сургалт 60, 10,000 гаруй иргэдийг хамруулсан.	ССАЖЗЯ	100	70.0	Өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээний хүрээнд олон ажил амжилттай зохион байгуулсан боловч үр дүнгийн талаар тусгаагүй.Журмын 6.2.2.2-р үнэлэв.

12	1.4.1. Үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгож, судалгааны эргэлтэд оруулна.	2021-2025	00..0, Улсын төсөв	"Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Чингис хаан Үндэсний музей, Чингис хаан судлалын олон улсын холбоо (IACKS) хамтран ""Монголын эзэнт гүрний өв: Бичгийн эх сурвалж ба эд өлгийн соёл"" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 08 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Чингис хаан Үндэсний музейд зохион байгуулсан. Энэ удаагийн хуралд Япон, Орос, Итали, Австри, Хятад, Иран, Франц, Герман, Ватикан Хот улс зэрэг 10 гаруй орноос Чингис хаан судлалаар судалгаа хийж байгаа хамгийн алдартай эрдэмтэн, судлаачид оролцож монголын эзэнт гүрний харъяат Улус, нэхмэл хийц ба материалын соёл, бараа, худалдаа, бэлэг солилцоо, эх сурвалж, гар бичмэлийн өв, бичгийн эх сурвалжийг баяжуулсан археологийн баримтууд, улс төрийн институци, бүтэц, гэр бүл, ураг төрлийн асуудал, шашны сүлжээ, угсаатны цөөнх зэрэг сэдвээр гадаад, дотоодын нэртэй 18 эрдэмтэд илтгэл хэлэлцүүлэхийн зэрэгцээ судалгааны үр дүнгүүдээ танилцуулсан. Хурлын илтгэлүүдийг нэгтгэн англи хэл дээр олон улсын томоохон хэвлэлийн газраар хэвлэн нийтлүүлсэн. Монголын эзэнт гүрэн дэлхий дахины улс төр, эдийн засаг, шашин, түүх соёл, оюун сэтгэлгээ, хууль, эрх зүй, шинжлэх ухаан, технологийн хөгжилд ихээхэн нөлөө үзүүлж, түүх соёлын дахин давтагдашгүй өвийг үлдээсэн учраас Монголын түүхийг харах дэлхий нийтийн хандлага ч өөр болж байгаа. Зөвхөн байлдан дагуулагч биш, Монголчууд Евро Азийн тухайн үеийн дэлхий ертөнцийн том солилцоог бий болгосон. Монголоос өөр ямар ч эзэнт гүрэн өнөөдрийг хүртэл хийж чадаагүй гэдгийг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрсөөр байна. Өөрөөр хэлбэл Чингис судлалын шинэ үе дахин бий болж байна. Өнөөгийн ертөнцийн эх суурийг үндэслэсэн Монголын эзэнт гүрний түүх, түүний өв соёлыг судлах, тэр дундаа монголчуудын дэлхийн түүхэнд оруулсан хувь нэмрийг тодорхойлох, монгол судлалын салбарыг сонирхон судлах гадаад, дотоодын залуу эрдэмтдийн тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа юм. Хурлын хураангуй эмхтгэлийг хэвлүүлсэн."	ССАЖЗЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-р үнэлэв.
13	1.4.2. Олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлж, нийтийн хүртээл болгоно.	2021-2025	32.7, Улсын төсөв	"1. Монгол бичиг, соёлоороо бахархах, монгол судлалыг дэмжих, бичиг соёлын өвийг хадгалж, хамгаалах зорилготойгоор ""Монголчуудын бичгийн соёл: Чингисийн чулууны бичиг-800, Цогтын хадны бичиг-400"" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдөр Чингис хаан Үндэсний музейн их танхимд зохион байгуулж, 20 гаруй эрдэмтэн судлаачид илтгэлээ хэлэлцүүлээ. 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Чингис хаан Үндэсний музей, Чингис хаан судлалын олон улсын холбоо (IACKS) хамтран ""Монголын эзэнт гүрний өв: бичгийн эх сурвалж ба эд өлгийн соёл"" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг энэ өдрүүдэд Улаанбаатар хотноо Чингис хаан Үндэсний музейд 8 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. 3. "Бурхан Халдун хайрхны түүх, соёлын судалгаа" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. 3. "Монгол ба Дотоод Азийн нүүдэлчдийн соёлын нэгдмэл үнэт зүйлсийн суурь судалгаа" судалгааний төслийг гүйцэтгэн судалгааны нэгдсэн тайлан бичиж дуусгасан. 4. ""Нүүдэлчин"" фестивалийн хүрээнд ""Кембриж Монгол II Форум""-ыг амжилттай зохион байгуулсан. 5. Эрдэм шинжилгээний сэтгүүл монгол бичгээр ISSN: 3007-1445 хэмээх дугаартай, ""Нүүдлийн соёл иргэншил судлал"" нэртэйгээр хэвлэгдэн гарсан 7. Эх хэлний хүрээнд Нүүдэлчдийн нийгэм ба соёл" 9 цуврал номыг хэвлүүлсэн 8. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд гарын авлага 60 хуудас бүхий бүтээлийг суурь судалгаанд үндэслэн гаргасан."	ССАЖЗЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-р үнэлэв.
				Зорилтын хэрэгжилтийн хувь			90.0	
Дэлхийн Монгол								
Зорилт 1.5. Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлнэ.								
14	1.5.1.Монгол хүний онцлог, давуу тал, үнэт зүйлийг тодорхойлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.	2021-2025	165.2, Улсын төсөв	Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлэх зорилтын хүрээнд "МОНГОЛ УРЛАГ ДЭЛХИЙН ТАЙЗНАА" арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, кино урлагийн чиглэлээр олон улсын өндөр зэрэглэлийн Берлинар, Канн, Пуссан зэрэг 3 наадам, дүрслэх урлагийн чиглэлээр Венеци, Норд Арт зэрэг 2 наадам, хөгжмийн урлагийн чиглэлээр гадаадын Герман, Франц, Азербайжан, Туркментсан, Узбекистан, Хонг Конг, Сингапур зэрэг оронд бүрэн хөгжмийн урлагийн болон дармын урлагийн чиглэлээр бүрэн хэмжээний тоглолт, Циркийн урлагийн чиглэлээр 2 наадамд, Японы соёлын өдөрлөгийн хүрээнд “Косплеи” уралдаанд монголын уран бүтээлдийг албан ёсоор оролцуулж, Монголын соёл, урлагийг суратчилж, монгол уран бүтээлчдийн уран бүтээл авьяас билиг, бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан монгол үндэсний үнэт зүйл, монгол хүний онцлогийг олон нийтэд түгээх олон талт үйл ажилагааг бодлого,санхүүгээр дэмжин ажилласан. Мөн 2024 онд БНСУ-ын Пусанд Монголын кино үзвэрийн өдөрлөг арга хэмжээг тус тус зохион байгуулж, нийт 11 удаагийн үзвэрийн хүрээнд 2,000 гаруй гадаад, дотоодын үзэгчид, "Би Эдит Пиаф байна" моно жүжиг, "Амьдрахуй" жүжгийг нийслэл, орон нутгийн 4,800 гаруй иргэдэд тус тус хүргэж, Орчин цагийн дуу хөгжмийн шинэ бүтээлийг олон нийтэд түгээх төслийн хүрээнд Дуу, бичлэг бүтээгчдийн үндэсний төв, Морин хуурын олон улсын уралдаан болон "World ballet and grand рrix 2024" олон улсын уралдааныг зохион байгууллаа. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд Дэлхийн морин хуурын холбоо, "Зөрөг жигүүр" ХХК-тай хамтран ажилласан.	ССАЖЗЯ	70	70.0	Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн. Журмын 6.2.2.2-р үнэлэв
15	1.5.2.Хилийн чанадад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулна.	2021-2025	-	Хилийн чанадад буй Монгол Улсын холбогдолтой соёлын өвийн https://abroad.mongoluv.mn цахим программыг хөгжүүлэн "Дэлхийд тархсан Монгол өв" төслийн хүрээнд хэвлэгдсэн 20 цувралаас 3 боть, Боннын их сургуулийн Дорно дахин, Ази судлалын хүрээлэнгээс хэрэгжүүлж буй Европын улс орнуудын музейнүүд болон хувь хүний цуглуулга дахь Монгол, Төвөдийн соёлын биет өвийн үзмэрүүдийн мэдээллийг судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглаж 1200 өвийн мэдээллийг цахим бүртгэлийн программд оруулсан. Эх хэрэглэгдэхүүн: - Норвеги дахь Монголын өв соёлын дурсгалууд. Мариа Картвейт 2023 (424 өвийн мэдээлэл), - Монгол болон Дорно дахины бурханы шашны өв (XVII-XX зуун) А.И.Шинковой 2023. (214 өвийн мэдээлэл), - Эрмитаж дахь Монголын гоёл чимэглэл, гар урлалын дурсгалууд. Ю.И.Елихина 2023 (200 өвийн мэдээлэл), - Боннын их сургуулийн Дорно дахин, Ази судлалын хүрээлэнгийн http://echo-monger.imdt.ac.mn/ сайтаас (362 өвийн мэдээлэл). Хилийн чанадад буй Монгол Улсын холбогдолтой соёлын өвийн https://abroad.mongoluv.mn цахим программд1200 өвийн мэдээллийг оруулсан. Хилийн чанадад буй Монголын соёлын өвийг эрэн сурвалжлах, судалгааны эргэлтэд оруулах замаар нэгдсэн мэдээллийн сан бий болгож төрөөс гадаадад буй Монголын соёлын өвийн талаар тогтвортой, оновчтой бодлого шийдвэр гаргахад бодит дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой."	ССАЖЗЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-р үнэлэв.
16	1.5.3. Үндэсний соёл, урлаг, зан заншил, ахуй, спорт, хоол хүнс судлалыг хөгжүүлж, өргөжүүлнэ	2021-2025	000.0, Улсын төсөв	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгаар ШУА-ийн Археологийн хүрээлэн "Монголын говь дахь хадны зургийн цогцолбор" дурсгалыг ЮНЕСКО-ийн Дэлхийн соёлын өвд нэр дэвшүүлэх урьдчилсан судалгааны ажлын хүрээнд зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг Дундговь аймгийн Өлзийт суманд 2024 оны 9 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр дурсгалын хамрах хүрээ, хил хязгаарыг тодорхойлох, хадгалж хамгаалах, сурталчлах, талуудын уялдаа холбоог улам сайжруулах, орон нутгийн холбогдох байгууллага, удирдлагуудад чиглэл, зөвлөмж өгөх, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг төлөвлөх зэрэг олон талын ач холбогдолтой болсноос гадна тулгамдаж буй асуудлыг цогцоор нь шийдэх зорилготой орон нутагт зохион байгуулсан анхны хэлэлцүүлэг болсноороо онцлог болов. 2."Үндэсний соёл, аялал жуулчлал, технологийн хөгжил" itm-монголиа 2024 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн нээлтээ хийлээ. Мөн тус арга хэмжээний үеэр Монголын Аялал жуулчлалын холбооноос орчин цагийн аялал жуулчлалын чиг хандлага үндэсний соёлд тулгуурласан соёл, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг онцлон үзэж энэхүү дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөөнд технологийн дэвшлийг салбарын хэмжээнд нэвтрүүлэх үүднээс “Эрксис” аялал жуулчлалын технологийн компанитай харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. 3. ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцын Засгийн газар хоорондын хорооны 19 дүгээр чуулган Бүгд Найрамдах Парагвай Улсын Асунсион хотноо 2024 оны 12 дугаар сарын 02-оос 07-ны өдрүүдэд хуралдсан бөгөөд Монгол Улсаас ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн "Монгол нүүдлийн зан үйл" өвийг хэлэлцэж, бүртгүүлээ.	ССАЖЗЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-р үнэлэв.
				Зорилтын хэрэгжилтийн хувь			83.3	
				Зорилгын хэрэгжилтийн хувь			84.3	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ								
Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.								
Боловсрол								
Зорилт 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.								
17	2.1.1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.	2021-2025	-	1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах ажлын хүрээнд - 2023-2024 оны хичээлийн жилд нийт 1410 цэцэрлэгт 274,236 хүүхэд хамрагдаж, 3-5 настай хүүхдийн хамран сургалт 92.7 хувь; - 2024-2025 оны хичээлийн жилд нийт 1407 цэцэрлэгт 264,818 хүүхэд суралцаж, 3-5 настай хүүхдийн хамран сургалт 92,8 хувь байна. 2023-2024 оны хичээлийн жилд 5 настай 73085 хүүхэд буюу нийт хүүхдийн 94.7 хувь нь хамрагдаж, өмнөх оны хичээлийн жилээс 1.3 хувиар өссөн. 2024-2025 оны хичээлийн жилд 5 настай 74027 хүүхэд буюу 94,1 хувь нь хамрагдсан. 2. "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2023 оны сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулсан зөвлөмжийн 2, 3 дугаар бүлгийн "Сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтны үүрэг, оролцоо", "Даалгаврын тогтсон заавар, аргачлалын дагуу үг хэллэгийг хэрхэн ашиглах вэ?" агуулгыг боловсруулан, зөвлөмжийг сургалт болон байгууллагын цахим хуудсаар танилцуулж, түгээн дэлгэрүүлсэн. Сургалтад төвийн бүсийн Говьсүмбэр, Дархан-Уул, Төв, Өмнөговь, Дорноговь аймгийн ЕБС-ийн сургалтын менежер, бага боловсролын багш, 21 аймаг, 9 дүүргийн хөгжмийн багш нийт 239 хүн хамрагдсан. Зөвлөмжийг багш нарт хүргэснээр үнэлгээнд оролцогч талууд хамтран ажиллах, багш хүүхдийн хөгжлийг бодитой үнэлэхэд дэмжлэг үзүүлж, арга зүйн нэгдсэн ойлголттой болсон.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, тодорхой үр дүн гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.

18	2.1.2. Ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээг жил бүр хийж, олон улсын үнэлгээнд хамруулна.	2021-2025	-		1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2024 оны 04 дүгээр сарын 29-05 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгууллаа. Улсын хэмжээнд ерөнхий боловсролын 708 сургууль үнэлгээнд хамрагдсан бөгөөд үнэлгээгээр нийт сургуулийн 8.7 хувь нь I түвшинд, 14.9 хувь нь II түвшинд, 16.6 хувь нь III түвшинд, 14.8 хувь нь IV түвшинд, 44.4 хувь нь V түвшинд тус тус үнэлэгдсэн. Сургалтын байгууллагын үнэлгээний улсын дундаж 78.6 хувьтай байна. Харин ЕБС-ийн багшийн үнэлгээнд 28,743 багш хамрагдсан бөгөөд нийт багш нарын 6.5 хувь (1874) нь I түвшинд, 19.0 хувь (5481) нь II түвшинд, 16 хувь (4604) нь III түвшинд, 15.3 хувь (4419) нь IV түвшинд, 43.0 хувь (12365) нь V түвшинд тус тус үнэлэгдсэн. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 77 хувь байна. 2. Боловсролын сайдын 2024 оны 08 сарын 27-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдын "Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ"-г 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 25-ны өдрүүдэд Боловсролын үнэлгээний төв нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулсан бөгөөд үр дүнд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа. 3. Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас зохион байгуулдаг PISA 2025 сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаанд оролцох бэлтгэл хангах ажлын хүрээнд PISA 2022 судалгааны үр дүнг танилцуулах, үнэлгээний даалгавар, аргачлалыг таниулах түгээн дэлгэрүүлэх цахим сургалтыг Боловсролын үнэлгээний төвөөс 2024 оны 10 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд зохион байгуулав. Мөн PISA сурлагын амжилтын нээлттэй даалгавар, аргачлалыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд түүвэрт сонгогдсон төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 15 настай 1500 орчим суралцагчийг туршилтын судалгаанд хамруулж байгалийн ухаан, математик, унших чадварыг үнэлэх компьютерт суурилсан шалгалт, судалгааг зохион байгууллаа.	БЯ	100	70.0	Сургалтын чанарын үнэлгээ хийгдсэн. Олон улсын үнэлгээнд хамруулах бэлтгэл ажил хийгдсэн боловч үнэлгээнд хамруулаагүй байна Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн. Журмын 6.2.2.2-р үнэлсэн
19	2.1.3. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлнэ.		-		Тухайн арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд:1. ЕБС-д БСШУС-ын сайдын тушаалаар "амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг болон сурах арга барил, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмшиж, үндэсний хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн" төлөвшүүлэх зорилго бүхий сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Мөн "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийг батлан өмчийн хэлбэр үл харгалзан 1-12 дугаар ангид 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүллээ. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсад амар амгалан, хүмүүнлэг нийгмийг бүтээх, сургууль, анги хамт олон, гэр бүлд эелдэг найрсаг уур амьсгал бүрдүүлэх, Монголын уламжлалт өв соёлд тулгуурлан хүмүүжүүлж төлөвшүүлэх, ёс суртахуунтай иргэдийг бэлтгэж, улмаар нэгдмэл хандлагаар улс орноо хөгжүүлэх иргэн төлөвшүүлэх зорилготой. 2.Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-д нийцүүлэн бага боловсрол сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулж, тохирц нийцлийг шалган турших ажлын хүрээнд "Сургуулийн өмнөх, бага боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах, сурах бичгийн эх зохиох ажлыг хэрэгжүүлж байна. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн бага боловсролын сургалтын хөтөлбөрийн төсөл, 1 дүгээр улиралд турших сурах бичгийн эхийг тус тус боловсруулж, туршилтын 7 нэрийн сурах бичгийг хэвлүүлсэн. Энэхүү бага боловсролын монгол хэл, унших бичиг, математик, Би монгол хүн, түмэн бодис, компьютерын ухаан, хөгжим, зураг урлал, биеийн тамир, эрүүл мэнд болон казах, тува хэлний сургалтын хөтөлбөр, сурах бичиг, дасгал ажлын дэвтрийн тохирц нийцлийг хот, хөдөөгийн ерөнхий боловсролын 26 сургуульд шалган турших ажлыг 2024 оны 11 дүгээр сараас эхлүүллээ.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, тодорхой үр дүн гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
20	2.1.4. Төрийн өмчит их сургуулийн засаглалыг төрөөс хараат бус болгож, эрх зүйн орчныг сайжруулан судалгааны их сургууль болгоно.	2021-2025	-		УИХ-аар 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн батлагдсан Дээд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д "Судалгааны их сургууль" гэж судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг, бакалавр болон ахисан түвшний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллага" гэж тодорхойлон мөн хуулийн 7.8 заалтад "Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна" гэсэн зохицуулалтыг шинээр тусгасан. Ингэснээр "Судалгаанд суурилсан үндэсний их сургууль"-ийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Мөн шинэчлэн батлагдсан Дээд боловсролын тухай хуулиар салбарын сайд төрийн өмчит их, дээд сургуулийн захирлыг томилдог байсныг өөрчлөн нээлттэй сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх эрхийг тухайн байгууллагын удирдах зөвлөлд олгосон. Түүнчлэн их, дээд сургуулийн захиралтай гүйцэтгэлийн гэрээ байгуулах, гэрээг дүгнэх, сургалтын төлбөрийг төрөөс хараат бусаар тогтоохыг сургуулийн өөрийн удирдлагад шилжүүлсэн.БШУ-ны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Журам батлах тухай" А/145 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журам"-ыг баталсан. Тус журмын дагуу дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлөөс захирлыг томилж байна.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, тодорхой үр дүн гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
21	2.1.5. Хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад сургалтын төлбөрийн бүрэн тэтгэлэг олгоно.	2021-2025	400.0, Улсын төсөв		Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд 2024 онд хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр суралцаж буй 3375 суралцагчид нийт 6.04 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон. Уг тогтоолын хавсралтаар баталсан "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу 4834 суралцагчид 11.6 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон байна. Ингэснээр, 2024 онд хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр суралцаж буй нийт 8934 суралцагчид 20.4 тэрбум төгрөгийн тэтгэлэг олголоо.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, тодорхой үр дүн гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
22	2.1.6. Засгийн газрын тэтгэлгээр дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, хөдөлмөрийн зах зээлийн захиалгатай уялдуулан мэргэжлээр нь томилон ажиллуулдаг болгоно.	2021-2025	700.0, Улсын төсөв		Монгол улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор хэрэгжиж байсан "Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг"-ийг Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор "Засгийн газрын тэтгэлэг" болгон нэрийг нь өөрчилж, үргэлжлүүлэн олгосон. Энэхүү тэтгэлгийг төгсөж ирсний дараа орон нутагт 3 жил, нийслэлд 5 жил ажиллах нөхцөлтэйгөөр олгож байгаа бөгөөд 2024 онд нийт 900 суралцагчид 7.2 тэрбум төгрөг олгосон. Дээрх тэтгэлгүүдийн хүрээнд 2024 онд нийт 2,174 суралцагчид 51.7 тэрбум төгрөг олгосон. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг нь төгсөж ирсний дараа орон нутагт 3 жил, нийслэлд 5 жил ажиллах нөхцөлтэй бөгөөд 2024 онд нийт 1,099 суралцагчид 40 тэрбум төгрөг олгосон. Үүнээс гадна Засгийн газар хоорондын гэрээний хүрээнд Монголоос гадаадад суралцагчдад төгсөж ирсний дараа 3 жил ажиллах нөхцөлтэйгөөр тэтгэлэг олгож байгаа. Тухайн тэтгэлэгт 175 суралцагчийг хамруулж 4.5 тэрбум төгрөг олголоо.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, тодорхой үр дүн гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
23	2.1.7. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.	2021-2025			УИХ-аар 2023 онд батлагдсан "Боловсролын ерөнхий хууль"-ийн 12.17, "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль"-ийн 16.7 дахь заалтаар Багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Тайлант хугацаанд сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой ""Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээ"-г Засгийн газрын 2024.05.01-ний өдрийн 192 дугаар тогтоолоор батлуулсан. Арга хэмжээ батлагдсанаар мэргэжлийн багшийн хангалт 100 хувьд хүрч; багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын гарааны багшийн стандартын хангасан төгсөгчийн эзлэх хувь 70-с доошгүй хувьтай болж; багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 10-оос доошгүй хувиар нэмэгдэн байна; багшийн нийгмийн баталгаа, цалин хөлсний талаар сэтгэл ханамжийн түвшинд жил бүр ахиц гарч;багшийн цалин хөлсний дундаж хэмжээ нь улсын дундаж хэмжээнд хүрч; нэг багшид ногдох суралцагчийн улсын дундаж 20-д хүрнэ. Мөн "Багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааны журам"-ыг А/64, "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлж, үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэхэд баримтлах аргачлал"- ыг А/246, "Ерөнхий боловсролын сургуульд багшийн туслах ажиллуулах тухай" А/63 дугаар 2024 оны сайдын тушаалаар тус тус батлан хэрэгжүүлж байна. Ерөнхий боловсролын 1, 2 дугаар ангийн 44-өөс дээш хүүхэдтэй бүлэгт багшийн туслах ажиллаж эхэлсэн ба багшийн хөгжлийг дэмжих үндэсний болон бүсийн төвийг байгуулж, бүтэц, орон тоог нь баталсан. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн Багшлах хүний нөөцийг гадаад, дотоодод бэлтгэх төлөвлөгөөний төслийг боловсруулсан.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
24	2.1.8. Газар зүйн мэдээллийн системд үндэслэн сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлэн, тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2025	-		"Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн оновчлол"-ын системийг боловсруулан 2023 оны 05 дугаар сараас үйл ажиллагаанд нэвтрүүлж, боловсролын салбарын сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалтын оновчтой төлөвлөлт, байршил, хамран сургах тойрог болон кластерийн тооцооллыг хийж байна. Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн саналыг 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Боловсролын сайдын 1а/95 тоот албан бичгээр холбогдох яаманд хүргүүлсэн. Шинээр хэрэгжүүлэх нийт 1,984,762.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 235 төсөл, арга хэмжээг газарзүйн мэдээллийн систем болон орон нутаг, нийслэлийн хэрэгцээ шаардлага, ирүүлсэн саналд үндэслэн эдийн засгийн үр нөлөө, бусад судалгаанд түшиглэн боловсруулсан. Ирах 2025 оны төсвийн төслийн саналд 235 төсөл, арга хэмжээнд 11500 хүүхдийн хүчин чадалтай 71 цэцэрлэг, 33860 хүүхдийн хүчин чадалтай 66 сургууль, 5540 хүүхдийн хүчин адалтай 44 дотуур байр, 8 спорт заал, 7 МСҮТ, 17 их дээд, 4 багш хөгжлийн төвийн барилгын төслийг эхлүүлэхээр тус тус төлөвлөсөн. Энэ онд Боловсролын салбарын орон зайн зохистой төлөвлөлт боловсруулах зөвлөх үйлчилгээг авч хэрэгжүүлэн ажилласан ба 2024 оны 10 дугаар сараас оновчлолын системийн 2.0 хувилбарыг хөгжүүлэх зорилгоор ажлын даалгаврыг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.

25	2.1.9. Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хоёр дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ.	2021-2025	-		Засгийн газрын 2024 оны 237-р тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 500 төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 2024 оны төсвийн тодотголд шаардагдах зардлыг тусган батлуулсан. Дээрх зардлыг 1000 төгрөгөөр нэмэгдүүлж, эцэг эх хариуцах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, 2024.09.11-ний өдрийн "Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73-р тогтоол батлагдсан. Боловсролын сайдын 2024.09.12-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хариуцах хоолны түүхий эдийн зардлын тодорхой хэсгийг төвлөрүүлэх, зарцуулах аргачлал"-ыг батлан хэрэгжүүлж байна. Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, эцэг эхийн хяналт, оролцоог хангаснаар цэцэрлэгийн хоол, хүнснээс авах шаардлагатай илчлэгийн хэмжээ 20 хувиар нэмэгдсэн. ЕБС-ийн үдийн хоолны зардлыг 1000 төгрөг, дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоолны зардлыг 2000 төгрөгөөр нэмэгдүүлэхээр 2025 оны улсын төсөвт тусган УИХ-аар батлагдсан. УИХ-ын 2019 оны 53-р тогтоолыг УИХ-ын 2022 оны 70-р тогтоолоор өөрчлөн "дунд, ахлах ангийн суралцагчдыг зохих бэлтгэл хангасны үндсэн дээр үдийн хоолны үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах" гэж зааснаар дунд, ахлах ангийн хүүхдийн үдийн хоолны үйлчилгээнд хамрагдах хугацаа хойшилсон. Үүнтэй холбоотойгоор ЕБС-ийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. Дунд, ахлах ангийн сурагчдын хоол шим тэжээлийн байдлыг сайжруулах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд тусган ажилласнаар 8 аймаг, нийслэлд 48 сургуулийн 10 мянга гаруй дунд ангийн сурагчдад орон нутгийн төсөв болон эцэг эхийн дэмжлэгтэйгээр үдийн хоол өгч байна. Дундговь, Орхон, Ховд, Завхан аймаг болон нийслэлд сургууль, цэцэрлэгийн 46.6 мянган хүүхдэд долоо хоногийн 3 өдөрт сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчилж байна.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
26	2.1.10. Цахим, зайн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоон, сургалтын платформыг хөгжүүлэн багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлсэн насан туршийн тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2025	-		БШУ-ны сайдын 2021 оны "Цахим сурах бичиг, ерөнхий боловсролын сургалтад ашиглах нээлттэй материалд тавих шаардлага батлах тухай" А/193 дугаар тушаалаар ЕБС-ийн сургалтад ашиглах цахим сурах бичигт тавих шаардлага, сургалтын интерактив контент, ээлжит хичээлийн цахим контентын шаардлагыг тус тус батлан мөрдөж байна. БШУ-ны сайдын 2022 оны "Журам батлах тухай" 123 дугаар тушаалаар ЕБС-ийн контентын санг бүрдүүлэх журам, 2022 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/384 дугаар тушаалаар ЕБС-ийн хичээлийн контент сонгон шалгаруулах аргачлал тус тус батлагдсан бөгөөд журам, аргачлалын дагуу багш нарын дунд нээлттэй сонгон шалгаруулах ажил үргэлжлэн хийгдэж байна. Энэхүү 2024 оны жилийн эцсийн байдлаар "Medle" контентын санд ээлжит хичээл 10,979 үүнээс заавал судлах хичээлийн 9,414, сонгон судлах хичээлийн 1,565 хичээл, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээлийг байршуулсан байгаа нь өмнөх оноос 1,892 ээлжит хичээлээр өссөн үзүүлэлттэй байна. . Боловсролын Дэлхийн Түншлэл олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжиж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төслөөр сурагчийн сурлагын амжилтыг дэмжих зорилгоор нөхцөл байдалд тохирсон хосолсон сургалтын загварыг 5 аймаг 9 дүүргийн нийт 85 ерөнхий боловсролын сургуульд туршин хэрэгжүүлээ. Багшийн мэргэжил дээшлүүлэх 2024 оны үндсэн сургалтыг Bagsh.edu.mn платформ дээр зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 5421 багшийг хамруулсан.БШУ-ны сайдын 2024 оны А/147 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-ыг баталсан. Тус журамд суралцахуйн идэвхтэй хэлбэр голлосон, мэдээлэл харилцаа, холбооны дэвшилтэт технологи, цахим сургалтын арга зүйг уламжлалт сургалтын арга зүйтэй зохистойгоор хослуулсан байхаар заасны дагуу сургуулиуд цахим сургалтыг хэрэгжүүлж байна.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
27	2.1.11. Боловсролын удирдлагын мэдээллийн системийг бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбон, бодлого, төлөвлөлт, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглан, боловсролын үйлчилгээг цахимжуулна.	2021-2025	-		Боловсролын салбарын үйл ажиллагааг цахимжуулах, иргэдэд шуурхай үйлчлэх, салбарын мэдээллийг бодитой болгох зорилгоор esis.edu.mn (боловсролын салбарын мэдээллийн систем), tvets.edu.mn (техник болон мэргэжлийн боловсролын систем), hemis.edu.mn (дээд боловсролын удирдлагын систем), medle.edu.mn (бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын платформ), elself.esis.edu.mn (цэцэрлэгчийн элсэлтийн систем), scholarship.esis.edu.mn (сургалтын тэтгэлгийн систем) болон холбогдох бусад систем, платформыг хариуцан хөгжүүлж байна. Мөн Мэргэжлийн болон техникийн боловсролын удирдлагын мэдээллийн системийн байгууллагын нэгтгэл, тусгай зөвшөөрөл, сургалтын хөтөлбөр,төлөвлөгөө, сургалтын агуулга тестийн түвшинд хөгжүүлэгдэн суурь дата мэдээллийг хөрвүүлэх ажил хийгдэж байна.Тайлант 2024 онд суралцагчийн модуль, ирц, дүн үнэлгээний бүртгэл, төгсөлт, боловсролын баримт бичиг зэрэг модулийг тестийн түвшинд ажиллуулж, МБТБ-ын байгууллагуудыг бүртгэн, шинэчлэгдсэн индексийн дагуу хөтөлбөр үүсгэн дээрх модулийг туршлаа. Боловсролын сайдын 2024 оны А/260 тушаалаар "Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам", А/261 тушаалаар "Боловсролын байгууллагад ашиглагдах системийн ерөнхий болон тусгай шаардлага"-ыг тус тус баталсан. Журмын дагуу шаардлагад нийцсэн системүүдийг цэцэрлэг, сургууль сонголттойгоор боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалт, үйлчилгээний зардлыг хувьсах зардлын цахим хэрэглээний зардлаас санхүүжүүлдэг болсон. Жилийн эцсийн байдлаар 520 сургууль SMS, LMS-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 тоот тушаалаар батлагдсан элсэлт, төгсөлтийн журмын дагуу төгсөгчийн мэдээллийг агуулсан QR-code үүсгэх 2 сервис солилцох 1 модулийн хөгжүүлэлтийг хийлээ.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
28	2.1.12. Олон улсад өрсөлдөж чадахуйц үндэсний боловсролын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлнэ.	2021-2025			Дээд боловсролын тухай хуулийн 12.9-д "Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ." гэж хуульчилсны дагуу их, дээд сургуулийн үндэсний эрэмбэ, чансааг анх удаа урьдчилсан байдлаар тогтоож 2023.10.17-ны өдөр олон нийтэд нээлттэй зарласан. БШУС-ын 2024 оны А/50, А/343 дугаар тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ, үндэсний эрэмбийг эцэслэн тогтоох үйл ажиллагааг зохион байгуулсан. Дээд боловсролын чанарын үнэлгээ хийсэн үйл ажиллагааны тайлангийн хурлыг Боловсролын үнэлгээний төвтэй хамтран 2024.10.29-ний өдөр дээд боловсролын сургалтын байгууллагын 82 төлөөллийг оролцуулан хийсэн. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага болох Их Британийн Times Higher Education байгууллагаар хийлгэхээр хамтран ажиллах санал хүргүүлсэн. Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем (hemis.edu.mn)-ээр тайлагнах захиргааны болон статистикийн мэдээний маягыг БШУС-ын 2023 оны А/240 дугаар тушаалаар баталсан дээд боловсролын сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлт, сургалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болон тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтийн дагуу шинэчлэн, хөгжүүлж эрэмбэ, чансааг тогтооход шаардагдах чанартай, үнэт бодит мэдээллийг уг системээр гаргах, бэлэн байдлыг хангаж ажилласан. БШУ-ны сайдын 2023 оны А/278 дугаар тушаалаар Англи Улсын Пийрсон-Мэдээллийн технологийн хөтөлбөрийг Ховд, Хөвсгөл, Өмнөговь, Дорнод болон Үйлдвэрлэл, Урлалын Политехник коллеж, Техник технологийн политехник коллеж, Дархан политехник коллежид нэвтрүүлж 2024-2025 оны хичээлийн жилд энэхүү хөтөлбөрөөр 857 суралцагч суралцаж байна.	БЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			88.3	
Эрүүл мэнд									
Зорилт 2.2.Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.									
29	2.2.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2025	,100.0, Улсын төсөв		Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай анхдагч хуулийг 2024.01.21-ний өдөр УИХ-ын нэгдсэн хуралдаанаар батлуулж, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх, салбар дундын үйл ажиллагааны уялдааг хангах чиг үүрэг бүхий НЭМ-ийн Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд ажиллуулах, НЭМ-ийн тусламж, үйлчилгээг НЭМ-ийн асуудал хариуцсан үндэсний төв, аймаг, дүүргийн НЭМТ зэрэг байгууллага үзүүлэхээр заасан. Энэхүү тогтолцоог бүрдүүлэх хүрээнд НЭМ-ийн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлуулсан ба одоогоор хуралдаагүй байна. Улсын хэмжээнд 2024 оны эхний 11 сарын байдлаар 27 төрлийн халдварт өвчний 33,342 тохиолдол бүртгэгдэж, өвчлөлийн түвшин 10,000 хүн амд 95.1 байна. Өмнөх оны мөн үеэс өвчлөл 4,306 тохиолдлоор буюу 10,000 хүн амд 13.8-аар буурсан байна. Харин тэмбүү, цусан суулга, сальмонеллёз, бактерийн гаралтай бусад хоолны хордлого, салхинцэцэг өмнөх оноос 2.4, 1.5, 1.2, 1.1 болон 1.1 пунктээр тус тус нэмэгдсэн. Улсын хэмжээнд 2024 онд дархлаажуулалтад шаардагдах вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслийн санхүүжилтэд шаардлагатай 23,345,849,200 төгрөгийг улсын төсөвт тусгаснаас 17.1 тэрбум төгрөгийг зарцуулсан. Заавал хийх дархлаажуулалтын товлолын дагуу 13 төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх 9 төрлийн вакцинд 0-15 насны хүүхдүүдийг хамруулж, хамралтын хувь 95.1% байна. Албан ёсны статистик мэдээгээр товлолын вакцинжуулалтын хамралт 95-аас дээш хувьтай гэж мэдээлэгддэг боловч хүн амыг төлөөлөх чадвартай санамсаргүй түүвэрлэлттэй судалгааны дүнгээс харахад хамралт жилээс жилд буурч байгаа нь алслагдмал, бүртгэлгүй, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс орхигдсон хүн ам нэлээд байгаатай холбоотой байна. Тухайлбал, Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сантай хамтран 2023 онд хийсэн "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-аар 12-23 сартай хүүхдийн суурь вакцинд хамрагдалт 76.2 хувь, 24-35 сартай хүүхдийн бүрэн тунд хамрагдалт 60.9 хувьтай байсан нь 2018 оны үзүүлэлтээс буурсан байна.	ЭМЯ	70	70.0	

30	2.2.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.	2021-2025	27,300.0, ЭМДС		Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаар Засгийн газрын 2023.08.30-ны өдрийн 321 дүгээр тогтоол батлуулж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.02.20-ны өдрийн А/75, А/09, А/34, А/73 дугаар хамтарсан тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн томоохон арга хэмжээ болох Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношлогоог 2022 оны 05 дугаар сарын 01-нд эхлүүлж, 2024 оны 12 дугаар сарын 19-ний байдлаар улсын хэмжээнд хамрагдвал зохих хүн амын 46.5 хувь буюу 1,572,777 иргэнийг хамруулаад байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамрагдсан нийт хүний 269,716 буюу 44.9 хувь нь 0-17 насны хүүхэд, 522,522 буюу 51.3 хувь нь 18-аас дээш насныхан байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн 686,000 буюу 43.6 хувь нь эрэгтэйчүүд, 886,777 буюу 56.4 хувь нь эмэгтэйчүүд байна.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 10 дугаар тогтоолоор “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам, үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ”-г 28-50 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү тогтоолын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн 6 насны багц баталсан бөгөөд 0-17 насны иргэдийн төлбөрийн хэмжээ нь анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн багцад багтсан болно. Харин 18-30 насны иргэд 90,000 төгрөгийн 9 нэр төрлийн багцын үзлэг (хуучин 60,000 төгрөг), шинжилгээ, оношлогоо хийлгэх бол 31-45 насныхан 190,000 төгрөгийн 14 нэр төрлийн багцын үзлэг (хуучин 130,000 төгрөг), 46-60 насныхан 200,000 төгрөг	ЭМЯ	70	70.0	
31	2.2.3. Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.ЭМЯ	2021-2025	2,300.0, ЭМДС		Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/347 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх дэвшилтэт технологийн тэргүүлэх чиглэл”-ийг баталсан. Эрүүл мэндийн сайдын 2024.08.30-ны А/367 дугаар тушаалаар Монгол Улсад нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, хүлээгдлийг бууруулах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллагаас аймаг, дүүрэгт нутагшуулах зорилго бүхий Зүрхний хэм судлал, Ангиографи, Гэмтэл, согог судлал, Хавдар судлалын үндэсний багийг тус тус байгуулан, багууд хөдөө орон нутагт ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Хавдар, ангиографийн үндэсний баг Хэнтий аймагт 2 удаа, Өмнөговь аймагт 2 удаа, Өвөрхангай, Орхон аймагт тус тус 1 удаа ажиллаж, нийт 1,039 хүнд амбулаторийн үзлэг хийж, 36 хүнд хавдрын ангиографийн эмчилгээ хийж, 158 хүнийг зүрх, тархины судсан дотуурх оношлогоо, 73 хүнийг судсан дотуурх эмчилгээнд хамруулж, хавдрын хими эмчилгээнд 48 хүн, хавдрын мэс засалд 15 хүн орсон байна. Мөн үндэсний баг орон нутагт ажиллах хугацаандаа эмч, мэргэжилтнүүдэд хавдар судлал, мэс засал, судсан дотуурх оношлогоо, эмчилгээ, хими эмчилгээ сэдвээр ажлын байран дахь 30 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан. Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчний оношлогоо, эмчилгээг нутагшуулах зорилгын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2024.09.03-ны өдрийн А/375 дугаар тушаалаар 13 үндэсний багийг байгуулж, гадаадын өндөр хөгжилтэй оронд чадавхжуулж байна. Үүнд: УХТЭ-ийн 3 эмч, 1 сувилагч, 1 дүрс оношлогооны техникийг БНХАУ-ын Шанхай хотын “И Да” эмнэлэгт, СЭМҮТ-ийн 5 эмчийг БНТУ-ын “Кануни Трайнинг” эмнэлэгт, ЭНЭҮТ-II-ийн 5 эмчийг БНЭнэтхэгУ-ын “Сарводаяа” эмнэлэгт, ГССҮТ-ийн 2 эмчийг БНСУ-ын Сунчинхян их сургуулийн Бүчөн эмнэлэгт, ГССҮТ-ийн 2 эмчийг БНХАУ-ын Өвөр Монгол анагаахын их сург	ЭМЯ	50	50.0	
32	2.2.4. Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.	2021-2025	0.0, Холимог эх үүсвэр		Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд үндэсний хэмжээнд түргэн тусламжийн тогтолцоог бүрдүүлэх, шинээр үндэсний түргэн тусламжийн төвийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх компани шалгарсан ба барилгын байршилд техникийн үнэлгээ, геологи болон геодезийн шинжилгээг хийлгэсэн. Төв аймаг, Хөвсгөл аймгийн Жанхайн даваа, Булган аймгийн Хутаг Өндөр, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хөвсгөл аймаг Мөрөн сум, Өвөрхангай аймаг Өлзийт сум, Дундговь аймаг Баянцагаан сум, Өмнөговь Дэлгэрцогт сум, Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Сэлэнгэ аймгийн Сант сум зэрэг 10 газарт сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн “Хар цэг” ойролцоох нутаг дэвсгэрт Яаралтай тусламжийн цэгийг байгуулснаар тусламж, үйлчилгээний үзүүлэх хугацаа 30 минутаар багассан үр дүн гарсан. Эдгээр сумын эрүүл мэндийн төвүүд нь 2024.03-09 дүгээр сард 680 гаруй иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Эрүүл мэндийн яам, Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран 2024.09.30-ны өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг сайжруулах зорилгоор гэмтэгсдийг аврах “Эмнэлэг хүртэлх тусламж, үйлчилгээ”, “Үй олныг хамарсан гамшиг ослын үеийн талбар дээрх эрэмбэлэн ангилалт” сэдэвт онол, практик хосолсон сургалтыг зохион байгуулж, нийслэл, 21 аймгаас яаралтай тусламжийн 75 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан. Түргэн тусламжийн машины парк шинэчлэлийн хүрээнд 2024 онд нийт 215 эрүүл мэндийн байгууллагад Засгийн газрын нөөц сан, улсын төсөв, Дэлхийн банк, Польшийн Засгийн газар, Бүгд Найрамдах Герман Улсын буцалтгүй тусламж (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам)-ийн хүрээнд бүрэн тоноглогдсон, туулах чадвар сайтай 49.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 214 түргэн тусламжийн автомашиныг олгосон (Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/104, А/116, А/127, А/188, А/195, А/212, А/228, А/229, А/264, А/267, А/280, А/327, А/363, А/400, А/452, А/454, А/501, А/503 дугаар тушаал). Эрүүл мэндийн байг	ЭМЯ	70	70.0	
33	2.2.5. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.	2021-2025	1,809.5, ЭМДС		Иргэдэд чанартай, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагад санхүүжилт олгодог гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжиж, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад гүйцэтгэлд суурилсан санхүүжилт бүрэн нэвтэрсэн. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй төр, хувийн хэвшлийн лавлагаа шатны 231, анхан шатны 546, 52 сувилалтай ЭМДЕГ 2024 онд гэрээ байгуулсан. 2024 оны эхний 11 сарын байдлаар 1,809.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон байна. Гэвч 2024 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн байгууллагуудад өгөх эрүүл мэндийн даатгалын өр 328.0 тэрбум төгрөгт хүрсэн. ДЭМБ-аас хийсэн судлагаагаар иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хувиасаа төлөх төлбөрийн хэмжээ 2015 онд 36.4 хувь байсан нь 2020 онд 43.4 хувь болж, нэмэгдсэн байна.	ЭМЯ	50	50.0	
34	2.2.6. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.	2021-2025	-		Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/177 дугаар тушаалын дагуу “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” сургалтыг 2024 оны 04-05 дугаар сард 9 дүүрэг, 21 аймагт зохион байгуулж, нийт 24,800 орчим эмч, эрүүл мэндийн ажилтныг хамруулсан. Монгол Улсын хэмжээнд нэгдсэн нэг мэдээний санг үүсгэх, аль байгууллагаар үйлчлүүлэхээс үл хамаарч мэдээллээ хоорондоо нэг хэлээр солилцдог болох, эрүүл мэндийн мэдээллийн “Health-ESB” санг бүрдүүлэхээр 2024 оны 02 дугаар сараас эхлэн сервис хөгжүүлэлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, бусад холбогдох байгууллагуудтай хамтран Эмийн жор, Дүрс оношлогооны дүгнэлт, Шинжилгээний хариу, Жирэмсний хяналтын хөтөч карт, Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ, Амбулаторийн карт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн мэдээллийг И-Монгол системээр дамжуулан нэвтрүүлж эхлээд байна. Улмаар ESB мэдээллийн санг үүсгэж, E-Mongolia платформ https://e-mongolia.mn/services/citizen/sector/5d88dc4d0384dfe86ce14e6c -д Шинжилгээ 5 (багц шинжилгээний хариу, дүрс оношилгооны дүгнэлт, зураг, цусны бүлгийн мэдээлэл, шинжилгээний хариу авах), Эмнэлэг 3 (эмнэлгийн цаг цуцлах, эмнэлэгт цаг захиалах, эмийн сангийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад ажлын байрны дүгнэлт гаргах), КОВИД-19 2 (вакцины гэрчилгээ, КОВИД-19-ийн шинжилгээний хариу), Эм, эмнэлгийн хэрэгсэл 2 (ахуйн хортон шавж, мэрэгч устгал, ариутгал, сувиллын чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад ажлын байрны дүгнэлт гаргах), эрүүл мэндийн даатгал 2 (ЭМД-аар хөнгөлөлттэй авсан тусламж, үйлчилгээний талаар гомдол илгээх, ЭМД-ын төлбөр төлөх), Үзлэг 1 (эмийн жор), Дархлаажуулалтын мэдээлэл, Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн лавлагаа, Эрүүл мэндийн ажилтны мэргэшлийн зэргийн лавлагаа зэрэг 16 үйлчилгээг холбож нэвтрүүлсэн. 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс цахимаар жор бичих, бичигдсэн жор төрийн мэдээллийн ХУР системээр дамжуулан эмийн сангийн систем, E-Mongolia системд иргэдэд харагдахаар болсон.	ЭМЯ	90	90.0	
35	2.2.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025	607.0, Улсын төсөв		УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан ба хуулийн 36.1.2-т олон улсын чанарын шаардлага хангасан хүний эмийг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллага, эмийн зохицуулалтын үнэлгээгээр ДЭМБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас шууд болон дамжуулан худалдан авах бол нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэхээр зохицуулсан. Улмаар Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор “Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам” батлагдсан. Гаалийн ерөнхий газрын УБ хот дахь Гаалийн газартай хамтран “Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ” санаачлагыг хэрэгжүүлэх төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй эм хүлээн авахтай холбоотойгоор хил дээрх зохицуулалтад оролцогч талуудын уулзалт, эм хүлээн авагч ЭХЭМҮТ, ЗӨСҮТ-ийн нийт 10 мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг 2024.04.12-ны өдөр зохион байгуулсан. Хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээнд шаардлагатай 30 гаруй нэр төрлийн эмийг 2024.05.21-ний өдөр ДЭМБ-аас ЭМЯ, ЭХЭМҮТ-д хүлээлгэн өгсөн. ДЭМБ, АНУ-ын Сэнт Жүүд хүүхдийн хавдрын эмнэлгийн төлөөлөгчидтэй хамтран оролцогч талуудад 2024.10.01-04-ний өдрүүдэд эм, эмнэлгийн хэрэгслийн төв агуулах болон хилийн боомт дээрх эм хадгалалтын процессын танилцуулга, “Бараа материалын удирдлагын загвар стандарт” үйл ажиллагааны стандарт ажиллагааны заавар болон тэдгээрийг тухайн улсын нөхцөл байдалд тохируулан авч үзэх практик сургалт, эмнэлэгийн САЗ-ын семинар зохион байгуулсан. Эрүүл мэндийн сайд 2024.09.22-25-ны өдрүүдэд БНСУ-д ажлын айлчлал хийж, тус улсын эм үйлдвэрлэгч байгууллагуудтай уулзалтууд хийсэн. БНСУ-ын Dongkoo Bio & Pharm, Hanmi Pharm, CKD, Hanlim Pharm, Yuhan Corporation, Korea United Phar	ЭМЯ	70	70.0	

36	2.2.8. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.	2021-2025	-		Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл”, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/125 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн ажилтны 2024-2025 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал”-ыг тус тус баталсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/199 дүгээр тушаалаар гадаад улсад богино хугацааны сургалтад эмнэлгийн мэргэжилтнийг хамруулах удирдамжийг баталж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын нийт 70 бага эмч, 69 сувилагчийг БНХАУ-д 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 17-ны хооронд 1 сарын сургалтад хамруулсан. Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр 2024 оны жилийн эцсийн байдлаар УХТЭ-ийн 31, ХСҮТ-ийн 33, УГТЭ-ийн 4, УНТЭ-ийн 51, ГССҮТ-ийн 4, нийт 117 эмнэлгийн мэргэжилтэнг АНУ, ОХУ, Япон Улс, БНХАУ, Итали Улс, БНСУ, Тайвань Улс, БНТУ-д сургалтад хамруулсан. 2024 онд гадаад сургалтад 697,995,600 төгрөг зарцуулсан. Харвардын их сургуулийн 1 жилийн “Эрүүл мэндийн салбар дахь манлайлал” сэдэвт Зүүн Өмнөд Азийн бүсийн хөтөлбөрт Эрүүл мэндийн яам, харьяа, орон нутгийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нийт 20 албан хаагч хамрагдаж, сургалт 2024 оны 03 дугаар сард дууссан. Дараагийн шатны сургалт 2024 оны 11 дүгээр сараас эхэлж, нийт 20 хүн хамрагдаж байна. Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчний оношлогоо, эмчилгээг нутагшуулах зорилгын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2024.09.03-ны өдрийн А/375 дугаар тушаалаар 13 үндэсний багийг байгуулж, хүний нөөцийг гадаадын өндөр хөгжилтэй оронд чадавхжуулж байна. Үүнд: УХТЭ-ийн 3 эмч, 1 сувилагч, 1 дүрс оношлогооны техникчийг БНХАУ-ын Шанхай хотын “И Да” эмнэлэгт, СЭМҮТ-ийн 5 эмчийг БНТУ-ын “Кануни Траининг” эмнэлэгт, ЭНЭҮТ-II-ийн 5 эмчийг БНЭнэтхэг-У-ын “Сарводаяа” эмнэлэгт, ГССҮТ-ийн 2 эмчийг БНСУ-ын Сунчинхян их сургуулийн Бучён эмнэлэгт, ГССҮТ-ийн 2 эмчийг БНХАУ-ын Өвөр Монгол анагаахын их су	ЭМЯ	70	70.0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			67.5	
Гэр бүл									
Зорилт 2.3.Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.									
37	2.3.1. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025	-		Гэр бүлийн тухай хуулийн төслийг ХНХЯ-наас 2018 оны 11-р сарын 28-нд ХНХСайдын А/3494 тоот албан бичгээр Засгийн газарт хүргүүлсэн. Хуулийн төслийг Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтоон. Засгийн газраас УИХ-д 2019 оны 4 дүгээр сарын 8-нд өргөн барьсан. Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-ын Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэж, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг Байнгын хорооны хуралдаанаар 80 хувь дэмжсэн. УИХ-ын чуулганы 2020 оны 01 дүгээр сарын 24-ний болон 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг олонхи дэмжсэн. Гэсэн хэдий ч Засгийн газраас 2021 оны 4-р сарын 9-нд хуулийн төслийг эргүүлэн татсан. Эргүүлэн татсанаас хойш Хууль зүй, дотоод хэргийн яам нь Монгол Улсын хууль эрх зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд хариуцан ажилласан. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төслийг ХЗДХЯ-тай хамтран боловсруулсан. Хуулийн төслийг Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр УИХ-д өргөн барьсан. УИХ-ын Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж УИХ-аар хэлэлцүүлэх хуулийн төслийн саналын томьёоллыг бэлтгэсэн. Гэвч УИХ-ын 2024 оны ээлжит сонгуультай холбогдуулан хэлэлцэгдэж амжаагүй. Энэ хугацаанд Ажлын хэсэг, Дэд ажлын хэсгийн хурлыг 4 удаа, олон нийтийн хэлэлцүүлгийг 2 удаа, мэргэжлийн байгууллагын хэлэлцүүлгийг 2 удаа тус тус зохион байгуулсан. Мөн Үндэсний олон нийтийн телевизээр УИХ-ын гишүүд, ажлын дэд хэсэг, Иргэний нийгмийн байгууллага, судлаачид оролцсон шууд нэвтрүүлгийг зохион байгуулсан.	ГБХНХЯ	100	90.0	Журмын 6.2.2.1.заасны дагуу үнэлсэн, хууль баталгаагүй боловч олон нийтийн болон УИХ-ын хэлэлцүүлэг хийгдсэн.
38	2.3.2. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшилийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2025	260.7, Тусгай сан		УИХ-ын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг болон дагалдан Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж “16.6.Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих зориулалт бүхий Хүүхдийн төлөө сантай байна.”, мөн 16.7-д “Энэ хуулийн 16.6-д заасан сангийн удирдлага, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.” гэж заасан. Мөн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 212.4-т заасны дагуу Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Сан байгуулагдсанаас /2021 оноос/ хойших хугацаанд “Хүүхдийн төлөө фонд” ТББ-аас 2,077.3 сая төгрөг, иргэдээс хандиваар 17.1 сая төгрөг, Автотээврийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсоноор Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос 20,388.2 сая төгрөг, нийт 22,482.6 сая төгрөгийн орлого төвлүүлснээс журамд заасан болзол шалгуур хангасан хүүхдүүдэд шагнал урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэхэд 287 хүүхдэд 690.0 сая төгрөг, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 7 хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд 40.3 сая төгрөг зарцуулсан. 2024.12 сарын байдлаар Хүүхдийн төлөө сангийн Төрийн сан дахь 100900039503 тоот дансанд 21,792.6 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна. Засгийн газрын 2024.10.23-ны өдрийн хуралдаанаар “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлуулсан. Журмын шинэчлэлээр: • Хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих; • Хүүхдэд зориулсан барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх; • Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зохицуулалт тусган, хүрээг тогтоосон.	ГБХНХЯ	100	90.0	Журмын 6.2.2.1.заасны дагуу үнэлсэн, Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй,
39	2.3.3. Залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөл сайжирна.□	2021-2025	-		Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 18 дугаар тогтоолоор баталж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, залуучуудын хөгжил, оролцооны асуудлыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудалд хамааруулсан.	ГБХНХЯ	100	100.00	
40	2.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.	2021-2025			1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолын хавсралтаар “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” нь хүчингүй болсон. 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2023 оны 12 дугаар сард ХЗДХ-ийн сайдтай хамтран баталсан. Хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 05 дугаар сарын 28-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “32.4. Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно” гэж заасан тул хуулийн төслийг дахин боловсруулж байна. 3.“Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн үзэл баримтлалыг 2024 оны 05 дугаар сард ХЗДХ-ийн сайдтай хамтран батлуулсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “32.4. Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно” гэж заасан тул хуулийн төслийг дахин боловсруулж байна. Хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандан судалгааг эцэслэн боловсруулсан. Мөн хуулийг дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна. 4. Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Ховд аймгийн ХБХТ-ийн барилгыг 2022 онд хүлээн авсан. Архангай аймагт баригдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга 50%-ийн гүйцэтгэлтэй байна. 5. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар хот дахь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг барьж, 2024 оны 06 дугаар сард ашиглалтад оруулж, хүлээн авсан.	ГБХНХЯ	100	90.0	Журмын 6.2.2.1.заасны дагуу үнэлсэн, Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй,
41	2.3.5. Хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгоно.	2021-2025	96.3, Улсын төсөв		Хүүхэд хамгааллын тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан. Хууль 2024 оны 09 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн ба хуулийг даган гарах дүрэм, журам, стандартыг боловсруулж батлах тухай Төрийн нарийн нарийн бичгийн даргын 2024 оны А/114, 115 дугаар тушаалыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ГБХНХ-ын сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/33 дугаар тушаалаар баталсан. Үүнд. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам, Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ёс зүйн дүрэм, Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх аргачлал, заавар, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, магадлан итгэмжлэх журам батлагдсан. Засгийн газрын 2024 оны 142 дугаар тогтоолоор “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрэм”, 143 дугаар тогтоолоор “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоо”-г тус тус батлуулсан. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам, болон бусад яамдтай хамтран батлах журмууд хянагдаж байна. - Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны “Хүүхэд хамгааллын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулийг олон нийтэд сурталчлан таниулах нөлөөллийн ажил зохион байгуулах тухай” А/40, А/67 дугаар тушаал батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Зүүн бүсийн аймгуудад 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд, баруун, хойд, говийн, төвийн болон нийслэлийн бүсүүдэд 04 дүгээр сарын 16-аас 05 дугаар сарын 20-ны хугацаанд, салбарын бүх яамд, Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газар, БЗД-ийн Ерөнхий боловсролын сургуулиудын Эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд 2024 оны 03-09 дүгээр сард зохион байгуулж, 6300 төрийн албан хааг	ГБХНХЯ	100	90.0	Хуулийг даган гарах зарим дүрэм, журам, стандартыг боловсруулах шатанд, хууль батлагдсанаар гарсан үр дүнгийн талаар тусгаагүй,
					Зорилтын хэрэгжилтийн хувь			92.0	
Шинжлэх ухаан, технологи, инноваци									
Зорилт 2.4.Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, ур ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлнэ.									
42	2.4.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг үе шаттай нэмэгдүүлнэ.	2021-2025	100.0, Улсын төсөв		Эрдэм шинжилгээний байгууллагын чадавхыг бэхжүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгох зорилгоор төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн жагсаалтыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Жагсаалт батлах тухай” А/51 дүгээр тушаалаар баталсан. Нийт 26 эрдэм шинжилгээний байгууллагын 99 судалгааны үндсэн чиглэл, хамрах хүрээний 322 сэдвийн жагсаалт багтсан. Шинжлэх ухааны салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлнэ. Судалгааны үндсэн чиглэлд 2023 онд 900.0 сая төгрөг, 2024 онд 1.1 тэрбум төгрөгийг тус тус олгосон.	ЭЗХЯ	100	100.0	

43	2.4.2. Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлого хэрэгжүүлж, эрдэм, шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлнэ.	2021-2025	15.0, Улсын төсөв	Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах ажлын хүрээнд Засгийн газрын 2024 оны "Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 214 дүгээр тогтоолоор шинжлэх ухаан, технологи, инновацийн өндөр мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, үндэсний чадавхийг бэхжүүлэх, тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр салбар дундын судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор ШУА болон төрийн өмчийн хүрээлэн тэдгээрийн материаллаг бааз, хүний нөөцөд түшиглэн Шинжлэх ухааны академийн их сургуулийг ахисан түвшний дээд боловсролын сургалтын байгууллага (UMAS) статустайгаар байгуулсан. Энэ сургууль байгуулагдсан нь шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах тогтолцоо бүрдэх эхний томоохон шийдэл болсон. Засгийн газрын 2024 оны 5-р сарын "Тогтоолын хавсралт нэмэлт оруулах тухай" 206-р тогтоол, "Төрийн өмчийн зарим их сургуулийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 207-р тогтоолоор ШУТИС-ийн харьяанд Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн 21, МУИС-ийн харьяанд Монгол судлалын хүрээлэн 5, Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэнг 8, Эдийн засгийн хүрээлэн 5, СУИС-ийн харьяанд Соёл, урлаг судлалын хүрээлэн 12 орон тоотойгоор тус тус байгуулж нийт эрдэм шинжилгээний ажилтны тоог 51-р нэмэгдүүлсэн.	ЭЗХЯ	100	100.0	
44	2.4.3. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан "Үндэсний судалгааны төв"-үүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	2021-2025		Засгийн газрын 2023 оны "Төрийн өмчийн их сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 306 дугаар тогтоолын 5 дахь заалтыг үндэслэн Шинжлэх ухаан, технологи, инновацийн өндөр мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, үндэсний чадавхийг бэхжүүлэх, тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр салбар дундын судалгаа хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор Шинжлэх ухааны академи, харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн материаллаг бааз, хүний нөөцөд түшиглэн Ахисан түвшний их сургуулийг байгуулах талаар ШУА, эрдэмтдийн төлөөлөл судалгааг хийж, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор ШУА-ийн харьяанд ахисан түвшний их сургуулийг байгуулах шийдвэрийг гаргуулсан. ШУА-ийн их сургууль нь Төрийн өмчийн таван их сургууль (МУИС, ШУТИС, МУБИС, ХААИС, АШУҮИС)-тай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан.	ЭЗХЯ	100	100.0	
45	2.4.4. Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг татварын бодлого, эдийн засгийн хөшүүргээр дэмжсэн эрх зүйн шинэчлэлт хийгдэнэ.	2021-2025	1,271.2, Улсын төсөв	Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор "Инновацын 7 хоног 2024" арга хэмжээний хүрээнд "Эрдэм хакатон"-ыг зохион байгуулж шилдэг 3 төсөлд грант олгосон. Нийгмийн инновацийн санаачилгыг дэмжих "Мон Икс" хөтөлбөрийн шилдэг 9 төсөлд тус тус дэмжлэг үзүүлж грант олгосон. Эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг татварын бодлого болон эдийн засгийн хөшүүргээр дэмжих зорилгоор Засгийн газрын 2023 оны 39 дугаар тогтоолоор "Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу 10 гарааны компани байгуулагдсан. Мөн 2024 онд батлагдсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн санхүү, татварын бодлогоор дэмжих эрх зүйн орчин бий болсон.	ЭЗХЯ	100	100.0	
46	2.4.5. Шинжлэх ухаан, технологи, инновацын дэд бүтцийг бий болгож, төрөлжсөн нээлттэй лабораторийг байгуулж, шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг ашиглалтад оруулна.	2021-2025	23,935, Улсын төсөв	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын 3 лабораторын ажил 90%, оффисын барилгын ажил 52%, нийт цогцолборын ажил 73% явагдаж байна. Шинжлэх ухааны парк байгуулах ажлын хүрээнд Төв аймгийн Хөшигийн хөндийд "Сургалт-Эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ын ерөнхий төлөвлөгөөнд Шинжлэх ухааны парк тусгагдаж батлагдсан. НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурал (UNCTAD)-тай хамтран "Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан шинжлэх ухаан, технологи, инновацын парк Монгол Улсын бодлогын орчин, практик чадавхыг бэхжүүлэх нь" төсөл хэрэгжиж байна. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг барих төсвийн саналыг 2025 оны төсөвт тусгахаар Сангийн яаманд хүргүүлсэн.	ЭЗХЯ	70	70.0	
47	2.4.6. Эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлж, үр дүнд тохирсон цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлсэн байна.	2021-2025	60.0, Улсын төсөв	Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор салбарын албан хаагчдын цалингийн доод хэмжээг 1,100,000.0₮ байхаар буюу 41.5%-иар нэмэгдсэн. Цалингийн системд өөрчлөлт оруулж, ТҮШУ ангилалын шатлалыг байхгүй болгож, ангилал тус бүрийн цалингийн доод хэмжээг тогтоож өгснөөр албан хаагч нь ажлын үр дүнгээрээ цалинжих боломжтой болсон. Эрдэм шинжилгээний ажилтны цалингийн сүлжээний шатлал байхгүй болж, нийт албан хаагчид цалингийн 5 дахь шатлалаар цалинждаг болсон. Мөн Засгийн газрын 2024 оны ""Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар салбарын эрдэм шинжилгээний ажилтны цалинг дахин 10 хувиар нэмэгдүүлсэн. -Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт, нийтлэг шаардлага шалгуур үзүүлэлтийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6094 дугаарт бүртгүүлсэн. Энэхүү захиргааны хэм хэмжээний актаар эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлэн баталж, үр дүнд тохирсон цалин, зэрэг дэвийн урамшууллыг авах тогтолцоо бүрдсэн.	ЭЗХЯ	100	100.0	
48	2.4.7. Шинжлэх ухаан, технологи, инновацын статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.	2021-2025	-	Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн мэдээний албан ёсны болон захиргааны маягыг Шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны А/69 тушаалаар шинэчлэн батлуулсан. Хуучин маягтаар авсан салбарын статистик мэдээллийг олон улсын мэдээ буюу ЮНЕСКО-гийн Шинжлэх ухааны газарт жил бүр явуулдаг мэдээллийг гарган өгөх боломжгүй байсан ба шинэ маягыг тус байгууллагын статистикийн маягтад нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлуулсан. Жишээлбэл, ЮНЕСКО-гийн статистикийн маягтад хагас цагийн судлаач, бүтэн цагийн судлаач гэсэн ангилал болон судлаачдыг насыг олон улсад мөрдөгддөг насны ангиллаар ялган тусгасан байдаг нь манай улсын хувьд гаргах боломжгүй үзүүлэлт байсан бөгөөд шинэ маягтаа тус үзүүлэлтүүдэд тохируулан боловруулж батлуулсан. Ингэснээр Монгол Улсын хуулийн хэрэгжилт, Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжилтийг дүгнэх, Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг тооцоход ашиглахаас гадна ЮНЕСКО-ын Шинжлэх ухааны байгууллагад салбарын үзүүлэлтийг жил бүр хүргүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх боломж бүрдсэн. Мөн Үндэсний Статистикийн хорооны дэмжлэгтэйгээр Аж ахуй нэгжийн улсын тооллогын асуулгад хувийн хэвшлийн байгууллагуудын судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулж буй хөрөнгийн хэмжээг холбогдох үзүүлэлтүүдийг тусган, анх удаа мэдээллийг гарган авсан.	ЭЗХЯ	100	100.0	
49	2.4.8. Хэмжил зүйн лабораторийг олон улсын жишигт хүргэсэн байна.	2021-2025	-	Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу, Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын тендерийн худалдан авах ажиллагаа хийгдэж, БНХАУ-д үйлдвэрлэсэн (0,016–10) м3/ц урсгалын зарцуулалттай, (90-250) мм-ийн хэмжих хязгаартай хийн тоолуур шалгах суурин ажлын эталон төхөөрөмж Стандарт, хэмжил зүйн газарт 2024 онд нийлүүлэгдсэн ба Монгол Улсад анх удаагаа хийн тоолуур шалгах лабораторийг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн байгуулсан. Хийн тоолуур шалгаж лаборатори байгуулснаар хийн тоолуур шалгаж баталгаажуулах, загварын туршилт хийх, нэгж дамжуулалтыг хангах шинжлэх ухаан, техникийн үндсийг бүрдүүлсэн ба үйл ажиллагаандаа ашиглаж байна.	СХЗГ	100	90.0	
50	2.4.9. Шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацын төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулна.	2021-2025	50.0, Улсын төсөв	Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн мэдээний албан ёсны болон захиргааны маягыг Шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны А/69 тушаалаар шинэчлэн батлуулсан. Хуучин маягтаар авсан салбарын статистик мэдээллийг олон улсын мэдээ буюу ЮНЕСКО-гийн Шинжлэх ухааны газарт жил бүр явуулдаг мэдээллийг гарган өгөх боломжгүй байсан ба шинэ маягыг тус байгууллагын статистикийн маягтад нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлуулсан. Жишээлбэл, ЮНЕСКО-гийн статистикийн маягтад хагас цагийн судлаач, бүтэн цагийн судлаач гэсэн ангилал болон судлаачдыг насыг олон улсад мөрдөгддөг насны ангиллаар ялган тусгасан байдаг нь манай улсын хувьд гаргах боломжгүй үзүүлэлт байсан бөгөөд шинэ маягтаа тус үзүүлэлтүүдэд тохируулан боловруулж батлуулсан. Ингэснээр Монгол Улсын хуулийн хэрэгжилт, Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжилтийг дүгнэх, Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг тооцоход ашиглахаас гадна ЮНЕСКО-ын Шинжлэх ухааны байгууллагад салбарын үзүүлэлтийг жил бүр хүргүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх боломж бүрдсэн. Мөн Үндэсний Статистикийн хорооны дэмжлэгтэйгээр Аж ахуй нэгжийн улсын тооллогын асуулгад хувийн хэвшлийн байгууллагуудын судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулж буй хөрөнгийн хэмжээг холбогдох үзүүлэлтүүдийг тусган, анх удаа мэдээллийг гарган авсан.	ЭЗХЯ	90	90.0	
				Зорилтын хэрэгжилтийн хувь			94.4	
Хүнд ээлтэй амьдрах орчин								
Зорилт 2.5.Эрүүл баталгаат орчныг бий болгоно:								
51	2.5.1.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадвартай болж, хүнсний аюулгүй байдал хангагдана.	2021-2025	-	1."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хавсралтад улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх, хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавхжуулах зэрэг асуудлыг тусган ажиллав. 2.Доор стандартыг СХЗГ-ын Хүнсний стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлж баталсан. - MNS CAC GL 71:2023 "Малын эмийг хүнсний зориулалттай мал амьтанд хэрэглэхтэй холбоотой хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах үндэсний зохицуулалтын хөтөлбөр. Боловсруулах хэрэгжүүлэх зааварчилгаа"; - MNS CAC RCP 1:2023 "Хүнсний эрүүл ахуйн ерөнхий дүрэм"; - MNS CAC MRL 2:2023 "Хүнсэн дэх мал эмнэлгийн эм, бэлдмэлийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ"; - MNS CAC GL 63:2023 "Микробиологийн эрсдлийн менежментийн зарчим, удирдамж"; - MNS CAC RCP 54:2023 "Мал амьтны тэжээл, тэжээллэгийн зохистой дадлын дүрэм";	ХХААХҮЯ	100	70.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, стандарт дүрэм батлагдсанаар гарсан үр дүнг дурдаагүй

52	2.5.2. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг олон улсын түвшинд хүргэж, шинэчилнэ.	2021-2025	21.0, ББНС		Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг УИХ-д 2020.01.22-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн Газрын тухай багц хуулийн төслийн хамт хэлэлцэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т заасны хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буцаагдсан болно. Иймд тус яамнаас хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ХББОСС-ын 2024 оны 79 дүгээр тушаалаар байгуулж, шинээр батлагдсан хууль тогтоомжтой уялдуулан боловсруулах, "20 минутын хот" стандартыг нэвтрүүлэх, холбогдох хуулийн уялдааг сайжруулах чиглэлээр хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахаар "Хууль зүйн бичигт хүрээлэн" НҮҮТББ-тай 2024.12.02-ны өдрийн 2024/192 тоот зөвлөх үйлчилгээний гэрээг гэрээ байгуулан ажиллаж байна. - БХБ-ын сайд, БОАЖ-ын сайд нарын хамтарсан 2023 оны 35/ А/36 тоот тушаалаар байгуулсан Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн хурал 2024.03.26, 04.17, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан. "Ажлын хэсгийн 2024 оны төлөвлөгөө"-г батлуулан, хуулийн үзэл баримтлалын төсөл, анхдагч хуулийн төсөл, олон улсын ижил төстэй хуулийн судалгааг боловсруулсан ба санал авах ажлыг зохион байгуулж байна. -Шинэчлэн боловсруулагдаж буй "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт" /БНБД 30-01-.../-ийн төслийг ШУТТЗХ-аар хэлэлцүүлэхээр БХТ-ийн 2024.04.18-ны өдрийн 2/956 тоот албан бичгээр ирүүлсэнийг ТНБД-ын баталсан 03/2018 дугаартай техникийн даалгаврын дагуу хянан үзээд дахин боловсруулах шаардлагатай тул 2024 оны 03/807 тоот албан бичгээр буцаасан. "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт" /БНБД 31-01-24/, Олон нийт иргэний барилга" /БНБД 31-01-03*/11/-ыг хянан үзээд хооронд нь нийцүүлэн дахин хянан тохиолдуулах шаардлагатай байх тул 2024.08.29-ны өдрийн 03/365 дугаар албан бичгээр буцаан төслүүдийн боловсруулалтыг сайжруулж, хянан тохиолдуулж, хамтад нь тус хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. /90 хувь/	ХББОСЯ	90	70.0	Бэлтгэл ажил хийгдсэн.
53	2.5.3. Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.	2021-2025	1,366.3, Улсын төсөв		Нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ЕТ”-г боловсруулж байгаатай холбогдуулан уг ерөнхий төлөвлөгөөний төсөлд БНСУ-ын “Дэхан консалтентс” ХХК-тай 2024 оны НХААГ/20240103 147 тоот гэрээ байгуулж, дүгнэлт зөвлөмж гаргуулсан. Уг дүгнэлт, зөвлөмж болон УИХ-аас 2024.06.05-ны өдөр баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль, “Хот байгуулах тухай” УИХ-ын 2024 оны 72-р тогтоол гарсантай холбогдуулан хөгжлийн ЕТ-ний төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг НЗДТГ, Нийслэлийн хот төлөвлөлт судалгааны институттэй хамтран гүйцэтгэсэн.Уг ажлын явцын талаар Засгийн газрын 2024.09.18-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 33 дугаар тэмдэглэл гарсан. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтийг боловсруулах 2024/03, 2024/01, 2024/06 дугаартай ажлын даалгаврыг боловсруулж, ХББОС-ыг сайд Ж.Батсуурь, МУ-ын сайд, 20 минутын хот ҮХ-ны дарга Р.Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нараар 2024.11.01-ний өдөр батлуулсан. Хөгжлийн ЕТ-ний төсөлд 2 үндэсний хороо, 16 яам, 6 дүүрэг, нийслэлийн 33 агентлагаас санал авч тусгасан бөгөөд МАЭ-ийн дэргэдэх Архитектур, хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2024.11.29-ний өдөр, "20 минутын хот" ҮХ-ны хурлаар 2024.12.18-ны өдөр, тус яамны дэргэдэх ШУТТЗХ-аар 2024.12.20-ны өдөр, БХБОСС-ын зөвлөлийн хурлаар 2024.12.23-ны өдөр тус тус хэлэлцүүлсэн. Мөн уг зураг төслийн баримт бичигт экспертизийн нэгдсэн дүгнэлт гаргуулахаар ХББОС-ын сайдын 2024.12.02-ны өдрийн 115-р тушаалаар орон тооны бус экспертүүдийн АХ-ийг байгуулан ажиллаж байна.	ХББОСЯ	90	50.0	Журмын 6.2.2.3-т заасан боловсруулалтын ажил хийгдсэн.
54	2.5.4. Эрүүл мэндийн болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлнэ.	2021-2025	-		Эрүүл мэнд болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн сайдын тушаалаар журмуудыг шинэчлэн баталсан. Үүнд: “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, үнэлгээ хийх байгууллага сонгон шалгаруулах журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/142 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга замыг тодорхойлох, эерэг нөлөөллийг дэмжихэд чиглэж байна. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/350 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. 2024 онд Эрүүл мэнд болон орчны тандалт, нөлөөллийн ямар нэгэн үнэлгээ хийгээгүй байна. 2024 онд Дорноговь аймгийн Улаанбадрах суманд үйл ажиллагаа явуулж буй “Бадрах энержи” ХХК, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргаас (иргэдээс) нөлөөллийн үнэлгээ хийх хүсэлт ирсэн ч ямар нэгэн үйл ажиллагаа хийж эхлээгүй байна. НЭМҮТ ДЭМБ-ын 10.9 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэгээр Монгол Улсын орчны эрүүл мэндийн 2016-2024 оны төлөв байдлын эмхэтгэл номыг боловсруулж, хэвлүүлэхээр ажиллаж байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвтэй хамтран Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэх техникийн болон тогтолцооны чадавхийг бэхжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд тусгах нь бэлэн байдлын төсөл”-ийн хүрээнд НЭМҮТ-ийн тандалтын программыг шинэчилж байна. Төслийн багаас тендер зарлаж, гүйцэтгэгчээр Robot systems LLC шалгарч, Цаг уур, орчны шинжилгээний газраас Агаар бохирдуулагч 4 үзүүлэлт, ЭМЯ-наас Ундны усны бохирдлын 5 үзүүлэлт, Хөрсний бохирдлын 4 үзүүлэлт, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Хүн амын өвчлөл, нас баралтын 2018-2023 оны тоон мэдээллийг нэгтгэж, https://www.tandalt.mn/ -д оруулж мэдээллийн сан үүсгэж байна.	ЭМЯ	50	50.0	
55	2.5.5. Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2025	-		1.“Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хүнсний салбарын үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх 7 зохистой дадлын зааврыг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Үүний хүрээнд: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны Зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар батлах тухай” А/100, А/68 дугаар тушаалаар “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадлын хялбаршуулан нэвтрүүлэх заавар”, “Турил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадлын хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ыг тус тус хавсралтаар батлан мөрдүүлж, зохицуулалт хийж байна. 2. Эрх бүхий байгууллага /СХЗГ/-аас хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж, гэрчилгээ олгосон нийт 33 ААНБ байгаагаас 17 ААНБ хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг, 16 ААНБ эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн байна. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн 16 ААНБ-ын 2 ААНБ нь 2023 онд шинээр нэвтрүүлсэн бол үйл ажиллагаандаа ISO14000 байгаль орчны менежментийн багц стандартыг нэвтрүүлсэн 3 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ААНБ байна. Харин үйл ажиллагаандаа хүнсний хог хаягдлын менежмент нэвтрүүлсэн ААНБ бүртгэгдээгүй байна.	ХХААХҮЯ	70	50.0	7 зохистой дадлын заавар батлахаас 2 батлагдсан, журмын 6.2.2.3. -ээр үнэлэв.
56	2.5.6. Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2025	5,354.4, Улсын төсөв		1.1.1. “Ус зайлуулах суваг, шугам /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3-р хороо, Нарны хороолол-Дунд гол /ХII.1.12/-ын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. трассын давхцалтай тул уг ажлыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай хамтран шийдвэрлэхээр ажиллаж байна. 1.1.2. 21 аймгийн хэмжээнд дараах ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Үүнд: - ХII.1.67 - Үерийн хамгаалалтын барилга байгууламж /Сэлэнгэ, Сант сум, Ивэн голын боомт/- “Эм Даблоь Ти” ХХК-ийн Үерийн боомтын ажлыг 11 дүгээр сарын 15-ны өдрийн Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Тус яам нь гүйцэтгэлийн тайланг хүлээн авч, хянан, санхүүжилтийг шийвэрлүүлэхээр ажиллаж байна; Гүйцэтгэл 100 хувьтай; - Төв аймгийн Шинэ Зуунмод хотод тус яамтай 2022/573 дугаартай гэрээ байгуулан хэрэгжсэн “Үерийн хамгаалалтын суваг-4 /4.9 км/-ийн ажлыг гүйцэтгэсэн “Хангилцаг” ХХК-ийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулаад байна. Ажлын гүйцэтгэл - 100 хувьтай.	ХББОСЯ	100	50.0	Журмын 6.2.2.3-ын дагуу үнэлэв.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			56.7	
Хөдөлмөрийн зах зээл									
Зорилт 2.6.Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ.									
57	2.6.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгоно.	2021-2025	-		1. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг УИХ-ын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа баталсан. Хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна. 2. Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдэж байгаатай холбогдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/214 дугаар тушаалаар байгуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банкны “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих” төслийн дэмжлэгтэйгээр хууль эрх зүйн актын зохицуулалт, уялдаа холбоог судлах дүн шинжилгээ хийж, дотоодын зөвлөхтэй хамтран ХАБЭАН-н тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.	ГБХНХЯ	70	50.0	Журмын 6.2.2.3-т заасан боловсруулалтын ажил хийгдсэн.
58	2.6.2. Ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2025	59,600.0 , ХЭДС		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-т хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг дэмжих, Засгийн газар болон хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 үйл ажиллагааны 34 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/39 дугаар тоот тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлан хэрэгжүүлж байна.	ГБХНХЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй

59	2.6.3. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ	2021-2025	115.0	Улсын төсөв	Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2021 оны 7 дугаар сард УИХ-аас баталж, хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Хөдөлмөрийн гэрээний төрлүүдийг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн гурвалсан харилцаа, ажлын бүтэн бус цагаар ажиллах, зайнаас ажиллах зэрэг хөдөлмөрийн гэрээний төрлөөс ажил үргийн онцлогтой холбогдуулан сонгож байгуулахаар тусгасан. 2023 онд ХЭҮЗ-өөр "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг батлуулж, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эргэн нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллах хүчнээс гадуур байгаа эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, тэдэнд болон гэртээ удаан хугацаагаар хүүхдээ харж буй бага насны хүүхэдтэй ээжүүдэд хөдөлмөрлөх боломж олгох хүрээнд богино хугацааны ур чадвар олгох, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих сургалтуудыг 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 оны 11 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр харуулвал Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад 661 иргэн хамрагдаж, 115,042,600 төгрөгийг зарцуулж, ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлж байна. Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг олон улсын жишигт нийцсэн, ижил стандарт бүхий "Job center" төвүүдийг байгуулахаар төлөвлөж, Улаанбаатар хотод эхний төвүүд үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэхүү төвийн онцлог нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд нээгдэж байгаагаараа онцлог юм. "Job center" төвөөр үйлчлүүлсэнээр ажилгүй иргэн, ажил хайгч иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил, мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл авах хүсэлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, оюутан залуучууд, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч иргэн, гадаадад амьдарч байгаад эх орондоо болон ажил олгогч байгууллагууд нэг дор хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг авахаас гадна цагийн ажил, зайнаас ажиллах ажилд зучлагдах боломжтой болсон.	ГБХНХЯ	100	90.0	Цахим, зайн ажлын байр нэмэгдсэн эсэх тодорхойгүй
60	2.6.4. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.	2021-2025	-		Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/150 дугаар тушаалаар холбогдох байгууллагуудтай хамтран албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэхэд цахим систем болон цахим үйлчилгээнүүдийг дэмжих, хэрэгцээ шаардлагад үндэслэн цахимаар албажуулах санал боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгийн шийдвэрээр албан бус эдийн засгийг бүртгэлжүүлэх, албажуулахад ашиглах системийн загвар /дизайн/ боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд бодлогын зөвлөмж боловсруулах мэдээллийн технологийн болон ахлах зөвлөх сонгон шалгаруулсан. Мэдээллийн технологийн болон ахлах зөвлөхүүд 2024 оны 05 дугаар сарын 21-30-ны өдрүүдэд холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцаж "Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албажуулахад системийн шийдлийн боломжит хувилбар", "Албан бус хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдлын тоон шинжилгээ, албажуулахад нөлөөлөх нөхцөл, боломж"-ийн талаарх судалгааг боловсруулж урьдчилсан тайланг 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр холбогдох яамд, агентлаг, нийгмийн түншлэлийн байгууллагуудыг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус судалгааны үр дүнд албан салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо 76759 буюу ХАА-н салбарыг оруулаагүй албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 35.6 хувийг хамарч байна. Мөн Албан бус салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 64.0 хувийг хамарч байна. Зөвлөхүүдийн гаргасан бодлогын зөвлөмж нь албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээллийн цахим бааз бий болгох талаар суурь судалгааг хийж эхний тайланг 2024 оны 11 дүгээр сард тус яаманд ирүүлсэн. Цаашид төрийн холбогдох мэдээллийн системүүдийг ашиглан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн цахим бүртгэлийн системийг хөгжүүлэх боломж бүрдэх юм.	ГБХНХЯ	50	30.0	Журмын 6.2.2.4.-т заасан бэлтгэл ажил дууссан буюу суурь судалгаа тайлан гарсан.
61	2.6.5. Төрийн албан хаагчдын цалинг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ	2021-2025	-		Засгийн газраас төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримталж ирсэн бөгөөд 2012 онд 53.0 орчим хувиар, 2014 онд 17.0 орчим хувиар, 2017 онд 4.0 орчим хувиар, 2018 онд 8.0 хувиар, 2019 онд 8.0 хувиар, 2020 онд мөн 8.0 хувиар төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёлын салбарын төрийн үйлчилгээний болон төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг цалингийн сүлжээний хамгийн өндөр буюу 5 дугаар шатлалаар тогтоож, төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин дунджаар 8.6 хувиар нэмэгдсэн. 2023 онд төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ: Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой дараах шийдвэрийг гаргаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлсэн. Үүнд: • Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ нь 15 зэрэглэл тус бүрт 3-5 шатлалтай, төрийн тусгай албаны цалингийн сүлжээ нь 18 зэрэглэл тус бүрт 3-5 шатлалтай буюу нийт 153 ялгаатай цалинтай байсныг өөрчлөн төрийн захиргааны албан тушаалын 15 зэрэглэлийг 10, тусгай албаны 18 зэрэглэлийг 12 болгон нягтаршуулсан. Мөн үндсэн цалинг цалингийн шатлалын хамгийн өндрөөр нь тогтоон нэг шатлалтай болгосон. • Төрийн захиргааны болон үйлчилгээний албанд анх ажилд орсон албан хаагч тасралтгүй 5 жил ажилласны дараагаас ажилласан жилийн нэмэгдэл авч эхэлдэг байсныг өөрчилж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил бүрээр бодож олгодог болсон. • Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 20.4-т заасны дагуу нийслэл, дүүргийн төсвөөс санхүүждэг захиргааны байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн. Түүнчлэн, Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Уг арга хэмжээний хүрээнд: Төрийн захиргааны албан хаа	ГБХНХЯ	100	100.0	

				Зорилтын хэрэгжилтийн хувь				72.0			
Монгол хүний удмын сан											
Зорилт 2.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.											
62	2.7.1. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээнэ.	2021-2025	-		"1. ЮНЕСКО-ийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн (UNESCO Memory of the World Programme) Ази-Номхон далайн бүсийн хорооны 10 дугаар Ерөнхий чуулганыг 2024 оны 5 дугаар сарын 6-10 өдрүүдэд зохион байгуулж, Монгол Улсын Үндэсний Номын Сангаас сан хөмрөгөөс ""Эзэн Богд Чингис хаанаас эхэлсэн Халхын долоон хошуу, дөрвөн аймгийн ноёдын гэрийн үеийн бичмэл"" баримтат өвийг ЮНЕСКО-ийн ""Дэлхийн дурсамж"" хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүс нутгийн баримтат өвийн жагсаалтад бүртгүүлсэн. 2. ЗГХА Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, нийслэл, 21 аймгийн Соёл, аялал жуулчлал, залуучуудын газар, угийн бичиг хөтлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Угийн бичгийн академи" ТББ, "Их Монголын ураг удмын нэгдэл" НҮТББ, "Уг удам, өв соёлын холбоо" НҮТББ, "Прогнат" ХХК-тай хамтран ажиллаж уламжлалт аргаар хөтөлсөн 6 угийн бичгийг сурвалжлан олсон."	ССАЖЗЯ	90	50.0	Үндэсний уламжлалыг хэрхэн сэргээсэн бэ? Авч хэрэгжүүлсэн ажил хангалтгүй.		
63	2.7.2. Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн соготгой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ.	2021-2025			Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэдэх Анагаахын удамзүйн лабораторид цитогенетик шинжилгээний аргууд нэвтэрч, хромосомын эмгэгийг оношлох бүрэн боломжтой болж, жилээс жилд үйлчлүүлэгчийн тоо нэмэгдэж байна. Шинээр төрсөн нярай бүрт 5 төрлийн эмгэгийг эрт үед нь илрүүлэх скрининг үзлэгийг тогтмол хийж байна. Үүнд: - Түнхний хэт авиан скринингийг хэрэгжүүлснээр 2024 онд 8,215 нярайд түнхний дутуу хөгжил, мултралын шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлж чадсан. - 2024 онд ЭХЭМҮТ-д төрсөн 7,960 нярай, бусад амаржихад төрсөн 627, хөдөө орон нутагт (Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Орхон) төрсөн 2,694 нярайд сонсголын скринингд хамруулж, чихний хөгжлийн төрөлхийн гажиг 9, сонсгол бууралт 50 оношлогдсон. Сонсгол бууралт илэрсэн 50 хүүхдээс 14 хүүхдэд эмийн эмчилгээ, 10 хүүхдэд агааржуулах гуурс тавих мэс засал, 15 хүүхдэд сонсгол нөхөн сэргээх (сонсголын аппарат) эмчилгээ хийгдээд байна. 5 хүүхдэд дунгийн суулгачын мэс засал хийгдсэн, 2025 онд дунгийн суулгац заалттай 6 хүүхдэд хийхээр мэс заслыг төлөвлөсөн. Чихний хөгжлийн гажигтай 9 хүүхдийг хяналтад авсан. - 2024 онд ЭХЭМҮТ-д нүдний угийн улаан рефлекс (НУУР) скрининг 4,886 нярайд хийгдэж, 1 тохиолдолд анофтальм илэрсэн байна. - Дутуу нярайн ретинопатийн илрүүлэх скрининг үзлэгт FORUS оношлогооны аппаратыг хэрэглэж, эмчилгээг олон улсын түвшинд, нотолгоонд суурилсан дутуу нярайн ретинопатийн оношлогоо, эмчилгээ хийгдэж байна. 2024 онд ЭХЭМҮТ-д 2,027 дутуу нярайд дутуу нярайн ретинопатийн скрининг үзлэг хийж, ДНР илэрсэн 1,091 нярайд хянаж, 59 дутуу нярайд (Laser 13 ба Anti VEGF эмийн эмчилгээ 46) эмчилгээ хийгдсэн. Нийт 59 нярайд 1 дүгээр хэлбэр оношлогдож, эмгэг судасны ургалтыг зогсоох эмийн эмчилгээ ба торлогийн лазер эмчилгээ, 851 нярайд ДНР-ийн 2-р хэлбэр оношлогдож, эмийн эмчилгээгүй намжмал байдалд орсон. - Нярайд зүрхний төрөлхийн гажгийг илрүүлэх пульс-оксиметрийн скринингийг НСТ-т 100% хамруулж, скринингийн үр дүнд зүрхний хөх хэлбэрийн хүнд гажигтай 10 нярайд оношлож, эмчилж	ЭМЯ	90	90.0			
64	2.7.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ	2021-2025	-		Монгол Улсад 2000-2004, 2005-2008, 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай Монгол Улсын Их Хурлын 2001 оны 96, 2005 оны 29, 2009 оны 44 дүгээр тогтоолд жилд оруулж болох цагаач гадаадын иргэний тоог жил бүр 100-аас дээшгүй байхаар тус тус тогтоож байсан. 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 1779 гадаадын иргэн Монгол Улсад цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаагаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн 1220 байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй ба зохистой түвшинд байна.	ХЗДХЯ	100	100.0			
65	2.7.4. Хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгоно.	2021-2025	-		Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай" 01 дүгээр тогтоолын 3 дэх хэсэгт зааснаар "Хүний генетикийн оношлогоо, эмчилгээ, генийн сангийн аюулгүй байдлыг зохицуулах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, УИХ-д 2023 онд багтаан өргөн мэдүүлэх" гэж тусгасан. Хүний генетикийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/111 дүгээр тушаалаар шинэчилсэн. Хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл зэргийг боловсруулж байгаа ч ахиц гараагүй байна. Мөн Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг дахин боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/456 дугаар тушаалаар батлуулсан ч одоогоор тодорхой ахиц гараагүй байна. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлж байна. "Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө 2024-2025 он"-д хэрэгжүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хууль	ЭМЯ	100	90.0	Хуулийн төсөл боловсруулсан. Эрх зүйн орчин хараахан бүрдээгүй.		
					Зорилтын хэрэгжилтийн хувь				82.5		
					Зорилгын хэрэгжилтийн хувь				79.1		
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА											
Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.											
Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл.											
Зорилт 3.1. Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлнэ.											

66	3.1.1. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.	2021-2025			Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжснээр олон давхаргат тэтгэврийн тогтолцог нэвтрүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилүүлэх, тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх, тэтгэврийн даатгалын нэрийн дансны хийсвэр бичилтийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх зэрэг томоохон өөрчлөлтийг хийх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх”-ээр хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих эрх зүйн орчин бүрдээд байна. Тухайлбал, 2024 оноос эхлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.1-д “энэ хуулийн 18.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлого;” гэж заасны дагуу шимтгэлийн орлогыг хуримтлал болгох арга хэмжээ үе шаттай хэрэгжиж эхлэх юм.	ГБХНХЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
67	3.1.2. Иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болж, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэл хийгдэнэ.	2021-2025	-		Монгол Улсын Засгийн газар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Шинэчлэн батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх” харилцааг зохицуулахаар тусгасан. Тэтгэврийн нөөц санг даатгуулагчийн төлөх шимтгэлийн 2 хувь, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу улсын төсөвт шилжүүлсэн орлого, улсын төсвөөс олгох бусад орлогоос бүрдүүлэхээр хуульчилсан. Тухайлбал, 2024 оноос эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2.0 хувийн шимтгэлийн орлогыг хуримтлал болгох арга хэмжээ үе шаттай хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2024 оны 12 дугаар сарын байдлаар 214.2 тэрбум төгрөг бодитоор хуримтлагдсан байна.	ГБХНХЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
68	3.1.3. Нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.	2021-2025	12.700.0 , Улсын төсөв		Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг танилцуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцох уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэл, мэдээллийн найдвартай байдал, захиргааны мэдээллийн шинэчлэлийг сайжруулах арга зам болон тус мэдээллийн санг ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах зорилтот өрх, иргэнийг сонгох журам дүрмийг сайжруулахаар шийдвэрлэлээ. “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.11.27-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/162 дугаар тушаалаар байгуулан журмын төслийг боловсруулан, журамд санал авахаар 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн “Санал авах тухай” 09/1292 дугаар албан бичгийг боловсруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, ирүүлсэн саналыг журмын төсөлд тусгасан.	ГБХНХЯ	90	70.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй , журмын төсөл боловсруулагдах шатанд байгаа тул журмын 6.2.2.4.-ээр үнэлэв.
69	3.1.4. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	2021-2025			Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг хамгийн сүүлд Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16, А/04 хамтарсан тушаалаар батлуулсан. Энэхүү аргачлалын дагуу УСХ, УБЕГ, НДЕГ, ХХҮЕГ, ТЕГ, АТУТ, ГЗБЗЗГ, ТАЗ зэрэг байгууллагуудтай мэдээлэл солилцож цахим мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. 2020 онд Монгол Улсын ядуурлын түвшин 27.8 байсан бөгөөд энэ үед нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний 409.679 ба түүнээс доош оноогоор тогтоож байсан. Харин 2022 онд Монгол Улсын ядуурлын түвшин 27.1 хувьтай байгаа тул түүнд харгалзах оноо буюу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний 401.2 оноо болон түүнээс оноогоор тогтоох тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/97 тушаалыг батлуулан Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлон хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний оноог тодорхойлох зорилгоор өрхийн гишүүн-иргэний мэдээллийг ЭМДЕГ, ТЕГ, НДЕГ, УСХ зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг ХҮР системээр дамжуулан авч өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлээд байна.	ГБХНХЯ	90	70.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй,
70	3.1.5. Нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	2021-2025			Засгийн газрын 2023 оны 239 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 10 хувиар нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 550.0 мянган төгрөгт, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 440.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр баталсан. Дээрх арга хэмжээний хүрээнд нийт 486.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, 555.0 мянган төгрөг байсан дундаж тэтгэвэр 685.6 мянган төгрөгт хүрч 2016 оны дундаж тэтгэврийн хэмжээтэй харьцуулахад 2.2 дахин нэмэгдсэн. Мөн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг дунджаар 10 хувиар нэмэгдүүлэхээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг баталсан. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр олгохоор “Тогтоолд өөрчлөлд оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 3 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 288 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 70 мянга гаруй зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн баталгааг хангах боломж бүрдсэн. Нэмж шаардагдах 109.5 тэрбум хөрөнгийг 2023 оны халамжийн сангийн төсөвт тусгасан. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн батлуулсан. Мөн Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар шинэчлэн тогтоов. Үүнд: •Нийгмийн халамжийн тэтгэвэр 288 мянгаас 325 мянган төгрөг, •Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих	ГБХНХЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			82.0	
Орлогод нийцсэн орон байр									
Зорилт 3.2.Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.									
71	3.2.1. Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулдаг тогтолцоог бий болгоно.	2021-2025			ГБХНХЯ: Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан хэрэгжиж байна. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлэх талаар тодорхой зорилтууд тусгагдсан. Тодруулбал, “байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, “Үндэсний баялгийн сангаар дамжуулан иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, орон сууцжуулалтыг эрчимжүүлнэ” гэж заасан. Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар Ирээдүйн өв сан, хөгжлийн сан хуримтлалын сан гэсэн 3 төрөлжсөн сантай бөгөөд Хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцжуулалттай уялдуулах, урт хугацаанд ипотекийн зээлийн эх үүсвэрт хөрөнгө оруулах чиглэлээр тус яам орон сууцны бодлого хэрэгжүүлэгчид болон олон улсын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, салбар дундын хамтын ажиллагааг ханган ажиллаж байна. Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу 2024 онд 499.5 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. Сангийн яам, Монголбанк хооронд 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр 81-0524/171 тоот “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г байгуулсан бөгөөд Хуримтлалын сангийн Монголбанкн дахь төрийн сангийн 010164002141 тоот дансанд 2024 оны 12 дугаар сарын гүйцэтгэлээр 487.6 тэрбум төгрөг байршсан байна. Монголбанк Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгө болох 499.5 тэрбум төгрөгийг орон сууцны ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулан ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар арилжааны 9 банкаар дамж ХББОСЯ: Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2024.12.01-ний өдрийн байдлаар 1,287.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 10,983 зээлдэгчид олгосон. 2021 оноос хойш 2024.12.01-ний өдрийн байдлаар нийт 35,147 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд нэмж хамруулсан байна. Батлан даалт гаргадаг болсон 2023 оноос хойш хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт 2024.12.01-ний өдрийг хүртэл нийт 1211 иргэний 129.3 тэрбум төгрөгийн зээлд 24.5 тэрбумын төгрөгийн урьдчилгаа төлбөрийн батланд даалт хийсэн. Батлан даалтыг хамгийн их 196 Орхон, 132 Дорнод, 110 Баянхонгор, 76 Сүхбаатар, 71 Өвөрхангай, 69 Говь-Алтай, 63 Сэлэнгэ, 61 Дархан-Уул аймгуудад тус тус гаргаад байна.	ГБХНХЯ, ХББОСЯ 100	100	90.0	Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэд хамрагдсан талаар тоо мэдээлэл тусгаагүй,

72	3.2.2. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлж эхэлнэ.	2021-2025	-		СЯ: Барилга, хот байгуулалтын яамнаас боловсруулсан Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Ерөнхий сайдын зүгээс Барилга, хот байгуулалтын сайдад бусад яамдын саналыг авсны үндсэн дээр УИХ-д өргөн мэдүүлэх чиглэлийг өгсний дагуу Барилга, хот байгуулалтын яамнаас 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/1544 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэнд Сангийн яамны 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 01/3832 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Хуулийн төслийг УИХ-д 2024 оны 5 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлж, чуулганы нэгдсэн хуралдаанаар болон байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэж байна. Үндэсний орон сууцны санхүүжилтийн корпораци байгуулах асуудлыг хуулийн төсөлд тусган боловсруулсан. ХББОСЯ: Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.04.30-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан. Орон сууцжуулалтын тухай хуулийн үзэл баримтлал Барилга, хот байгуулалтын сайд, Сангийн сайд, Хууль зүйн, дотоод хэргийн сайд нараар батлуулсан. Хуулийн төсөл, түүний хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, үзэл баримтлал, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ, дагах хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын 2024.5.08-ны өдрийн хуралдаанаар дэмжигдэж, Улсын Их Хуралд 2024.5.16-ны өдөр өргөн барьж Эдийн засгийн байнгын хороогоор 2024.5.28-ны өдөр хэлэлцэн дэмжигдсэн. Хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Улсын Их Хурлын 2024.5.30-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэн дэмжигдэж анхны хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангахаар Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугараар ахлуулсан ажлын хэсэгт шилжүүлсэн. УИХ ээлжит сонгууль болж хуулийн төслийг ЗГ-г буцаасан. Засгийн газрын 2024.8.14-ний өдрийн хуралдаанаар “Орон сууцжуулалтын талаар 2024-2028 онд баримтлах бодлого, чиглэл”-ийг танилцуулсан. Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлүүлсэнтэй холбоотойгоор тус яамны Сайдын 2024.12.02-ны өдрийн 107 дугаар тушаалаар Орон сууцжуулалтын тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан 2024.12.03-ны өдөр анхны хурал зохион байгуулсан. Хуулийн төсөлд зөвлөх үйлчилгээ авахаар 2024.11.25-ны өдрийн 2024/159 дугаартай хамтран ажиллах гэрээг “Легал инновешн хаав” ХХК-тай байгуулсан. Хуулийн зөвлөх үйлчилгээний компанитай 2024.12.05-ны өдөр уулзаж, холбогдох чиглэлийг өгч ажилласан.	СЯ 90, ХББОСЯ 100	90, 100	70	Арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд эрх зүйн орчиныг бүрдүүлэхээр тодорхой ажлууд хийгдсэн боловч хуулийн төсөл эцэслэн батлагдаагүй. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулагдаагүй, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлж эхлээгүй байна.
73	3.2.3. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгоно.	2021-2025	860345.7, Гадаадын зээл, тусламж		Солонго-1, Солонго-2 орлогод нийцсэн орон сууцны хороолол төсөл”-ын барилга барих бэлтгэл ажил 18 блок барилгын төмөр бетон каркас цутгалтын ажил бүрэн дуусч, 5 блок 9 давхар, 12 блок 8 давхрын каркас цутгалтын ажил гүйцэтгэж, 2 дугаар ээлжийн 31 блок барилгаас энэ жил 16 блок барилгын суурийн ул бетон хийж үүнээс 11 барилгын суурийн бетон цутгалт, нэгдсэн гражийн цутгалтын ажлыг гүйцэтгэсэн. Барилгын ажил төслийн хэмжээнд 35 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. - Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн орон сууцны барилга, сургууль, цэцэрлэгтийн гадна хэрэгцээний цэвэр усны шугамын ажил 95 хувь, 1-8-р блокуудын төмөр бетон хийцийн ажил бүрэн дуусаж барилгын цонхны рам /шилтэй/ суурилуулалтын ажил 90.0 хувь хийгдэж байна. 2024 оны 11 сарын 30-ны байдлаар нийт 143,985,253.6 юань буюу 2022 онд 40.3 тэрбум төгрөг, 2023 онд 8.2 тэрбум төгрөг, 2024 онд 32.3 тэрбум төгрөг, нийт 67.9 төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд байна Төслийн нийт хэрэгжилт 2024.12.06-ны өдрийн байдлаар 75 хувийн гүйцэтгэлтэй байна.	ХББОСЯ	100	70.0	Зорилт арга хэмжээний хүрээнд хэрэгжилт хангалтгүй
74	3.2.4. Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025	-		1. Макс группын “Цэн газар” ХХК-ийн Говь-Алтай аймгийн Тайшир суманд байгуулах цемент, шохойн үйлдвэрийн төслийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаанд хэсэглэн төлүүлэх асуудлыг Засгийн газрын 2024.01.25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, тухайн өдрийн Засгийн газрын 37 дугаар тогтоолоор албажуулж, 3 талт гэрээний төслийг боловсруулан Сангийн сайдад 2024.02.08-ны өдрийн 1/457 тоот албан бичгээр хүргүүлэн батлуулсан. Мөн тус компанийн импортлох тоног төхөөрөмжийг БТКУС-ийн дагуу кодлуулах хүсэлтийг ГЕГ-т 2024.02.16-ны өдрийн 6/495 тоот албан бичгээр хүргүүлэн кодлуулсан. 2. “Моңцемент билдинг материалс” ХХК-ийн тээвэрлэлтийн асуудлаар УБТЗ ХНН-ийн удирдлагуудтай 2024.02.02-ны өдөр уулзалт хийж, “МАК”, “Моңцемент билдинг материалс” ХХК-иудын тээвэрлэлт саатаад байгаа тухай албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн сайдад 2024.02.07-ны өдрийн 01/426 тоот албан бичгээр уламжлав. 3. Цемент үйлдвэрлэгчдийн нүүрс, түүхий эдийн тээвэрлэлтэд үүссэн хүндрэлийг шийдвэрлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар 2024.04.17-ны өдөр хэлэлцүүлж, тухайн өдрийн 15 дугаар тэмдэглэлээр Зам тээврийн хөгжлийн сайдад даалгах тухай шийдвэрийг албажуулж, уг тэмдэглэлд туссан цементийн үйлдвэрүүдийн авто тээвэрлэлтэд зохицуулалт хийх тухай хүсэлтийг Зам тээврийн хөгжлийн сайдад 2024.05.17-ны өдрийн 01/1614 тоот албан бичгээр хүргүүлсэн. 4. “Төгс засал” ХХК-ийн барилгын ган туйван үйлдвэрлэх 20,0 мян.тн/жил хүчин чадалтай үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг 2024.04.20-ны өдөр Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, зөвлөмж гаргасан. 5. “Блю Старлит” ХХК-ийн хүсэлтийг судлан Ногоон барилгын материалын талаар санал боловсруулан БОУАӨ-ийн яаманд 2024.08.23-ны өдрийн 01/334 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тус үйлдвэрийн бүтээгдэхүүнийг дэмжин, гишүүн байгууллагуудаа мэдээлэл хүргүүлэх тухай хүсэлтийг “МБУА”, “МБМУХ”, “МБИХ” зэрэг ТББ-уудад 2024.11.15-ны 03/1362 тоот албан бичиг хүргүүлсэн.	ХББОСЯ	100	50.0	Журмын 6.2.2.3-ын дагуу үнэлэв.
Зорилтын хэрэгжилтийн хувь								70.0	
Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес									
Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.									
75	3.3.1. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2025	395.1, Улсын төсөв		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны Залуучуудын сургалтын зөвлөгөөнд 1132 иргэн хамрагдаж, 49,584,800 төгрөгийг, санхүүгийн дэмжлэгийн үйл ажиллагааны Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 60 иргэн хамрагдаж, 18 иргэн ажлын байраар хангагдаж, 345,680,000 төгрөгийг тус тус зарцуулсан.	ГБХНХЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй
76	3.3.2. Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинө.	2021-2025			1.Олон улсын хөгжлийн "Глобал сивик шейринг" байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар нь МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн орлогыг дээшлүүлэх, МАА-н бүтээгдэхүүний өртгийн сүлжээнд анхан шатны үйлдвэрлэгчдийн оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой 15 жилийн урт хугацааны төслийг хэрэгжүүлж байгаа ба ЖДҮГ хамтран ажиллаж төслийн хүрээнд хоршоог бойжуулах, чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулдаг ба 2024 онд 10 удаагийн хоршооны гишүүдэд зориулсан вакум сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажилласан. Хамтын ажиллагааны хүрээнд Төв аймгийн Батсүмбэр суманд байрлах "Глобал сивик шейринг" байгууллагын сургалтын базад "Төрөөс хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн талаар баримталж буй бодлого, арга хэмжээ болон Шинэ хоршоо хөдөлгөөний мэдээлэл" сэдвээр төслийн сургалтын оролцогчдод сургалт, мэдээлэл хийсэн. 2. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоотой хамтран Баруун бүсийн хоршоодыг чадавхжуулах 5 удаагийн цахим сургалтыг 2024.10.14-12.04-ний өдрийг хүртэл, "Төрөөс хоршоо, ЖДҮ-ийн салбарт баримталж буй бодлого, арга хэмжээ" сэдвээр мэдээлэл өгсөн. Мөн танхимын хэлбэрээр "Хоршоо хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжууд" сэдвээр МХААХҮХ-ны гишүүн хоршоодын төлөөлүүдэд 2024.09.19, 12.04-ний өдөр сургалт, мэдээлэл өгч зохион байгуулсан. 3. ХХААХҮ-ийн Сайдын 2021 оны "Журам батлах тухай" А-295 дугаар тушаалаар баталсан Улсын шилдэг хоршоог шалгаруулах, шагнах журмын дагуу Улсын шилдэг 4 хоршоог 2024 онд шалгаруулж, шагнасан. 4. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хоршооны хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан хоршооны гишүүн малчдыг чадавхжуулан БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол ажил мэргэжлийн дээд сургууль, МУ-ын Их Хурлын даргын Ажлын албатай хамтран мал аж ахуйн туршлага судлах богино хугацааны сургалтыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Шилийн хотод 2024.08.31-09.07-ны өдрүүдэд зохион байгуулж 17 аймгийн 50 хоршооны дарга, гишүүдийн төлөөлөл оролцсон. Тус туршлага судлах сургалтын дамвтамжийг нэмэгдүүлж 2024 оны 10 сард дахин зохион байгуулсан	ХХААХҮЯ	100	90.0	Журмын 6.2.2.1-ээр үнэлэв
77	3.3.3. Малчид, тариаланчдыг бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болгоно.	2021-2025			Тариаланч - Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх нийтдээ 138 иргэн аж ахуйн нэгж трактор 65 ширхэг, анжис 10 ширхэг, сийрүүлүүр 14 ширхэг, хор цацагч 6 ширхэг, төмс ухагч 25 ширхэг, төмс, хүнсний ногоо хураах комбайн 4 ширхэг, роторт сийрүүлүүр 3 ширхэг, мөр гаргагч 1 ширхэгийг худалдан авч төмс, хүнсний ногооны 1200 га талбайн ажлыг механикжуулах боломжоор хангасан байна. Техник шинэчлэх хөнгөлөлттэй зээлийг сүүлийн хоёр жилд 238 иргэн аж ахуйн нэгжид 88,4 тэрбум төгрөг олгосноор ур тариа, тос, тэжээлийн 45.0 мянган га талбайн ажлыг гүйцэтгэх техникийн хангамжийг бүрдүүлсэн. Үүнийг хураан авах ургацын мөнгөн дүнгээр тооцоход жил бүр 69.3 тэрбум төгрөгийн улаанбуудай, тосны ургамал, малын тэжээлийг нийлүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Техникийн ашиглалтын 8-10 жилийн хугацаанд 554.4-693.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлэх боломжийг бүрдүүллээ. Малчид - "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоол батлагдсан. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хэрэгжүүлэх 5 их наядын "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан бөгөөд Малжуулах арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2750 өрхийг хамруулахаар шийдвэрлэсэн. Малчдыг малжуулах арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн хуваарийн дагуу 21 аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт нийт 2769 өрхөд 22,152,000,000.0 төгрөгийг зарцуулж бог малд шилжүүлснээр нийт 132614 мал худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар сум, хорооны Засаг дарга бусад холбогдох байгууллагуудтай мэдээ, мэдээлэл түгээн хамтран ажиллаж байна. Малжуулах арга хэмжээнд хамрагдахаар нийт 2667 өрх хүсэлт ирүүлснээс одоогийн байдлаар 950 өрхийн хүсэлтийг Амьжиргааг дэмжих зөвлөл дэмжиж, 431 өрхийн хүсэлтийг Хөдөлмөр эрхлэлтийг байгууллагаас шийдвэрлэн 220 өрхөд батламж олгосон байна. Иргэдийг хүсэлтийг судалж шийдвэрлэх үйл ажиллагаа үргэлжилж байна. Мөн Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн "шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай Засгийн Газрын 166 дугаар тогтоол батлагдан 21 аймаг 330 сумдад хоршооны сургагч багш бэлтгэн ажлуулж 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар шинээр 2500 орчим хоршоо шинээр байгуулагдаж 3681 хоршоо байгуулахаар нэрээ авсан бөгөөд улсын хэмжээнд 25900 гаруй малчин хоршооны гишүүнээр элсээд байна. 256 хоршооны зээл арилжууны банкуудад судлагдаж байгаагын 157 хоршооны зээлийн шийдвэр гарч 21.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгосон байна	ХХААХҮЯ	100	90.0	6.2.2.1. зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

78	3.3.4. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.	2021-2025			"MNS 4588:2008 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлагын стандартыг олон улсын стандарттай харьцуулан шинэчлэхээр зочид буудлуудын төлөөлөл бүхий 18 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж стандартын шинэчилсэн төслийг боловсруулсан. MNS 5927:2008 Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандартын төслийг 247 шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулсан. MNS 6043:2019 Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлагын стандартын төслийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, өрөө үйлчилгээ, угтах үйлчилгээ, хүний нөөцийн гэсэн чиглэлүүдээр баг бий болгон 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулахаас гадна дэн буудал, гэр буудал, жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын төлөөллийг хамруулж ажилласан. MNS 5738:2007 Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлагын стандартыг 15 зүйл, 126 шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулж, 4 удаа хэлэлцүүлсэн. БОАЖЯ, ТоС хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Ногоон аялал жуулчлал” хөтөлбөрийн хүрээнд танилцуулж, байгальд ээлтэй, үйлчилгээг жуулчдад хүргэх зөвлөмж боловсруулсан. 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдөр сүүлийн хэлэлцүүлгийг зохион байгуулж Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлээд байна."	ССАЖЗЯ	70	70.0	
79	3.3.5. Хоршооны тогтолцоо, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулна.	2021-2025	-		ХЗДХЯ: Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр эцэслэн баталсан. ХХААХҮЯ: 1 Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд батлагдасан. 2. Дээрх хуулийн хүрээнд Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх Засгийн газрын 166, 167 дугаар тогтоолууд батлагдаж 2024 онд улсын хэмжээн 10000 гаруй хоршоо шинээр байгуулагдаж 6800 орчим хоршоо хөнгөлөлттэй зээлд хамрагдав. 3. Малчин ерхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль батлагдаж дагаж НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт орж хоршоодыг татварын бодлогоор дэмжих боломжтой болсон. 4.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний 4.2.1-т заасан хөрөнгө болон Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хооронд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 104/03-706/49 дугаартай “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн зээлийн үлдэгдэл хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу орон нутагт түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 4,200,000,000 төгрөгийг хөдөө аж ахуйн загвар хоршооны үндсэн хөрөнгө оруулалтад зориулж жилийн 5 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, эхний жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэй “Хөдөө аж ахуйн Загвар хоршооны зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай” ХХААХҮСайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/26 тоот тушаалыг батлуулав.	ХЗДХЯ 100, ХХААХҮЯ 90	100/ 90	90.0	Эрх зүйн орчинг 2021 онд бүрдүүлсэн. 2023 онд юу хийсэн бэ? Хууль баталсанаар ямар үр нөлөө үзүүлсэн талаар мэдээлэл
					Зорилтын хэрэгжилтийн хувь			86.0	
Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт									
Зорилт 3.4.Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ.									
80	3.4.1. Зорилтот санхүүжилт, хөнгөлөлт, хүртээмжтэй үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025	1,806.5, Улсын төсөв		Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ажлын байрыг дэмжих, ипотека, репо санхүүжилт, хөдөө аж ахуйг дэмжих зориулалтаар нийт 6.9 их наяд төгрөгийн зээлийг Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр олгохоор шийдвэрлэснээс нийт 72 мянган зээлдэгчид 6.0 их наяд төгрөгийн зээл олгосон.	СЯ	100	90.0	Журмын 6.2.2.1-ийн дагуу үнэлэв.
81	3.4.2. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.	2021-2025	-		Зээлийн хүүг бууруулах стратегийг УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дугаартай тогтоолоор батлан, Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран хэрэгжүүлж, стратегийн хэрэгжилтийг хагас жил тутам тайлагнан ажиллаж байна. Тус стратегийн баримт бичиг нь 4 заалт, 4 дэд заалтын хүрээнд тодорхойлсон 19 арга хэмжээ, 47 дэд арга хэмжээнээс бүрдсэн бөгөөд дараах үндсэн 4 чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд: зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдүүлэх; зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах; банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах; хөрөнгийн захыг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах зэрэг байна. Монголбанкнаас КОВИД-19 цар тахлын үед нийгэм, эдийн засагт тулгарч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийг дэмжих ажлын хүрээнд бодлогын хүүг 2020 онд 5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэсэн бөгөөд 2021 оны туршид хэвээр хадгалсан. Үүний үр дүнд шинээр олгосон зээлийн хүү 2019 оны 2 сард 16.9 хувь байсан бол 2020 оны төгсгөлд 14.8 хувьд хүрч, 2022 онд 15.3 хувь, 2023 оны 10 дугаар сарын байдлаар 16.3, 2024 оны 10 дугаар сарын байдлаар 16.4 хувьтай байна.	СЯ	100	70.0	Арга хэмжээний хүрээнд зээлийн хүүг бууруулах стратегийг боловсруулсан байна. Гэсэн хэдийч 2023, 2024 онд зээлийн хүү буураагүй байна.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			80.0	
Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг									
Зорилт 3.5. Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.									
82	3.5.1. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025	24.8, Улсын төсөв		Биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх зорилгоор Бие бялдрын түвшин тогтоох сорилын төвийг Баянгол, Налайх дүүрэгт байгууллаа. Цаашид энэ онд, Сэлэнгэ, Архангай гэсэн газруудад байгуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Тус төвийг даган гарах Монгол хүний бие бялдрын үзүүлэлтийг үндэслэн үнэлгээ тогтоох, хувь хүнд чиглэсэн дасгалын болон амьдралын хэв маягт чиглэсэн зөвлөгөө өгөх, цахим сан бүрдүүлэх, Үндэсний дата төвтэй хамтран мэдээллийг хадгалах, цуглуулах, хувь хүний мэдээллийн нууцлалыг хадгалах серверийг хийж гүйцэтгэн ажиллаж байна. Салбарын хэмжээнд нийтийг хамарсан арга хэмжээ 120 арга хэмжээнд 1675 байгууллагын дунд зохион байгуулж 148177 хүн хамрагдсан байна.	ССАЖЗЯ	100	100.0	
83	3.5.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ.	2021-2025			Монгол Улсад 2023 оны жилийн эцсийн байдлаар ашиглагдаж байгаа спортын заалны тоо 1219 буюу 10,9 %, спортын гадаа талбайн тоо 1053 буюу 18,4 %,байна. Энэ нь 2020 оныхоос спорт заал 133 буюу 12,2 %, гадаа талбай 194 буюу 22,5 %-р тус тус нэмэгдсэн байна. Спорт заалны нийт талбай м.кв 789,912, гадаа талбай м.кв 4,156,976 болж, нэг хүнд оногдох заалны талбай 0.27513 м.кв, нэг хүнд оногдох гадаа талбай 1.449 м.кв нэмэгдсэн байна.	ССАЖЗЯ	90	70.0	
84	3.5.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	2021-2025	1806.6, Улсын төсөв		Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, идэвхтэй хөдөлгөөний мэдлэг, хандлага, дадал, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн БТСГ, хороодод 87 хэлэлцүүлэг, сургалтыг 440 байгууллага аж ахуй нэгжийн 12993 хүнд зохион байгуулсан байна. Нийтийг хамарсан биеийн тамирын арга хэмжээ, өдөрлөг, алхалт, гүйлт, марафон өвлийн арга хэмжээ зэрэг биеийн тамирын 566 арга хэмжээг 229259 байгууллага хамт олны дунд зохион байгуулж 651706 хүнийг хамруулсан байна.	ССАЖЗЯ	100	90.0	
85	3.5.4. Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилт дээшилсэн байна.□	2021-2025	176.8 , Улсынн төсөв		Бөийн тамир, спортын улсын хороонд бүртгэлтэй мэргэжлийн 21 холбоо байна. Үүнээс: идэвхтэй хамтран ажиллаж байгаа 6 мэргэжлийн спортын холбоо байна. Энэ онд нийт 176,853,620 төгрөгний санхүүгийн дэмжлэгийг баг, тамирчдыг тэмцээнд оролцоход нь үзүүлсэн. 1.Монголын холимог тулааны холбоо нь 2 удаагийн санхүүгийн дэмжлэгийг Дэлхий, Азийн тэмцээнд оролцох 11 тамирчин үзүүлж, 1 мөнгө, 5 хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан. 2.Монголын муайтай спортын холбоо нь 2 удаагийн санхүүгийн дэмжлэгийг Зүүн Азийн болон Азийн цомын тэмцээнд оролцох 9 тамирчинд үзүүлж, 7 алт, 4 иөнгө, 4 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцсон. 3.Японы мэргэжлийн сумо бөхийн 2024 оны дээд зиндааны барилдаануудад түрүүлсэн бөхөд олгох Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит жижгэрүүлсэн 6 цомыг Төрийн уран дархан Н.Баатаржав гуайгаар бүтээлгэж хүргүүлэн ажилласан. 4.Монголын автомашин мотоцикл, сонирхогчдын холбоо нь 1 удаагийн санхүүгийн дэмжлэг авч, КТМ Mongolia, Storm riders клубын тамирчин П.Мөрөн алдарт "Дакар ралли" уралдаанд оролцсон. 5. Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо 2024 оны 05-р сарын 10,11,12-ны өдрүүдэд Олон улсын Power expo & festival XII - International cup олон улсын дрифтийн анхдугаар тэмцээн зохион байгуулагдаж Монгол улсаас Мэргэжилийн ангилалд 30 тамирчин, Сонирхогчийн ангилалд 68 тамирчин, БНХАУлсаас шилдэг 3 тамирчин машин техник хэрэгсэл болон инженер техникийн 18 хүний баг бүрэлдэхүүний хамт, Япон улсын 2 тамирчид тус тус ирж амжилттай оролцлоо. Тэмцээн уралдааны 6 төрлөөр зохион байгуулсан. Наадмын экспо төрөлд дараах үзэсгэлэн, 7 үйл ажиллагаа зохион байгуулагдсан. наадмын энтертаймент хөтөлбөрт анх удаа 9 гадаадын уран бүтээлч нартай хамтарсан анхны уран бүтээлийг зориулан гаргаж хаалтын тоглолтод дуулсан. Арга хэмжээг 3 өдрийн туршид давхардсан тоогоор 26,000 үзэгч үзсэн байна. Монгол улсыг зорин шалтгаануудын тоог нэгээр нэмсэн үйл явдал болсон юм. Шинэ үеийн залуучуудын хүсэл мөрөөдөл, хоббиг дэмжиж шинэ тутамд хөгжиж буй спортуудыг дэлхийн тавцанд гарах.	ССАЖЗЯ	100	70.0	

86	3.5.5. Хоол, хүнсний тухай боловсрол олгох талаар сургалтын хөтөлбөрт тусгана.□	2021-2025	-		Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д үндэслэн боловсруулсан сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх төлөвлөгөөний төслийг сайдын 2024 оны А/317 дугаар тушаалаар баталлаа. Тус төлөвлөгөөнд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг холбогдох мэргэжлийн байгууллага, сургалтын байгууллага, судлаач, эрдэмтэн, багш нартай хамтран шинэчлэх, тохирцыг шалгах үйл ажиллагааг 2024-2029 онд үе шаттай гүйцэтгэхээр тусгасан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын бага ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, тохирцыг шалгах ажлыг 2024-2025 оны хичээлийн жилд эхлүүлээ. Бага ангийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрт суралцагчдад хоол, хүнсний тухай мэдлэг, чадвар олгох талаар тусган боловсрууллаа.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт эрүүл хооллолтын энгийн ойлголтоос эхлээд хоол шим тэжээл, зөв зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, хүнсний эрх зүйн орчин, хүнсний нэмэлтийн талаарх мэдлэгийг олгож байна. Үүнд сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрөөр хоол, хүнсний талаарх энгийн ойлголтыг, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрөөр: 1-3 дугаар ангид хоол тэжээл ба хооллолт, эрүүл хүнс, хоол хүнс болон хөдөлгөөний хамаарлын учир шалтгаан, 4-5 дугаар ангид өглөөний цайг тогтмол ууж, идэвхтэй хөдөлгөөн хийж хэвших, хүнсний бүлгээ ялган тодорхойлж, хоол, хүнсийг сонгоход шошго ашиглаж сурах, 6-9 дүгээр ангид зохистой хооллох зарчимд тулгуурлан хоол, хүнсний үндсэн шимт бодисыг харгалзан сонгох, зөв хадгалж, хэрэглэх, биеийн өсөлтийг үнэлэх аргыг мэдэж, өөрт тохирсон идэвхтэй хөдөлгөөнийг сонгон тогтмол хийж хэвших, насны бүлэг, хэрэглээг тодорхойлж сурах, өвчлөлөөс сэргийлэх мэдлэгтэй болох, 10-12 дугаар ангид ажил хөдөлмөр, идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл байх зэрэг мэдлэг, мэдээллийг олгодог. ХХААХҮЯ : 1.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Үдийн хоол” үйлдвэрлэлд шаардагдах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээгээр худалдан авах тендерийг 57 нэр төрлийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээр Төрийн худалдан авах ажиллагааны газар болон Боловсролын ерөнхий газартай хамтран 7 удаа зохион байгуулж холбогдох хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан. Тус тендер шалгаруулалтын үр дүнд /2024.11.20 байдлаар/ цахим дэлгүүрээс 13 аж ахуйн нэгжийн 89 багц хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс 3 их сургууль, 53 цэцэрлэг, 78 ерөнхий боловсролын сургууль нийт 8,467,751,048 төгрөгийн үнэ бүхий 179,924 ширхэг бүтээгдэхүүн худалдан авалт хийсэн байна. Худалдан авалтын дүнд 170,965,869 төгрөгийн хэмнэлтийг төсөвт бий болгосон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад цахим дэлгүүрийн худалдан авалт 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2. “Бүх нийтийн хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, соён гэгээрүүлэх, боловсролыг дэмжих агуулга бүхий мэдээлэл боловсруулж, контент бэлтгэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах” ажлыг “Ти Би Дайтус” ХХК-иар гүйцэтгүүлж, “Эрүүл байх амархан” уриан дор нийт 18 контент рийлс, 28 постер бүтээсэн ба олон нийтийн сүлжээгээр нийт 493300 хүнд хүргэн, хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулан, эрүүл хооллолтын талаар мэдлэг боловсролыг дэмжин ажилласан байна. 3. “Монголын уламжлалт таван өнгийн идээ ундааг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж буй иргэн, аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчлан таниулах, контент бэлтгэх” ажлыг гүйцэтгэж, 11 сэдвийн хүрээнд хэвлэлийн мэдээ видео хийсэн бөгөөд олон нийтийн сүлжээгээр 35.0 мянга орчим хүнд хүрсэн. 4. “Иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зохион байгуулж байгаа хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх соён гэгээрүүлэх боловсролыг дэмжих ажилд дэмжлэг үзүүлж, олон нийтэд сурталчлах” ажлыг гүйцэтгэж, нийт 20 сэдвийн хүрээнд хэвлэлийн мэдээ видео хийсэн бөгөөд олон нийтийн	БЯ/ХХААХҮЯ	100/30	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авалдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн. Журмын 6.2.2.1-ээр үнэлэв.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			84.0	
Газрын харилцаа									
Зорилт 3.6.Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.									
87	3.6.1. Газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна.	2021-2025	-		Монгол улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгах санал боловсруулан газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1/2421 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үндсэн чиглэлд тусгагдсан Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагын хүрээнд боловсруулж, батлуулахаар хуулийн төслүүдийн үзэл баримтлал, хуулийн төслийг эцэслэн боловсруулах, батлуулах ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, хамтран ажиллаж байна. Хаягжуулалтын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/3225 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	ГЗБЗЗЕГ	100	70.0	Өөрсдөөс шалтгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
88	3.6.2. Хаягжилтын нэгдсэн системийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна	2021-2025	-		Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 180 дугаар тогтоолоор хаягийн мэдээллийн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулах ажлын хүрээнд улсын хэмжээнд 1:100000 масштабтай газар усны нэрийн тоон зургийн 258650 газар, усны нэр, 223608 замын өгөгдөл мэдээллийг бүрдүүлж, гудамж, зам тэдгээрийн эхлэл, төгсгөл болон нэгж талбар, барилгын орц, гарцыг тэмдэглэх арга хэмжээг гүйцэтгэж, олон улсын стандартад нийцсэн хаягийг автоматаар олгох нөхцөлийг бүрдүүлсэн. Төрийн нэгдсэн ХУР, ДАН систем болон орон зайн өгөгдлийн геопорталын системээр бусад байгууллагуудтай холбогдох хаягийн мэдээллийн санг төрийн бусад үйлчилгээнд ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн. Одоогийн байдлаар 21 аймгийн хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлж шинэчилсэн хаяг олгосон бөгөөд 330 сумаас 241 сум холбогдох журам, стандартын дагуу тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгээд байна. Харин Нийслэлийн нийт 575714 нэгж талбарт хаяг олгоход шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх, шинэчлэн зураглах шаардлага тулгарсан бөгөөд энэхүү ажлын хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн өнөөдрийн байдлаар хаягийн системд шаардлагатай 57889 зам, 47860 гудамж, 522501 орц, гарцын мэдээллийг бүрдүүлээд байна. Нийслэлийн нийт нэгж талбарт олон улсын стандартад нийцсэн шинэчилсэн хаягийг олгох арга хэмжээг Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яам, Газар геоматик (LX) корпорацтай хамтран хэрэгжүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна. Тус ажлын үр дүнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг сайжруулж нийслэлийн хэмжээнд бүрдүүлсэн өгөгдөл мэдээлэлд суурилан дахин шинэчилсэн хаягийг тооцоолох, хууль, журмын дагуу тэмдэгжүүлэх ажил хүлээгдэж байна.	ГЗБЗЗЕГ	100	90.0	Үр дүнтэй ажлууд хийгдэж байна.
89	3.6.3. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025	-		Мониторингийн сүлжээний 3000 цэгт ГТБЧ-ын судалгаа хийж, хөрсний хяналт-шинжилгээний улсын 1 лабораторийг зүүн бүсэд байгуулах төслийг МУ-ын хөгжлийн 2022-2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар саналыг хүргүүлсэн хөрөнгө батлагдаагүй. Төсөв батлагдаагүй ч дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд: “Газрын мониторингийн сүлжээний 350 цэгт ГТБЧХБ хийх” АД/2023-06 дугаартай ажлын даалгаврыг батлуулсан. ТЭЗҮ 2022 онд батлагдсан. Газрын мониторингийн цахим системд дундын мэдээллийн сан бүхий нэмэлт хөгжүүлэлтийг хийж бусад газрын мониторинг хийдэг байгууллагуудаас өгөгдөл, мэдээллийг авч, хамтран ажилласан. Үүнд: 1. Нийслэлийн ЭМ-ийн газраас хүн амын суурьшлын бүсийн 77 цэгт хийгддэг судалгааны ажлын үр дүнг 2023 оны 1/416, Нийслэлийн БО-ны газраас ариун цэврийн байгууламжийн байршил, холбогдох судалгаа мэдээллийг 2023 оны 01/426, ХХХААХҮЯ-ны 2023 оны 1/117 албан бичгээр тариалангийн газрын 2022 оны мониторингийн 300 цэг, Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны бэлчээрийн мониторингийн 1513 цэг, Үндэсний статистикийн газраас 2023 оны 1/955 тоот албан бичгээр 254192 малчин өрхийн малын тоо, толгой болон малчин өрхийн байршлын мэдээллийг хүлээн авч, www.egazar.gov.mn-ийн мониторингийн вебэд суурилсан орон зайн дүн шинжилгээний статистик мэдээлэлд бусад байгууллагын холбогдох мэдээллүүдийг оруулах боломжтойгоор дундын мэдээллийн сангийн систем хөгжүүлэлтийн ажлыг хийж Газрын мониторингийн цахим системд оруулсан. 2. Газрын мониторингийн үндэсний сүлжээний бэлчээрийн 50, тариалангийн 50, хот, тосгон, бусад суурины газрын 200, тусгай хэрэгцээний газрын 50 цэг буюу зайлшгүй судалгаа шинжилгээ хийх шаардлагатай нийт 350 мониторингийн цэгийн байршлыг тогтоож ГТБЧХБ-ны ажлыг зохион байгуулсан. 2024 онд урсгал төсвөөр Газрын мониторингийн үндэсний сүлжээний хот тосгон бусад суурины газрын мониторингийн 300 цэгт ГТБЧХБ-ны ажлыг гүйцэтгэхээр ажлын даалгавар батлуулж, тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2024/70 дугаартай гэрээг байгуулсан.	ГЗБЗЗЕГ	100	100.0	
90	3.6.4. Монгол Улсын геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаар бүрэн хангана.	2021-2025	-		1.2023 онд уг арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв тусгагдаагүй тул салбарын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх үүднээс боломжит хувилбарын төсөл болох шинээр баригдах авто зам, төмөр замын дагуу өндрийн сүлжээ байгуулах саналыг ЭЗХЯ-д 2023 оны 1/361 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2024 онд хэрэгжих шинэ төсөл арга хэмжээний жагсаалтад оруулах саналаа холбогдох 30 асуулт, танилцуулга, хавсаргах материалын хамт боловсруулж 2023 оны 1/2035 тоот албан бичгээр СЯ-нд хүргүүлсэн. 2.2017 онд батлагдсан “Монгол орны өндрийн тулгуур сүлжээг шинэчлэх” ТЭЗҮ-ийг БХБС-ын 2021 оны 123 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан барилгын дүрэмд тусгагдсан үнэ, бүрдлийн дагуу дахин шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулсан. 3.“Геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн 1-р ангийн сүлжээтэй холбох, хэмжилт хийх” ажлыг ГЗБГЗЗГ-ын урсгал зардлаар хийхээр шийдвэрлэсэн тул гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж “Геоосет” ХХК-тай 2023/89 дугаар гэрээг 2023.06.06-ны өдөр байгуулсан /нийт төсөв 20.6 сая төгрөг/. Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд 2023.07.26-2023.08.10-ны хооронд Эхлэл цэгтэй холбох өндрийн 1-р ангийн сүлжээний хэмжилт хийгдсэн. Гүйцэтгэгчээс 2023.10.09-ний өдрийн 23/42 дугаар албан бичгээр нэгдсэн тайланг ирүүлсэн бөгөөд Захиалагчийн техник хяналт хийх 2023.10.18-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу ГЗБГЗЗГ 2023.10.19-23-ны өдрүүдэд захиалагчийн хяналтыг хийж 2023.10.27-ны өдрийн ГЗЗХ/29 дугаар дүгнэлтийг тус газрын Архив, мэдээллийн төв хүлээлгэн өгсөн. Өндрийн I ангийн сүлжээний 472 цэгийн солбицол, өндрийн утгыг Газрын даргын 2024 оны А/81 дугаар тушаалаар баталж, хэрэглээнд нэвтрүүлэв. Өндрийн II ангийн сүлжээний 6 шугамыг 2023 онд хэмжсэн бөгөөд гүйцэтгэсэн ажлын тайланд (Нийт шугамын урт 3413 км /шууд, урвуу/, 386 цэг) 2024 оны 04 дүгээр сарын 05-11, 30-ны өдрүүдэд хяналт хийв. Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах ажлын төслийг тооцож гаргаж, 2025 оны төсөвт тусгуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын саналыг 2020-2023 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төсвийн төсөлд тусгуулахаар БХБС-ын албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн хөрөнгө тусгагдаагүй. 1.Дунд масштабтай байр зүйн зургийн технологийн дарааллыг геодези, зураг зүйн чиглэлийн барилгын 4 норм, нормативын барим бичгийг үндэслэн боловсруулж, холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2023.05.22-ны хэлэлцүүлж 2023.06.09-ний өдөр ГЗБГЗЗГ-ын даргаар батлуулсан. - 1:25000 масштабтай байр зүйн зураг зохиох ажлын даалгаврын төслийг боловсруулж Үндэсний Геологийн албанд хүргүүлсэн. - Монгол Улс,ОХУ-ын хоорондын улсын хилийн дагуу сансрын зураг авах ажлын техникийн даалгавар боловсруулж 2023 оны 03 дугаар сарын 22-ны мн/11 дугаартай албан бичгээр Гадаад хэргийн яаманд ГЗБГЗЗГ-аас хүргүүлсэн. 2.Сансрын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах төсөл арга хэмжээний жагсаалтад уг арга хэмжээг тусгах ажлыг зохион байгуулж “хиймэл дагуулын технологи ашиглан тухай масштабын байр зүйн зургийг зохиох судалгаа, шинжилгээ, тооцоог боловсруулах” арга хэмжээг тус зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгасан. 3.БХБС-ын 2021 оны 123 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ” /БД 81-103-21/ барилгын дүрмийн дагуу өнөөгийн нөхцөл байдлын судалгаа, зах зээлийн үнийн судалгаа, 2019-оноос өнөөдрийг хүртэл хийгдэж байгаа ажлуудын судалгааг хийж 2017 онд батлагдсан тус ажлын ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж 2023.05.25-ны өдөр БХБ-ын дэд сайдаар батлуулсан. Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 23/187	ГЗБЗЗЕГ	100	70.0	Өөрсдөөс шалтгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

91	3.6.5. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.	2021-2025	-		"Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газрын сан бүрдүүлэх, газар хөгжүүлэлт хийх" ажлын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдэн техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан. 2024 онд Газрын биржийн цахим системд газрын нөөц сан байгуулж, бүртгэх боломжийг бүрдүүлэх, газар хөгжүүлэлттэй холбоотой нэмэлт хөгжүүлэлтийг хийж байна. Шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалт хийх саналыг 2025 оны улсын төсөвт тусгуулах саналаа Сангийн яаманд хүргүүлсэн.	ГЗБЗЗЕГ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд үр дүнтэй ажлууд хийгдсэн.
92	3.6.6. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийнэ.	2021-2025	11,990.0 , Улсын төсөв		"Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын төсөл боловсруулах ажлын хүрээнд эдийн засаг, газарзүйн орчин үеийн онол, тогтвортой хөгжлийн ойлголтод тулгуурлан эдийн засгийн өсөлтийн төвийг тогтоох арга зүйг боловсруулсан. Уг аргазүйн дагуу МУ-ын хэмжээнд хөрш болон дэлхийн бусад орны эдийн засгийн интеграци, коридортой холбогдох тээвэр, логистикийн зангилаа хот, суурин, орон нутгийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх орон нутгийн хөгжлийн 69 төвийг тус тус тодорхойлсон. Мөн логистик төвүүдийн нэгдсэн байршлыг үндэсний, бүсийн, орон нутгийн түвшинд, эдийн засгийн функциональ бүсчлэл, түүний хөгжлийн чиг хандлага, аймгийн төвүүдийн хотуудыг хөгжүүлэх хөгжлийн концепцийг тодорхойлсон. Улаанбаатар хотноо 2024 оны 01 дүгээр сарын 18-аас 30-ны өдрүүдэд "Бүсчилсэн хөгжлийн урьдчилсан хэлэлцүүлэг"-ийг 6 бүсүүдээр зохион байгуулсан. Уг арга хэмжээнд салбар салбарын 969 төлөөлөл оролцож, давхардсан тоогоор 440 гаруй санал зөвлөмж гарсан. Мөн "Монголын эдийн засгийн чуулган-Бүсчилсэн хөгжлийн чуулган" арга хэмжээг 2024 оны 02 сарын 1-2-ны өдрүүдэд Найрамдах Солонгос Улстай байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн "Хөрөнгө оруулалт" бүлгийг боловсруулахад судалгаа хийж, санал бэлтгэн ажилласан бөгөөд 4 шатны хэлэлцээг Солонгосын талтай хийсэн. Бүгд Найрамдах Турк Улсын Аж үйлдвэр, технологийн яамны Хөрөнгө оруулалтын урамшуулал, гадаад хөрөнгийн газрын төлөөлөгчидтэй 2024.12.09-ний өдөр цахимаар уулзсан бөгөөд БНТУ-ын Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээрийн загвар 2024 оны 08 дугаар сард шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан хэлэлцээрийн төслийг туркын талаас шинээр ирүүлснийг судалж байна. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Самарканд хотноо зохион байгуулагдсан Европын сэргээн босголт, хөгжлийн банкны жилийн уулзалтын үеэр 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр "The next frontier: investing in Mongolian promising future" сэдэвт Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчныг сурталчилсан салбар хурал зохион байгуулагдсанд Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж Монгол Улсын хувийн хэвшлийн төлөөлөл болон хөрөнгө оруулагч нарын хамт оролцож, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин, уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулагчдыг урьж, нягт хамтран ажиллах боломжийн талаар танилцуулсан. СЯ: Өрийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор "Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг"-ийг батлуулж, дараах үндсэн арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулнана;Засгийн газрын гадаад үнэт цаас /ЗГГҮЦ/-ны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна;Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх. Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх;Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулах;Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах; Засгийн газрын өрийн ил тод байдлыг сайжруулах.	ШСАА /Онцгой байдал/	100	100.0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			86.7	
					Зорилгын хэрэгжилтийн хувь			81.4	
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ									
Зорилго 4.Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.									
Чинээлэг Монгол									
93	4.1.1. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2025	-		ЭЗХЯ: Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны А/21 тоот тушаалаар Монгол Улсын бусад улстай шинэчлэн байгуулах болон шинээр байгуулах "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр"-ийн төслийн асуудлаар хэлэлцээ хийх, эцэслэн тохиролцох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хүрээнд Гадаад харилцааны яамнаас 2023 оны 09/1668, 09/1666, 09/1667, 09/1727 тоот бичгүүдээр БНСУ, БНЭУ, Вьетнам, Тайландын Хаант Улсуудтай байгуулах Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрт санал авах бичгийг ирүүлснийг судалж, айлын талаас тодруулах асуултуудыг боловсруулсан бөгөөд ойрын хугацаанд уулзалт зохион байгуулах саналыг хүргүүлсэн. Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн "Хөрөнгө оруулалт" бүлгийг боловсруулахад судалгаа хийж, санал бэлтгэн ажилласан бөгөөд 4 шатны хэлэлцээг Солонгосын талтай хийсэн. Бүгд Найрамдах Турк Улсын Аж үйлдвэр, технологийн яамны Хөрөнгө оруулалтын урамшуулал, гадаад хөрөнгийн газрын төлөөлөгчидтэй 2024.12.09-ний өдөр цахимаар уулзсан бөгөөд БНТУ-ын Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээрийн загвар 2024 оны 08 дугаар сард шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан хэлэлцээрийн төслийг туркын талаас шинээр ирүүлснийг судалж байна. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Самарканд хотноо зохион байгуулагдсан Европын сэргээн босголт, хөгжлийн банкны жилийн уулзалтын үеэр 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр "The next frontier: investing in Mongolian promising future" сэдэвт Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчныг сурталчилсан салбар хурал зохион байгуулагдсанд Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж Монгол Улсын хувийн хэвшлийн төлөөлөл болон хөрөнгө оруулагч нарын хамт оролцож, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин, уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулагчдыг урьж, нягт хамтран ажиллах боломжийн талаар танилцуулсан. СЯ: Өрийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор "Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг"-ийг батлуулж, дараах үндсэн арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулнана;Засгийн газрын гадаад үнэт цаас /ЗГГҮЦ/-ны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна;Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх. Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх;Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулах;Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах; Засгийн газрын өрийн ил тод байдлыг сайжруулах.	ЭЗХЯ 90, СЯ 100	90, 100	90.0	
	4.1.2. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болгоно.	2021-2025	-		Сангийн яамнаас төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, ил тод нээлттэй байдлыг дээшлүүлэх чиглэлээр олон арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал: -Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн аргачлалыг боловсруулан цахим системд шилжүүлсэн. -Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, хэрэгжилтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан. -Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг батлуулсан. Төрийн хэмнэлтийн хуульд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үр ашгийг нэмэгдүүлэх, сайжруулах зорилт бүхий заалтуудыг тусгасан. -Төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилт бүхий заалтуудыг тусгасан. -Төсвийн төлөвлөлтөд иргэдийн саналыг тусгах боломжийг бүрдүүлсэн.	СЯ	100	100.0	
95	4.1.3. Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлнэ.	2021-2025	-		"Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны аравдугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолын хүрээнд экспорт, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох ажлуудыг амжилттай гүйцэтгэж, хилийн боомтуудын үйл ажиллагаа идэвхжиж, экспорт нэмэгдсэнээр гадаад валютын улсын нөөц 2024 оны 11 сарын байдлаар 4,960.2 сая ам.долларт хүрч, оны эхнээс 38.8 сая ам.доллараар буюу 0.8 хувиар өсөж, тогтвортой хадгалагдлаа. Энэ нь манай орны валютын төлбөртэй импортын хэрэгцээний 5.1 сарын хэрэгцээг хангах түвшинд буюу Олон улсад түгээмэл ашиглагддаг нөөцийн хүрэлцээт байдлын 3 сарын импортын хэрэгцээний үзүүлэлтээс өндөр байна. Монгол Улсын Засгийн газрын гадаад бондын төлбөр 2022-2024 онд нийт 2.4 тэрбум ам.доллартой тэнцэж байсан бөгөөд үүнийг төсвөөс төлж барагдуулсан тохиолдолд Гадаад валютын албан нөөц дээрх хэмжээгээр буурч төлбөрийн тэнцэлд дарамт учруулахаар байсныг Сенчири-1, 2, 3 бондуудыг олон улсын зах зээлд арилжаалснаар 2.0 тэрбум ам.доллартой тэнцэх гадаад валютыг хадгалж, төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулсан.	СЯ	100	100.0	
96	4.1.4. Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлтийг тасралтгүй нэмэгдүүлнэ.	2021-2025	44,800.0, ХЭДС, Дэлнийн банк		ЭЗХЯ: Сүүлийн 3 жил дэлхийн улс орнууд цар тахал, геополитикийн тогтворгүй нөхцөл байдлаас үүдэлтэй үнийн өсөлт, эдийн засгийн уналт зэрэг олон хүндрэлүүдтэй нүүр туллаа. Монгол Улсын Засгийн газраас 2022-2024 онд макро эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, тогтворжуулах бодлогын чиглэлийн хүрээнд экспортын орлого, гадаад валютын улсын нөөц, эдийн засгийн идэвхжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Засгийн газраас ашигт малтмал тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоож, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн. Мөн Гашуунсүхайт, Шивээхүрэн хилийн боомтуудад чингэлэг тээврийн терминал байгуулж, автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл ашиглалтад нэвтрүүлсэн. Түүнчлэн, 10 их наяд цогц хөтөлбөр, өрхүүдэд чиглэсэн нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ зэрэг мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлж эдийн засгийн идэвхжилтийг дэмжсэн. Үүний үр дүнд Монгол Улсын нэрлэсэн ДНБ 2021 онд 43.6 их наяд, 2022 онд 53.9 их наяд, 2023 онд 70.4 их наяд төгрөг хүрч, өмнөх оны мөн үеэс 14.4 хувь, 17.7 хувь, 21.8 хувиар тус тус, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 2021 онд 27.1 их наяд, 2022 онд 28.5 их наяд, 2023 онд 30.6 их наяд төгрөг хүрч, өмнөх оны мөн үеэс 1.6 хувь, 5.0 хувь, 7.4 хувиар тус тус өслөө. 2024 оны эхний 3 улирлын байдлаар нэрлэсэн ДНБ 56.2 их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 19 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 22.8 их наяд төгрөг хүрч 5 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн хүлээгдэж буй өсөлт 2024 онд 5.6 хувь, 2025 онд 8 хувьд хүрэх төлөвтэй байна. Ажиллах хүчний оролцооны түвшин алгуур нэмэгдэж, хөдөлмөрийн зах зээл сэргэж байна. Ажиллагчид цар тахлын нөлөөгөөр 2021 онд 1.1 сая болж өмнөх оны мөн үеэс 58 мянган хүнээр буурсан бол 2022 онд 54.8 мянган хүнээр нэмэгдэж 1.2 сая, 2023 онд 134.6 мянган хүнээр нэмэгдэж 1.3 сая боллоо. 2024 оны 3-р улиралд ГБХНХЯ: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-т хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг дэмжих, Засгийн газар болон хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 үйл ажиллагааны 34 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/39 дугаар тоот тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд нийт 6534 иргэн хамрагдаж, 8994 иргэн ажлын байраар хангагдаж, 44,822,477,791.81 төгрөгийг зарцуулсан, хэрэгжилт 73.6 хувьтай байна. Үүнээс: Иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1454 иргэн хамрагдаж, 1349 иргэн ажлын байраар хангагдаж, 11,452,069,000 төгрөгийг; Малчдыг малжуулах үйл ажиллагаанд 3137 иргэн хамрагдаж, 6274 иргэн ажлын байраар хангагдаж, 25,128,069,500 төгрөгийг; Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 60 иргэн хамрагдаж,18 иргэн ажлын байраар хангагдаж, 345,680,000 төгрөгийг; Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1211 иргэн хамрагдаж, 1211 иргэн ажлын байраар хангагдаж, 7,351,550,000 төгрөгийг; Ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаанд 24 иргэн хамрагдаж, 24 иргэн ажлын байраар хангагдаж, 170,670,000 төгрөгийг; Түрээсийн болон	ЭЗХЯ, ГБХНХЯ	100, 100	100.0	

97	4.1.5. Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ.	2021-2025	-		Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлэх зорилгоор дизель түлшний онцгой албан татварыг тэглэх Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор "Автобензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай" Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 18 дугаар тогтоолыг болон импортоор оруулж байгаа 92 октантай автобензиний гаалийн албан татварын хэмжээг 0 хувиар тогтоосон "Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 35 дугаар тогтоолыг Засгийн газрын 2023 оны 12 сарын 20-ны өдрийн 455 дугаар тогтоолыг 2025 он хүртэл тус тус сунгасан.	СЯ	100	70.0	Арга хэмжээний хүрээнд авч, хэрэгжүүлсэн ажил тайлагнасан хэдийч гарсан үр дүнг тайлагнаагүй. Тайлан хангалтгүй. /иргэдийн худалдан авах чадвар хэдэн
98	4.1.6. Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.	2021-2025	-		ЭЗХЯ: Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/17 дугаар тушаалаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төсөлд 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн олон нийтээс санал авч, 2 удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ хугацаанд олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс нийт 695 саналыг ирүүлсэн. Нийт ирүүлсэн саналын 60 хувийг тусган Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанд танилцуулан дэмжигдэж, Засгийн газрын 27 дугаар тэмдэглэл гарч 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцэж дэмжигдсэн. Улмаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг УИХ-ын 2024 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж эхэлсэн бөгөөд УИХ-ын даргаас хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэх саналыг хураалтыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгавраар “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, Засгийн газарт танилцуулж, УИХ-д өргөн барих ажлыг Шадар сайд Х.Доржханд хариуцан ажиллахаар болж, 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 09 тоот тушаалаар холбогдох яам, төрийн болон төрийн бус байгууллага, салбарын мэргэжилтэн, хөндлөнгийн судлаачдын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд ажлын хэсэгт тус яамнаас орж ажиллаж байна. УИХ-аас 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн чуулганаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг баталсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. СЯ: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг 2023 оны 01 дүгээр сараас эхэлж мөрдөж эхэлсэн бөгөөд түншлэлийн төслийн төрөл, ТХХТ-ийг олон улсын жишигт нийцсэн, хөгжлийн бодлого, төлөвлөлт болон улсын төсвийн хөрөнгө оруулалттай уялдуулан төлөвлөх, ТХХТ-ийн төсөлд тавигдах шаардлагыг тусгайлан хуульчлан тусгасан. Засгийн газрын 2023 оны 404-р тогтоолын 1-р хавсралтаар “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”, 2-р хавсралтаар “Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам”, 3-р хавсралтаар “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах журам”, 4-р хавсралтаар “Түншлэлийн хүрээнд эрсдэл тооцоолох, хуваарилах аргачлал”, 5-р хавсралтаар “Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам”-ыг тус тус баталсан. Сангийн сайдын 2023 оны А/267-р тушаалаар ТХХТ-ийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэл тооцох загварыг батлуулсан. “Улсын хөрөнгө оруулалтыг зохистой удирдах замаар болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн менежментийн чадавх бэхжүүлэх төсөл”-ийн баримт бичигт Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга нар 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан. Төслийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгон шалгаруулах, төсөвт учруулах эрсдэлийг тодорхойлох зөвлөмж өгөх, оролцогч байгууллагуудын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	ЭЗХЯ 100, СЯ 100	100	100.0	
99	4.1.7. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ.	2021-2025	-		ТХААГ: Тайлант хугацаанд 2,898.1 тэрбум төгрөгийн 256 төсөл, арга хэмжээний 417 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа ба тендерийн баримт бичигт дотоодын давуу эрхийн зөрүү тооцохоор тендер шалгаруулалтыг зохион байгууллаа. Тайлант хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4-т заасан барааны санал ирүүлээгүй, хуулийн 8.7-д заасны дагуу дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах хүсэлт ирүүлсэн боловч шаардлага хангаагүй тул тооцоогүй. Төрийн худалдан авалтаар эх оронч худалдан авалтыг дэмжих зорилгоор дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахыг хориглож, Монгол улсад үйлдвэрлэсэн тавилга, тоног төхөөрөмж гэх мэт 10 нэр, төрлийн 325 ширхэг 177.0 сая төгрөгийн барааг худалдан авлаа. Ерөнхий гэрээгээр дотоодод үйлдвэрлэсэн, чанар, стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай, бараа бүтээгдэхүүн худалдан авах тендер шалгаруулалтыг 10 удаа зохион байгуулж, 71 нэр, төрлийн бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх 252 аж ахуй эрхлэгчтэй 505 ерөнхий гэрээ байгууллаа. СЯ: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн, баталсан. Хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд Дотоодын үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчдийг дэмжиж одоогийн хуулийн сайн зохицуулалтуудыг бүрэн хадгалж давуу эрхийн зөрүү тооцох аргачлалыг боловсронгуй болголоо. Мөн дотоодын барааг импортын бараатай өрсөлдүүлэхгүй ба зөвхөн Монгол бараа үйлдвэрлэгч хоорондоо өрсөлдөнө. Засгийн газар чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг баталж, чанартай, стандартад нийцсэн дотоодын барааг цахим дэлгүүрт байршуулж, төрийн байгууллагад тогтмол нийлүүлэх боломжийг хуулиар бий болгосон.	ТХААГ	70	70.0	Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн. Журмын 6.2.2.2-р үнэлэв.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			90.0	
Зорилт 4.2.Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.									
100	4.2.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдүүлнэ.	2021-2025	24,022.8, Улсын төсөв		1. Ханбогдын хүдрийн дүүргийн хэмжээнд 954.68 кв.км талбайд хийх агаарын геофизикийн соронзон зураглалын ажлыг Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн 31 сумыг хамарсан талбайд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ ба Икссалибур Авэйшн Австралиа ХХК-ийн түншлэл 2024 оноос эхлэн Агаарын цахилгаан соронзон, соронзон, уран, тор, кали болон нийлбэр гамма орны зураглалыг хийж байна.Төсөл бүрэн хэрэгжээгүй нь байгаль, цаг уурын гэнэтийн давагдашгүй хүчин зүйл, тооцоологдоогүй техникийн эвдрэл, гэмтэл болон агаарын орон зайг ашиглах эрх зүйн байдалтай холбоотой. 2.“Өндөр технологийн түүхий эд-I” /ӨТТЭ-1/ төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. 2.“Өндөр технологийн түүхий эд-II” /ӨТТЭ-2/ ажлын төсөв, төлөвлөгөө Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар баталсан. “ӨТТЭ-2-2022” төслийн 2024 оны төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хэрэгжүүлэх дүгнэлт гарсан. 3.“Геологийн баримт-1-2022” хүрээнд үр дүн: Нийт 7160 мэдээллээр баяжуулсан. Энэхүү судалгааны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх 2024.12.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэнэ. “Чулуун дээжийн сан-1-2022” Чулуун сангийн агуулахад байгаа ордуудын дээжийг бүртгэх ажлын хүрээнд нийт 165 ордын чулуун дээж- 252, чөмгөн дээж-776, шлиф-621, аншлиф-318, технологийн дээж-6 ширхэг буюу 1973 ширхэг дээжийг бүртгэлжүүлсэн. “Цахим архив”-ыг баяжуулах ажлын хүрээнд 839 тайлангийн 1261 боть буюу 151,761 хуудас геологийн материалыг цахимжуулсан. Эдгээр ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 4.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох цахим сонгон шалгаруулалт 2024 онд 144,187 га талбайд 45 талбайд сонгон шалгаруулалт зарлаж 117 480,39 га талбайд 42 тусгай зөвшөөрөл олгож улсын төсөвт 34.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.	АҮЭБЯ	90	30.0	Зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн ажил хангалтгүй. Тайлагнал дутуу
101	4.2.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	2021-2025			Монгол Улсын Их Хурлын 2024 оны "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр "Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр болон хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг" -ыг 2024 оны 12 сарын 06-ны өдөр байгуулахаар төсөлд санал хүргүүлэн ажилласан. Мөн "Цагаан алт" хөдөлгөөний хүрээнд олгогдох ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг тогтоолыг Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв. "Намрын ногоон өдрүүд - Үндэсний үйлдвэрлэл-2024" нэгдсэн арга хэмжээг 2024 оны 9 дүгээр сарын 23-29 өдрүүдэд зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд малчид, тариаланчид, үндэсний үйлдвэрлэгчид зэрэг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, ААНБ, хоршоодын бараа, бүтээгдэхүүнийг дундын зуучлалгүйгээр хэрэглэгчдэд шууд хүргэж ажилласан. • 2024 оны 10 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд Мишээл экспо төвд "Ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн 2024", 10 дугаар сарын 19, 20-нд Дархан-Уул аймагт ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Мөн Дархан-Уул аймагт ОХУ-ын төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөл монголын үйлдвэрлэгчидтэй уулзалт хийж Евразийн чөлөөт худалдааны хэлэлцээрийн талаар ярилцсан.	ХХААХҮЯ	90	50.0	6.2.2.3. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;
102	4.2.3. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	2021-2025	1,940.0, Улсын төсөв		"Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар батлуулсан 2024 оны эвентийн календарийн дагуу Олон улсын 78, үндэсний хэмжээний 47, Орон нутгийн хэмжээний 38 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан. Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилтын хүрээнд: - Архангай аймагт ""АРА фестиваль"", "Улаанбаатар олон улсын медиа урлагийн наадам", "Нүүдэлчин дэлхийн фестиваль", "Бүргэдийн баяр", "Бодибилдингийн фитнесийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээн", "Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам", "Хар хорин айс фестиваль" зэргийг дэмжин хамтран ажилласан. - Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд сур харвааны ажлын хэсэгт ажиллахаас гадна жуулчдад зориулан наадмын нээлтийн арга хэмжээг орой тоглуулах арга хэмжээг зохион байгуулсан. - Монголын эдийн засгийн форумын ажлын хэсэгт орж "Аялал жуулчлалын салбар хуралдаан"-ы зохион байгуулалтыг хариуцан ажилласан."□	ССАЖЗЯ	100	100.0	

103	4.2.4. Бүтээлч үйлдвэрлэл (соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн, архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурь тавигдана.	2021-2025		-	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Улсын их хурлаас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай" хуулийг баталсанаар Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.3-т "... үндэсний агуулгатай инноваци шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацийн салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ" гэсэн зорилтыг хангасан. хуулийн үйлчилэх хүрээнд 2022 онд 3Г-аас баталсан 314 дүгээр тогтоолоор баталсан салбарын тэргүүлэх чиглэл кино урлаг, дуу хөгжим, дизайн, архитектур, хувцас загвар, утга зохиол болон бусад салбар болох соёлын өв зэрэг салбарт суурилсан бүтээлч үйлдвэрлэл, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгож, эдийн засгаа солонгоруулах буюу олон тулгуурт болгох нөхцөлийг бүрдүүлэхэд соёл, урлагийн салбарын үүрэг оролцоог нэмэгдүүлж, Уг хуулийн төсөл батлагдсанаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эко системтэй уялдсан төрийн бодлогыг тогтворжуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх орчин бүрдэн импортыг орлох, экспорт чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах үйл явцыг эрчимжүүлнэ. Мөн төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр тодорхой болж соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүтээх, туурвихтай холбогдолтой үе шат бүрд бүртгэл мэдээллийн тогтолцоо нэвтэрч, соёлын нийгэм, эдийн засгийн ач холбогдол хэмжих боломжийг бий болгох юм. Энэ хүрээнд "Урлаг, уран бүтээлийг дэмжих хөгжүүлэх" /2024-2034 он/ 10 жилийн дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулаа. Бодлогын баримт бичигт урлагийн салбарын хөгжлийг тодорхойлохдоо хууль, эрх зүйн орчин, хүний нөөц, дэд бүтэц, эко систем, маркетинг коммуникацийг хөгжүүлэхдээ үндэсний урлаг, сонгодог урлаг болон орчин үеийн урлагийг шинжлэх ухааны салбар судлагдахуун салбарын хувьд суурь үндэслэн, ЮНЕСКО-гийн конвенци, зөвлөмжид тулгуурлан олон улсын жишигт хүргэх зураглал, матрицийг бий болгосон.□	ССАЖЗЯ	100	100.0	
104	4.2.5. Мэдээллийн технологийн салбарыг дэмжих, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.	2021-2025			"1.Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулахад үндэсний компанийн боловсруулсан програм хангамжийг түлхүү ашиглах, төсөвт зардлыг хэмнэх зайлшгүй шаардлагыг харгалзан “Мэдээллийн технологийн программ хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 311 дүгээр тогтоолыг батлуулсан. Төрийн программ хангамжийн худалдан авах үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах, үргүй зардлыг бууруулах зорилгоор “Үндэсний программ хангамжийн их дэлгүүр” /Mindgolia/ системийг 2022 оны 12 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн ба 2024 онд 254 компанийн 133 төрлийн 487 бүтээгдэхүүн байршиж байна. Mindgolia.mn платформын хэрэглээнд нэвтрүүлснээр төрийн байгууллагууд программ хангамж бүтээж, хөгжүүлэхэд хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй, систем захиалан давхардал хийдэл үүсгэхгүй, оюуны өмч, эх кодыг нь нэхдэг ухаалаг бус худалдан авалтыг цэгцлэх, бүгдийг нэг дороос харьцуулан сонгох боломжтой болсон. 2.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан ""Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам""-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 810 сервисийг Төрийн мэдээлэл солилцооны систем (www.xyp.gov.mn)-ээр дамжуулан солилцож, төрийн 136, хувийн 369 байгууллага, Танилт, нэвтрэлтийн систем (www.dan.gov.mn)-д төрийн 87 байгууллагын 167 систем, хувийн 231 байгууллагын 267 систем тус тус холбогдсон байна.	ЦХИХХЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
105	4.2.6. Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	2021-2025			Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Цагаан алт" хөдөлгөөнийг дэмжихтэй холбогдох "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан. Тогтоолын төслийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн УИХ-ын үйлдвэржилтийн байнгын хороогоор хэлэлцүүлэн, 06 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Уг тогтоолоор "3.а/түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд татвар, зээлийн хүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх; в/эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэхэд чиглэсэн бодлогоор дэмжиж, үндэсний үйлдвэрүүдийг олон улсын томоохон үзэсгэлэнд тогтмол оролцоход дэмжлэг үзүүлэх; з/малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх.." тусгагдсан	ХХААХҮЯ	50	50.0	6.2.2.3. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;
106	4.2.7. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	2021-2025	2,2681.4, Холимог эх үүсвэр		ХББОСЯ: Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р баг “Залуус 2” хорооллын гадна ус хангамжийн 3,35 км, 2,11 км шугам хоолойн ажлыг 2024.10.30-нд ашиглалтад оруулсан. "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл"-ийн хүрээнд 2024 онд 9.2 км ус хангамжийн шугам сүлжээний угсралтыг гүйцэтгэсэн. Говь-Алтай аймагт "Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл" ажлын хүрээнд 1.5 км урт шугам сүлжээний гүйцэтгэж, 2024.10.10-ны өдөр ГАА-КД-08/2024, Баян-Өлгий аймгийн Өлгий суманд "Гэр хорооллын усан хангамжийн шугам сүлжээ төслийн хүрээнд 1380 м ус хангамжийн шугам сүлжээг гүйцэтгэж, 2024.10.03 өдрийн ББКД-83 05/24 дугаар бүхий комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Залуус-1 " орон сууцны хорооллын гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил 110кВа-ын Цахилгаан дамжуулах агаарын шугам 6,2км хийгдсэн. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 6.4 км, ариутгах татуургын 3.8 км хийгдсэн, 27 км шугамын ажил 80 хувьтай хэрэгжиж байна.Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийн Шувуун фабрик эх үүсвэрийн ус цуглуулах 7 км, ус дамжуулах 15,5 км шугам угсрагдсан. Чингис хотын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ багц-2 ажлын хүрээнд 9600 м ариутгах татуургын шугам сүлжээ хийгдсэн байна. Орхон, Баян-Өндөр сумын "Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ариутгах татуургын 3-р коллекторын төв шугам татах ажил"-ын хүрээнд 7.6км ариутгах татуургын шугам хийгдсэн. "Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажил-Хөндий 35кВ ЦДАШ, 35/10кВ-ын 2х10000кВА чадалтай “Хөндий” дэд станц, 110/35/10кВ-ын дэд станцын өргөтгөл/Төв/, нийт 105 ширхэг анкер цахилгаан дамжуулах агаарын шугам 15,7км хийгдэж комисс ажиллахад бэлэн болсон. Мөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ /гүний худаг, 16 км салбар шугам/-ний гүйцэтгэгч “Эс Энд Трейд” ХХК ус хангамжийн 2 дамжуулах Ф280х25.4 мм-ийн голчтой 3,756 км шугам, Эдийн засгийн чөлөөт бүсээс 1-15 худаг хүртлэх 2,69 км шугам, гол шугамын 1-р хэсгийн 4,83 км шугамын ажлыг гүйцэтгэж, 2024.12.06-нд улсын комисс ажилласан. ЭХЯ: 4.2.7. Зорилт арга хэмжээний хүрээнд дараах 5 төсөл хэрэгжиж байна. Үүнд: Эрчим хүчний төсөл-2: Төслийн хүрээнд 0.4-10кВ-ын 879,5 км цахилгаан дамжуулах шугам, 6,10/0.4кВ-ын 100-400кВА чадалтай 33 дэд станц, 35/10кВ-ын 10МВА, 35/6кВ-ын 2*10МВА чадалтай дэд станц шинээр барьж, ашиглалтад оруулсан. Нийт 41086 хэрэглэгчид 1 болон 3 фазын ухаалаг тоолуур суурилуулж системд холбосон. Төслийн хэрэгжилт 100%, Төслийн үлдэгдэл хөрөнгөөр баруун таван аймгийн 13 суманд 0,4 кВ-ын түгээх шугамыг шинэчлэн сайжруулах ажлыг нэмж гүйцэтгэсэн. Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл: Төслийн зөвлөхөөр Integration Umwelt& Energie компани ажиллаж, БУА-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2 удаа зарлаж, тендерт “Эм Си Эс” ХХК шалгарч 2024 онд гэрээ байгуулсан. Төслийн хүрээнд хийгдэх “ЦДҮС” ТӨХК-ын нийт 32 дэд станцаас 13 дэд станцын анхдагч хэлхээний ажлын зураг, Рашаант сумын 110/10 кВ-ын “Сансар” дэд станцын хоёрдогч хэлхээний ажлын зураг хяналтад ирсэн. Зураг төсөл боловсруулах болон тоног төхөөрөмжийн захиалга хийгдэж байна. Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл: Төслийн эхний үе шатны 5а, 3г, 4а,б, 9а, б,ж, 12г магистраль шугамуудын өргөтгөл, шинэчлэлийн ажлууд 2021-2023 онд хийгдэж, ашиглалтад орсон. 2024 онд 23.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 дулааны шугамыг сольж шинэчлэх замаар өргөтгөх ажлыг эхлүүлсэн, үргэлжилж байна. Үүнээс Ф500 мм-ийн голчтой 1830 хос.м, Ф800 мм-ийн голчтой 363 хос.м шугам угсрагдаж, өвлийн ачаалалд оролцож байна. Төслийн гүйцэтгэл 74,6% байна. Улаанбаатарын төвийн дулаан хангамжийн төсөл: 2021-2023 онд 8г,в магистраль шугамын өргөтгөл, шинэчлэл, Даралт өргөх насос станц 2-ын БУА дуусч ашиглалтад орсон. Төслийн гүйцэтгэл 77.1 хувьтай хэрэгжиж байна. 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл: Төслийн хүрээнд 9 аймгийн БУА-ын гүйцэтгэгчийг	ХББОСЯ 90, ЭХЯ 61	90, 61	50.0	
107	4.2.8. Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана.	2021-2025	29,184.2, Гадаадын зээл, тусламж		МУ-ын ЭХС-ийн нийт суурилагдсан хүчин чадлыг 2879,3 МВт-аар нэмэгдүүлэх төслүүдийг эхлүүлж байна. 2021 онд ДЦС-4-ийн хүчин чадлыг 46 МВт-аар, Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 35 МВт-аар, 2024 онд Дорнодын ДЦС-ын хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлсэн. Амгалан ДС-ын хүчин чадлыг 100 Гкал/ц-аар нэмэгдүүлсэн. Бөөрөлжүүгийн ДЦС-ын 300 МВт-ын төслийн эхний 150 МВт-ын БУА 100% нийт төслийн явц 55%-тай байна. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын 90 МВт болон Багануурын 400 МВт-ын станц, ДЦС-3-ын 300 МВт-ын өргөтгөл, ДЦС-2-ын 300 МВт, Тавантолгойн 450 МВт-ын төслүүд 2027-2028 онуудад ашиглалтад орохоор байна. Түүнчлэн хувийн хөрөнгө оруулалтаар Завханы Тосонцэнгэлд 30 МВт-ын ДЦС-ын БУА 95%-тай, Сэлэнгийн 70 МВт-ын, Төв аймгийн Баян сумын нутагт 660 МВт-ын ДЦС-уудын БУА-ыг 2024 онд эхлүүлсэн байна. Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр Ховдын Мянгад суманд 10 МВт-ын, Говь-Алтайн Есөнбулаг суманд 10 МВт-ын, Завхан аймгийн Алдархаан суманд 5 МВт-ын, Говь-Алтайн Алтай суманд 0,3 МВт-ын, Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 10 МВт-ын, Дорноговь аймгийн Эрдэнэ суманд 30 МВт-ын нарны цахилгаан станцууд 2022-2024 онд ашиглалтад орсон. Мөн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 80 МВт-ын, Багануур дүүрэгт 50 МВт-ын батарей хуримтлуурын станцууд 2024 онд ашиглалтад орсон. Дээрх төслүүдийн үр дүнд цахилгаан үйлдвэрлэлийн суурилагдсан чадал 519,3 МВт-аар, дулаан үйлдвэрлэлийн суурилагдсан чадал 447 МВт-аар нэмэгдэж, 1050 МВт-ын төсөл БУА-ын үе шатанд, 1450 МВт-ын төсөл санхүүжилтийг шийдвэрлэх болон гэрээ байгуулах, гүйцэтгэгчийн сонгох үе шатанд эхэлсэн байна.	ЭХЯ	64	70.0	
108	4.2.9. Олон улсын чанартай тээвэр, логиcтикийн төвүүдийг байгуулсан байна.	2021-2025	-		Гашуунсухайт боомтод жилдээ 10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай терминал байгуулж, 2021.09.20-ны өдөр, Шивээхүрэн боомтод 17 га талбайд 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар жилдээ 10 сая тн нүүрс экспортлох чингэлэг тээврийн терминал байгуулан 2022 онд тус тус ашиглалтад оруулсан. - Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн цэргийн 0119 анги Замын-Үүд-Эрээн боомтын дундын бүсэд чингэлэг шилжүүлэн ачих талбайн өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгасан. - "Тавантолгойн нүүрс ачих логиcтикийн төв"-ийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Бодь интернэйшнл" ХХК ажиллаж, 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулсан. -Алтанбулаг логиcтикийн төв байгуулах ТЭЗҮС-г КОТРА олон улсын байгууллагын техникийн туслалцааны хүрээнд 2023 онд, Замын-Үүдийн Бүс нутгийн логиcтикийн төвийг түшиглэн олон улсын хуурай боомт байгуулах ТЭЗҮС-т Дэлхийн банкны санхүүжилтээр 2024 онд хийсэн. - "Олон улсын нисэх онгоцны буудал, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логиcтикийн нэгдсэн төв байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, байр зүйн зураг боловсруулах" гэрээт ажлын тайланг 2022 оны 12 дугаар сард БХБЯ-ны ШУТ-ийн Зөвлөлийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан. -"Ландбридж" ХХК нь Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд 13000м2 талбай бүхий бүрэн автомат логиcтикийн төвийг "Urban Tower" нэртэйгээр байгуулж, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ашиглалтад оруулсан. - "Драгон холдинг" ХХК 30000м2 талбай бүхий байгууламж, нэг ээлжинд 20 гаруй автобус, өдөрт 260 автобус зорчинг тээврийн үйлчилгээнд гарах боломжтой 3000 м.кв тусгай зогсоол бүхий "Улаанбаатар хотын баруун терминал"-ыг барьж,2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр нээлтээ хийсэн. -Дархан-Уул, Завхан, Ховд, Өмнөговь аймгуудад байгуулах “Бүсийн тээвэр, логиcтикийн төв”-ийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг батлан “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ-т хүргүүлэв.	ЗТЯ	70	70.0	

109	4.2.10. Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлсэн байна.	2021-2025	-		2021-2024 онд Лаос, Катар, Грек, АНУ, ИБУИHXУ, Узбекистан, Испани, Латви, Унгар, Туркменистан улсуудтай Агаарын харилцааны хэлэлцээр байгуулснаар нийт 47 улстай Агаарын харилцааны хэлэлцээртэй болсон. Нислэгийн давтамж багтаамж нэмэгдүүлэх чиглэлээр: -Япон-Монголын нислэгийн давтамж долоо хоногийн 13.5 нэгж буюу 13 хүртэлх давтамж, үүнээс 7 давтамж нь Улаанбаатар-Токио чиглэлд ашиглагдаж байсныг 2022 онд долоо хоногийн 9000 суудлын багтаамж, 30 хүртэлх давтамж болгон нэмэгдүүлсэн. - Улаанбаатар-Хонконг чиглэлийн нислэгийн давтамжийг долоо хоногийн 11 байсныг 15 болгож нэмэгдүүлсэн. - ОХУ-тай Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Улаангом, ОХУ-ын нутаг дэвсгэр дээр Кызыл нислэгийн цэгийг нэмж тохирч, нислэг гүйцэтгэх зохицуулалт бүрдүүлсэн. - Сингапур Улстай нислэгийн давтамжийг нэмэгдүүлсэн бөгөөд Агаарын тээврийн 3, 4, 5 дугаар эрхээр 7 хоногт 3 хүртэлх давтамжтайгаар нислэг үйлдэх эрхтэй байсныг Агаарын тээврийн 3 болон 4 дүгээр эрхийн хүрээнд ямарваа хязгаарлалтгүй, Агаарын тээврийн 5 дугаар эрхийн хүрээнд долоо хоногийн 14 удаагийн давтамжтай байхаар нэмэгдүүлсэн. -2024 онд БНСУ-ын талтай хэлэлцээ хийж, Улаанбаатар-Бусан чиглэлд долоо хоногийн 6 удаагийн давтамжтай байсныг 9 болгон нэмэгдүүлж, Инчeon, Гимпо, Бусан зэрэг хотуудаас бусад БНСУ-ын орон нутгийн 5 чиглэлд долоо хоногийн нийт 15 удаагийн давтамжтай, Улаанбаатараас бусад МУ-ын орон нутгийн 5 чиглэлд долоо хоногийн нийт 15 удаагийн давтамжтай нислэг үйлдэхээр тохиролцсон. Мөн Монгол-Солонгос хоорондын нислэгийн давтамжийг суудлын багтаамжтай уяж тооцдог байсныг халж, Улаанбаатар-Сөүлээс бусад чиглэлд аливаа багтаамжийн хязгаарлалтгүй болгож, дан давтамжаар тооцох нөхцөлийг бүрдүүлсэн. 2024 онд шинээр 12 чиглэлд томилогдоогосноор нийт 26 улсын 132 чиглэлд дотоодын 5 агаарын тээвэрлэгчийг олон улсын хуваарьт нислэг гүйцэтгэх агаарын тээвэрлэгчээр томилоод байна. Орон нутгийн найман чиглэлд нислэг сэргээж, тийзийн үнийг 2-2,5 дахин хямдрууллаа.□	ЗТЯ	100	100.0	
110	4.2.11. Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.	2021-2025	1,014,926.5, Холимог эх үүсвэр		ЗТЯ: Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлүүдийн төмөр замын холболтын төсөл: Өмнөговь аймгийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замыг барих төсөл: Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар тушаалаар байгуулагдсан Комисс 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдөр ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан. Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барих төсөл: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 125 дугаар тушаалаар байгуулагдсан Улсын комисс 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан. 2. Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын төсөл: Зам, тээврийн ТНБД-ын 2024 оны А/212 тушаалаар "Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын дээд, доод бүтэц, хиймэл байгууламжийг хүлээн авах ажлын хэсэг"-ийг байгуулж 2024 оны 11 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд ажилласан. Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын 2024.12.19-ний өдрийн 138 дугаар тушаалаар байгуулагдсан комисс 2024.12.23-нд байнгын ашиглалтад хүлээж авсан. 3.Тавантолгойн орд газрын Ханги боомттой холбох 477 км тусгай зориулалтын авто замын төсөл: Засгийн газрын 2019 оны 238 дугаар тогтоолын дагуу Үндэсний хөгжлийн газраас "Тахилт хайрхан транс" ХХК-тай концессын гэрээг байгуулсан бөгөөд 2020.01.22-ны өдөр гэрээ хүчин төгөлдөр болсон. Зам барилгын ажлыг 2020.04.15-ны өдөр эхлүүлсэн. Ажлын явц 99.3 хувьтай байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай автозам 2024 оны зам барилгын ажлыг 4 дүгээр сарын 10-ны өдөр эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 71 хувьтай байна. Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэсэн.ЭХЯ: нийт 4 төсөл хэрэгжүүлж байна. Үүнд: -Оюутолгой-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг 2021 онд ашиглалтад хүлээн авсан. -Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг 2021 онд ашиглалтад бүрэн хүлээн авсан. -Чойр-Сайншандын 230 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн санхүүжилт шийдвэрлэгдсэн. ТЭЗҮ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, газрын трасс зэргийг баталгаажуулж, төслийн бэлтгэл ажлыг хангасан. Төслийн зээлийн гэрээний хэлцэл амжилттай хийгдэж, зээлийн гэрээнд ЕСБХБ, МУ-ын Сангийн яам гарын үсэг зурсан. БУА-ын гүйцэтгэгчийг сонгох үе шатанд хэрэгжиж байна. -Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх хүрээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2 удаа зарласан боловч амжилтгүй болсон. АҮЭБЯ: 1.Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2024 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. 2023 онд дараах барилга угсралтын ажлыг гүйцэтгээд байна. • Анхан шатны бутлуурын хүчитгэсэн хананы угсралт дууссан, • Барилга болон тоног төхөөрөмжийн суурийн цутгалт хийгдсэн. • Барилгын металл хийц угсралтыг хийсэн. 2.-Хармагтайн алт-зэсийн үндсэн ордод 2013-2018 онд хийгдсэн хайгуулын ажлын үр дүнд тулгуурлан ордын нөөцийг 2018 онд ЭБМЗ-өөр батлуулсан. Өнөөгийн байдлаар ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд нэмэлт, хайгуул судалгааны ажлыг	ТЯ/ЭХЯ/ АҮЭБ	100	70.0	Бүтээн байгуулалтын ажлууд эхэлсэн. Арга хэмжээний хүрээнд тодорхой үр дүнд хүрсэн.
111	4.2.12. Улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	2021-2025			"Багануур пауэр" ХХК-тай байгуулсан концессын гэрээнд 2021.05.14-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдон дагалдах гэрээнүүдэд өөрчлөлт оруулж "ДҮТ" ТӨХХК, "ЦДҮС" ТӨХК болон "Багануур Пауэр" ХХК хооронд "ЦЭХХХАГ"-ний нэмэлт гэрээ №2-г байгуулсан. ЭХЯ-наас станцыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох техникийн нөхцөлийг олгосон. Усны газраас Усны дүгнэлт гарсан. БОНБНУ-ний тодотголын тайлан БОАЖЯ-ны холбогдох мэргэжлийн зөвлөлийн 2022.02.22-ний өдрийн хурлаар баталгаажсан. Мөн станцын нүүрс дамжуулах туузан дамжуурга, ус татах шугам хоолой, өргөтгөлийн насосын станц болон ус хангамжийн шугамын нийт 20 га газрын ашиглах эрхийг 5 жилийн хугацаатай авсан. Концессын гэрээний нэмэлт, өөрчлөлтийн дагуу "Багануур Пауэр" ХХК-иас төслийн шинэчилсэн техникийн шийдлийг БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд бүртгүүлэх шаардлагатай байсан ба тус ажлын хүрээнд ЗГ-ын 2022 оны 8, 28, 39 дүгээр тэмдэглэл гарсан. БНХАУ-ын төрийн бодлоготой уялдан "Багануур пауэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигч "Цөмийн инженерийн барилга групп" ТӨХК төслийн хяналтын багц хувьцааг шилжүүлэх хүсэлтийг 2022.08.01-ний тоотгоор ЭЗХЯ-д хүргүүлж, улмаар хувьцаа шилжүүлэх ажлыг 2022-2023 онд зохион байгуулж, хяналтын багцын 90%-ийг "Касень групп" компанид шилжүүлэхийг хоёр тал хүлээн зөвшөөрснөөр дахин концессын болон ЦЭХХАГ-нд зохих өөрчлөлт оруулах ажлуудыг 2023.06.05-ны өдрөөс зохион байгуулж, ЭЗХЯ-тай 2023.10.27, 2023.12.05-ны өдрүүдэд уулзалт хийсэн. "Багануур Пауэр" ХХК-аас Касень групп компанитай хийсэн хэлцэл амжилтгүй болсон бөгөөд хөрөнгө оруулалтын түншүүдийг идэвхтэй хайж хувьцаа шилжүүлэх ажлыг дуусгах талаар 2024.03.19-ны өдөр албан бичгээр Эрчим хүчний яаманд мэдэгдсэн. ЭХЯ-ны БТГ-ын дарга болон холбогдох хүмүүс 2024.08.28-ны өдөр "Багануур Пауэр" ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт хийж, төслийн явцын талаар санал солилцож, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийг үүрэг болгосон.	ЭХЯ	30	30.0	
112	4.2.13. Баянтээг нүүрсний уурхайг түшиглэн 20 МВт-ийн цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөн, хөрш зэргэлдээх аймгуудын түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулна.	2021-2025			"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ Баянтээг нүүрсний уурхайг түшиглэн 2х20 МВт-ын цахилгаан станц барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан 2021.07.06-ны өдөр ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэгдэн дэмжигдсэн. Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2021.02.09-ний өдрийн шийдвэрээр "Баянтээг түлш" орон нутгийг өмчит, бие даасан ХХК байгуулагдсан. Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн байгуулагдсан хагас коксын ба сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн өргөтгөлийн ажлын хүрээнд хатаалтын зуух барих ажил хийгдэж байна. Эрчим хүчний үндэсний төвийн Захиалагчийн хяналтын алба нь техникийн хяналтыг хэрэгжүүлж байна.	ЭХЯ	30	30.00	
113	4.2.14. Завхан, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний дутагдлыг арилгах зорилгоор шаардлагатай агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийн шинэчлэл, барилгын ажлыг хэрэгжүүлнэ.	2021-2025	29,184.2, Гадаадын зээл, тусламж		зорилт арга хэмжээний хүрээнд Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлж байна. - Говь-Алтай аймгийн Алтай сумын нарны цахилгаан станцын 0,3 МВт-ын өргөтгөл дуусч, 2022.08.01-ний өдөр ашиглалтад хүлээн авснаар Алтай сум 24 цаг тасралтгүй цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна. Завхан аймгийн Алдархаан суманд 5 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц, Улиастай суманд 3.6 МВт-ц-ийн цэнэг хуримтлуур суурилуулах ажлын гүйцэтгэл 100%-тай, 2022 оны 11 дүгээр сарын 25-нд ашиглалтад хүлээн авсан. Нийлбэр дүнгээр 9,4 МВт ашиглалтад орсон. - Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил дуусч 2023 онд ашиглалтад орсон. - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил 2024 онд дууссан. - Увс аймгийн Өмнөговь, Завхан аймгийн Тэлмэн суманд барихаар төлөвлөж байгаа 15 МВт-ын нийлбэр хүчин чадалтай хоёр салхины цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх газруудад 2022-2023 онд хийгдсэн салхины хэмжилтээр эдийн засгийн үр ашгийг гарсан тул тус бүс нутагт нарын станц болгон хэрэгжүүлэхээр АХБ-тай зөвшилцсөн. Төслийг зөвлөх үйлчилгээний ажил үргэлжилж байна. Мөн зорилтын хүрээнд Завхан аймгийн Тосонцэнгэл суманд 30 МВт-ын дулааны цахилгаан станцын төсөл, Завхан аймгийн Улиастай, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумдад дулааны станц барих төслүүд үргэлжилж байна.	ЭХЯ	100	100.00	
114	4.2.15. Арц суурь боомтыг Нөмрөг сумтай, Улиастай хотыг Алтай хоттой холбосон автозамуудыг барина.	2021-2025	-		ЗТЯ: - Завхан аймгийн Нөмрөг сумыг Арцсуурь хилийн боомт чиглэлийн авто замын ТЭЗҮ, зураг төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн төсөлд Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад энэхүү зам барилгын ажлыг эхлүүлэхээр санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан. - Алтай-Улиастай чиглэлийн 138 км хатуу хучилттай авто замын зураг төсөл 2013 онд боловсруулсан. Үлдэгдэл 60 км авто замын зураг төсөл 2022 онд боловсруулж дууссан. Авто замын барилгын ажлыг Азийн хөгжлийн банкны "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арилалтын төсөл"-ийн 3-р шатны төслийн хүрээнд Алтай-Улиастай чиглэлийн авто замыг хэрэгжүүлэхээр АХБ-тай тохиролцон 2024 онд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.□	ЗТЯ	30	30.0	
115	4.2.16. Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлнэ.	2021-2025	148,857.7, Гадаадын зээл, тусламж		зорилт арга хэмжээний хүрээнд Эрчим хүчний сүлжээнд ашиглах том хэмжээний хуримтлуурын төслийг хэрэгжүүлж байна. Төслийн зөвлөхөөр ХБНГУ-ын "RWE Technology International GmbH" компани болон МУ-ын "Мон-Энержи-Консалт" ХХК-ийн баг шалгарсан. 2021-2022 онд БУА-ын гүйцэтгэгчийг шалгаруулж, БУА-ыг 2022.08.04-ний өдөр эхлүүлсэн. ЦДҮС ТӨХК-тай тарифын хэлэлцээрийг эхлүүлж, ЭХБББ тусгай зөвшөөрлийг 2023.06.14-ны өдөр ЭХХХ олгосон. Зураг төсөл боловсруулах, хянах, батлах ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, тээвэрлэлт, зам талбай, удирдлагын барилга, станцын угсралтын ажлууд бүрэн дууссан, улсын комисс 2024 онд хүлээн авсан. Мөн зорилтын хүрээнд 2024 онд Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 50 МВт-ын батарейн хуримтлуурын станц Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад ороод байна.	ЭХЯ	100	90.00	Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлсэн эсэх нь тодорхойгүй.
	Ухаалаг санхүүгийн зах зээл							66.25	
Зорилт 4.3.Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.									

116	4.3.1. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, биржийн бус болон үүсмэл санхүүгийн зах зээл дээр хийгдэж байгаа арилжааны дүнг өсгөнө.	2021-2025	-		Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 05 сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн баталсан. "Moody's" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B2,тогтвортой" хэмээн үнэллээ. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч "Moody's" агентлаг /2024.11.18/ Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 9 жилийн дараа "B2, тогтвортой" болж сайжирсныг зарлалаа. Өмнөх сард олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч "Fitch" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B+тогтвортой", "S&P" агентлаг "B+ээрэг" гэж үнэлснээ дараалан зарлаж байсан юм. Харин "Moody's" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ "B2, Тогтвортой" болж сайжрахад дараах хүчин зүйлс нөлөөлснийг онцолжээ. СЗХ: Санхүүгийн зохицуулах хороо МҮХАҮТ-тай хамтран "ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр"-ийг баталсан. Хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 ААН-үүдийг хөрөнгийн зах зээлд IPO хийх, компанийн бонд гаргахтай холбоотой харилцааг хялбаршуулан хөнгөвчилж, үнэт цаас гаргагчид тавих нөхцөл, шаардлагыг багасгах арга хэмжээг авах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, холбогдох ажлуудыг хийн ажиллаж байна. Тухайлбал Хорооны зүгээс "Үнэт цаасны бүртгэлийн журам", "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-уудад ТОП-100 ААН-ийг нийтэд санал болгон хувьцаа гаргахад хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, нээлттэй болон хаалттай хүрээнд бонд гаргахад аливаа барьцаа, батлан даалт шаардахгүй байх, нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгүүлэх тухай хүсэлтийг хялбаршуулсан горимоор хянах, бонд гаргахад заавал андеррайтертай гэрээ байгуулахыг шаардахгүй байх зэрэг нэмэлт, өөрчлөлтийг хийхээр ажиллаж байна. Ажлын хэсгийн зүгээс төлөвлөгөөний дагуу хуралдаж шаардлагатай асуудлуудыг хэлэлцэн, олон улсын судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд дэд бүтцийн байгууллагуудтай хамтран "Нээлттэй хувьцаат компани болохын давуу тал, хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөө" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг ТОП 100 ААН-ийн төлөөлөл болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын дунд зохион байгуулахаар төлөвлөж байна. Биржийн бус зах зээлийн анхдагч болон хоёрдогч арилжаа 2021 оны 09 дүгээр сараас эхэлсэн. Биржийн бус зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 2024 оны 09 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд 127 компанийн, нийт 3.37 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 233 өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 2.38 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлснээс гадна доллароор 106.8 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 66.4 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Энэ нь компанийн бондын зах зээлийн арилжаа биржийн бус зах зээл дээр идэвхтэй явагдаж байгааг илтгэн харуулж байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 1.06 их наяд төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.62 дахин өссөн үзүүлэлт бөгөөд өдрийн дундаж арилжаа 5.7 тэрбум төгрөг байна. Нийт арилжааны 998.9 тэрбум төгрөгийн арилжаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар, 59.8 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар тус тус хийгдсэн байна. Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 58.44 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 23.06 хувийг хувьцаа, 12.44 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 6.07 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байна. Үнэт цаасны зах зээлийн голлох үзүүлэлт болох зах зээлийн үнэлгээ Монгол Улсын хувьд 2023 оны жилийн эцсийн байдлаар 11.65 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 69 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 16.7 хувьтай тэнцсэн. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 12.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн	СЯ,СЗХ	100, 100	100.0	
117	4.3.2. Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	2021-2025	-		СЯ: Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж 2024.09.13-ны өдөр хуулийн төслийн хэлэлцүүлгийн даатгалын салбарын оролцогчид, СЗХ, ОБЕГ, ХХААХҮЯ, ҮСХ зэрэг байгууллагуудыг оролцуулан зохион байгуулж, цахимаар санал авч хуулийн төсөлд тусгасан. Энэ хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулаад байна. Мөн Сангийн сайдын 2024.11.22-ны өдрийн 01/9698 тоот албан бичгээр яамдаас санал авахаар хүргүүлж, саналуудыг хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслийг 3Г-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Сангийн сайдын 2024.12.12-ны өдрийн 01/10222 тоот албан бичгийг 3ГХЭ-гт хүргүүлсэн бөгөөд 3Г-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн болно. ГБХНХЯ: Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Улмаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан 10 аймаг, нийслэлд ахмадууд, залуучууд, сайн дураар даатгуулагчид, үйлдвэрчний эвлэлийн шат шатны байгууллага, ажил олгочдын төлөөлөл, худалдаа аж үйлдвэрийн танхим, хуульчдын холбоо зэрэг газруудаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэн, иргэд олон нийтээс санал авах арга хэмжээг зохион байгуулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Анужин баталсан. Энэ дагуу Ажлын дэд хэсгийн гишүүд хуулийн төслийн санал дүгнэлт боловсруулан ажиллаж байна. Улсын Их Хурлын D parliament цахим хуудсанд хандан 21 дэмжсэн санал, зарим холбогдох хуулийн заалтуудад өөрчлөн найруулах 22 саналыг тус тус ирүүлсэн бөгөөд 17,560 дэмжсэн санал өгсөн байна. УИХ-ын 2023 оны намрын чуулганаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийгмийн бодлогын байнгын хорооны дэд ажлын хэсэг 12 удаа хуралдсан. Мөн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг хэлэлцсэн.	СЯ, ГБХНХЯ	100, 100	90.0	
118	4.3.3. Бичил санхүүгийн байгууллагуудыг чадархжуулан эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааны хүрээг тэлнэ.	2021-2025	-		Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс мэдээлэл хүлээн авах, гүйцэтгэлд хяналт тавих, өгөгдлийн сан үүсгэх, санхүүгийн тайлан хүлээн авахтай холбоотой програм хангамж бүтээлгэх Ажлын албаны даргын А/97 тушаалаар байгуулагдсан "Интеллигент финанс" ХХК-тай байгуулсан "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тайлан хүлээж авах, боловсруулах, бүртгэх цахим системийн хөгжүүлэх" гэрээнд заасан программ хангамжийг хүлээн авах ажлын хэсэг байгуулагдаж ажлын хэсэг нь нийт 4 удаа хуралдаж 2 удаа тест хийж, МЗУАЭ-ээс санал холбогдох саналыг авсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 82 дугаар тогтоолоор баталсан "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам"-ын хавсралтаар баталсан маягтын дагуу Цахим тайлангийн системээр тайлан мэдээ хүлээн авахаар мастер файлыг бэлтгэн, фина системд 2024 оны эхний хагас жилийн тайланг 174 хуулийн этгээд, 45 иргэнээс хүлээн авсан байна.	СЗХ	100	100.0	Арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгөө гаргаж ажилласан. Төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн.
119	4.3.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно.	2021-2025	-		СЯ: Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 26 дахь удаагийн жилийн хурал Канад Улсын Ванкувер хотод энэ оны долдугаар сарын 9-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсын явцын тайланг хэлэлцүүлж хамгаалах багийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд ахалж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Терроризмтой тэмцэх үндэсний зөвлөлийн ажлын алба, Татварын ерөнхий газрын төлөөллүүд оролцлоо. Монгол Улсын хувьд ФАТФ-ын 40 зөвлөмжийг бүрэн хангасан үнэлгээ авсан нь Монгол Улсын эрх зүйн орчныг бий болгон холбогдох шаардлагыг хууль тогтоомжид тусгаж, зохицуулалтыг боловсронгуй болгосныг олон улсаас баталгаажуулж буй явдал юм. Сангийн яамны зүгээс харьяа байгууллагуудаас мэдээллийг нэгтгэн авч Монголбанканд улирал бүр тогтмол тайлагнаж ажиллалаа. ХЗДХЯ: Цагдаагийн байгууллагад шалгагдаж буй мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах хэрэгт Олон улсын хамтын ажиллагааг ашиглан гэмт хэрэг үйлдсэн этгээд, тэдгээрийн хөрөнгийн талаарх мэдээлэл, нотлох баримтыг олж авах зорилгоор Эрх зүйн харилцан туслалцааны 1 хүсэлт илгээж, гадаад улсын Санхүүгийн тагнуулын албанд "ЭГМОНТ"-ын шугамаар 4 хүсэлт илгээж, 8 хүсэлтийн хариуг авч, Ази, номхон далайн хөрөнгө буцаан авах байгууллага хоорондын сүлжээ /ARIN-AP/-гээр дамжуулан мөнгө угаах гэмт хэрэгт гадаад улсаас ирүүлсэн 2 албан бус хүсэлтийг хүлээн авч, манай улсаас 1 хүсэлтийг илгээсэн. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, үндэстэн дамнасан зохион байгуулалттай мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах, гэмт хэргийн улмаас хулгайлагдсан хөрөнгийг олж тогтоох чадавхыг дээшлүүлж, мэргэшүүлэх чиглэлээр 12 удаагийн сургалтад 107 алба хаагчийг хамруулсан. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/-ээр давхар зүйлчлэн 171 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хэрэг бүртгэлт явуулсан 122 хэргээс 25 буюу 20.5 хувийг хааж, 39 буюу 32 хувийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулсан 73 хэргийн 2 буюу 2.7 хувийг хэрэгсэхгүй болгож, 31 буюу 42.4 хувьд яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэн, 15 буюу 20.5 хувийг анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэн ажилласан.	СЯ 100, ХЗДХЯ: 100	100	100.0	100
120	4.3.5. Банк санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдал хангагдана.	2021-2025	-		Монголбанкны ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн А122/А-172 дугаар хамтарсан тушаалаар "Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам"-ыг баталсан. Тус журам батлагдсанаар банкинд төсвийн байгууллага данс нээхэд банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангасан байх, тус банкин дахь төрийн хөрөнгө нийт хөрөнгийн 30%-иас ихгүй байх шаардлагыг хангасан байх болон данс нээсний дараа тогтмол хяналт тавих зохицуулалт зэргийг тусгасан. Тус журамд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд эрсдэл бууруулах арга хэмжээ авна гэж заасны дагуу тогтмол хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.	СЯ	100	90.0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			96.0	
Бүс нутгийн хамтын ажиллагаа									
Зорилт 4.4. Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгааг эхлүүлнэ.									
121	4.4.1. Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын эдийн засгийн коридорыг хөгжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.	2021-2025	18.0, Улсын төсөв		3Т-ийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн №А/201 дугаар тушаалаар Монгол, Орос, Хятадын Эдийн засгийн коридорын төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЗЗҮ-ийг судлах хамтарсан ажлын хэсгийн Монголын талын ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэн. Улаанбаатар хотноо 2024 оны 04 дүгээр сард болсон Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн Төмөр замын төв шугамыг шинэчлэн хөгжүүлэх ТЗЗҮ-ийг боловсруулах хамтарсан ажлын хэсгийн III хуралдаанаар талууд 2025, 2035, 2050 он хүртэлх гадаад худалдааны ачааны тоо хэмжээний тооцооллыг гаргаж протоколд гарын үсэг зурсан. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Пакистан Улсад 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр ШХАБ-ын гишүүн орны Засгийн газрын тэргүүн нарын уулзалтад оролцох үеэр ОХУ-ын Засгийн газрын дарга М.В.Мишустин, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Чян нартай хийсэн гурван талын уулзалтын ярианы сэдэв, Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хотноо 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр ШХАБ-ын гишүүн орнуудын дээд хэмжээний уулзалтын үеэр Монгол Улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавров, БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И нарын анхдугаар уулзалтын ярианы сэдэвт Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар санал боловсруулав. БНХАУ-ын Шанхай хотноо энэ оны 11 дүгээр сарын 05-10-ны өдрүүдэд "Шинэ эрхн үед ирээдүйгээ хамтдаа хуваалцъя" уриан дор зохион байгуулагдсан "Хятадын олон улсын импортын VII ЭКСПО"-д Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гишүүн 50 гаруй компани оролцож, хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдийн мэдээллээ танилцуулав. Монгол Улс, ЕАЗЗХ-ны гишүүн орнууд хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төсөлд хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зорилтыг хангах хүрээнд 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хөнгөлтийн жагсаалтаас хасах; тарифын бус хориг саадыг хөнгөвчлөх чиглэлээр холбогдох байгууллагын төлөөлөл оролцуулах саналыг хүргүүлсэн болно.	ГХЯ	100	50.0	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгөө боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд ажил тодорхой хэмжээнд эхэлсэн тул журмын 6.2.2.3-ын дагуу үнэлэв.

122	4.4.2. Гурвалдаг хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ.	2021-2025	30.0, Улсын төсөв		АНУ: АНУ-ын Худалдааны яам, АНУ-ын ЭСЯ-тай хамтран "Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар дахь хөрөнгө оруулалтын боломжууд" вэбинарыг 2024.05.17-нд зохион байгуулж, Монгол, Америкийн төр, хувийн хэвшлийн нийт 135 төлөөлөл оролцов. Монгол Улс, АНУ-ын Эрчим хүчний яриа хэлэлцээг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ГХЯ-нд зохион байгуулав. Яриа хэлэлцээнд Монголын талаас ГХЯ, ЭХЯ, АҮЭБЯ, Үндэсний геологийн алба, МУ-ын Эрчим хүчний засаглал хөтөлбөр, Монголын бизнесийн зөвлөл, МҮХАҮТ-ын дэргэдэх Эрчим хүчний зөвлөл, Монголын чухал ашигт малтмалын холбоо, Монголын зэс корпораци, Америкийн талаас Төрийн департамент, АНУ-ын ЭСЯ, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол) зэрэг төр, хувийн хэвшлийн 40 орчим төлөөлөгч оролцов. Япон Улс: Монгол-Японы төр, хувийн хэвшлийн 11-р зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулав. Япон Улсын Кансай мужид зохион байгуулагдах "Осака-Кансай ЭКСПО-2025" үзэсгэлэнд оролцох "Оролцогчийн гэрээ"-нд ГХ-ны Сайд, Монголын хэсгийн Ерөнхий комиссар Б.Батцэцэг 2024 оны 01 дүгээр сард гарын үсэг зурж баталгаажуулж японы талд илгээв. ЕХ: Монгол Улс, ЕХ хооронд 2013 онд байгуулсан "Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийн дагуу "Монгол Улс, Европын Холбоо хооронд газар зүйн заалтын тухай" хэлэлцээр байгуулах 3 дахь үе шатны яриа хэлэлцээг 04 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд Брюссель хотноо хийж, тус тусын нутаг дэвсгэр дэх газар зүйн заалттай хоёр бүтээгдэхүүнийг харилцан солилцсон. Монгол Улсын гадаад худалдааг төрөлжүүлэх, худалдааны бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилготой "Олон улсын худалдааг дэмжих төсөл" ГХЯ-ны харьяа хэрэгжиж эхэлсэн. БНСУ: Монгол Улс, БНСУ-ын хоорондын "Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр байгуулах хэлэлцээний 2 дахь үе шат 2024 оны 05 дугаар сарын 19-21-ний өдөр, 3 дахь үе шат 2024 оны 09 дүгээр сарын 10-13-ны өдөр, 4 дэх үе шатны хэлэлцээг 2024 оны 11 дүгээр сарын 25-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав.	ГХЯ	100	70.0	Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, тодорхой шийдвэрүүдийг гаргасан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа тул журмын 6.2.2.2-ын дагуу үнэлэв.
123	4.4.3. Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, худалдааг хөнгөвчилнө.	2021-2025	5.0, Улсын төсөв		ЗЗХЯ: Монгол Улсын Засгийн газраас гадаадын улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр нийт 30 гэрээ хэлэлцээрийг тохиролцох, байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллав. - Эдийн засаг, хөгжлийн сайдын тэргүүдэд Монгол-Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн хурлыг 2024.11.18-нд, Монгол, Японы төр, хувийн хэвшлийн XI зөвлөлдөх уулзалтыг 2024.11.28-нд тус тус зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллав. - Монгол Улс, ХБНГУ хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хамтын ажиллагааны 2 баримт бичиг байгуулав. - Их түмэн санаачилга хөтөлбөрийн хүрээнд ОХУ, БНХАУ, БНСУ-тай зам тээвэр, эрчим хүч, худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх 4 жилийн хамтын ажиллагааны үйл ажиллагааны стратеги хөтөлбөрийг байгуулахаар ажиллаж байна. - Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн 2-4 дүгээр шатны хэлэлцээний бэлтгэл ажлыг ханган зохион байгуулав. Хэлэлцээр 14 бүлгээс бүрдэх ба хэлэлцээрийн үр дүнд хоёр улс хоорондын худалдаан дахь саад тогтор буурч, худалдааг хөнгөвчлөх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах, бүхий л салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, экспортлогчдын зах зээл тэлж, өрсөлдөх чадвар, бараа, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжрах, дотоодод нийлүүлэх барааны үнэ, хангамж тогтворжиж ач холбогдолтой. - Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн хоёр шатны хэлэлцээ, 3 удаагийн уулзалтын бэлтгэл ажлыг ханган зохион байгуулснаар Худалдааны түр хэлэлцээрийн төслийг 2024 онд талууд эцэслэн тохиролцсон бөгөөд хэлэлцээр байгуулах асуудлыг Засгийн газрын 2024.11.13-ны өдрөөр хэлэлцэн дэмжсэн болно. Тус хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсаас гарал үүсэлтэй, хөдөө аж ахуйн гаралтай БТКУС-ын 6 орон бүхий 375 төрлийн экспортын бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх нөхцөл бүрдэх юм. ГХЯ: Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орсноор манай аж ахуйн нэгжүүд 10,667 нэр төрлийн бүтээгдэхүүнд 5-100%-ийн татварын хөнгөлөлт эдлэх боломж нээгдсэн. 2022 онд Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд 10 гаруй аж ахуйн нэгжид 406 гарал үүслийн гэрчилгээг МҮХАҮТ-аас олгож, хөнгөлөлт эдэлсэн бол 2023-2024 онд нийт 49 аж ахуйн нэгжийн rapc, rapc-ын үр, цагаан архи, ноолууран бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, чихэр, шоколад, ундаа, шүүс зэрэг нэр төрлийн 65,7 сая ам.долларын экспортын бараанд давхардсан тоогоор 2060 хөнгөлөлттэй Гарал үүслийн гэрчилгээ олгосон байна. АНДХХ-ийн хүрээнд дэх 5 дахь үе шатны тариф, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх хэлэлцээг эхлүүлэх, оролцох тухай саналаа Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлээд байна. АНДХХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газраас 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн АПТА-ийн хүрээнд Барааны гарал үүслийг нотлон гэрчилгээ олгож, баталгаажуулах үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгтэй холбоотой мэдээлэл ирүүлэх тухай хүсэлтийн дагуу ГЕГ, МҮХАҮТ-аас холбогдох мэдээлэл, санал авч, нэгтгэн 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдөр дээрх газар хариу хүргүүлэв. Ази, Номхон далайн хил дамнанас цаасгүй худалдааны ерөнхий хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурал 2021 онд соёрхон баталсан. Ази, Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн Комисс (ESCAP)-оос зохион байгуулсан Цаасгүй худалдааны ерөнхий хэлэлцээрийн Байнгын хорооны 3 хуралдаанд Монголын төлөөлөгчид оролцсон. АНДХХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газраас 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр "БНХАУ-ын Гаалийн газраас гаргасан саналыг авч хэлэлцэх тухай" цахимаар зохион байгуулсан хуралд оролцож, байр сууриа илэрхийлэв.	ЭЗХЯ 100, ГХЯ 90	100, 90	100.0	
124	4.4.4. Экспортыг дэмжих, худалдааг хөнгөвчлөхөд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор дэмжлэг үзүүлнэ.	2021-2025	-		Олон Улсын органикийн итгэмжлэлийн байгууллага (IOAS)-аас 2024 оны 07-р сарын 29-ны өдөр органик бүтээгдэхүүнийг баталгаажуулахаар итгэмжлэгдсэн. Үүний үр дүнд 2024 онд Стандарт, хэмжил зүйн газраас ХАЛАЛ стандартыг хангаж гэрчилгээжсэн Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүн Булангийн болон Арабын орнуудад экспортлож эхэлсэн ба бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, худалдааг хөнгөвчилж байна. Түүнчлэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, үзэл баримтлалыг Монгол Улсын Шадар сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан ба Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Хуулийн шинэчилсэн найруулгад тохирлын үнэлгээний бодлого, эрх зүйн орчинг тодорхой болгох зохицуулалтыг нарийвчлан тусгасан. Олон улсын дэвшилтэд стандартаар үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлж байгаа Аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, олон улсын стандартыг нутагшуулах, үндэсний хэмжээнд батлан мөрдүүлэх зорилгоор АНУ болон БНХАУ-ын Газрын тосны салбарын 9 стандартыг бүртгэн дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал: - ASTM D892-13 Тосолгооны тосны хөөсөрч буй шинж чанарыг шалгах стандарт арга зүй", ASTM D 6130-2018 Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний дээж дэх цахиур болон бусад элементүүдийн агууламжийг индукцийн холбоот плазмтай атом цацаргалтын спектрометр багажаар тодорхойлох шинжилгээний арга", БНХАУ-ын үндэсний 7 стандарт. -GB/T 7304-2014, GB/T 18612-2011, GB/T 11140-2008, GB/T 1884-2000, GB/T 511-2010, GB/T 260-1977 шинжилгээний аргын стандартууд: - ОХУ-ын Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх зориулалттай савны стандартыг түр хэрэглэхээр бүртгэсэн.	СХЗГ	100	90.0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			77.5	
Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн									
Зорилт 4.5.Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.									
125	4.5.1. Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2021-2025	-		Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор дараах компаниудтай инкубаторын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна. Үүнд: 1. "Natural synergy" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбулган: Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай хамтран судлаад уушиг, элэг, бөөр хамгаалах бэлдмэл, хатаасан сармис, Эрүүл уушги & Хүчтэй дархлаа, Эрүүл хооодоо & Гоо сайхан, Эрүүл элэг & Эрч хүчтэй амьдрал, Уламжлалт тан эм мана-4 зэрэг бүтээгдэхүүнүүдийг шинжлэх ухаанд суурилсан дорно дахины анагаах ухааны жороор бэлтгэн үйлдвэрлээд байна. 2024 онд Уушиг хамгаалах цай 100 ширхэг, Элэг хамгаалах цай 100 ширхэг туршилтаар Аму брэндтэй хамтран Америк улс руу экспортлохоор явуулсан. 2. "Баршим" ХХК-ийн захирал Б.Тунгалаг: Монгол улсын биологийн идэвхит бүтээгдэхүүний бүртгэлд бүртгүүлсэн "Чихэрлэг барагшун" нэрийн бүтээгдэхүүнийг Олон улсын зах зээлд нийлүүлэх юм. 3. "Акүзла" ХХК-ийн захирал Л.Ганхараа: Ардын уламжлалт аргаар бэлтгэсэн тойны тос арьс арчилгааны бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсээр байна.Монгол улсын үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг экспортлох боломж нөхцөлүүдийг нэмэгдүүлэх, хоёр орны бизнесийн харилцан түншлэлийг өргөтгөх, зах зээлд хамтран ажиллах зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо "МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭВ–2024, БНСУлсад" үзэсгэлэн худалдаа 6 дахь удаагаа зохион байгуулагдсан. Тус үзэсгэлэнд "Акүзла" ХХК нь тойны тос, алжаал тайлах хөлийн дүрлэг, банны бөмбөлөг гэх зэрэг 4 төрлийн бүтээгдэхүүнийг гадны зах зээлд танилцуулж, үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг зохион байгууллаа	ХХААХҮЯ	100	90.0	
126	4.5.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2025	-		Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2025 онд Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлд өөрчлөлт оруулна гэж заасны дагуу Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн "хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ", "Үр нөлөө", "Зардлын тооцоо"-ны судалгааг хийгээд байна. Хуулийн төсөлд Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх холбогдох заалтыг тусган ажиллах болно. Судалгааны ажлыг хавсаргав.Жижиг, дунд үйлдвэрийн газраас хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд "Кластераар бүсчилэн хөгжүүлэх чиглэл", "Кластерыг тооцох журам"-ын төслийг боловсруулж, холбогдох газруудаас саналыг авч олон нийтээр хэлэлцүүлсэн боловч Монгол Улсыг бүсчилэн хөгжүүлэх чиглэлийг шинэчлэх, ЖДҮҮДТХуульд нэмэлт өөрчлөлт оруулж холбогдох заалтыг өөрчлөхтэй холбоотойгоор энэхүү ажлыг түр хойшлуулаад байна. Гэсэн хэдий ч кластераар нэгдэх үйл явцыг дэмжих зорилгоор 2022-2023 онд Дэлхийн банкны "Экспортыг дэмжих хөтөлбөр"-тэй хамтран экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, кластераар нэгдсэн 3 ААН-д 940,0 сая төгрөгийн буцалтгүй санхүүжилт олгосоны үр дүнд 3000-4000 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжиж, экспортын гарцыг нээсэн. Үүнээс харвал бүтээгдэхүүний төрөл бүрээр кластераар нэгдэн үйл ажиллагаа явуулах, нэмүү өртгийн сүлжээ үүсгэх гарц харагдаж байна. 2024 онд Зах зээл бэлчээрийн удирдлага хөгжил төслөөс 4.2 тэрбум төгрөг, УИХ-ны 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жимс, жимсгэний салбарт 2.9 тэрбум , зөгийн кластерт 270.0 сая төгрөг, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Орхон аймгийн санхүүжилтээр 4.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлж, 61 төсөлд 8.7 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр гарснаас 36 төслийн 4.3 тэрбум төгрөгийг олгоод байна.	ХХААХҮЯ	90	70.0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			80.0	
Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн									
Зорилт 4.6.Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.									

135	5.3.1. Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно.	2021-2025			Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаанаар цахим хөгжлийн багц хууль болох Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Кибер аюулгүй байдлын тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг тус тус хэлэлцэн баталсан. Эдгээр багц хуулийн хүрээнд нийт 48 захиргааны хэм хэмжээний акт батлагдахаас батлагдсан 35, батлаагүй 13 захиргааны акт байна. Үүнд Засгийн газраар батлуулсан 22, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд баталсан 13.	ЦХИХХЯ	90	90.0	арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй,
136	5.3.2. Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болгоно.	2021-2025	800.0, Улсын төсөв		1.Үндэсний дата төв (УТУГ)-ын үйл ажиллагааг олон улсын дата төвийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн клауд (PaaS-Platform as a Service) хэлбэрт шилжүүлж, 2024 оны жилийн эцсийн байдлаар mCloud системд 54 байгууллагын үндсэн болон дэд систем бүхий нийт 292 зохиомол серверийг үүсгэж, үүлэн орчинд шилжүүлсэн. 2.“Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан журам”-ыг Засгийн газрын 2024 оны 77 дугаар тогтоолыг батлуулсан. 3.Мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сан, тэдгээрийн их өгөгдлийн санд нэгтгэх суурь нөхцөлийн бэлэн байдлын үнэлгээ, мэдээллийн сангийн мета-өгөгдлийн судалгааны өгөгдөл, Хүн ам, өрхийн бүртгэлийн сан, Статистикийн бизнес регистрийн сан, Мал тооллогын мэдээллийн сангийн мэдээллийг агуулсан ""Мета-өгөгдлийн платформ"" хөгжүүлж, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэ платформд төрийн байгууллагуудын үүсгэсэн өгөгдлийн багц (мэдээллийн сан) 45, хүснэгт 453, үзүүлэлт 7137, ангилал, код 725, тэдгээрийг цуглуулж буй маягт 248 бүхий өгөгдлийг бүрдүүлээд байна. 4.Их өгөгдлийн (big data) сан үүсгэх тухай” Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоолын дагуу их өгөгдлийн (big data) сан үүсгэхэд хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлж, хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга, аргачлал, төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр нууцлалтай дамжуулах шийдлийг боловсруулж, хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон турших ажлыг эхлүүлсэн. 5.Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд 2022 онд 3, 2023 онд 15 мөн 21 аймагт, 2024 онд 9 нийт 48 зөвлөмж, дүгнэлт гаргасан. ТА3: Төрийн албаны зөвлөлийн 2024 оны худалдан авах төлөвлөгөөний дагуу Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, Төрийн албан хаагчдын нэгдсэн тоо бүртгэлийн тайлангийн портал хөгжүүлж, Дашбоардад 2023 оны мэдээллийг оруулан хэрэглэгчдэд ашиглах боломжийг бий болгосон. Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд Боловсролын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар зэрэг байгууллагын цахим сангаас /мэдээллийн эх сурвалж/ 8 төрлийн сервисийг Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан авч төрийн албан хаагчийн мэдээллийг бүрдүүлж, төрийн 7 байгууллагын цахим сангаас 19 төрлийн сервисийг нэмэлтээр авахаар ажиллаж байна. Байгууллагын бүтцийн бүртгэл болон албан тушаалын тодорхойлолт, ЕС зүйн бүртгэл, хяналт, Хяналт, үнэлгээ, Төрийн албан хаагчийн оролцоо зэрэг модулийг шинээр хөгжүүлж дуусгасан. Цахим системийн хөгжүүлэлтэд 2024 онд 730.9 сая төгрөгийг зарцуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Төрийн албаны зөвлөл төрийн мэдээлэл солилцооны ХУР, танилт нэвтрэлтийн ДАН системтэй мэдээлэл солилцох гэрээ байгуулан ажиллаж, нэгдсэн бодлого, төлөвлөлтийг уялдуулах боломжийг бүрдүүлсэн.	ЦХИХХЯ, ТА3	100, 100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
137	5.3.3. Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирна.	2021-2025	-		1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төрийн мэдээлэл солилцооны систем (www.xyp.gov.mn)-ээр дамжуулан 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 810 сервисийг солилцож, төрийн 136, хувийн 369 байгууллага, Танилт, нэвтрэлтийн систем (www.dan.gov.mn)-д төрийн 87 байгууллагын 167 систем, хувийн 231 байгууллагын 267 систем тус тус холбогдсон байна. 2.Албан бичиг солилцооны дундын DocX системийг хөгжүүлэн Аблесофт, erp.e-mongolia.mn, Digital office, Veritech erp, “e-doc”, “Able” зэрэг 12 төрлийн албан бичиг солилцооны системтэй холболт хийн 4000 гаруй байгууллагатай албан бичиг солилцох боломж бүрдсэн. 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 127,637 бичгийг 165,496 хавсралттай илгээж, 154,682 албан бичиг хүлээн авсан байна. Албан байгууллагууд Docx.gov.mn системийг ашигласнаар 1,716,162,000 төгрөгийн төсвийн хэмнэлт хийсэн байна. ТА3: төрийн албан хаагчтай холбоотой 5 төрлийн лавлагаа үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-MongolПа платформоор дамжуулан нэвтрүүлсэн. Үүнд: “Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтад өгч тэнцэн, нөөцөд бүртгэгдсэн тухай лавлагаа”, “Төрийн жинхэнэ албаны нөөцийн лавлагаа”, “Төрийн жинхэнэ албаны нөөцийн лавлагаа (бүртгэлгүй хариулт)”, “Албан хаагчийн цалингийн тодорхойлолт”, “Албан хаагчийн ажиллаж буй тодорхойлолтыг” цахимаар олгож, төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирсан. Цаашид төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-MongolHa платформоор дамжуулан бусад үйлчилгээг үзүүлэхээр системд нэмэлт хөгжүүлэлт хийгдэж байна. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг дотоод удирдлагын программ болох Able программын албан бичиг солилцооны Оосх системд холбож, албан хэрэг хөтлөлтийг бүрэн цахимжуулж, тоон гарын үсэгт шилжсэн.	ЦХИХХЯ, НЗДТ	100,100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
138	5.3.4. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2025	-		1.Иргэдэд төрийн байгууллагаас олгодог баримт бичиг, гэрчилгээ, зөвшөөрөлтэй холбоотой төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдлийг Мэдэгдэл хүргэх систем (www.E-Mongolia.mn)-ээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж, иргэдэд 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 30,622,732 мэдэгдлийг хүргэсэн. Үүнээс үндэсний цахим шуудан (69.4% буюу 21,272,282), хувийн цахим шуудангийн хаяг (1.3% буюу 442,286), Push Notification (29.3% буюу 8,908,164)-ээр дамжуулан хүргэсэн. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэнийг холбосон мэдээлэл дамжуулах цахим суваг болох Үндэсний цахим шуудангийн систем (www.mail.e-mongolia.mn)-ийг нэвтрүүлж, 1,7 сая хэрэглэгчид мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн. 2.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хүрээнд иргэний мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах зорилгоор 68 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй байлгахаар зохицуулсан. Нээлттэй мэдээллийг 87 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр үнэлж, 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 571 байгууллага тайлан ирүүлснээс 513 байгууллагын үнэлгээг хийж нийтэлсэн. Үүнд төрийн захиргааны төв байгууллагын дундаж үзүүлэлт 90.07%, төрийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 93.97%, нутгийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 72.61% гэсэн үзүүлэлттэй байна.	ЦХИХХЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			90	
Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба									
Зорилт 5.4. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.									
139	5.4.1. Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшүүлнэ.	2021-2025	-		Төр хүнээ мэддэг байх, хуульд заасан шаардлага хангасан, мерит чадахуйн зарчмын хүрээнд хүний нөөцийн төлөвлөлт хийдэг байх зорилгоор Засгийн газар Төрийн албаны зөвлөлийн бүрдүүлсэн төрийн албан хаагчийн нэгдсэн мэдээллийн сантай ажиллах системийг боловсруулсан. Уг систем нь төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санд дүн шинжилгээ, боловсруулалт хийн, удирдлага, төлөвлөлтийг мэдээлэл, судалгаанд үндэслэн хэрэгжүүлэхээс гадна шийдвэр гаргалтан дахь субъектив хамаарлыг багасгах, төрийн албан хаагч мэдээллийн ил тод байдалд хяналт тавих, оролцох бололцоог олгох ач холбогдолтой “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих систем” буюу Төрийн албан хаагчийн платформыг хөгжүүлж нэвтрүүлсэн. Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 15 дугаар хуралдаанаар Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих системийг танилцуулж, 5 дугаар сарын сарын 08-ны өдрийн 18-р хуралдаанаар Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих системийн талаар авах авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлэн, батлуулсан. Улмаар тус цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.	ЗГХЭГ	100	90.0	
140	5.4.2. Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.	2021-2025	-		1. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын нэгдсэн судалгааны ажлыг зохион байгуулж, нэгдсэн тайлан, дүгнэлтийг бэлтгэж байна. Энэ хүрээнд төрийн албаны тогтвортой, бүтээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, төрийн албан дахь карьерын тогтолцоог илүү оновчтой болгох боломжит чиглэлүүдийг тодорхойлон тусгасан. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээг хийхдээ 16 яам, аймаг, нийслэлийн 24 төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хуулийн 9 зүйлийн 12 заалт тус бүрээр үнэллээ. Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.6 дахь хэсэгт заасныг удирдлага болгон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийлээ. Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж буй Tony Blair Institute-тэй хамтран “Government Productivity and Public Sector Efficiency” шинжилгээг хийж, эхний шатны тайланг хүлээн авсан. 2. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтнуудад танилцуулгыг хийсэн. Засгийн газрын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан Төрийн албаны реформ хийх санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг шинэчлэгдэн байгуулагдаж, холбогдох ажлуудыг эхлүүлээд байна. 3. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг шинэчлэх ажлын хүрээнд “Төрийн албаны шалгалт өгөх болзол шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулалтын журам”, “Төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгохтой холбоотой журам”, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Албан	ЗГХЭГ	100	90.0	
141	5.4.3. Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025	-		УИХ-аас 2023 оны 5 дугаар сард “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийг баталж, Төрийн албаны зөвлөлийн дэргэд 9 гишүүнтэй ЕС зүйн хороо байгуулагдаж улсын хэмжээнд төрийн албанд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиг үүрэг бүхий тогтолцоо, нийт төрийн байгууллагад “ЕС зүйн дэд хороо” байгуулан ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг 2024 оны 4 дүгээр сард баталж, ёс зүйн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан.	ТА3	100	70.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, хууль, хөтөлбөр батлагдсанаар гарсан үр дүнг тайлагнаагүй
142	5.4.4. Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.	2021-2025	37 сая		Төрийн албаны сургалтын нэгдсэн тогтолцооны дагуу төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын ангилал, зэрэглэлд нь тохирсон мэргэшүүлэх сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж байгаа нь мэргэшсэн, чадварлаг төрийн албыг бэхжүүлэх суурь нөхцөл болж байна.Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих боломжийг бүрдүүлж, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 цахим сургалт, мэдээллийг 29 удаа зохион байгуулж, 48,800 хэрэглэгчийн эрхээр 103,680 гаруй төрийн албан хаагч хамрагдсан байна. Сургалтын хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн мэдлэгт хувь нэмэр оруулах үүднээс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудасны Сургалт, судалгаа цэс, youtube сувгаар сургалт бичлэгийг эх хувиар байршуулж, тухай бүр татан үзэх боломжийг хангасан. Zoom эрхийн хураамжийн төлбөрт 37 сая төгрөгийг зарцуулсан.	ТА3	100	90.0	

143	5.4.5. Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлнэ.	2021-2025	-		Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 03 сарын 11-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 44 дүгээр тушаалаар 10 байгууллагын төлөөлөл бүхий 21 гишүүнтэй Ажлын хэсэг байгуулж, "Монгол улсын төрийн албаны зарим төрлийн стандартыг бусад улсын төрийн албаны стандарттай харьцуулах нь" сэдэвт судалгаа, Олон улсын туршлагад үндэслэн "Төрийн албаны үйл ажиллагааны стандартад тавих ерөнхий шаардлага MNS ... 2024" үндэсний стандартын төслийг боловсруулж, батлуулахаар 2024.12.11-ний өдрийн 01/2590 тоот албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн.Төрийн үйлчилгээний стандартчиллын техникийн хороо стандартын төслийг хэлэлцэхээр бэлтгэж байна.	ТАЗ	100	70.0	Стандартыг өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан буюу холбогдох байгууллагад хүргүүлсэн тул журмын 6.2.2.2-т
144	5.4.6. Төрийн үйл ажиллагааны бүхий л шатанд Шилэн дансны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах замаар иргэдийн мэдээлэл авах эрхийг дээдлэн ажиллаж, холбогдох хуулийн дагуу иргэний шаардсан мэдээллийг гаргаж өгөөгүй төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын удирдлагад хариуцлага тооцдог болно.	2021-2025	-		Авлигатай тэмцэх "5 Ш" ажиллагааны хэрэгжилтийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, олон нийтэд мэдээлэх ажлын хүрээнд тус яам нь "Шил" ажиллагааны хэрэгжилтийг хариудан зохион байгуулж "shilen.gov.mn" системийг 2024 оны 3 дугаар сарын 25-нд системийн хиймэл оюунд суурилсан 2.0 хувилбарыг тус тус ашиглалтад оруулж, үндэсний хэмжээнд "Шилэн индекс"-ийг зарлан, 14 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, иргэд, олон нийтийг нээлттэй мэдээллээр ханган ажилласан. Тус системд 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 39 төрлийн 970,355 мэдээллийг байршуулж, 14,583,675 удаагийн хандалтыг аваад байна. "Шил" ажиллагааны хэрэгжилтийг Засгийн газарт нийт 4 удаа танилцуулж, холбогдох төрийн байгууллагад чиглэл хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайд 01 дүгээр албан даалгавар болон бусад шийдвэрийг гаргуулан хэрэгжүүлж ажилласан. Тус албан даалгаврын биелэлтийг "Хангалттай" гэж үзэн , Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Shilen.gov.mn системд мэдээлэл хариуцагчаас ил тод, нээлттэй байршуулахаар ирүүлсэн 6,090 хуудас архивын материалыг бэлтгэн, нийт мэдээллийг машинд уншигдах хэлбэрээр бэлдэж, зөөврийн дискт хуулан албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд хиймэл оюуны сүүлийн үеийн (GPT) технологийг сургаж, ашиглалтад оруулсан. Шинэчлэгдсэн "shilen.gov.mn" системд хандах эрх олгох, сургалтад хамруулах тухай 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 01/817 тоот албан бичгийг Засгийн газрын гишүүд, Аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт, шил ажиллагааны хүрээнд хамтран ажилласан 123 байгууллагын 257 албан хаагч нарт цахим шуудангаар хүргүүлсэн."Шил ажиллагаа"-ны хүрээнд цахим шилжилтийг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хүнд суртлыг арилгах зорилгоор www.shilen.gov.mn цахим системээр төрийн захиргааны төв болон төрийн захиргааны 123 мэдээлэл хариуцагч байгууллага холбогдож, info@shilen.gov.mn цахим шуудангаар 604 багц мэдээллийг хүлээн авч, цахим системд байршуулан үндэсний хэмжээнд "Шилэн индекс"-ийг зарлаж, иргэд, олон нийтийг нээлттэй мэдээллээр ханган ажиллаж байна.Төрийн захиргааны төв байгууллагын хувьд дундаж үзүүлэлт 2024 оны жилийн эцсээр яамны дундаж хувь 91,6% 2024 оны жилийн эцсээр 16 агентлаг дундаж хувь 70,9% 2024 оны жилийн эцсээр 14 аймаг дундаж хувь 81.42% тус тус үнэлэгдсэн. 2024.12.09-ны өдрийн байдлаар 39 төрлийн 970,355 мэдээллийг байршуулж, 15,758,833 удаагийн хандалтыг авсан. 2. Шил ажиллагааны хэрэгжилтийг 2023.04.05, 05.31, 08.16 болон 2024.04.17-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд нийт 4 удаа танилцуулж, холбогдох төрийн	ЗГХЭГ	100	100.00	
145	5.4.7. Орон нутагт томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулна.	2021-2025	-		Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргаа, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргаа, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус олгох саналыг хүргүүлж, Засгийн газрын 2024 оны 82, 171 дүгээр тогтоолоор тус тус батлагдаж, нийгмийн зарим асуудлыг шийдвэрлэсэн.	ТАЗ	100	50.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, тогтоол батлагдсанаар гарсан үр дүнг тусгаагүй
					Зорилтын хэрэгжилтийн хувь			80.0	
-									
Зорилт 5.5.Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлнэ.									
146	5.5.1. Хүний эрхийг хангасан хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ.	2021-2025	-		Нийт 37 хууль тогтоомжийн төсөлд тусгуулахаар 185 саналыг хүргүүлсэн. Дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: 1.Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үйл ажиллагаанд олон нийтийн сүлжээний платформ ашиглаж байгаа байдалд мониторинг хийх; 2.Зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд цахим гав ашиглаж байгаа байдал; 3."Монгол Улс дахь хиймэл оюун ухааны хэрэглээ, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах"; 4.Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор суурилуулсан хяналтын камер, хууль сахиулах ажиллагаанд хөдөлгөөнт камерыг ашиглаж буй өнөөгийн нөхцөл байдал, төлөвлөгөөг судлах, хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ хийх; 5.Иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтэд судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалтын удирдамж боловсруулах, 6.Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийг үнэлэх аргачлал дагуу үнэлгээ хийх; 7.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг дээдэлж буй байдал: олон нийтийн санал асуудлын судалгаа; 8.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд мониторинг хийх; 9.Орон нутгийн 2024 оны сонгуулийн ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд мониторинг хийх; 10."Сэтгүүлч, өмгөөлөгч хүний эрх хамгаалагчдын өнөөгийн нөхцөл байдал" судалгаа 11."Өмгөөлөгч, сэтгүүлч хүний эрх хамгаалагчдын шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг, маргаанд дүн шинжилгээ хийх" 12.Цахим хөгжлийн хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн туслах цахим технологийн бодлого, зохицуулалт судалгаа;13."Гэмт, хэрэг зөрчилд холбогдох мэдээллийн сангууд дахь хүний хувийн мэдээлэл хамгаалал" 14."Эрүүл мэндийн салбарын цахимжилт ба хүний эрх, хүний хувийн мэдээллийн эрсдэл" тойм судалгаа; 15."Тагнах төхөөрөмжийн эрх зүйн зохицуулалт ба хэрэглээ" судалгаа; 16."Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын механизмын үнэлгээ"; 17."Хүүхдийн бэлгийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт, хүчингүй болсон тохиолдлуудад дүн шинжилгээ хийх" 18.УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль, Орон нутгийн сонгуулийн үед үүссэн хүний эрхийн зөрчилд дүн шинжилгээ хийх. 19.Иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд хүний хувийн мэдээллийн хамгаалж байгаа байдал, E-Mongolia системийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх	ХЭҮК	100	70.00	
147	5.5.2. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшүүлнэ	2021-2025	-		2025 онд дараах ажлыг зохион байгуулсан. Гүнд: 1. Комиссоос "хүний эрхийн төлөв-хамтдаа" зүүн бүсийн нээлттэй өдөрлөгийг 2024 оны 11 дүгээр сарын 12-13-ны өдрийн хооронд Дорнод аймагт зохион байгуулсан бөгөөд ИНЗ-ийн гишүүн Д.Ундраа хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, "Анна хоум" хүүхдийн асрамжийн газар, ЕБС-ийн дотуур байр, Хамтарсан баг, цэцэрлэгт ажилласан. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяагаар ахлуулсан ажлын хэсэг Ховд, Баян-Өлгий аймагт 2024 оны 10 дугаар сарын 21-27-ны өдрүүдэд ажилласан бөгөөд ИНЗ-ийн гишшн Б.Ардак ажилласан. 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн Комиссын гишүүн Х.Мөнхзулаар ахлуулсан ажлын хэсэг Хангайн бүс болох Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймагт ИНЗ-ийн гишүүн Н.Арвинтариа Баянхонгор аймагт ажилласан. Хүний эрхийн сургалт удирдах ажилтнуудад зохион байгуулж, Хүний эрхийн сургалт, Баянхонгор аймгийн ахмад настны асрамжийн төвд ажилласан. 2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр ажиглалт мониторинг хийх удирдамж болон санал авах байрны зохион байгуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлж, шаардлагад нийцсэн эсэх, зөөврийн битүүжилсэн хайрцагар санал авах ажиллагаанд ажиглалт мониторинг хийв. Баянзүрх дүүрэгт- Д.Ундраа, Чингэлтэй дүүрэгт Б.Өлзийсайхан, Налайх, Багахангай, Багануур дүүрэгт Б.Ардак нар тус тус ажилласан. 3. Комисс, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хамтран "Технологи ашиглан үйлдэгдэж буй жөндөрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдал, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь" хэлэлцүүлгийг Азийн сангийн дэмжлэгтэйгээр 2024 оны 10 дугаар сарын 10-ний өдөр зохион байгууллаа. 4.ХЭҮК-ын дарга Д.Сүнжид, Комиссын гишүүн Ж.Хунан, Х.Мөнхзул нар Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн Д.Ундраа Д.Мөнхтуяа, П.Цэвээн нартай 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр уулзаж, ХЭҮК, ХНХЯ-тай хамтран 2023 онд хийсэн хүүхдийн эрхийн хууль, журам, стандартын хэрэгжилтийн нээлттэй хяналт шалгалтын үр дүн, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, Төр, иргэний нийгмийн түншлэлийн хүрээ, хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. 5. Олон улсын Хүний эрхийн өдөр, Жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, "Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" ТББ хамтран Азийн сан, Австрали Улсын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр "Хүний эрхийн талаар ярилцъя" арга хэмжээг 2024 оны 12 сарын 09-ний өдөр зохион байгууллаа. 6. ХЭҮК-ын дарга, гишүүдтэй /2024.05.08/ уулзаж, Хүний эрхийн Дээд Комиссар Волкер Түркийн Монгол Улсад хийх айлчлалын үеэр хамтран зохион байгуулах үйл ажиллагаа, НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн Хүний эрхийн сургалт, судалгааны төвийг Монгол Улсад байгуулах ажлын явц, Комиссын Хүний эрх хамгаалагч болон Хувийн мэдээлэл хамгаалах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх асуудлаар харилцан мэдээлэл хуваалцаж, санал солилцсон юм.7. Комисс, "Эмнести интернэшнл" олон улсын байгууллагатай хамтарч олон улсын Ахмадын өдрийг утгаж, Ахмадын эрхийн конвенцын төслийн үзэл баримтлал, ач холбогдлыг таниулах зорилгоор "Ахмад настны эрх: Өнөөгийн байдал" сэдэвт дугуй ширээний уулзалт, хэлэлцүүлгийг өнөөдөр /2024.09.30/ зохион байгуулсан бөгөөд тусУулзалтад Б.Ардак, Б.Цэцэгсүрэн нар оролцож ярилцлага өгсөн. 8. Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн Б.Ардак 2024.10.03, Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн, "Цогц хөгжлийн үндэсний төв"-ийн Гүйцэтгэх захирал М.Энхбадрал, Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн Б.Чулуундолгор нар 2024.06.13-ны өдөр хэвлэлийн бага хуралд оролцож мэдээлэл өгөв. Түүнчлэн "Хүний эрхийг хангах үндэсний хоёрдугаар хөтөлбөр"-ийн төслийн хэлэлцүүлэг, Нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийн захиргааны байгууллагын удирдлагуудтай уулзаж, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг, хүүхэд болон ахмадын асрамжийн төв, сургалт, цэцэрлэг, дотуур байр, хормх ани болон бэрхшээлх байр, нэргийн ажиллагаа				
148	5.5.3. Хилийн чанадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, улс төрийн болон бусад эрхээ хэрэгжүүлэх, монгол хүүхэд эх хэлээрээ сурч боловсрох боломжийг бий болгосон эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	2021-2025	82.0, Улсын төсөв		2024 оны 12 дугаар сарын байдлаар Хилийн чанадад суугаа ДТГ-уудаас ирүүлсэн тайлан мэдээллээр дэлхийн 90 гаруй улсад Монгол Улсын 216 мянга орчим иргэн оршин сууж байгаагаас хууль ёсоор оршин суугаа 140 мянга орчим, 0-16 насны хүүхэд 20 мянга, оюутан 40 мянга гаруй байна. Иргэдэд мэдээ зөвлөмж түгээх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх, эрх ашиг нь хөндөгдсөн тохиолдолд дэмжлэг тусалцааг тухай бүр нь шуурхай үзүүлв. Мөн түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч болон УИХ-ын ээлжит сонгуульд хилийн чанадад оршин суугаа иргэдээс санал авах ажлыг Сонгуулийн ерөнхий хороотой хамтран 2021, 2024 онуудад тус тус зохион байгуулав. Цахим нотариатын системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, иргэдэд 44532 цахим үйлчилгээг хүргэв. Цахим апостиль системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. ГИХГ-ын Визийн бүртгэлийн нэгдсэн системд нэвтрэх эрх ДТГ-уудад олгуулах ажлыг гүйцэтгэв. Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН системийг нийт ДТГ-т нэвтрүүлэв. МУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх ХБҮЗ-тэй хамтран хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй Монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төвийн багш нарын заах арга зүй, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх "Гадаад дахь монгол хэлний багш нарт зориулсан мэргэжил, арга зүйн цуврал сургалт"-нд 2022-2023 онд идэвхтэй хамрагдсан 44 багшид батламж олгов. Мөн "Гадаад дахь монгол хэлний багш нарт зориулсан мэргэжил, арга зүйн цуврал сургалт-3"-ын хүрээнд хуваарийн дагуу тайлангийн хугацаанд нийт 64 сургалт зохион байгуулав. Хилийн чанадад оршин суугаа 12 монгол иргэнийг төрийн одон, медальд нэр дэвшүүлж ЕТГ-т хүргүүлсэн. Хилийн чанадад оршин сууж буй "Алдарт эх" I, II дугаар зэргийн одонгийн болзол хангасан 105 иргэний асуудлыг шийдвэрлүүлэв.	ГХЯ	90	70.0	Тавьсан зорилгод эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд тайланд эрх зүйн орчинг бүрдүүлсэн талаарх мэдээлэл байхгүй.
149	5.5.4. Шүүх засаглалыг улс төр, бизнесийн бүлгийн ашиг сонирхлоос ангид, хараат бус байлгаж, шүүхийн үйл ажиллагаанд шударга ёсыг тогтоож, иргэдийн итгэлийг сэргээж ажиллана.	2021-2025	-					0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			52.5	
Авлигагүй засаглал									

Зорилт 5.6.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.									
150	5.6.1. Нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.	2021-2025			1.Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгасан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр баталсан. 2.Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үйлдлийг гэмт хэрэгт тооцох, бага насны хүүхдийн эсрэг үйлдэх зарим гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах гэмт хэргийн тусгай субъектэд оногдуулах ялын бодлогыг чангатгасан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. Сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих ажиллагаанд шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгосон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 25, Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолоор Засгийн газарт даалгасан асуудлын хүрээнд боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлагдаж, энэ оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. Мөн Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоолоор Засгийн газарт даалгасан асуудлын хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дахин боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Түүнчлэн, Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” батлагдсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 тоот албан даалгавартай холбоотойгоор Авлигын эсрэг багц хуулийн төслийг үзэл баримтлалын хэмжээнд Засгийн газрын хуралдаанд 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр танилцуулсан. Уг төслийн хүрээнд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай, Түр хураасан, хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулж, санал авахаар 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1868 дугаар албан бичгээр Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагуудааас санал авч, нэгтгэсэн. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулан 2025 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөн Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн төсөлд тусгасан.	ХЗДХЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон хууль батлагдсанаар гарсан үр дүн, нөлөөний талаар дурдаагүй
151	5.6.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял, шийтгэлийн бодлогыг чангатгана.	2021-2025	-		УИХ-аас 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг агуулгыг товчилбол, · Халдашгүй байдлыг нь баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон үеэс сэргээн тоолно. · Авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд аливаа хэлбэрээр өршөөл үзүүлэхгүй. · Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Ерөнхий сайд, сайд нар, Цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах болон эрх бүхий албан тушаалтан авлигын гэмт хэрэг үйлдсэн бол гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй. · Дээр дурьдсан албан тушаалтан авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасаж, 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. · Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт торгох ял оногдуулахгүй. · Үндэслэлгүйгээр хөрөнгөжсэн этгээдийн үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ	АТГ	100	100.0	
152	5.6.3. Төрийн бүх шатанд авлигыг таслан зогсоох хөтөлбөр хэрэгжүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.	2021-2025			Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” батлагдаж, 2024 оны 46 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” тус тус батлагдсан. Төрийн албаны зөвлөлөөс Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-2030 оны төлөвлөгөөнд 12 арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 10 арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна.	ТАЗ	100	90.0	төлөвлөгөөний 12 арга хэмжээнээс 10 нь 100 хувийн хэрэгжилттэй, 2 арга хэмжээ тодорхойгүй, арга хэмжээний хүрээнд
					Зорилтын хэрэгжилтийн хувь			93.3	
					Зорилгын хэрэгжилтийн хувь			80.83	
ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ									
Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.									
Эх байгаль анхдагч экосистем									
Зорилт 6.1.Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий газар нутгийг судалж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг үнэлнэ.									
153	6.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн нийт газар нутгийн 27 хувьд хүргэж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна.	2021-2025	-		Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн онцлог хэв шинж, унаган төрх, байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүй, экологийн хувьд онцгой ач холбогдол бүхий 14 газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл, холбогдох бичиг баримтыг боловсруулан Засгийн газрын гишүүдээс 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01/1598 дугаар албан бичгээр санал авч, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/2247 дугаар албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн Улсын тусгай хамгаалалтад авах чиглэлийг тус яаманд өгч, дурсгалт газрын ангилалыг дээшлүүлэн дархан цаазат газрын ангилалд хамруулахаар холбогдох судалгаа, үндэслэл, УИХ-ын тогтоолын төсөл болон холбогдох бичиг баримтуудыг бэлтгэн, 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж батлуулав. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь 21%-тай, Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбай 50%-тай байна.	БОУАӨЯ	30	30.0	Арга хэмжээний хүрээнд ажил эхэлсэн.
154	6.1.2. Монгол орны ургамал газарзүйн 4-өөс доошгүй тойргийн ашиглалтад өртөмтгий 200 зүйл ургамал, 10 зүйл амьтны тархац нөөцийг тогтоож, Олон улсын улаан дансны шалгуураар 600 зүйл амьтан, ургамлыг нарийвчлан үнэлж, ховордлын шалтгааныг тодорхойлно.	2021-2025	100.0, Улсын төсөв, 194.3, ОНТ, 150.0, ОУБ		Ургамал: Монгол орны төвийн бүсийн харь зүйл ургамал, амьтны судалгааг хийж Монгол оронд 50 зүйл (хачиг 5 зүйл, шавьж 27 зүйл, загас 13 зүйл, хөхтөн 5 зүйл) амьтан, 32 овог, 108 төрөлд хамаарах 153 харь зүйл ургамал бүртгэгдсэнээс Дархан уул, Сэлэнгэ, Төв аймгууд хамгийн олон харь зүйл ургамал бүртгэгдлээ. Судалгааны үр дүнд үндэслэн дараагийн арга хэмжээний ажлыг гүйцэтгэхээр “Биологийн олон янз байдлыг хамгаалах 2025-2030 оны үндэсний төлөвлөгөө”-ий 4 болон 18 дугаар зорилтуудад тусган төлөвлөсөн. 2022-2024 онд олон улсын улаан дансны үнэлгээгээр үнэлэж ховордлын зэргийг тогтоосон 1436 зүйл ургамлыг багтаасан Монгол орны ургамлын улаан данс 4 дүгээр цувралыг хэвлүүлсэн. АМБТАН: 1. Монгол орны идлэг шонхор шувууны тархац, нөөцийг тогтоох судалгааг хийх 100 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тендерт ШУА-ийн Биологийн хүрээлэн шалгарч, гэрээ байгуулан, ажлыг гүйцэтгэж, Амьтны мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн тайланг хүлээлгэн өгөв. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг Архангай аймаг 28.0, Говь-Алтай аймаг 52.0 сая, Булган аймаг 45.7, Увс аймаг 43.6 сая төгрөг буюу нийт 169.3 сая төгрөгөөр хийлгэж, аймгийн хэмжээний Аргаль, янгир, саарал чоно, халиун буга тарвага, зэрлэг гахай, бор гөрөөс зэрэг агнуурын амьтдын тархац, нөөцийг тогтоож, менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулав. Хяргас нуурын загасны нөөцийн судалгааг 25.0 сая төгрөгийн өртөгтэй хийж, загас барих бүсийг тогтоох, менежмент төлөвлөгөөг боловсруулан, судалгааны тайлан, үр дүнг яамны дэргэдэх Амьтны мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлав. Тархац нөөцийн судалгааг хийснээр жилд ашиглах амьтны нөөцийн тоо хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох боломж бүрдэж байна. Дэлхийн байгаль хамгаалах сан, Эншүре төсөлтэй хамтран хөхтөн, хоёр нутагтан, мөлхөгчид, загасны нийт 233 зүйл амьтны улаан дансны үнэлгээг хийлгэж, хамгааллын төлөвлөгөөг боловсруулж байна.	БОУАӨЯ	90	90.0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			60.0	
Байгалийн баялагийн үр өгөөж									
Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохимтой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдлыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно.									
155	6.2.1. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.	2021-2025	34.0, Улсын төсөв		"Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Говьсүмбэр аймагт 10 га талбайд байгалийн ургамал тарьж элсний ургамлан бүрхэвчийн талбайг нэмэгдүүлэх болон Булган аймагт 6 га талбайд элсний нүүлт сааруулах механик хаалт хийх ажлыг хүлээн авч, нийт 16 га талбайг хөрсийг хамгаалах зорилгоор элсний хамгаалалт, байгалийн ургамлын тариалалт хийсэн.	БОУАӨЯ	90	70.0	Хөтөлбөрийн хүрээнд хэдэн аймгийн хэдэн га талбайг нөхөн сэргээхээр тусгасан талаар тайланд тайлагнах. Тус арга хэмжээний хүрээнд 2 аймагт л ажил хийсэн үү?

164	6.4.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан үндэсний ногоон санхүүгийн корпорац (НСК) байгуулан ногоон эдийн засгийг дэмжих төсөл, хөтөлбөрийн санхүүгийн шинэ эх үүсвэрийг бүрдүүлнэ.	2021-2025	-		СЯ: Засгийн газар нь Нэгдсэн үндэсний байгууллагын Уур амьсгалын ногоон сан болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход болон эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн ногоон санхүүгийн эх үүсвэрийг улсын хэмжээнд нэгдсэн журмаар татан төвлөрүүлж, үүний дагуу банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан хөнгөлөлттэй ногоон зээл олгох чиг үүрэг бүхий "Монголын ногоон санхүүгийн корпораци"- ийг байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Ногоон санхүүгийн хүртээмжийн нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Засгийн газрын 2024.11.20-ны өдрийн 172 "Монголын ногоон санхүүгийн корпорацид хөрөнгө оруулах тухай" Засгийн газрын тогтоолын дагуу МУХБ-д 13 сая доллартой дүйцэх хэмжээний санхүүжилтийг төсөвт эргэж төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна. БОУАӨЯ: Монгол Улсад үндэсний хэмжээний ногоон санхүүжилтийн тогтолцоог бий болгож, Парисын хэлэлцээрт тусгагдсан үндэсний зорилтот хувь нэмрийг хэрэгжүүлэн, тогтвортой, ногоон ирээдүйг бий болгоход санхүүжилтээр дамжуулан дэмжлэг үзүүлэхээр БОУАӨЯ, НҮБ-ын Уур амьсгалын ногоон сантай 2017 оноос хамтран ажиллаж ирсэн. Засгийн газрын шинэчилсэн бүтцийн дагуу Эдийн засгийн хөгжлийн яам уг асуудлыг хариуцаж байгаа бөгөөд Монголын ногоон санхүүгийн корпорацийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор тус корпорацийн дүрмийн санд 5 сая доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулах болон ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тогтоолын төслийг боловсруулсан. Уг асуудлыг Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 172 дугаар тогтоолоор батлуулж, тус корпорацийн үйл ажиллагааг эхлүүлэн зохион байгуулахаар Монгол Улсын Хөгжлийн банкинд даалгасан.	СЯ 100, БОУАӨЯ 90	100, 90	100.0	
165	6.4.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна.	2021-2025			Уур амьсгалын Үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө” батлуулсан. Төлөвлөгөөнд 8 салбарын 10 зорилт бүхий 99 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. "Монгол орны хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг сайжруулах нь" (АДАПТ) төслийг Ховд, Завхан, Сүхбаатар, Дорнод аймгуудад хэрэгжүүлж байна.	БОУАӨЯ	70	50.0	тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил
166	6.4.3. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшигын эрсдэлийг бууруулна.	2021-2025	396.4, Улсын төсөв		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цаг уурын автомат станц 25 иж бүрдлийг, ус судлалын автомат станц 17 иж бүрдлийг тус тус худалдан авч суурилуулан улсын сүлжээг өргөжүүлэн техник технологийн шинэчлэл хийсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Байгаль орчны яам, Байгаль орчны корпорцтай хамтран Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд агаарын чанарын хяналтын автомат харуул суурилуулах, чадавхыг бэхжүүлэх төслийг эхлүүлж, Сөүл хотноо 2024 оны 02 дугаар сарын 18-наас 25-ны өдрүүдэд Цаг уур, орчны шинжилгээний газар, түүний харьяа байгууллага Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори, орон нутгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв, Байгаль орчны шинжилгээний лабораторийн нийт 35 албан хаагчийг агаарын чанарын хяналт-мониторингийн чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалтад хамруулсан. Төслийн хүрээнд багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийг БНСУ-д зарлаж, тендэрт шалгарсан "Кентек" компани 2024 оны 11 дүгээр сарын 5-наас 12-ны өдрүүдэд Дархан-Уул, Орхон, Завхан, Увс, Хөвсгөл, Хэнтий, Архангай аймгуудад ажиллаж, нөхцөл байдалтай танилцсан. Дээрх 7 аймгийн агаарын чанарыг тодорхойлох багаж, тоног төхөөрөмжийг 2025 оны 1-2 дугаар улиралд суурилуулж дуусахаар гэрээ байгуулагдсан. Ойн болон хээрийн түймэр, цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг тухай бүрт оруулсан ба нийт 50 гаруй мэдээллийг яамны цахим хуудас, хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллага, 8 телевизээр түгээж ажиллав. Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх мэдээний онч 1.7 хувиар нэмэгдсэн.	БОУАӨЯ	90	90.0	
167	6.4.4. Хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	2021-2025	-		НЗДТГ: 2024 оны хүйтний улирлын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад РМ2.5 тоосонцор 2020 оны 12 дугаар сард 105 мкг/м3 байсан бол 2024 онд 44 мкг/м3 болсон нь 156 мкг/м3-ээр буюу 41.9%-иар буурсан байна. - РМ10 тоосонцор 2020 оны 12 дугаар сард 132 мкг/м3 байсан бол 2024 онд 112 мкг/м3 болсон нь 20 мкг/м3-ээр буюу 84.8%-аар буурсан байна. - Хүхэрлэг хий SO2: Агаар бохирдуулах бодисын дундаж агууламж нь 2020 оны 12 дугаар сард 211 мкг/м2 байсан бөгөөд 2024 онд 55 мкг/м2 болсон нь 156 мкг/м3-ээр буюу 26%-аар буурсан байна. БОУАӨЯ: Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хоёр жил тутмын ил тод байдлын анхдугаар тайланг боловсруулж байна. Уг тайлангийн хоёрдугаар бүлэгт Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын урьдчилсан дүнгээр эрчим хүчний салбарын зорилт 16 хувь, зам тээвэр 13 хувь, аж үйлдвэр 20 хувь, хөдөө аж ахуйн салбарын зорилт 9 хувьтай тус тус хэрэгжсэн байна.	НЗДТГ 100, БОУАӨЯ 50	100, 50	50.0	Журмын 6.2.2.3-р үнэлэв.
168	6.4.5. Засгийн газрын ногоон худалдан авалтын зэлэх хувийг нэмэгдүүлж, 20 хувьд хүргэнэ.	2021-2025			ТХААГ: Барилга, байгууламжийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод тус тус заасны дагуу ашиглалтын зардал хэмнэсэн, ногоон барилгын шаардлага, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байх заалтыг үнэлгээнд харгалзан үзэж байна. СЯ: Тогтвортой худалдан авах ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд эхний үе шатанд ногоон худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай жишиг техникийн тодорхойлолтыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийтлэг худалдан авдаг бараа бүтээгдэхүүнийг тодорхойлж, олон улсын туршлага болон Монгол улсын зах зээлээс худалдах авах боломж зэргийг харгалзан нийт 11 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журам, заавар, жишиг баримт бичигт нийцүүлэн боловсруулж, “Аргачлал батлах тухай” Сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 66 дугаар тушаалаар батлуулж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт Сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 01/1907 тоот албан бичгээр холбогдох мэдээллийг хүргүүлсэн.	ТХААГ 70, СЯ 100	70, 100	50.0	Журмын 6.2.2.3, 6.2.2.1-р үнэлэв.
169	6.4.6. Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ 27 хувьд хүрнэ.	2021-2025			НЗДТГ: Нийслэлийн хэмжээнд хаягдал картон цаас, бүх төрлийн хуванцар, хаягдал төмөр, хөнгөн цагаан, гялгар уут дахин боловсруулах 39 үйлдвэр үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр үйлдвэрүүд 2024 оны байдлаар нийт хог хаягдлын 9 хувийг дахин боловсруулж эдийн засгийн эргэлтэд оруулсан. Анхны төлөвлөлтөөр дахин боловсруулалтын хэмжээг 27 хувьд хүргэх зорилт тавьж байсан бөгөөд хувийн хэвшлийн дахин боловсруулах үйлдвэрүүд ажиллах хүчний хомсдол, бараа бүтээгдэхүүний борлуулалт, төрөөс дэмжих тодорхой бодлого байхгүйн улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй тул үйлдвэрүүд ашиглалтад тооцоолж байснааср ашиглалтад орох боломжгүй байна. Иймд зорилтод түвшинд хүрээгүй байна. БОУАӨЯ: Хатуу хог хаягдлын нийт хэмжээ 2020 онд 2712.7 мянган тонн, 2021 онд 2626.7 мянган тонн, 2022 онд 3067.9 мянган тонн, 2023 онд 3042.9 мянган тонн болж нэмэгдэж байна. 2020-2023 оны дунджаар хатуу хог хаягдлын 39.5 хувийг эдийн засгийн салбарууд, 60.4 хувийг айл өрх үүсгэсэн бол 0.1 хувийг импортоор оруулсан байна. Дахин ашигласан, боловсруулсан хог хаягдлын бүтцийг хог хаягдлын төрлөөр авч үзвэл 2020-2023 онд дунджаар цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 22.2 хувь, метал бүтээгдэхүүний хаягдал 15.6 хувь, хуванцар бүтээгдэхүүний хаягдал 15.5 хувь, автомашины эд ангийн хаягдал 14.9 хувь, шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал 8.2 хувь, хүнс, био массын төрлийн хаягдал 6.2 хувь, барилгын хог хаягдал 4.7 хувь, цахилгаан барааны болон бусад хог хаягдал 12.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт хаягдлын 196.3 тн буюу 23.8 хувийг дахин боловсруулж эдийн засгийн эргэлтэд оруулсан.	НЗДТГ:60, БОУАӨЯ 70	60, 70	30.0	Зорилтот түвшингийн 30 хувьд хүрсэн.
170	6.4.7. Аймгийн төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	2021-2025	1,200.0, Улсын төсөв		Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн Зарим сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг дарж булах, нүүлгэн шилжүүлэх” А/740 дүгээр тушаалыг батлуулж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд Булган аймгийн 13 сум, Хөвсгөл аймгийн 7 сумын төвлөрсөн хогийн цэгийн нийт 36052 тонн хог хаягдлын цэвэрлэгээ хийгдсэн. Усны энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд орсон зориулалтын бус хогийн цэгийг 9 сав газар, 15 аймгийг хамарсан голын дагуух хог хаягдлыг цэвэрлэх судалгаа, зурган мэдээллийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр гаргаж, судалгаанд үндэслэн нийт 10 аймгийн 26 сумын нутаг дэвсгэрт Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд орсон зориулалтын бус төвлөрсөн 145.45 га талбайг хамарсан хогийн цэгийн цэвэрлэж, нийт 80200 тонн орчим хог хаягдлыг цэвэрлэх, түрж булах, ажлыг зохион байгуулан ажилласан. Ядуурлыг бууруулах япон сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилттэй "аймгуудын төвийн хатуу хог ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН 09206-MON ТӨСӨЛТ"-ийг Барилга, хот байгуулалтын яамтай хамтран хэрэгжүүлсэн. Уг төсөл нь Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай, Сүхбаатар аймгийн төвүүдэд амжилттай хэрэгжиж дууссан. Эдгээр 4 аймгийн төвд нийт 117000 тонн хүртэл хатуу хог хаягдлыг үйлдвэрлэх бөгөөд нэмэлтээр аймгийн төвүүдэд 14,868 тонн хатуу хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд шилжүүлнэ. Говь-Алтай, Сүхбааатр аймгуудын төвд хатуу хог хаягдлын хяналттай шинэ төвлөрсөн цэг барьсан.	БОУАӨЯ	70	70.0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			62.9	
					Зорилгын хэрэгжилтийн хувь			70.2	
ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ									
Зорилго 7. Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчн аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.									
Зэвсэгт хүчин									
Зорилт 7.1. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.									
171	7.1.1. Мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, алба хаагчдын амьдрах нөхцөл шинэчлэгдэж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.	2021-2025	4.7, Холимог эх үүсвэр		Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг шинэчлэн Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хувь хэмжээг бусад Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай ижил түвшинд хүргэж, тус нэмэгдлийг тухайн алба хаагчийн албан тушаалын үндсэн цалингийн 25 хувиар тооцож, сар бүр олгох зохицуулалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэсэн. Цэргийн албаны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр Батлан хамгаалах салбарт 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14, Зэвсэгт хүчний Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 9 төсөл арга хэмжээ хэрэгжүүлснээс улсын комисс ажилласан-18, хэрэгжиж буй-5 төсөл арга хэмжээ байна. Улсын төсвийн урсгал зардлаар 16 нэгтгэл, ангийн 28 цэргийн байранд засвар үйлчилгээг хийж, хугацаат цэргийн алба хаагчдын орчин нөхцөлийг сайжруулсан байна. Бусад тайлан Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул албан бичгээр тайланг хүргүүлсэн болно.	БХЯ	90	70.0	

172	7.1.2. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.	2021-2025	4, Холимог эх үүсвэр		Төрийн захиргааны төв байгууллагууд, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөний боловсруулалтад ашиглах зөвлөмж, аргачилсан зааврын 2024 оны нууц албан бичгээр яамд, аймаг, нийслэлд хүргүүлсэн.Мөн 2024 онд Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг хянаж, санал дүгнэлт гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2024 оны нууц албан бичгээр хүргүүлээд байна. "Зэвсэгт хүчний Жанжин штабыг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах төлөвлөгөө"-г Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаар 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр батлуулснаар цэргийн дайчилгааны төлөвлөлт бүрэн шинэчлэгдэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 16.1.1, 17.1.3 дахь заалт, БХС-ын Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 4.1-т заалтыг үндэслэн Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн "Хээрийн дадлага" сургалтыг Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Сэлэнгэ, Ховд, Хэнтий, Дорноговь аймаг, Нийслэлийн Баянзүрх, Налайх дүүрэгт дүүргүүдэд Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн "Хээрийн дадлага" сургалтыг зохион байгуулагдаж 13 аймгийн 84 сумын 93 томилгоот нэгжийн 1300 гаруй бэлтгэл үүрэгтэн, нийслэлийн Баянзүрх, Налайх дүүргийн 6 томилгоот нэгжийн 80 гаруй бэлтгэл үүрэгтэн хамрагдсан. Бусад тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул албан бичгээр хүргүүлсэн болно.	БХЯ	90	70.0	
173	7.1.3. Энхийг дэмжих ажиллагаа болон улс орны стратегийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлнэ.	2021-2025	-		2024 оны жилийн эцсийн байдлаар энхийг дэмжих 8 ажиллагаа / UNFICYP ажиллагаанд штабын офицер 3, ахлагч 1, MINURSO ажиллагаанд цэргийн ажиглагч офицер 4, UNISFA ажиллагаанд штабын офицер 1, цэргийн ажиглагч офицер 2, MONUSCO ажиллагаанд цэргийн ажиглагч офицер 1, MINUSCA ажиллагаанд штабын офицер 4, БНӨСҮ-д явагдаж байгаа UNMISS ажиллагаанд 800 гаруй хүнтэй мотобуудлагын батальон, штабын офицер 13, штабын ахлагч 1, цэргийн ажиглагч офицер 9, UNIFIL ажиллагаанд эмнэлгийн бүлгийн 4 нийт 900-аад цэргийн алба хаагч ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байна. Улс орны стратегийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2024 оны ТГ/360 дугаартай зөвшөөрөл, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/171 дүгээр тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2024 оны 303 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний 341, 342 дугаар ангиудын Бутлуурын үйлдвэр, бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт байрлах "Хан-Алтай" төслийн ажлын талбайд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс шилжүүлэн байрлуулж, хүдэр бутлах ажилд үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2024 оны ТГ/360 дугаартай зөвшөөрөл, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/171 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн хүн хүч, техник хэрэгслийг Говь-Алтай аймгийн Төгрөг сумын нутагт байрлах "Цэрдийн тал" ХХК-ийн нүүрсний уурхайн хөрс хуулалт, олборлох ажилд үүрэг гүйцэтгэж байна. Бусад тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул албан бичгээр хүргүүлсэн болно.	БХЯ	100	90.0	
174	7.1.4. Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэн, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, Зэвсэгт хүчний зэвсэглэл,	2021-2025	9,455.3, ЗХХС		Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул албан бичгээр хүргүүлсэн болно.	БХЯ	70	50.0	имжүүлэх шаардлагатай
					Зорилтын хэрэгжилтийн хувь			70.0	

Дархан хил									
Зорилт 7.2.Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ.									
175	7.2.1.Хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг боловсронгуй болгоно.	2021-2025	-		Монгол, Оросын улсын хилийг хамтран шалгах комиссын хоёрдугаар хуралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 28-наас 30-ны хооронд Улаанбаатар хотод зохион байгуулж, монголын талын ажлын хэсгийн ажлын хуваарийг боловсруулсан. Хилийн 1607 баганыг боржин чулуун баганаар шинэчлэх, улсын хилийн 839 км ойн огтолсон зурвас сэргээх талаар судалгаа гаргаж, Монгол Улсын ХХЕГ, ОХУ-ын ХАБА-ны Хилийн алба хооронд 2021-2024 онд хамтран ажиллах хөтөлбөрийг шинэчлэн баталсан. "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т нэмэлт, өөрчлөлт оруулсан БНХАУ-ын Улсын цагаачлалын удирдах газартай "Хилийн боомтын хууль сахиулах хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулсан. Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах Монголын талын хэсгийн дарга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарын хамтарсан "Хээрийн ажлыг зохион байгуулах тухай" 2023 оны мн/05/мн/02 дугаар тушаалыг батлуулж, ажлын хэсгүүдийн 2023 онд хийх ажлын график төлөвлөгөөг гарган бүрэн хэрэгжүүлж ажилласан. Монгол, Оросын улсын хилийг хамтран шалгах комиссын III, IV хуралдаанд оролцож, хилийн инженерийн төхөөрөмжийн талаар санал солилцон ажлын дүнг гаргасан. 2024 онд Хил залгаа улсын хилийн төлөөлөгч (бүрэн эрхт)-ийн бүрэлдэхүүнтэй хилийн шугамын дагуу хамтарсан шалгалтыг 199 удаа зохион байгуулсан.	ХЗДХЯ	100	100.0	
176	7.2.2. Хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, бүс нутгийн онцлогт тохирсон хил хамгаалалтын арга тактик шинэчлэгдэнэ.	2021-2025			Хилийн анги шинээр анги байгуулах (Хөвсгөл, Цагаан-Уул сум) ажлын төсөв 2024 онд 3,482.0 сая төгрөгийн санхүүжилт авч, барилга угсралт (штаб /спорт заал, соёлын төв/, цэргийн байр, эмнэлэг, зочид буудал, уурын зуух)-ын ажлын гүйцэтгэл дууссан. Эрэнцавын шалган нэвтрүүлэх заставын өргөтгөл, хилийн анги шинээр байгуулах ажил (Дорнод, Чулуунхороот сум)-ын барилга угсралт (штаб, цэргийн байр, тавиулан, уурын зуух, эмнэлэг, зочид буудал, агуулах)-ын ажлын гүйцэтгэл дууссан. Хилийн цэргийн ангийн 36 айлын орон сууцны барилгын 1, 2, 3 давхрын бетон цутгалт, ханын өрлөг, гадна шугам сүлжээний сувгийн ажил хийгдсэн.	ХЗДХЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй,
177	7.2.3. Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдла дээшилнэ.	2021-2025			"Төрийн болон хууль сахиулах байгууллагуудын радио холбоог шинэчлэх" төслийн хүрээнд АНУ-ын Засгийн газар болон "Моторола" компанитай төслийн I шат (Улаанбаатар хүрээний радио холбооны дэд бүтцийг байгуулах)-ны гэрээг 2023 оны 12 дугаар сард байгуулсан. -Дорноговь аймгийн Эрдэнэ сум дахь хилийн цэргийн 0129 дүгээр ангид тоон радио релейн системийг ажиллагаанд оруулж, хилийн салбаруудыг ангийн төвтэй 200-300 мегабайт хүртэл хурдаар түрээсийн сувгийн зардал шаардахгүй өөрийн бие даасан сүлжээг байгуулан, хариуцсан хэсгийн камерын хяналтыг ангийн шуурхай удирдлагын төвийн 24 цагийн хяналтад шилжүүлсэн. Хөдөлгөөнт хяналтын бүлгийн "ЗИЛ-131" загварын 2, "Ниссан Навара" загварын 4 автомашиныг мэдээллийн технологийн техник хэрэгслээр тоноглогосон. - Бүгд Найрамдах Франц Улсын "Атермес" компанитай хилийн боомтыг дохиолол, хяналт хамгаалалтын нэгдсэн системд шилжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хилийн цэргийн 0245 дугаар ангийн "Хүдэ"-ийн заставын хариуцсан хэсэг болон "Боршоо" боомтод 52 км шилэн кабелийн дохиоллын систем, 12 иж бүрэн хяналтын камер суурилуулах ажлын гэрээг "Бодь-электроникс" ХХК-тай байгуулан гүйцэтгүүлж, улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлэв. -Хилийн цэргийн 22 ангийн хариуцсан хэсэгт радио релейн дэд бүтцийг байгуулах суурь судалгааг хийж, тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааг хээрийн байрлалд туршиж, үр дүнг баталгаажуулсан -Хилийн цэргийн 14 ангийн хариуцсан хэсэгт нийт 5430 километр радио релейн дэд бүтцийг байгуулах ажлын хүрээнд бетон шон, цамхаг (антенн), нарны дэлгэц суурилуулах ажил, Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг, Сүхбаатар боомт (хилийн цэргийн 0101, 0243 дугаар ангийн Тавт, Номт, Бүргэдэй Уул, Хутаг өндөр салбарын хариуцсан хэсэг)-д 72.5 километр газар мэдрэгчтэй, шилэн кабелийн дохиоллын системээр төхөөрөмжлөх ажил тус тус хийгдсэн.	ХЗДХЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, хөрөнгө оруулалтын ажил хийгдснээр гарсан үр дүнг дурдаагүй
178	7.2.4. Гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025			"Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)" системийг нэвтрүүлэх ажлыг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын "Тоног төхөөрөмж" багцаас 470.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан. Цахим хөгжил, иноваци, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" (ISF) системтэй холбож, 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс холбон үйлчилгээ үзүүлж эхэлсэн. "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд нийт 636 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулснаар визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, гадаадын иргэний хаягийн бүртгэл, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийн талаар 47174 хүсэлтийг тус тус хүлээн авч, хянан шийдвэрлэлээ. Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг "ЗҮ-03: Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гадаадын иргэн, харьяатын байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн. Засгийн газрын 2022 оны 228-р тогтоол (Хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай)-ын 3.1 дэх заалт "Олон улсын хилийн боомтод хүний биеийн давхцахгүй өгөгдлийг таних цахим гарц, зорчигч өөрийгөө бүртгүүлэх төхөөрөмжийг нэвтрүүлж, хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг боловсронгуй, шуурхай болгох"-ыг хэрэгжүүлж, хилийн Замын-Үүд боомтын орох, гарах чиглэлд нийт 10 ширхэг Герман улсад үйлдвэрлэсэн цахим гарц, зорчигч өөрийгөө бүртгүүлэх төхөөрөмжийг суурилуулсан.	ХЗДХЯ	100	90.0	Хүний биеийн давхцахгүй өгөгдлийг таних цахим гарц, зорчигч өөрийгөө бүртгүүлэх төхөөрөмжийг бусад боомтод байршуулсан эсэх тодорхойгүй, арга хэмжээ үргэлжилж байгаа
					Зорилтын хэрэгжилтийн хувь			92.5	

Хүн, нийгмийн амар тайван байдал

Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

179	7.3.1. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.	2021-2025	-		"Дэлхийн кибер гэмт хэрэгтэй тэмцэх стратеги, кибер гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах байгууллагыг бэхжүүлэх", "E learning course", "Train the Trainer for Computer Forensics", "Тоон ул мөр бэхжүүлэх, шинжлэх" "Sumuri" программ хангамжийн ашиглалт, тоон ул мөр бэхжүүлэх, "Reverse Engineering 101", "Ил эх сурвалж ашиглан гүйцэтгэх ажлын мэдээлэл цуглуулах нь", Үндэстэн дамнасан хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөх, тоон ул мөр бэхжүүлэх, мэдээлэл солилцох" сэдэвт сургалтад 44 алба хаагчийг хамруулсан . Монгол Улсын Засгийн газар Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаменттай хамтран хэрэгжүүлж буй "Хүүхэд хамгаалал түншлэлийн компакт гэрээ", Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран "Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанд "Хүүхдэд ээлтэй өрөө"-г байгуулж, "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдэвт чадавхжуулах сургалтад 305 алба хаагчийг хамруулж, Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн Монголын мэдээ сувгийн "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөрт "Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" чиглэлээр 2 цуврал сурвалжлага бэлтгэж, олон нийтэд түгээн,Гадаад харилцааны яамны Консулын газар, Тагнуулын ерөнхий газар, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагуудтай хамтран хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон нийт 10 иргэнд сэтгэл зүйн, эрүүл мэнд болон хууль зүйн туслалцааг үзүүлсэн. Улсын хэмжээнд 2024 онд бүртгэгдсэн хүн худалдаалах 11 гэмт хэргээс 8 гэмт хэргийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, үлдэгдэл 3 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулж, гэмт хэргийн илрүүлэлт 72.6 хувьтай байна. Гадаад улсад үйлдэгдсэн буюу үндэстэн дамнасан гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.	ХЗДХЯ	100	70.0	Гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн эсэх тодорхойгүй, инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлсэн талаар тайлан дусгагдагүй.
180	7.3.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	2021-2025	-		Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2023 онд 94, 2024 онд 96.7 хувьтай тус тус үнэлэгдсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 252 гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгаснаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 191, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 49, нийт 240 гомдол мэдээллийг шалгаж шийдвэрлэн, 12 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Хүлээн авч, шалгасан гомдол, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 нэгжээр буюу 5.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хэрэг бүртгэлтийн 342 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 187, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн 47, нийт 234 хэргийг шийдвэрлэн, ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 108 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэг 25 нэгжээр буюу 7.8, шийдвэрлэлт 1.4 хувиар тус тус өссөн.Мөрдөн байцаалтын 222 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас шүүхэд шилжүүлэх саналтай 209 хэргийг шийдвэрлэж, ажиллагаанд 13 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэг 2 нэгжээр буюу 0.9, шүүхэд шилжүүлэх саналтай шийдвэрлэсэн хэрэг 17 нэгжээр буюу 8.8 хувиар тус тус өсч, түдгэлзүүлсэн хэрэггүй эерэг үзүүлэлттэй байна.Зөрчлийн шинжтэй 239 хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулснаас 172 хэрэгт 183 этгээдийг шүүхийн шийдвэрээр баривчлуулж, 24 иргэнийг 2.560.000 төгрөгөөр торгох, насанд хүрээгүй 11 иргэнийг сургалтад хамруулж, нийт 207 зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн байна.Бүртгэгдэн шалгасан хэргийн холбогдогчийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 нэгжээр буюу 5.0 хувиар өссөн байна.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэмцэх зорилгоор "Бүлэг-2024", "Фест-2024", "Туншил", "Тархцын хяналт", "Цахим нөлөөлөл", "Студент","Илэри" зэрэг 6 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, үр дүнг тоолсон.	ХЗДХЯ	100	90.0	Урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг бүрэн тайлагнаагүй,
181	7.3.3. Орон нутгийн гамшаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2025	5,902.7, Улсын төсөв		Монгол Улсын Засгийн газрын 2024 оны мн/231 тогтоолоор Нийслэлийн Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон, Ерөө сумын Бугант тосгон, Дорноговь аймгийн Хатанбулаг, Өмнөговь аймгийн Ханбогд суманд Гал түймэр унтраах, аврах анги, Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд Эрэн хайх, аврах салбар, Нийслэлийн Багануур, Налайх дүүрэг, Архангай аймгийн Эрдэнэмандал, Завхан аймгийн Отгон, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд Эрэн хайх, аврах бүлгийг тус тус шинээр байгуулсан. 2021-2024 онд нийт 28 салбар, нэгж шинээр байгуулсан ба 2021 онтой харьцуулбал гал түймэр унтраах ангийн тоог 7 буюу 9.9 хувиар, эрэн хайх аврах нэгж /анги, салбар, бүлэг/-ийн тоог 6 буюу 12.5 хувиар нэмэгдсэн байна.	ОБЕГ	100	90.0	
182	7.3.4. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна.	2021-2025			Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулах" төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг 139.2 сая төгрөгөөр 2023 онд шинэчлэн боловсруулсан. Мөн 1300 п/м салбар төмөр замын төсөв, ажлын зураг төслийг 16.6 сая.төгрөгөөр, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 13.2 сая.төгрөгөөр гадна цахилгаан хангамжийн зураг төслийг 16.0 сая.төгрөгөөр боловсруулсан. Мөн газар эзэмших гэрчилгээ, газрын байршлын кадастрын зураг, иргэн хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээ хийгдэж, дулаан болон цахилгаан, барилгын инженер геологийн техникийн нөхцөлүүдийг 2022-2023 онд тус тус шинэчлэн холбогдох зөвшөөрлийг авсан. Түүнчлэн агуулахын зураг, төслийг 2024 онд магадлалаар /10.0 сая.төгрөг/ оруулаад байна. Иж бүрэн механикжуулсан махны зоорь, хүнсний агуулах байгуулах" төсөл хэрэгжүүлэхээр ажлын хүрээнд агуулахын газар эзэмших гэрчилгээ, газрын байршлын кадастрын зураг, иргэн хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээг хийсэн, мөн агуулахын зураг төсвийг шинэчилж, агуулахын техник-эдийн засгийн үндэслэлийг 150.0 сая төгрөгөөр шинэчлэн боловсруулсан. Мөн дулаан, цахилгаан, барилгын инженер-геологийн техникийн нөхцөл болон холбогдох зөвшөөрлийг шинэчилсэн. Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн ЗГ-2/186 дугаар албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу "Улаанбаатар хотод 20.0 мянган тонн хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан агуулах барих төсөл", "20.0 мянган м3-ийн багтаамжтай газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулах төсөл"-үүдийн саналын мэдээллийг улсын төсвийн оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-д 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр бүртгүүлж оруулсан.	ОБЕГ	30	30.0	
183	7.3.5. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлж, архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	2021-2025			Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар "Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан байгуулах, сангийн үйл ажиллагааны журам батлагдаж, "Итгэл 2023" үргэлжлүүлэн зохион байгуулахад шаардлагатай 1.200.0 /нэг тэр бум хоёр зуун сая/, Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулахад шаардлагатай 240.0 /хоёр зуун дөчин сая/ төгрөгийг тус тус баталсан. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан 20 цагдаагийн байгууллага /Нийслэлийн 4 дүүрэг, 16 аймаг/-аас хөтөлбөр, төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэхтэй холбоотой 2.3 тэрбум төгрөг шийдвэрлүүлж, тайлант хугацаанд 62 төрийн болон төрийн бус байгууллага, АА нийгэмлэг, бүсийн оношилгооны төв, сэтгэц наркологиын тасагтай хамтран ажиллаж, сайн дурын эмчилгээнд 497, албадан эмчилгээнд 286 иргэнийг хамруулж, 356 удаа сургалт, зөвлөгөөнд 18640 иргэнийг хамруулж, архины хамгаалалттай иргэдэд чиглэсэн 5 өрөө, кабинетыг тохижуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын "Эрүүл Монгол хүн" хөдөлгөөн, Хууль зүй, Дотоод хэргийн яамны дэргэдэх Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сантай хамтран "Та татгалз" ерөнхий арга хэмжээг улсын хэмжээнд амжилттай зохион байгуулснаар 2023 онд улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 528 буюу 10.0 хувиар буурсан. Улсын хэмжээнд 2024 онд архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 6 тогтоол, 15 захирамж, 2 хөтөлбөр, бусад 21 шийдвэр гарч, 158.201.000 төгрөгийг зарцуулсан. Улсын хэмжээнд 2024 онд архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 6 тогтоол, 15 захирамж, 2 хөтөлбөр, бусад 21 шийдвэр гарч, 158.201.000 төгрөгийг зарцуулсан. Цагдаагийн байгууллагаас архидан согтуурахтай тэмцэх, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг арилгуулах зорилгоор иргэн, аж ахуй нэгж байгууллагад мэдэгдэл 742, шаардлага 566 хүргүүлснээс 905 хариуг авч, тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй, хариу ирүүлээгүй 121 аж ахуй нэгж, 57 иргэнийг нийт 232.950.000 төгрөгөөр торгож, иргэдийн аюулгүй амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гудамж талбайд удаа дараалан архидан согтуурч бусдын амгалан тайван байдал алдагдуулдаг тэнэмэл байдлаар амьдардаг давхардсан тоогоор нийт 956 хүнийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулж, 615 хүнийг төрийн болон төрийн бус байгууллага, ар гэрийнхэнд хүлээлгэн өгч, 341 хүнийг Иргэний хэргийн анхан шатны шүүхээр оруулж, архины албадан эмчилгээнд хамруулсан. Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар телевизэд 28 удаа, сайтад 42 удаа, радиод 35 удаа, сонинд 3 удаа тус тус мэдээлэл, ярилцлага өгч, 2232 жолооч, ажилтан нарт сургалт зохион байгуулж, 981 ширхэг сурталчилгааны материалыг тарааж, нийслэлийн хэмжээнд 9 байршилд лед дэлгэцээр видео контентуудыг байршуулж, цахим орчинд 9 видео шторк, 11 зурагт хуудас, 5 видео контент, 3 рийл, нийт 47 мэдээлэл байршуулсныг нь 8.791 хүн дэмжиж, 22.266 удаа бусадтай хуваалцаж, 12.783 хүнд таалагдаж, 1.049.250 хүнд хүрсэн байна.	ХЗДХЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.

184	7.3.6. Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.	2021-2025	82.0, Улсын төсөв	ХЗДХЯ: Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/316, 2023 оны А/308 дугаар тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс байгуулж, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий 13 , тусгай чиглэлийн 689, соён гэгээрүүлэх чиглэлийн 760, сургалт, сурталчилгааны ажил 2350, уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөг 726 зохион байгуулж, 3861 аж ахуйн нэгжийн алба хаагч, ажилтан, оюутан сурагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч зэрэг 359722 иргэнийг хамруулсан. Иргэд олон нийтэд 347 төрлийн гарын авлага, 85984 зөвлөмж, сэрэмжлүүлэг тараасан. Төрийн болон хувийн 476 сургууль орчимд “Хүүхэд хамгаалагч” 133, “School police” 2024, “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийн 7140 сурагч, эцэг эхийг төсөл, хөтөлбөрт хамруулан тухай бүрд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 онд төрийн болон төрийн бус 38 байгууллагуудтай хамтран нийт 1 аян, 3 нэгдсэн арга хэмжээ, 2 өдөрлөг, 2 хэлэлцүүлэг, соён гэгээрүүлэх, нөлөөллийн 705 ажил, арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 7250 аж ахуйн нэгж, байгууллага, 590553 иргэн (оюутан 45607, сурагч 390656, сургууль завсардсан 3879 хүүхэд)-ийг тус тус хамруулж, цахим орчинд 1971 мэдээ, мэдээлэл байршуулсныг 45.682.188 хүн үзжээ. Улсын хэмжээнд “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” мэдээлэл сурталчилгааны аяныг зохион байгуулж, 25 телевиз, 68 сайт, 23 фм радиогоор 44 мэдээ сурвалжлага, 49 ярилцлага 171 ширхэг мэдээ, мэдээлэл, контентыг инстаграм, твиттер, фейсбүүкт оруулж, ухуулга нөлөөллийн 50.000 ширхэг зурагт зурагт хуудсыг тараан ажилласнаар аяны хугацаанд насанд хүрээгүй хүн холбогдсон 19, хохирсон 51 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9,5 хувь буурсан. Үргэлжлэлийг хавсралтаас үзнэ үү. ГБХНХЯ: Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан буюу etuslamj-ийг нэвтрүүлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг холбосон. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн хамгааллын үйлчилгээний e-tuslamj.mn мэдээллийн системийг “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн програм”, “Иргэд, олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөө өгөх, хэрэглэгчийн програм” гэсэн 2 үндсэн хэсэгтэйгээр хөгжүүлж 2023 оны 03 дугаар сар хүртэл ашигласан бөгөөд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэлтэй уялдуулж Хүүхэд хамгааллын компакт төслийн хүрээнд Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагатай хамтран Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн үйлчилгээний бүртгэл, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчлүүлэгчдийн бүртгэл гэсэн 2 модуль бүхий “Хохирогч иргэдийн мэдээллийн систем”-ийг хөгжүүлэлт хийж хэрэглээнд нэвтрүүлээд байна. Энэ хүрээнд “Нийслэл 7 дүүрэг, 21 аймгийн “Түр хамгаалах байр”, “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн 50 гаруй мэргэжилтэн, албан хаагч, нийгмийн ажилтнуудыг танхимаар болон цахимаар хамруулан 2024 оны 09 дүгээр сард “Хохирогч иргэдийн мэдээллийн систем”-ийн сургалтыг зохион байгуулж, түр хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн иргэдийн мэдээллийг системд бүртгэн, ажиллаж байна.	ХЗДХЯ, ГБХНХЯ	100, 100	90	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
				Зорилтын хэрэгжилтийн хувь			76.7	
Хууль сахиулах салбарын хөгжил								
Зорилт 7.4.Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ.								
185	7.4.1. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулна.	2021-2025		Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023.05.09-ний өдрийн А/66 дугаар захирамжаар 38 эмзэг цэг, нийтийн тээврийн 30 автобусны буудалд теле хяналтын камер суурилуулах, хяналт тавих, системийн программ хангамжийг шинэчлэх, нэгдсэн сүлжээнд холбох ажилд 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг батлуулсан. “Теле камерын хяналтын нэгдсэн төв”, “Дэд төв” байгуулах болон камержуулахад шаардагдах 117.5 тэрбум (нийслэлд 87.9, орон нутагт 29.6) төгрөгийн зардлыг аймаг, дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоол, захирамжаар 2024 оны төсөвт тусган батлуулсан. Нийслэл, дүүргийн хэмжээнд гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны хяналтын камеруудыг нэгтгэн зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий “Теле камерын хяналтын нэгдсэн төв”-ийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд, “Теле камерын хяналтын дэд төв”-үүдийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд тус тус байгуулахаар шийдвэрлэж, нийслэлийн автозамын 176 уулзварыг бүрэн камержуулах ажлыг “Бодь-Электроникс” ХХК гүйцэтгэж, нийслэлийн 8 дүүрэг, Орон нутагт Архангай, Орхон, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Төв, Увс, Сэлэнгэ, Баян-Өлгий зэрэг 9 аймагт “Теле камерын хяналтын дэд төв”-ийг байгуулсан. Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий аймагт “Теле камерын хяналтын дэд төв”-ийн засвар болон тоног төхөөрөмж шилжүүлэх, угсралтын ажил хийгдэж байна.	ХЗДХЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
186	7.4.2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөлийг дээшлүүлнэ.	2021-2025	-	Цагдаагийн байгууллагаас 2024 оны эхний 11 сарын байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгасан гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан 1251.5 тэрбум төгрөгийн хохирлын 723 тэрбум төгрөг буюу 57.8 хувийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар 12 иргэнд 157.200.082 төгрөгийг, 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн А/02 дугаар тушаалаар 13 иргэнд 226.831.507 төгрөгийг тус тус олгож, төрөөс олгосон нөхөн төлбөрийг эргэн төвлөрүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар нийт 3.2 тэрбум төгрөг биелүүлэхээс нийт 1.3 тэрбум төгрөгийг барагдуулан, 2024 оны жилийн эцсийн байдлаар 155.8 сая төгрөгийг сангийн дансанд буцаан төвлөрүүлжээ. Гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол төлбөртэй 1575 хоригдлоос давхардсан тоогоор 1534 хоригдлыг цалинтай ажлын байраар хангаж 381,747,046 төгрөгийн цалин олгосон байна. Хоригдлын гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах, хохирогчийг эрхийг хамгаалах, хоригдлыг хугацаанаас өмнө суллах нөхцөлийг бүрдүүлэх болон тэдний ар гэрээс хохирол, төлбөр төлөх эрмэлзсэнийг бий болгох зорилгоор “Хохирлоо төлөөд гэртээ харья” 90 хоногийн аяныг зохион байгуулж, үр дүнг тооцсон.	ХЗДХЯ	100	90.0	Нийт хохирол барагдуулалтын хувь, аяны үр дүн тодорхойгүй,
187	7.4.3. Шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлнэ.	2021-2025	-	“Шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлнэ.” гэсэн арга хэмжээний хүрээнд БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний чадамжийг сайжруулах төсөл”-ийг амжилттай хэрэгжүүлэн ДНХ-ийн шинжилгээний лаборатори, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх химийн шинжилгээний лаборатори, дижитал, бичиг судлалын лабораториудын техник тоног төхөөрөмжийг шинэчлэн, өрөө тасалгааг засварласан. Мөн ДНХ, Хими, Дижитал, Бичиг баримтын шинжилгээний лабораториудын 19 шинжээчийг БНСУ-ын Үндэсний шүүх шинжилгээний байгууллагад 45 хоногийн хугацаатай сургалтад хамруулж, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж, сургалт зохион байгуулсан бөгөөд олон улсын стандартад нийцсэн, сүүлийн үеийн дэвшилт техник, технологи бүхий тус шинжилгээний лабораториудыг хүлээн авах нээлтийн арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Шүүх шинжилгээний ерөнхий газрын төв байранд зохион байгуулсан. Төслийн хүрээнд шинээр суурилуулсан тоног төхөөрөмж, БНСУ-ын сургагч багш нарын сургалтын үр дүнд Монгол Улсад хийгдэх боломжгүй байсан ахуйн хэрэглээний хийн найрлага тодорхойлох шинжилгээ болон биоматериалаас ахуйн хэрэглээний хийг /газ/ илрүүлэх шинжилгээ болон шинээр бүртгэгдэж буй мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис тодорхойлох шинжилгээг Химийн шинжилгээний лабораторид хийх бүрэн боломжтой болсон. Мөн Хүний биений яс, шүднээс геномын ДНХ ялган авч, харьцуулах шинжилгээг ДНХ-ийн шинжилгээний лабораторид хийж, дүгнэлт гаргаж эхэлсэн.Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газрын агентлаг Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан (ЭЗХХАС)-г төлөөлж, Экспорт-Импорт Банк хоорондын “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)”-ийн 18,735,000 ам.долларын зээлийн гэрээг 2021 онд байгуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/162 (А/143) дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулж Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж, БНСУ-ын “Аум энд Лий Архитектур энд Ассецацн” ХХК шалгарч, 2023 оны 6 дугаар сарын 26-ны өдөр зөвлөх үйлчилгээ үзүүлэх 3,212,000 ам.долларын гэрээ байгуулсан. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу 2023 оны 7 дугаар сарын 04-ний өдөр төслийн зөвлөх “Аум энд Лий Архитектур энд Ассецацн” ХХК-д 642,400 ам.долларыг санхүүжүүлсэн. Төсөл хэрэгжих газрын дулаан, ус суваг, цахилгаан, мэдээлэл сүлжээний техникийн нөхцөлийг Ус сувгийн удирдах газар, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-аас авч, инженер геологийн судалгаа хийлгэхэд шаардагдах 11,745,000 төгрөгийн санхүүжилтийг Сангийн сайдын багцаас санхүүжүүлж, “Монгео Экотех” ХХК-аас инженер геологийн дүгнэлт гаргасан. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, Өлзийтийн авто замаас төсөл хэрэгжих талбай хүртэлх 1300 метр авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврыг нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, төсөл хэрэгжих газрын орц гарцын гүүрэн гарц, авто зам байгуулах төсөв 2,735,200,000 төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулсан.	ХЗДХЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, хөрөнгө оруулалтын ажлын үр дүнгийн талаар дурдаагүй,
188	7.4.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно.	2021-2025	-	“Фатф”-аас гаргасан зөвлөмжийн 15-д заасны дагуу Виртиуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсн хуралдаанаар хэлэлцүүлж, хуулийн төслийг хэлэлцэн баталсан. Тус хуулийн төсөл батлагдсанаар Фатф-ын 15 дугаар зөвлөмж биелэх боломж бүрдсэн. Түүнчлэн “Фатф”-аас гаргасан зөвлөмжийн 8-д заасны дагуу боловсруулсан Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг төслийг боловсруулан, 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан ба цагдаагийн байгууллагаас “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг улирал бүрийн дараа сарын 20-ны өдрийн дотор Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэн ажилласан. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн гишүүнээр 1, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүнээр 2, дэд ажлын хэсэгт 4, виртуал хөрөнгийн эрсдэлийг үнэлэх ажлын хэсэгт 2 алба хаагч ажиллаж, чиг үүргийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийж гүйцэтгэсэн ажлын мэдээллийг тухай бүр гарган хүргүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн хурал 7 удаа зохион байгуулагдаж, цагдаагийн байгууллагаас мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн.	ХЗДХЯ	100	90.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг дурдаагүй,
189	7.4.5. Мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.□	2021-2025	-	Улсын хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар мал хулгайлах 377 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 192 нэгжээр буюу 33.7 хувиар буурсан. Нийт гэмт хэргийн 24 буюу 6.3 хувийг нийслэлд, 353 буюу 93.4 хувийг орон нутагт тус тус эзэлж байна. Бүртгэгдсэн мал хулгайлах 377 гэмт хэргээс 166 хэргийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан илрүүлэлт 46.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах зорилгоор 2 тусгай арга хэмжээ (“Хянамгай байя”, “Тор”) байгуулж, 7 бүлгийн 28 этгээдийг дайчлан баривчилж 77 хэргийг илрүүлсэн байна.	ХЗДХЯ	100	100.0	Өссөн дүнгээр тайлагнаагүй

190	7.4.6. Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2021-2025	-		Хууль зүйн туслалцааны тухай хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Уг хуулийн хүрээнд эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтнаас гадна эрүүгийн хуулийн тодорхой зүйл ангид хамаарах төлбөрийн чадваргүй хохирогч, арван найман нас хүрээгүй хүүхэд, зорилтот бүлгийн иргэд буюу ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд төлбөрийн чадвартай эсэхээс үл хамааран хууль зүйн туслалцаа үзүүлж байна. Мөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн төлбөрийн чадваргүй тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн. Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийн хүрээнд 2024 онд 2649 эрүүгийн хэрэгт холбогдсон 2579 холбогдогч /сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан/-д, эрүүгийн хэргийн 155 хохирогч, 11 гэрчид, Захиргааны хэргийн 2 оролцогчид, Иргэний хэргийн 60 нэхэмжлэгчид, Зөрчлийн хэргийн 117 оролцогчид өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн. Хууль зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд 2024 онд нийт 11031 хүнд Иргэний эрх зүйн маргаантай зөвлөгөө мэдээллийг 2154, Эрүүгийн эрх зүйн маргаантай 7868, Зөрчлийн хэргийн маргаантай холбоотой 612, захиргааны эрх зүйн маргаантай холбоотой 397 хүнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн 2711 хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулж ажилласан. Хууль зүйн туслалцааны төвийн захирал, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгчийн 2024.01.16-ны өдрийн А/03, А/15 дугаар хамтарсан тушаалаар "Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг хууль зүйн тусалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах журам", Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж гарах нийт 20 дүрэм журмын төслийг боловсруулан 18 журмыг батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	ХЗДХЯ	100	100.0	
191	7.4.7. Хууль сахиулах байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ.	2021-2025	-		Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяат агентлаг, байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2024 оны 3 дугаар улирлын тайлан, мэдээгээр салбарын хэмжээнд нийт 31826 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд шийдвэрлэлт 97.4% байна. Тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 834, Цагдаагийн ерөнхий газар 10835, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 3218, Хил хамгаалах ерөнхий газар 7309, Улсын бүртгэлийн ерөнхий газар 2748, Архивын ерөнхий газар 1331, Гадаадын иргэн, харьяатын газар 729, Шүүх шинжилгээний ерөнхий газар 603 гэх мэт. Үүнээс 11- 11 төвөөс Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжлан ирсэн 252, Цагдаагийн ерөнхий газар 4030, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 989, Хил хамгаалах ерөнхий газар 106, Шүүх шинжилгээний ерөнхий газарт 5 гомдол, санал хүсэлт ирсэн байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас төрийн цахим үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор иргэн, төрийг холбосон "Үндэсний цахим шуудан"-ийн (www.mail.e-mongolia) системд хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээний нэгдсэн "e-mongolia" системтэй цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагыг бүрэн холбосон. Иргэн, хуулийн этгээдээс "Үндэсний цахим шуудан"-д холбогдсон алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад нийт 139 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн. Гадаадын иргэн, харьяатын газар Хууль зүй, дотоод хэргийн салбарын архив, албан хэрэг хөтлөлтийн "edoc" программыг нэвтрүүлсэнтэй холбогдуулан төв, орон нутаг дахь нэгжийн нийт 258 албан хаагчийг системд бүртгэн уг системийн "Өргөдөл" цэсийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн ашиглаж, шийдвэрлэлтийг хянаж байна.	ХЗДХЯ	100	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			92.9	
Мэдээллийн аюулгүй байдал									
Зорилт 7.5.Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ.									
192	7.5.1. Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2025	-		Кибер аюулгүй байдлын тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг судлан үйл ажиллагаандаа мөрдөж байна . Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны А/366, 2014 оны А/571, 2015 оны Б/251, 2017 оны А/23, 2018 оны А/152, 2020 оны А/223, 2022 оны А/205, А/206, 2023 оны А/308 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй газрыг өргөтгөн байгуулсан. Гар утаснаас тоон үл мөр илрүүлэх, шинжлэх "Mobile device extractor tool Hancorn WITH-MD-NEXT" программ, Фейсбүүк орчинд залилах гэмт хэрэг илрүүлэх, үйлдэгдэж байгаа арга барилыг судлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор тест XML орчин угсарч Bogsport сайт дээр фишинг сайтын домайн нэршил авах, гэмт хэрэгт ашиглагдсан дансны хуулгын мэдээллийг нэгтгэн сан үүсгэж дүн шинжилгээ хийх, хоорондоо хамаарал бүхий хэргүүдийг ашиглагдсан дансны хуулга дээр дүн шинжилгээ хийж нэгтгэх JobAnalyse программ хангамжийн кодын бичилтийг хийн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд тусгай дугаарын 102 утсанд ирүүлсэн Кибер гэмт хэрэгтэй холбоотой дуудлага, мэдээллийг 24 цагаар 1040 тусгай дугаарт хүлээн авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн харьяа дүүргийн прокурорын газрын хяналтын прокурорт танилцуулж "Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах тухай" прокурорын зөвшөөрлийг 24 цагийн дотор гаргуулан мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна. Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2012 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/16 дугаартай тушаалаар батлагдсан "Генетик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах тухай" журмын дагуу Шүүх шинжилгээний ерөнхий газарт 2012 оноос хойш цуглуулж хадгалагдаж байгаа ял эдэлж байсан, өршөөлөөр суллагдсан, захиргааны хяналт тогтоосон, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, тэнэмэл байдлаар амьдардаг нийт 17,128 иргэнээс авсан биологийн дээж (завжны арчдас)-ийг санд оруулах урвалж бодис, тоног төхөөрөмжийн зардал 6,3 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хуралдаар нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн.	ХЗДХЯ	100	90.00	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
193	7.5.2. Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдэж, технологийн хараат байдал буурч, кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавх дээшилсэн байна.	2021-2025			1.Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулахад үндэсний компанийн боловсруулсан програм хангамжийг түлхүү ашиглах, төсөвт зардлыг хэмнэх зайлшгүй шаардлагыг харгалзан "Мэдээллийн технологийн программ хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 311 дүгээр тогтоолыг батлуулсан. Төрийн программ хангамжийн худалдан авах үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах, үргүй зардлыг бууруулах зорилгоор "Үндэсний программ хангамжийн их дэлгүүр" /Mindgolia/ системийг 2022 оны 12 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн ба 2024 онд 254 компанийн 133 төрлийн 487 бүтээгдэхүүн байршиж байна. Нийтлэгдэхээр хүлээгдэж буй 146 бүтээгдэхүүн байна. 2.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор "Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв" Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлуулж, Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр бүртгүүлж, улсын бүртгэлийн 9068001076 дугаартай гэрчилгээ олгосон. Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан нийт 11 захиргааны акт батлуулахаас 2024 оны жилийн эцсийн байдлаар 11-ийг батлуулсан. Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийг байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв"-д шаардлагатай программ хангамж, тоног төхөөрөмж худалдан авах ажлын даалгаврыг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна. Япон Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ын Зүүн ба Төв Азийн Хамтын Ажиллагааны Төвийн зүгээс Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвд буцалтгүй тусламжаар программ хангамж, техник хангамж авахаар техникийн даалгавар боловсруулан хүсэлт хүргүүлсэн.	ЦХИХХЯ	90	90.0	Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн.Журмын 6.2.2.1-р үнэлэв.
					Файл 10			90.0	
					Зорилгын хэрэгжилтийн хувь			84.4	
НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ									
Зорилго 8. Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.									
Дэд бүтэц									
Зорилт 8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.									
194	8.1.1. Өрнө-Дорнын бүсийн орнуудыг холбох дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн авто зам болон хойд, урд хөршийг холбох зарим бүсийн босоо тэнхлэгийн авто замыг барьж худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2025		2, Гадаадын зээл тусламж	1. АН-3 чиглэлийн авто замд Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 1026.6 км авто зам Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.2 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил дуусч байнгын ашиглалтад хүлээн авсан. Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын барилгын ажил 95%-тай, 1-р багцын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан, 2, 3, 4-р багцын ажилд Улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангуулж байна. 2. АН-4 буюу Новосибирск-Барнаул- Горно-Алтайск-Ташанта-Улаан байшинт-Ховд- Ярантай-Такешкен-Өрөмч- Каши-Хонкираф чиглэлийн авто замын сүлжээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр нийт 756 км авто замыг дайран өнгөрдөг. "Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн 2 дахь шатны төслийн хүрээнд Ховд-Өлгий-Улаанбаишинт чиглэлийн 189.7 км авто замын барилгын ажлыг 4 багц хэсгээр зохион байгуулан хэрэгжүүлж, 2018-2022 онд ашиглалтад оруулсан. Азийн авто замын АН-4 сүлжээний Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто зам, төмөрбетон 201.08 урт метр гүүрийг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр улсын байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллаж, байнгын ашиглалтад хүлээн авч хөдөлгөөн нээсэн.□	ЗТЯ	100	100.00	
195	8.1.2. Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр зам, авто замуудыг барьж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зам, тээврийн дэд бүтцийг өргөжүүлнэ.	2021-2025		2, Шууд хөрөнгө оруулалт	Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлүүдийн төмөр замын холболтын төсөл: Өмнөговь аймгийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замыг барих төсөл: Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар тушаалаар байгуулагдсан Комисс 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдөр ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан. Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барих төсөл: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 125 дугаар тушаалаар байгуулагдсан Улсын комисс 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан. 2. Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын төсөл: Зам, тээврийн ТНБД-ын 2024 оны А/212 тушаалаар "Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын дээд, доод бүтэц, хиймэл байгууламжийг хүлээн авах ажлын хэсэг"-ийг байгуулж 2024 оны 11 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд ажилласан. Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын 2024.12.19-ний өдрийн 138 дугаар тушаалаар байгуулагдсан комисс 2024.12.23-нд байнгын ашиглалтад хүлээж авсан. 3.Тавантолгойн орд газрын Ханги боомттой холбох 477 км тусгай зориулалтын авто замын төсөл: Засгийн газрын 2019 оны 238 дугаар тогтоолын дагуу Үндэсний хөгжлийн газраас "Тахилт хайрхан транс" ХХК-тай концессын гэрээг байгуулсан бөгөөд 2020.01.22-ны өдөр гэрээ хүчин төгөлдөр болсон. Зам барилгын ажлыг 2020.04.15-ны өдөр эхлүүлсэн. Ажлын явц 99.3 хувьтай байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай автозам 2024 оны зам барилгын ажлыг 4 дүгээр сарын 10-ны өдөр эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 71 хувьтай байна. ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэсэн. □	ЗТЯ	90	90.0	

196	8.1.3. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээ, үндэсний тээвэр логиcтикийн тогтолцоог хөгжүүлнэ.	2021-2025	-		Байгаль ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр ЗТХС, 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай 2021, 2022, 2023, 2024 онд хамтран ажиллах гэрээнд тусгасан. Цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 2024-2026 онд хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг ЗТХС, Сангийн сайд, БОАЖС, Эрчим хүчний сайдаар батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг 21 аймгийн Засаг дарга, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд уг арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайд, 21 аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээнд цахилгаанаар ажилладаг автомашиныг цэнэглэх станц 1-ээс доошгүй байгуулж ашиглах заалтыг тусган хэрэгжилтийг хангуулж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар цахилгаан тээврийн цэнэглэх станц 27-р нэмэгдэж, 70 цэнэглэх байгууламжийн 110 цэнэглэгчээр нэг дор цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх боломж бүрдээд байна. Автотээврийн хэрэгслийг хийгээр цэнэглэх станц 21 аймагт 80, Улаанбаатар хотод 54-ийг үйлчилгээнд ашиглаж байна. Олон улс улсын чанартай авто замын дагуу зогсоол байгуулах дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх зогсоолын байршлыг нарийвчлан тогтоож, хийгдэх ажлыг тодорхойлох ажлаар 2022 оны 5 дугаар сард газар дээр нь ажилласан. Тогтоосон байршил хийгдэх ажлын дагуу олон улс, улсын чанартай авто замын дагуу 2022 онд 15 цэгт амрах талбай барих, 4 цэгт зогсоол тохижуулах тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/188 дугаартай тушаал гарсан. Тушаалын дагуу нийт 15 байршилд зогсоол барих, 4 байршилд зогсоол тохижуулах ажил хийгдсэн. Тээвэр логиcтикийн сүлжээг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлуудыг 4.2.1 дээр тайлагнасан. □	ЗТЯ	90	90.0	
197	8.1.4. Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аймгууд, аюулын эрсдэл өндөртэй зарим сумдад үе шаттайгаар байгуулна.	2021-2025	1,050.0 ам.доллар, Буцалтгүй тусламж		ОБЕГ: Онцгой байдлын ерөнхий газраас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2020-2022 онд “Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь” техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд “Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх зээлийн төсөл”-ийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн ерөнхий загвар, төслийн удирдлагын гарын авлага, техникийн тодорхойлолтууд болон холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулж, Азийн хөгжлийн банкны захирлуудын зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлсэн. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн системийг улсын хэмжээнд байгуулах зорилгоор “Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь” зээлийн төслийг Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2022-2023 оны зээлийн төлөвлөгөөний санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалт батлах тухай Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 323/а дугаар тогтоолоор баталсан. Тус төслийг эхлүүлэх, Азийн хөгжлийн банктай байгуулах тусгайлсан хэлэлцээрийг хийх хүсэлтийг Монгол Улсын шадар сайдын 2024 оны ЗГ-3/251 дугаар албан бичгээр Сангийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яаманд уламжилсан бөгөөд Эдийн засгийн хөгжлийн яамны 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 02/944 дугаар албан бичгээр тус төсөл нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцэж байгаа тул Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэхийг дэмжсэн. БОУАӨЯ: Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Өвөрхангай, Хэнтий, Дорноговь аймгуудад цаг уурын радарын станц байгуулахаар тусгуулсан. Цаг агаарын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээгээр үйлчлэх ажлыг Завхан, Сүхбаатар аймгуудад туршиж эхлүүлсэн.	ОБЕГ 30, БОУАӨЯ 30	30	30.0	
198	8.1.5. Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.	2021-2025	-		ЭЗХЯ: ЭЗХЯамны эрхлэх асуудлаас шилжсэн. ХББОСЯ: 1.Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ШУТТЗ-ийн хурлаар 2023.12.08-ны өдөр, Сайдын зөвлөлийн 2024.11.13-ны өдөр тус тус хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд 2024.05.15-ны 0649/2024 дугаартай экспертизийн дүгнэлт гарсан. Уг зураг төслийн баримт бичгийг Засгийн газраар хэлэлцүүлэн батлуулахаар 2024.11.05-ны өдрийн 01/1198 дугаартай албан бичгээр тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал аван, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. 2. Хоёр улсын Засгийн газрын хооронд байгуулсан “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай” хэлэлцээрийн ажлын хүрээнд Монголын талаас ЭЗХЯ-ны ХОБГ-ын дарга Б.Анараар ахлуулсан баг, БНХАУ-ын талаас ӨМӨЗО-ны Худалдааны танхимын орлогч дарга Гую Жөүминаар ахлуулсан ажлын хэсэг хамтран 2024.04.08-10-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Замын-Үүдийн чөлөөт бүс, БНХАУ-ын Эрэн хотын чөлөөт бүсэд ажилласан. “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төсөлд өгөх санал боловсруулж тус яамны 2024 оны 03/1250 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд ерөнхий төлөвлөгөө боловсруулах үнийн тооцооллын хамт хүргүүлсэн. 3.“Цагаандэл-Уул” боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг тус яамны дэргэдэх ШУТТЗ-ийн хурлаар 2024.09.25-ны өдөр хэлэлцүүлж, зөвлөлөөс өгөгдсөн зөвлөмжийн дагуу Инженерийн байгууламж, шугам сүлжээний инженерийн орон тооны бүс мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. 4. Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтуудад “Барилгын материалын импортын хангамж байгуулах” тухай ЭЗХЯ дээр танилцуулан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 3.6.23-т “Замын-Үүд хотын эдийн засгийн чөлөөт бүсэд барилгын материал, түүхий эдийн импортын хангамж, логиcтикийн төвийг байгуулна.” гэж тусгуулсан. Уг асуудлыг “Боомтын сэргэлтийн үндэсний хороо”-ны хурлаар хэлэлцүүлэхээр тус хороонд 2024.09.04-ний өдрийн 03/426 тоот албан бичгээр хүргүүлсэн.	ЭЗХЯ, ХББОСЯ 70	70	70.0	
199	8.1.6. Орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулж, үйл ажиллагааг өргөжүүлж, агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	2021-2025	056.0 Холимог эх үүсвэр		Ховд аймгийн “Ховд”, Хөвсгөл аймгийн “Мөрөн”, Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлын хүчин чадлыг 4С, Өмнөговь аймгийн “Турвансайхан” нисэх буудлын хүчин чадлыг 4D ангиллын болгон нэмэгдүүлэх төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, Засгийн газрын 2023 оны 253-р тогтоолоор төслийг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэлтээр оруулсан. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл “Түншлэлийн төсөлд тавих шаардлага”-ын 18.2.1-т “Төслийн төсөв, санхүүгийн үнэлгээ, урьдчилсан болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байх” тухай шаардлагын дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд саналаа хүргүүлсэн. “Ховд”, “Дэглий цагаан”, “Мөрөн” нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэн 4С ангиллын нисэх буудал болгох ТЗЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн батлагдсан хөрөнгөөр 2024 оны 11 сарын 15-д сонгон шалгаруулалт зарласан, үнэлгээ хийж байна. ЗТЯ-аас орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын дагуу нисэх буудлуудыг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх тогтоолын төслийг боловсруулж Монгол Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр, Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон. “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх төлөвлөгөө”-г Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга 2024 оны 08 дугаар сарын 20-ний өдөр баталсан. Тус төлөвлөгөөний 2024 онд хэрэгжүүлэх ажил 93.3%-тай хэрэгжиж байна.□	ЗТЯ	50	50.0	
200	8.1.7. Инновац, дэвшилтэт техник технологи, дижитал шилжилтийг зам, тээврийн салбарт нэвтрүүлж, ухаалаг тээврийн нэгдсэн тогтолцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2021-2025	90.0, Улсын төсөв		Цахим засаглалын эрх зүйн орчинг сайжруулах зорилтын хүрээнд: - Авто тээврийн дүрэмд “Салбарын мэдээллийн нэгдсэн сан”-тай холбоотой нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан. - Сангийн сайдын тушаалаар НӨАТ-ын буцаан олголтын журамд “Авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг И-Баримтаар дамжуулан автоматаар суутган тооцох авах” талаар нэмэлт, өөрчлөлт оруулсан. - “Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох”, “Техникийн хяналтын үзлэг явуулах” журмуудад авто замын төлбөр төлөлтийг зохицуулах заалтыг нэмэлтээр оруулж батлуулсан. - RFID шошго суурилуулах зааварчилгаа, түр журам, RFID “ISO18000-6C” олон улсын стандартыг хэрэглэж батлуулсан. - Зам, тээврийн салбарын статистик мэдээлэл боловсруулах, платформыг ажиллуулах, мэдээллийн систем хооронд мэдээлэл солилцох журмыг батлуулсан. - Нийслэл Улаанбаатар хотод автотээврийн хэрэгслийн дугаар бүртгэх шалгуур үзүүлэлтэд санал тусгасан. - Хөдөлмөрийн дотоод журманд цахим шилжилт, цаг бүртгэл зэргийг тусгасан ба албан хэрэг хөтөлөлтийн журамд цаасгүй технологи, тоон гарын үсэг зэрэг зохицуулалтыг мөн тусгаж батлуулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 тушаалаар “Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр” (цаашид “Дэд хөтөлбөр” гэх)-ийг баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2023 оныг “Бүрэн цахимжсан, бүтээмжийг дээдэлж, хариуцлага, үр дүнг тооцох жил” болгон зарлан 2023 онд 93 үйлчилгээг цахимжуулсан бол 2024 онд үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн мэдээллийн нэгдсэн цонх “E-Mongolia”-оор дамжуулан 31, яам, харьяа байгууллагуудаас иргэд олон нийтэд мэдээллийн системээр дамжуулан 23, яам, харьяа байгууллагуудаас дотооддоо цахимаар 30 үйлчилгээг үзүүлж байна. Дэлгэрэнгүй тайланг хавсаргав	ЗТЯ	100	90.0	Тайлагнал хангалтгүй зам тээврийн салбарт ямар үйлчилгээг цахимжуулсан талаар дэлгэрүүлэх
201	8.1.8. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжинд алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.	2021-2025	-		ЭЗХЯ: ЭЗХЯамны эрхлэх асуудлаас шилжсэн. ХББОСЯ: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд ХАНСХЕТ-ийг боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, тооцоо, төлөвлөлтийн шийдлүүдийг харилцан уялдуулах зорилгоор 2024.04.22-ны 02/1381 тоот албан бичгээр холбогдох саналыг ЭЗХЯ-нд хүргүүлсний дагуу “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” УИХ-ын 2024.06.05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор батлагдсан. “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Зээлийн ерөнхий хэлэлцээр 2023 оны 07 дугаар сард УИХ-аар соёрхон батлагдсан ба 1-р үе шатны төслийн зээлийн тусгайлсан хэлэлцээрүүд МУЗГ болон АХБ хооронд 2024.01.11-ны өдөр байгуулагдан төсөл хэрэгжиж эхэлсэн. Төслийг хэрэгжүүлэх нэгж ЭЗХЯ-ны харьяа 2024 оны 6 сард бүрэн байгуулагдаж бүрдсэн бөгөөд үндсэн хэрэгжилтийг хариуцан ажиллаж байна. Уг хөтөлбөрийн 1-р үе шатны төсөл Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудад хэрэгжиж бөгөөд одоогоор төслийн хүрээнд “Төслийн хэрэгжилт болон менежмент, бодлогын зөвлөх үйлчилгээ”-ний ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж, олон улсын нээлттэй тендерийн сонгон шалгаруулалт зохион байгуулж байна. Барилгын ажлыг 2026 оноос эхлэн үе шаттайгаар эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	ЭЗХЯ, ХББОСЯ 100	100	100.0	
202	8.1.9. Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн, Чандмань, Дөргөн, Дарви, Хөшөөтийн чиглэлийн 160 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлнэ.	2021-2025	-		Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн сумдыг холбох авто замын барилгын ажлыг АХБ-ны “Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэсэн. А0305 дугаартай улсын чанартай авто замаас Ховд сум хүртэлх 18.755 км хатуу хучилттай авто зам, А0305 дугаартай улсын чанартай авто замаас Эрдэнэбүрэн сум хүртэлх 19.776 км хатуу хучилттай авто замын бүрэн дуусч байнгын ашиглалтад хүлээн авсан. - Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн хавсралтад тусган шийдвэрлэсэн. Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх хатуу хучилттай 56.9 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгч “Хотгор зам” ХХК-ийн барилгын ажлын явц 90.8%-тай хийгдэж, 2024 оны авто замын барилга угсралтын ажил зогссон. - Хөшөөтийн уурхай нь Ховд аймгийн Цэцэг сумтай хатуу хучилттай авто замаар холбогдсон. - Ховд аймгийн Дарви сум нь Алтай-Ховд чиглэлийн А0304 дугаар бүхий улсын чанартай авто замын дагуу байрлаж байгаа ба хатуу хучилттай авто замаар холбогдсон.□	ЗТЯ	100	90.0	

203	8.1.10. Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2025	11,736, Улсын төсөв		ЭЗХЯ: Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн эзэлийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаан, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулж, дэмжигдсэн. Улсын Их Хурлаар соёрхон батлуулахаар Засгийн газраас 2023 оны 7 сарын 6-ны өдөр өргөн барьсан. 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн УИХ-аар "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг баталсан. Тус хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих инженерийн дэд бүтэц, тээвэр логистикийн төвийг байгуулах, хөдөө аж ахуйн салбарт оруулах ногоон санхүүжилтийг дэмжиж (тухайлбал: ногоон зээл, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл), хөдөө аж ахуйн менежментийг сайжруулан, түүнийг хянах тогтолцоог бүрдүүлнэ. Дээрх төлөвлөж буй арга хэмжээг Архангай, Булган, Дорнод, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Ховд, Увс, Хөвсгөл, Говь-Алтай, Баян-Өлгий, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Дорноговь аймгийн 52 суманд хэрэгжүүлнэ. Төслийн удирдах хороог байгуулсан. Мөн "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд тус хөтөлбөрийн I дүгээр үе шатыг хэрэгжүүлэх Монгол Улс, Европын хөрөнгө оруулалтын банк хоорондын Санхүүгийн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Сангийн сайд Б.Жавхланд олгосон. Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан, Европын хөрөнгө оруулалтын банкны зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд 628 сая амд.долларын санхүүжилт бүхий "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн төслийг хэрэгжүүлж байна. ХББӨСЯ: "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл арга хэмжээг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 161 дүгээр тогтоолоор батлуулсан. 1. Өвөрхангай, Хужирт сумын трассын дагуу сувгийн ухлага хийгдэж, лотки болон шугамын угсралтыг гүйцэтгэн сувгийг таглаж булах ажил дуусгасан. Мөн нийт 23 худагны цутгалтын ажил хийгдэж дууссан. Бух18-20 худгийн ухлага болон шугам угсралт дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Улсын комисс ажиллаж хүлээн авсан.100 хувь 2. Төв, Борнуур сумын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажил дуусч, улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. 100 хувь 3. Төв аймгийн Дэлгэрхаан сумын инженерийн шугам сүлжээний ажлаас гадна ариутгах татуурга, гадна цахилгаан хангамжийн шугамын ажил дуусч улсын комисс ажиллаж хүлээн авсан. 100 хувь 4. Төв аймгийн Сэргэлэн сумын инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэн улсын комисс ажиллаж хүлээн авсан. 100 хувь 5.Төв аймгийн Эрдэнэ сумын инженерийн шугам сүлжээний 2024 оны ажлыг гүйцэтгэн инженерийн шугам сүлжээний ажлыг улсын комисс ажилласан байна. 100 хувь 6. Төв аймгийн Баянчандмань сумын цэвэр усны эх үүсвэрийн 1150 м шугам хоолойн угсралтын ажил дууссан. Цэвэр усны 2 худгийн ажлыг гүйцэтгэсэн. 2 ширхэг усан сангийн ажил 90 хувьтай, нийт гүйцэтгэл 90 хувь байна. Хугацаандаа хэрэгжиж байна. 7. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын төвийн гадна ариутгах татуургын PVC-U Ф160-200мм-ийн 2152 метр, "Аварга тосон" рашаан сувиллын газрын гадна ариутгах татуургын PVC-U Ф160-Ф200мм 3030 метр 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын 3,757 метр шугам, 100кВА-ын дэд өртөөний ажил, "Аварга тосон" рашаан сувиллын газрын 50м3/хон хүчин чадалтай бохир усны цооногийн ажлыг гүйцэтгэж дууссан. Сумын төвийн 100м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж гүйцэтгэн улсын комисс ажилласан. 100 хувь	ЭЗХЯ 70, ХББӨСЯ 90	70, 90	70.0	
204	8.1.11. Өвөрхангай аймгийн Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий чиглэлийн аялал жуулчлалын зам, Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол, Дундговь аймгийн Сайхан-Овоо, Өмнөговь аймгийн Цогт-Овоо чиглэлийн босоо тэнхлэгийн ачаа тээврийн замуудын зураг төслийг боловсруулан, барьж эхлүүлэх ба баруун бүсийн А0301, А0302 замын дагуух сумдыг улсын чанартай автозамтай үе шаттай холбох ажлын эхлүүлнэ.	2021-2025	-		Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт хүртлэх авто замын зураг төслийн ажлыг дуусгасан. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг бүрэн хийж дуусган улсын байнгын ашиглалтад хүлээн авсан. Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий чиглэлийн аялал жуулчлалын замын барилгын ажил 71%-тай.□	ЗТЯ	100	90.0	Хужирт-Бат-Өлзий чиглэлийн замын ажлын талаар дэлгэрүүлж тайлагнах
					Зорилтын хэрэгжилтийн хувь			79.09	
Аялал жуулчлал									
Зорилт 8.2.Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.									
205	8.2.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.	2021-2025	-		"MNS 4588:2008 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлагын стандартыг олон улсын стандарттай харьцуулан шинэчлэхээр зочид буудлуудын төлөөлөл бүхий 18 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж стандартын шинэчилсэн төслийг боловсруулсан. MNS 5927:2008 Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандартын төслийг 247 шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулсан. MNS 6043:2019 Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлагын стандартын төслийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, өрөө үйлчилгээ, утгах үйлчилгээ, хүний нөөцийн гэсэн чиглэлүүдээр баг бий болгон 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулахаас гадна дэн буудал, гэр буудал, жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын төлөөллийг хамруулж ажилласан. MNS 5738:2007 Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлагын стандартыг 15 зүйл, 126 шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулж, 4 удаа хэлэлцүүлсэн. БОАЖЯ, ТоС хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй "Ногоон аялал жуулчлал" хөтөлбөрийн хүрээнд танилцуулж, байгальд ээлтэй, үйлчилгээг жуулчдад хүргэх зөвлөмж боловсруулсан. 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдөр сүүлийн хэлэлцүүлгийг зохион байгуулж Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлээд байна."	ССАЖЗЯ	70	70.0	
206	8.2.2. "Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор" байгуулж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттай зохион байгуулж, түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	2021-2025	,633.1, Улсын төсөв		ССАЖЗЯ: 1. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Хэнтий аймаг дахь түүх, аялал жуулчлалын Их хуралдай, Хүлэг Баатар Боорчи-Андлалын өргөө", "Монголын нууц товчоо", Шихихутуг-Нууц товчоо" түүхэн аялал жуулчлалын цогцолбор, "Чингис хаан" аялал жуулчлалын цогцолбор зэрэг 5 цогцолборыг Чингис хаан Үндэсний музейд харьяалуулах санал гаргаснаар бүтцэд өөрчлөлт орох шаардлага үүссэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон "Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн" цогцолборын барилга, барилгын интерьер, дотоод уран сийлбэр шинэчлэл, гадна цахилгаан, барилгын коорийн ажил, гадна тохижилт, шугам сүлжээ зэрэг 7,8 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг тус музейд шилжүүлсэн. 2. Эзэн Богд Чингис хааны суу алдрыг гадаад болон дотоодод сурталчлах түтээн дэлгэрүүлэх зорилгоор "Чингис хаан: ХХI зууны энтертайнмент орчин" хэлэлцүүлгийг 2024 оны 12 сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэг нь "Чингис хаан: Түүх соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж" аялал жуулчлал, утгах үйлчилгээ, аяллын хөтөч; "Чингис хаан: Дижитал ертөнц ба энтертайнмент" дэлгэцийн урлаг, тайзны урлаг, дижитал контент, тоглоом хөгжүүлэлт гэх ерөнхий 2 агууллагын хүрээнд болж өндөрлөвөө. 3. "Түүхэн аялал жуулчлал-Чингис хаан" хөтөлбөрийн хүрээнд Чингис хааны өв соёлын хүрээлэнгийн хүрээлэнг ""Орхон-Тамирын голын бэлчир нутгийн түүхэн аялал жуулчлалын нөөц, боломж"", "ХIII зууны үеийн монгол адуу, адууны махны хэрэглээ" сэдвээр СЭЗИС-н Зочлох үйлчилгээ, аялал жуулчлалын ангийн 1, 2-р курсийн оюутнуудад 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав. ЗТЯ: Чингис хот Дадал чиглэлийн 50 км авто замын барилгын ажил 2022 онд дуусч 06/04/22 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан. 2024 онд Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн 52.5 км, Өндөрхаан-Норовлин чиглэлийн 68,6 км авто замын барилгын ажил дуусч байнгын ашиглалтад оруулсан. Өндөрхаан-Норовлин чиглэлийн 62 км авто зам, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км авто замын барилгын ажил үргэлжилж байна. Өмнөдэлгэр-Биндэр чиглэлийн 152 км замыг 7 багц болгон төндөр зарласан. Биндэр-Баян-Адарга-Дадал чиглэлийн 1,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй авто замын зураг төслийн тендерийг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс зарлан гүйцэтгэгчийг шалгаруулсан.□	ССАЖЗЯ, ЗТЯ	100, 100	70.0	1. Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн Журмын 6.2.2.1-р үнэлэв. 2.Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн. Журмын 6.2.2.2-р үнэлэв.
207	8.2.3. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хөвсгөл, Хэнтий, Архангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ.	2021-2025			Өөрсдөөс шалтгаалаагүй учир дундаж үнэлгээнд тооцоогүй болно. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээ боловч ТЭЗҮ, үзэл баримтлалын асуудал Байнгын хорооны хурлуудаар орж дэмжигдээгүй тул Азийн хөгжлийн банкнаас тус төслийг цаашид хэрэгжүүлэхгүй гэсэн шийдвэрийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 20/24 дугаартай албан бичгээр ирүүлсэн.	ССАЖЗЯ	0	-	Өөрсдөөс шалтгаалаагүй учир дундаж үнэлгээнд тооцоогүй болно. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээ боловч ТЭЗҮ, үзэл
					Зорилтын хэрэгжилтийн хувь			70.0	
Тогтвортой хөдөө аж ахуй									
Зорилт 8.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.									
208	8.3.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.	2021-2025	-		2024 онд 18.6 мянган га талбайд төмс тариалж 250.8 мянган тн, 17.2 мянган га–д хүнсний ногоо тариалж 267.3 мянган тн ургац хураан авч дотоодын үйлдвэрлэлээр 100 хувь хангалаа. Хүн амын хэрэгцээний нормыг дотоодын үйлдвэрлэлээр тооцвол байцааны хангамж 70 хувь, шар лууван 100 хувь, шар манжин 100, хүрэн манжин 100 хувь, сонгино,сармис 45 хувийг хангаж байна.Хүнсний ногооны таримлын бүтцийн хувьд нийт ургацын 18.3 хувь нь байцаа, 27.9 хувь нь шар лууван, 29.5 хувь нь шар манжин, 6,1 хувь нь хүрэн манжин, 8,6 хувь нь сонгино, 1 хувь нь сармис, 3,5 хувь нь хэмх, 0,5 хувь нь лооль, 4,5 хувийг бусад ногоо эзэлж байна. Нийслэлийн хүн амын 2024-2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан нийт 5100 тн махыг 6 аж ахуйн нэгж бэлтгэн нийлүүлэхээр шалгарсан бөгөөд нийт бэлтгэх махны 60%-ийг хонины мах, 40%-ийг үхрийн мах байхаар тооцож, үхрийн махны бэлтгэлийн үнийг 9400 төгрөгөөр, хонины махыг 8800 төгрөгөөр бэлтгэхээр тохиролцсон. Нөөцийн мах бэлтгэлийн санхүүжилтийг арилжааны банкны эх үүсвэрээр, нийт 18 хувийн хүүтэй олгох ба үүнээс 11%-ийг хүүгийн хөнгөлөлтийг нийслэлийн төсөвт тусган, 7%-ийг аж ахуйн нэгж төлөхөөр шийдвэрлэсэн ба өнөөдрийн байдлаар 3 аж ахуйн нэгж нийт 21.0 тэрбум төгрөгийн зээл авч, 2330 тн мах бэлтгэхээр ажиллаж байна. 2. Сүүний урамшуулал: 2024 онд нийт 8271 малчин, фермерт 13,7 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон бөгөөд сэрүүний улиралд 29.2 сая литр сүүг үйлдвэр, цехэд нийлүүлсэн байна.	ХХААХҮЯ	70	70.0	

209	8.3.2. Монгол малын махны ач тусыг олон улсад сурталчлан таниулж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	2021-2025	-		1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газрын 2021 оны 248 дугаар тушаалаар баталсан “Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын аж ахуйн нэгжийг бүртгэх захиргааны журам”-ын хүрээнд тус улсын Гаалийн ерөнхий газрын цахим системд адууны мах 4, дулааны аргаар боловсруулсан мах 9, самар 5, загас 1, сүүн бүтээгдэхүүн 1, нийт 20 аж ахуйн нэгжийг шинээр бүртгүүлж, Монгол Улсаас тус улсад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох эрхтэй аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж ажилласан. 2.МҮЕС Л.Оюун-эрдэнэ БНХАУ-д хэрэгжүүлсэн ажлын айлчлалын хүрээнд “Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад экспортлох тэжээлийн зориулалттай уураг болон өөх, тосны мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай Монгол Улсаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын протокол”-ыг харилцан тохиролцож, хамтран байгуулсан. 3.Монгол Улсын мал сүргийн өсөлт, 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, бэлчээрийн даацыг харгалзан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2024 оны “Монгол Улсын экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээний тухай” 2024/003 дугаар зөвлөмжийг гаргуулж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хонь, ямааны түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах, адууны түүхий маханд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. Монгол Улс 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 63.8 мянган тонн (түүхий маханд шилжүүлснээр 87.1 мянган тн) мах, махан бүтээгдэхүүнийг 257.8 сая ам доллароор экспортолсон байна. 4. БНХАУ-д адууны дайвар бүтээгдэхүүн, дулааны аргаар боловсруулсан дотор мах, дайвар бүтээгдэхүүн экспортлохтой холбогдсон хяналт, хорио цээр, мал эмнэлэг ариун цэврийн шаардлагын тухай протоколын төслийг монгол, англи, хятад хэл дээр тус тус боловсруулж, ХХААХҮ-ийн сайдын албан бичгээр БНХАУ-ын ГЕГ-т хүргүүлсэн.	ХХААХҮЯ	70	50.0	6.2.2.3. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;
210	8.3.3. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангана.	2021-2025			1. ХХААХҮ-ийн Сайдын 2024 оны А/38 дугаартай “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ багцлах тухай” тушаал гаргав. 2. 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр гаргах худгийн байршил орон нутгийн хүсэлтэд үндэслэн ХХААХҮСайдын 2024 оны А/99 дугаартай “Шинээр гаргах худгийн байршил батлах тухай” тушаал гаргуулав. 3. Бэлчээрийн усан хангамж “Улсын хэмжээнд” ХХААХҮЯ/20240101002-р нээлттэй тендерийг цахимаар 2024.02.28-ны өдөр зарласан. 4. УТХ-өөр 2024 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XVI.1.25-д заасан Бэлчээрийн усан хангамж /Улсын хэмжээнд/ ХХААХҮЯ/20240101002 дугаартай тендерт оролцогчдод ТНБД-ын “Гэрээ байгуулах эрх олгох, тендерээс татгалзах дахин нээлттэй тендер зарлах тухай” 2024 оны А/164 дугаартай тушаал гаргуулж, 6 багцад гэрээ байгуулсан. 5.ХХААХҮЯ/20240101002/01 дугаартай тендерт ТНБД-ын 2024 оны А/272 дугаартай “Гэрээ байгуулах эрх олгох тухай” тушаал гаргуулж, үр дүнг цахимд тайлагнасан. 2024.06.06-ны өдөр 12 багцтай тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан. 6.Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг 8 аймгийн 53 сумын 156.0 гаруй мянган га бэлчээрийн талбайд зохион байгуулж, бэлчээрийн ургамлыг ургаж эхлэх үед буюу хаврын технологит хугацаанд зохион байгуулж, мэрэгч амьтдын хөнөөлд өртөхөөс сэргийлж, цаашлаад бэлчээрийн 95.2 мян тонн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. 7.ХХААХҮ-ийн сайдын 2024.02.15-ны өдрийн “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” А/96 дугаар тушаалын хүрээнд бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой энгийн механик, микробиологийн аргаар тэмцэх арга хэмжээг 14 аймаг, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны бэлчээрт гүйцэтгэсэн. УХЭШХ-тэй байгуулсан ХХААХҮЯ20240201065 гэрээний үр дүнгийн хүрээнд УТХ-өөр 450.0 мянган га, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 150.0 мянган га, нийт 600.0 мянган га талбайд тэмцэв.	ХХААХҮЯ	100	90.0	Бэлчээл усжуулах ажлын үр дүнг тайланд тусгаагүй,
211	8.3.4. Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.	2021-2025	499.0 сая төгрөг		ХХААХҮСайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, нийлүүлэх хуваарь батлах тухай” А/137 дугаар тушаал, ажлын удирдамж, гэрээний төслийг боловсруулж, орон нутгийн мэргэжлийн байгууллагад хүргүүлэв. Улсын төсвийн нийт 499.0 сая төгрөгийн санхүүжилтээр хуц 792, ухна 610, бүгд 1402 хээлтүүлэгчийг худалдан авч Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгжид гэрээ, түрээсээр ашиглуулж, нийт 18 аймгийн 25 нэгжийг бодлогоор дэмжсэн. Улсын хэмжээнд 2020 оны байдлаар /суурь түвшин/ 131 Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж үржил, бүртгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар 193 МҮТАҮ-ний нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нь зорилтот түвшинг 42 нэгж буюу 27.8%-иар давуулан биелүүлсэн байна. Улсын хэмжээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дундговь, Хөвсгөл, аймгуудын хэмжээнд гойд ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр 5500 толгой үнээ үүнээс 2200 үнээ улсын төсвийн хөрөнгөөр, 2000 үнээ иргэд, фермер эрхлэгчдийн захиалгаар хийгдсэн. Биотехнологийн дэвшилтэт арга технологиудыг ашиглан 5200 толгой малыг зохиомол хээлтүүлэгт хамруулсан ба жилийн эцсийн байдлаар нийт 10,707 толгой малд зохиомол хээлтүүлэгт хамруулан ажиллав. Монгол улсад баталгаажсан үүлдэр, омгийн гойд ашиг шимт бод, бог малын генийг доройтох, мөхөх, устахаас сэргийлж хамгаалах зорилгоор үржүүлгийн бүтээгдэхүүнийг хадгалах үндэсний генийн санг бүрдүүлэх, баяжуулах ажлын хүрээнд 5 үүлдэр, үржлийн хэсгийн 17 толгой хуц, ухнаас стандартын шаардлага хангасан 3.5-4 баллын үнэлгээтэй 5359 тун үр үйлдвэрлэв. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 14,954 тун үр үйлдвэрлэн ажилласнаас малын үндэсний генийн санд акт үйлдэж 13,504 тун, судалгаа шинжилгээ, сургалтын чиглэлээр 450 тун, 1000 тун үрийг хоёр орны төрийн тэргүүний айлчлалын хүрээнд хүлээлтэн өгсөн байна.	ХХААХҮЯ	90	90.0	
212	8.3.5. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжинэ.	2021-2025	-		Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах хүрээнд 2024 онд дараах хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. ХХААХҮЯ-ны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан “Улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 08-00-02/29 дугаар удирдамжийн хүрээнд 2023.11.01-ний өдрөөс 2024.01.29-ний өдрийн хооронд ЭМЯ, БОАЖЯ, МЭЕГ, НХХААГ, НМЭГ, НБООГ-ын хамтарсан ажлын хэсгүүд 8.1.3, 8.1.4 кодтой хяналтын хуудасны эрсдэлийн үнэлгээ хийсэн. Хяналт шалгалтад 93 мал төхөөрөх, 58 мах боловсруулах үйлдвэр, нийт 151 үйлдвэр хамрагдаж, нийт 4,028 зөрчил дутагдал илрүүлж, 735 буюу 18.2%-ийг арилгуулан 68 аж ахуйн нэгж, иргэнд 2,072 заалт бүхий улсын (ахлах) байцаагчийн хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, ХХААХҮЯ-ны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024.03.25-ны өдрийн 08-00-01/001/01 дугаар “Дүгнэлт цуцлах тухай” шийдвэрээр “их эрсдэлтэй” үнэлэгдсэн аж ахуйн нэгж, иргэдийн мал төхөөрөх, мах боловсруулах 50 үйлдвэр, цехийн үйл ажиллагаа эрхлэх улсын (ахлах) байцаагчийн хамтарсан дүгнэлтүүдийг цуцалсан. 2. ХААХҮЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан “Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 08-00-03/23 дугаар удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн ЭМГ, МЭГ, ХХААГ, БОАЖГ-ын хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 8.1.3, 8.1.4 кодтой хяналтын хуудасны дагуу 2024.05.27-ны 2024.11.01-ний өдрийг хүртэл хийж гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтад хамрагдвал зохих 102 аж ахуй нэгж хамрагдахаас 66 (65%) нь хамрагдаж, хяналт шалгалтын явцад үйл ажиллагаа явуулаагүй зогссон 36 үйлдвэр байна. Шалгалтаар 39 аж ахуй нэгжид давхардсан тоогоор нийт 2,049 зөрчлийг илрүүлэн, 1,241 заалт бүхий улсын байцаагчийн хамтарсан 40 албан шаардлагыг хүргүүлж, 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд 14.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Гүйцэтгэлийн хяналтаар 17 объект бага, 6 объект дунд буюу эрсдэл буурсан. Бага болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 31 аж ахуйн ХХААХҮЯ : 1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газрын 2021 оны 248 дугаар тушаалаар баталсан “Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын аж ахуйн нэгжийг бүртгэх захиргааны журам”-ын хүрээнд тус улсын Гаалийн ерөнхий газрын цахим системд алдвны мах 4, дулааны аргаар боловсруулсан мах 9, самар 5, загас 1, сүүн	ЭМЯ /ХХААХҮЯ	70/50	70.0	
213	8.3.6. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2021-2025	-		Салбарын Сайдаас арилжааны 10 банктai “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл”-ийн санхүүжилтийн гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээнд заасны дагуу мөөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 5 хувийн хүчтэй эргэлтийн хөрөнгийн зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр олгож байна. Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг эрчимжүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Мөөгний үйлдвэрлэл, мицель үйлдвэрлэх, тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх, Мөөг судлалын төв, лаборатори байгуулахад хөрөнгө оруулалтын зээл олгох, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх, Мөөг тариалах, судлах, хэрэглээг сурталчлах, борлуулалтыг дэмжих ашигт ургамлыг тарималжуулах төсөл хэрэгжүүлэх, Монголын мөөгний салбарыг хөгжүүлэх Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлуудыг тусгасан. Энэ оны Ургац хураалтын дүнгээр 336.1 мянган га талбайгаас 430.0 мянган тонн үр тариа, үүнээс 386.4 мянган тонн улаанбуудай, 18.6 мянган га-гаас 250.8 мянган тонн төмс, 17.7 мянган га-гаас 256.3 мянган тонн хүнсний ногоо, 96.1 мянган га-гаас 246.9 мянган тонн тэжээлийн ургамал, 115.2 мянган га-гаас 53.3 мянган тонн тосны ургамал тус тус хураан аваад байна. Хураасан ургацын хэмжээг өмнөх онтой гүйцэтгэлтэй харьцуулахад төмс 39.7 хувь, хүнсний ногоо 22.9 хувиар тус тус нэмэгдсэн дүнтэй байна.Намрын ургац хураалтаас стратегийн нөөцөд “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 46.3 мянган тонн, гурилын үйлдвэрүүд 157.2 мянган тонныг тус тус худалдан авч, одоогоор нийт 203.5 мянган мянган тонн улаанбуудай хүнсэнд нийлүүлэгдээд байна. Малын тэжээлд 56.0 мянган тонн, спиртийн үйлдвэрт 12.6 мянган тонн нийлүүлэгдсэн бөгөөд 73.6 мянган тонн улаанбуудай борлуулалтын шатандаа явж байна. Нийт нөөцөөр тооцвол 2024-2025 оны хэрэгцээт гурилыг дотоодосоо бүрэн хангах боломжтой байна.	ХХААХҮЯ	70	70.0	
214	8.3.7. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэр, борлуулалтын ложистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025	13.0, Улсын төсөв		1.Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх хүрээнд баруун бүсэд “Шинэ Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахаар дэд бүтцийн бүтээн байгуулалтын 5 багц ажлыг улсаас санхүүжүүлж ажлын гүйцэтгэл 42 хувьтай явагдаж байна. 2.“Дархан арьс ширний цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн зураг төсөл, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн барилгын зураг төсөл боловсруулах ажил дуусаж, магадлалд хянагдаж байна. 2024 оны байдлаар төслийн бүтээн байгуулалтын ажил 20 хувьтай явагдаж байна. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрын 1.3.5.6.Дархан арьс ширний цогцолборыг барьж дуусгана гэж тусгасан. Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах тухай Улсын Их хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн асуудлыг шийдвэрлэн 2023-2024 онд зоорь агуулах барих чиглэлээр хөрөнгө оруулалтын зээлийг нийт 69 иргэн, аж ахуй нэгжид 63,7 тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгосон бөгөөд үүний үр дүнд 33 мянган тонноор агуулах, зоорины багтаамжийг нэмэгдүүлээд байна. ХХААХҮ-ийн Сайдын тушаалаар үнэлгээний ажлыг гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагаар Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо МБАНХ-г томилж, хариуцлагатай нүүдэлчин зоохистой дадал нэвтрүүлсэн тухай тохирлын гэрчилгээ олгох ажлыг хариуцан гүйцэтгэх 230426/04-266 дугаартай гэрээг байгуулав. - МБАНХ нь Баталгаажуулалтын албаны Тохирлын үнэлгээ, бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтад мөрдөгддөг нийт 22 журам, дүрэм, чанарын гарын авлагыг шинэчлэн боловсруулж баталгаажуулав. - МБАНХ нь Хариуцлагатай нүүдэлчин зоохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага” MNS 6891:2020 стандартын хүрээнд итгэмжлэгдсэн цагаасаа хойш нийт 30 байгууллагаас хөндлөнгийн үнэлгээнд хамрагдах хүсэлт авсан.	ХХААХҮЯ	50	70.0	6.2.2.2. тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь;

215	8.3.8. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээл, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, үнэ цэний сүлжээг хөгжүүлж, эдийн засгийн чадамж, үр өгөөжийг сайжруулна.	2021-2025	228,900.0, Банк		1 Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд батлагдсан. 2. Дээрх хуулийн хүрээнд Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх Засгийн газрын 166, 167 дугаар тогтоолууд батлагдаж 2024 онд улсын хэмжээн 10000 гаруй хоршоо шинээр байгуулагдаж 6800 орчим хоршоо хөнгөлөлттэй зээлд хамрагдав. 3. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль батлагдаж дагаж НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт орж хоршоодыг татварын бодлогоор дэмжих боломжтой болсон. 4.УИХ-ын 63 тогтоолын 2024 онд боловсруулан батлуулж уг тогтоолын төлөвлөгөөний 2.3. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржээр дамжуулан борлуулах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн тогтолцоог бүрдүүлэхээр тусгагдсан. Таримал бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээг бий болгох хүрннд 2024 оноос стратегийн хүнсний улаанбуудай, үрийн улаанбуудайг биржээр борлуулах туршилтын арилжааг эхлүүсэн. ХААК ТӨХХК-д хадгалж байгаа хүнсний 10.0 мянган тонн улаанбуудайг, 4 сортын 2.0 мянган тонн үрийн улаанбуудайг биржээр нээлттэй борлуулсан. Ноолуур бэлтгэлийн зориулалтаар Монголбанктай 1824/139-240411/06-264 дугаар, арилжааны банкуудтай 240418/06-291 дугаартай гэрээнүүдийг байгуулсан. Аж ахуйн нэгжтэй хяналтын гэрээ байгуулах эрх олгох тухай ХХААХҮ-ийн сайдын 2024 оны А/239 дугаартай тушаал гарсан. Зээл олгох шийдвэр гарсан 29 аж ахуйн нэгжтэй 47 хяналтын гэрээ байгуулсан. Арилжааны банкуудаас 228.9 тэрбум төгрөгийн зээл олгогдсон.	ХХААХҮЯ	70	70.0	
216	8.3.9. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	2021-2025	1,580.0, Улсын төсөв		1.Монгол Улсын мал сүргийн өсөлт, 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, бэлчээрийн даацыг харгалзан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2024 оны "Монгол Улсын экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээний тухай" 2024/003 дугаар зөвлөмжийг гаргуулж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хонь, ямааны түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах, адууны түүхий маханд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. Монгол Улс 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 63.8 мянган тонн (түүхий маханд шилжүүлснээр 87.1 мянган тн) мах, махан бүтээгдэхүүнийг 257.8 сая ам доллароор экспортолсон байна. 2.Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-эрдэнэ БНХАУ-д хэрэгжүүлсэн ажлын айлчлалын хүрээнд "Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад экспортлох тэжээлийн зориулалттай уураг болон өөх, тосны мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай Монгол Улсаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын протокол"-ыг харилцан тохиролцож, хамтран байгуулсан. 3.Дархан арьс ширний цогцолбор төслийн бэлтгэл ажлын хүрээнд 1.58 тэрбум төгрөгийн зураг төслийн ажлуудыг хийгээд байна.Тухайлбал: Хонины арьс боловсруулах үйлдвэрийн зураг төсөл, ямааны арьс боловсруулах үйлдвэрийн зураг төсөл, үхрийн шир боловсруулах үйлдвэрийн зураг төсөл, химийн материалын агуулахын зураг төсөл, түүхий эдийн агуулахын зураг төсөлд нийт 867 сая төгрөг, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, дэд бүтцийн зураг төсөлд 713.8 сая төгрөг тус тус зарцуулаад байна. Хонь, ямаа, үхрийн шир боловсруулах болон химийн материалын агуулахын зураг төслийг магадлалаар баталгаажуулахаар "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-т хянагдаж байгаа бөгөөд магадлалын ерөнхий дүгнэлт хүлээгдэж байна. Түүхий эдийн агуулахын зураг төсөл бүрэн дууссан байна. Цэвэрлэх байгууламжийн зураг төсөл батлагдсан бөгөөд төслийн цаашид хэрэгжих хувилбараас шалтгаалан зураг төсөлд өөрчлөлт оруулж, үргэлжлүүлэх асуудал шийдэгдэнэ.	ХХААХҮЯ	50	50.0	
217	8.3.10. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд зориулан санхүүжилтийн шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлж, төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үр чадварыг хөгжүүлэн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	2021-2025			1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2024 оны 29,000,000,000 төгрөгийг хавсралтад заасан салбар, чиглэлийн дагуу жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн хөрөнгө оруулалтад зориулж, 5 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй сангаас шууд олгох, үндсэн зээлийн төлбөрөөс эхний 12 сар хүртэл хугацаанд чөлөөлөх "Хөнгөлөлттэй зээл олгох ерөнхий нөхцөл батлах тухай" ХХААХҮСайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/28 тоотр тушаалыг батлуулав. 2. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний 3.10.2-т заасан хөрөнгөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар дамжуулан Жимс жимсгэний төрөлжсөн аж ахуй байгуулахад 2,850,000,000 төгрөгийг үндсэн болон эргэлтийн хөрөнгөд оруулалтад зориулж 8 жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй, зээлийн үндсэн төлбөрөөс эхний 3 жилийн хугацаанд чөлөөлөх нөхцөлөөр "Жимс, жимсгэний төрөлжсөн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай" ХХААХҮСайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/27 тоот тушаалыг батлуулав. 3. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний 4.2.1-т заасан хөрөнгө болон Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хооронд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 104/03-706/49 дугаартай "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл"-ийн зээлийн үлдэгдэл хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу орон нутагт түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 4,200,000,000 төгрөгийг хөдөө аж ахуйн загвар хоршооны үндсэн хөрөнгө оруулалтад зориулж жилийн 5 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, эхний жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэй "Хөдөө аж ахуйн Загвар хоршооны зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай" ХХААХҮСайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/26 тоот тушаалыг батлуулав.	ХХААХҮЯ	100	70.0	Тодорхой хэмжээнд гүйцэтгэл гарсан.Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй,
218	8.3.11. Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ.	2021-2025	4,500.0, Улсын төсөв		Газар тариалангийн чиглэлээр азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд 55,6 тэрбум төгрөгөөр малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалах зориулалт бүхий 3.1 мянган га талбайг услах хүчин чадалтай 10 услалтын систем шинээр барих, шинэчлэн сэргээн засварлаж байна. 2024 онд 544 га талбайг услах хүчин чадалтай Төв аймгийн Батсүмбэр сумын Сөгнөгөр, Сэлэнгэ аймгийн Сант сумын Ивэн гол, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цул-Улааны услалтын системийг аиглалтанд хүлээн аваад байна. МөнУлсын Төсвийн 17,5 тэрбум төгргийн хөрөнгө оруулалтаар Увс, Булган, Ховд аймагт 7,3 мянган га талбайг услах хүчин чадал бүхий 3 услалтын системийг 2025-2026 онд ашиглалтанд оруулна. Эрчимжсэн мал ахуйн чиглэлээр УИХ-ын 36 тогтоол, Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолоор Хүнсний болон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийг банкны эх үүсвэрт тулгуурлан , Засгийн газрын хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт 13.0 нэгж хүтэл хувь байхаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд Мал аж ахуйн үйлдвэрлэлд 132.3 тэрбум, үүнээс Тэжээлийн үйлдвэрүүдийн эргэлтийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэхэд 15.0 тэрбум, Засгийн газраас төлөх хүүгийн хөнгөлөлт 1.96 тэрбум төгрөг тусгагдсан, тэжээл үйлдвэрлэгч 5 аж ахуйн нэгжид 3.0 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн. - 2024 онд Хүнсний болон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгө" - ийн зээлийн санхүүжилтийн 2024.02.01-ны өдрийн 240201/07-60 дугаар гэрээ,(энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2024.04.19-ны өдрийн 240419/08-300 дугаар гэрээ) тус тус байгуулагдсан. Гэрээнд Тэжээлийн үйлдвэрүүдэд дотоодоос түүхий эд худалдан авахад 2,500.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэх батлагдсан. 2024.06.10-наар "Нүүдэл тэжээл" ХХК, "Өгөөмөр Жавхлант Хангай" ХХК, "Төгс хязгаар" ХХК-иудтай 2,200.0 сая төгрөгийн "Хяналтын гэрээ" байгуулах ажлыг зохион байгуулсан. 2023 онд нийт 5 тэрбум 500 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн.	ХХААХҮЯ	90	90.0	
219	8.3.12. Малын гаралтай түүхий эд боловсруулах, экспортлох үйлдвэр, технологийн парк байгуулж, ажлын байрыг шинээр бий болгож, малчдын орлогыг өсгөнө.	2021-2025	297.4, Улсын төсөв		Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн төслийн хөрөнгө оруулалт 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 онд гэрээт ажил бүрэн дуусахаар төлөвлөж, магадлалын дүгнэлтээр төсөвт өртөг нэмэгдэж 36,018.1 сая төгрөгөөр батлагдсан байна. Тус төслийг 5-н багц арга хэмжээнд хувааж тендер шалгаруулалтыг явуулснаас Оффреүд таван богд ХХК, Вокон констракшн ХХК, Эм Ай Эс Эс ХХК, Монкабель ХХК, Жаргалантлуу ХХК тус тус шалгарч 36,018.1 сая төгрөгийн санхүүжилтээс гүйцэтгэлээр 2023 он дуустал хугацаанд 9,571.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 2024 онд 11.297.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гүйцэтгэлийг хянан баталгаажуулаад байна. 2025 онд 18,184.0 сая төгрөг Улсын төсөвт батлагдсан.Нийт ажлын гүйцэтгэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 57,94 хувьтай байна.	ХХААХҮЯ	50	50.0	
220	8.3.13. Хөдөө орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, малын үүлдэр, угсааг сайжруулах, малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэгчдийг дэмжих "Шинэ хөдөө" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	2021-2025			Засгийн газраас хоршоогоор дамжуулж малчин өрхийн амьжиргааг дэмжих, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөнгөн урсгалыг тогтмолжуулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор улсын хэмжээнд "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг өрнүүлж, "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний таван жилийн төлөвлөгөөг хэлэлцэн баталж, хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн.Хөрөнгө оруулалтын зээлийг арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон бөгөөд хүүгийн зөрүүний дэмжлэгийг Засгийн газраас олгож, зээлийн барьцаа хөрөнгийн батлан даалтыг Зээлийн батлан даалтын сангаас 80-100 хувь хэрэгжүүлсэн аж. Энэхүү арга хэмжээний хүрээнд өнөөдрийн байдлаар 4.4 мянган (4466) малчдын хоршооны 14.6 мянган (14688) хоршооны гишүүн малчинд 502,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон, 1570 малчны 88.3 тэрбум төгрөгийн төсөл арилжааны банкаар судлагдаж байна. • ХХААХҮЯ/20240102038 дугаартай XVIII.3.33 Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/ УТ2401900387 төсөл, арга хэмжээний Багц №8 "Оёдлын машины иж бүрдэл" нийлүүлэх ажлыг 37,840,000.0 (гучин долоон сая найман зуун дөчин мянга) төгрөгөөр гүйцэтгэхээр "Голден хоул" ХХК-ийн ирүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн, "хамгийн сайн" тендерээр шалгаруулж гэрээ байгуулав. • Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн "Гэрээ байгуулах эрх олгох тухай" А/530 тоот тушаалыг үндэслэн XIII.3.33 Орон нутгийн хөгжлийн дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/ УТ2401900387 төсөл, арга хэмжээний багц-4 "Хөнгөн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж" нийлүүлэх 241118/06-961 дугаар бүхий гэрээг Монгол жайнт трейд ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр байгуулав.	ХХААХҮЯ	70	50.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, худалдан авах ажиллагааны үр дүнг тусгаагүй,
221	8.3.14. Малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэн экспортлох чиглэлийн боловсруулах үйлдвэрүүдийг богино хугацаанд барьж ашиглалтад оруулна.	2021-2025	3,038.2, Улсын төсөв		Бичил үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тоног төхөөрөмж "Зөгийн балний үйлдвэрлэлийн төхөөрөмж" тендер сонгон шалгаруулалтыг зарлаж сонгон шалгаруулалтыг хийж байна. Мөн мал нядалгааны тоног төхөөрөмж худалдан авах тендер сонгон шалгаруултын ажлыг зохион байгуулж байна. Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" УТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт ХХААХҮСайдын багцад 42,691.6 сая төгрөгийн үнийн дүнгээр батлагдсан. Худалдан авалтыг 6-н багцад хуваан шалгаруулалт явуулж шалгарсан байгууллагууд 2018-2023 оны хооронд гүйцэтгэлээр 13,982.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 2024 онд 13,197.4 сая төгрөгийн санхүүжилт авахаас 3,038.2 сая төгрөгийн үе шатны санхүүжилтийг авч, гэрээт ажил үргэлжилж байна. Нийт ажлын гүйцэтгэл 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 47 хувь байна. Төлөвлөгөөний дагуу 2025 онд ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгөх бөгөөд шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсөвт бүрэн тусуулан саналыг хүргүүлсэн. • Дархан арьс ширний цогцолбор төслийн бэлтгэл ажлын хүрээнд 1.58 тэрбум төгрөгийн зураг төслийн ажлуудыг хийгээд байна. Тухайлбал: Хонины арьс боловсруулах үйлдвэрийн зураг төсөл, ямааны арьс боловсруулах үйлдвэрийн зураг төсөл, үхрийн шир боловсруулах үйлдвэрийн зураг төсөл, химийн материалын агуулахын зураг төсөл, түүхий эдийн агуулахын зураг төсөлд нийт 867 сая төгрөг, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, дэд бүтцийн зураг төсөлд 713.8 сая төгрөг тус тус зарцуулаад байна. Хонь, ямаа, үхрийн шир боловсруулах болон химийн материалын агуулахын зураг төслийг магадлалаар баталгаажуулахаар "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-т хянагдаж байгаа бөгөөд магадлалын ерөнхий дүгнэлт хүлээгдэж байна. Түүхий эдийн агуулахын зураг төсөл бүрэн дууссан байна. Цэвэрлэх байгууламжийн зураг төсөл батлагдсан бөгөөд төслийн цаашид хэрэгжих хувилбараас шалтгаалан зураг төсөлд өөрчлөлт оруулж, үргэлжлүүлэх асуудал шийдэгдэнэ.Одоогоор магадлалын ерөнхий дүгнэлт хүлээгдэж байна.	ХХААХҮЯ	50	30.0	Шинэ Ховд УТП-аас бусад бүтээн байгуулалтын ажил боловсруулалтын шатанд байна

8.3.15.	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилго бүхий төрийн, орон нутгийн төсвийн санхүүжилтээр болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа, төлөвлөлт, явц, үр дүн, зээл тусламжийн олголт нь зорилтот бүлэгтээ бодитой чиглэн ажиллаж чадаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих гурван талт түншлэлийн механизмыг бий болгож ажиллуулна.	2021-2025			Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд хяналт тавин ажиллахыг үр дүнд ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй нийт 9 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсээр 84.2 хувиар үнэлэгдсэн болно. Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн дараах 3 төсөл 2023 онд дууссан байна. Үүнд: 1. Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл 2. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил 3. Экспортыг дэмжих төсөл Төслийн нэгжүүд Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10.3-д заасны дагуу үйл ажиллагааг тайлагнаагүй, тухайн жилийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойгүй тусгасан байгаа тул хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой хийхэд хүндрэл учирч байна. Тайлант хугацаанд 5 төслийн хэрэгжилтээр нийт 596 аж ахуйн нэгжид 49.4 тэрбум төгрөгийн урт хугацаатай хөнгөлөлттэй зээл, батлан даалтын дэмжлэг олгож байнгын 699, түр 726, нийт 1425 ажлын байр бий болсон байна. Мөн салбарт хэрэгжсэн 9 төслийн хүрээнд 2023 онд нийт 259 удаагийн сургалт зохион байгуулж, 10490 хүнийг хамруулсан байна.	ХХААХҮЯ	90	70.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, санхүүжилтийн 3 эх үүсвэрээс гадаадын зээл тусламжийг төсөл хөтөлбөрийн талаар тайлагнасан.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			66.0	
					Зорилгын хэрэгжилтийн хувь			71.7	
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ									
Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.									
Хүн төвтэй хот									
Зорилго 9.1. Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.									
222	9.1.1. Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	2021-2025	92.3, Улсын төсөв		НЭДТГ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: - 4 давхар 500 хүний суудалтай спорт заал, жижиг спорт заалтай, 25 метрийн 4 замтай усан бассейнтай Баянгол дүүргийн спорт цогцолбор, - Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороонд 1000 хүний суудалтай, зоорийн давхартай 4 давхар А, В, С блоктор, 4 улирал ажиллах, талбай дээрээ 1 удаа 100-120 тамирчин хүлээн авах хүчин чадалтай Чингэлтэй дүүргийн Спорт цогцолбор, - Налайх дүүрэгт 700 суудал бүхий спорт заал, 4 зам бүхий усан бассейнтай спорт цогцолборын барилга, - Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Дээд Салхитын аманд байрлах Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолбор ашиглалтад орлоо. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 5 спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 67 хувь (Налайх-100%, Нийслэл-50%, Сүхбаатар-40%, Баянзүрх-85%, Багахангай-80%)-тай үргэлжилж байна. - Нийслэлд улс, нийслэл, дүүргийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр өмнөх онуудаас он дамжин хэрэгжиж буй болон 2024 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 34 сургууль, 70 цэцэрлэг, 21 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 3 спорт заал, 1 дотуур байр, нийт 129 боловсролын байгууллагын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс нийт 9 сургууль, 19 цэцэрлэг, 1 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтад орж сургуулийн суудлын тоог 4980-аар, цэцэрлэгийн орны тоог 3330-аар тус тус нэмэгдүүлсэн. - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах тусламж үйлчилгээний Хантуул төв, Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Бяцхан тэмүүлэл төв ашиглалтад орсон. - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн дэмжих төв, Баянзүрх дүүрэгт Жишиг эмнэлэг, Баянзүрх дүүргийн ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга ашиглалтад орлоо. ГБХНХЯ: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан 7 төрлийн тусламж, үйлчилгээг 39 Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр үзүүлж байгаа бөгөөд 2024 онд нийт 3502 иргэн үйлчилгээ авснаас 2456 хүүхэд, 1046 насанд хүрэгч байна. Үйлчилгээнд хамрагдсан байдлаар нь авч үзвэл: □ Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд 2625 хүүхэд □ Сэтгэл зүйн үйлчилгээнд 1565 хүүхэд □ Эрх зүйн туслалцаа 923 □ Боловсролын үйлчилгээ 1155 □ Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд 1045 хүүхэд тус тус хамрагдсан байна. Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага стандартыг/MNS 7038:2024/ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны C/12 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Стандартыг хэрэгжүүлснээр Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн аюулгүй байдлыг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх, хосын харилцааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх гэр бүлд чиглэсэн шууд болон шууд бус үйлчилгээг үзүүлэх юм.	НЭДТГ, ГБХНХЯ	100/100	90.0	ГБХНХЯ-ны тайланд хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн талаар тайлагнаагүй,
223									
224	9.1.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.	2021-2025	82.3, Улсын төсөв		НЭДТГ: Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2021 оны А/678, А/869 дүгээр хамтарсан тушаал, захирамжийн дагуу Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт эрүүл мэндийн анхан шатны байгууллага, лавлагаа шатлалын эмнэлгийн уялдаа холбоог сайжруулах, интеграцчילה, санхүүжилтийг үр дүнтэй зарцуулах, улмаар эрүүл мэндийн анхан шатны байгууллагын үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн хөтөлбөрийн цогц үйл ажиллагаа шат дараатай хэрэгжиж байна. - Нэгдсэн удирдамж, протокол ашиглан үйлчлүүлэгчид үзүүлж буй тусламж үйлчилгээг харилцан уялдаатай нэг үйл явцад нэгтгэх, өвчтөнийг лавлагаа шатлалд илгээх болон эмнэлэг хооронд шилжүүлэх үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах үйл ажиллагааны чиглэл, ажиллах журмыг боловсруулсан, - Эмнэл зүйн удирдамжуудыг анхан шатанд мөрдөн ажиллах алгоритмүүдийг хэрхэн ашиглах талаар 5 өдрийн сургалтыг зохион байгуулж 105 эмч, эрүүл мэндийн нийгмийн ажилтныг хамруулсан, - Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг дээр тус тус Зохицуулах зөвлөлүүдийг байгуулсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар Чингэлтэй, Хан-Уул дүүргийн “Зохицуулах зөвлөл”-ийн хурлыг 11 удаа тус тус зохион байгуулж, 2 дүүргийн эрүүл мэндийн төвөөс өрхийн эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналтыг хийсэн. - Интеграцлалын хүрээнд Хан-Уул дүүргийн шилжүүлгийн цахим бүртгэл ашиглан нийт 98 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд шилжүүлгийн эрхийг нээж, 468 хүнийг өрхийн эрүүл мэндийн төвөөс 4 чиглэлээр нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шилжүүлснээс нарийн мэргэжлийн эмч нар үзлэг, шинжилгээ хийж 259 үйлчлүүлэгчийг буцаан шилжүүлсэн. - Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн 11 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өрхийн эрүүл мэндийн төвийн 92, нийт 103 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд шилжүүлгийн эрхийг нээж, өрхийн эрүүл мэндийн төвөөс 673 хүнийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шилжүүлснээс нарийн мэргэжлийн эмч нар үзлэг, шинжилгээ хийж, 429 үйлчлүүлэгчийг буцаан шилжүүлсэн байна. ЭМЯ: УИХ-ын 2024.06.05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдаж, Хангай, Баруун, Хойд, Зүүн, Говийн зэрэг 5 бүсэд Бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтийг бүсийн хэмжээнд төвлөрүүлэн зохион байгуулахаар төлөвлөжээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн агуулахын нэг маягийн зураг төслийн холболтын зураг төсөл /Ховд, Орхон, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь/ төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн”-д хүргүүлсэн. Тус газраас худалдан авах ажиллагаа 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зарлаж, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр нэхээд 5 оролцогч санал ирүүлж, “Өрнөлпроект” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл олгосон. Баруун бүсд Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, зүрх, судасны тусламж, үйлчилгээгээр төрөлжүүлэх, Осол гэмтэл ихээр гардаг Орхон, Дорнод, Өмнөговь аймаг дахь Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, осол гэмтлийн болон мэс заслын тусламж, үйлчилгээгээр төрөлжүүлэх, Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ, Хэнтий, Өмнөговь аймагт мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төв байгуулах, Өвөрхангай аймагт Бүсийн оношлогоо, эмчилгээний төвд түшиглэн эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон уламжлалт анагаах ухаанд суурилсан сувилал байгуулах, Орхон голын сав, хангайн нурууны экосистемд түшиглэн түүх, соёл, рашаан сувиллын аялал жуулчлалыг уламжлалт, сэргээн засах анагаах ухаантай уялдуулан хөгжүүлэх, Дархан-Уул аймагт орчин үеийн стандартад нийцсэн нэгдсэн эмнэлэг барих зэрэг арга хэмжээнүүдийг тусгасан байна. Нийслэлийн харьяа 25 ЭМБ-ын бүтэц, дүрэм, орон тоо баталсан эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийсэн. Нийслэлийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай	НЭДТГ 100, ЭМЯ 30	100	50.00	Зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн.
225	9.1.3. Хотын соёлт иргэнийг төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудыг хамарсан төсөл хэрэгжүүлж, нийгэмд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг төрийн байгууллага, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж хэвшинэ.	2021-2025	-		НЭДТГ: “Хотын соёл” арга хэмжээний хүрээнд Нийслэлийн иргэдэд “Бүх нийтийн соёлын боловсрол”-ыг түгээх, соён гэгээрүүлэх ажлыг “Go Mongolia”, “Соёлын сэргэлт-2024” аянуудтай хамтатган зохион байгуулж, соён гэгээрүүлэх, нөлөөллийн 10 контент, соёлын боловсрол олгох, соёлын үйлчилгээ үзүүлэх 95 багц арга хэмжээг 84,404 хүнд үзүүлж, цахим мэдээллээр нийт 240,093 хүнд хүргэсэн байна. - "Ирээдүйн хотын иргэн" төслийг Нийслэлийн ЕБС-ийн дунд ангийн суралцагчдад зориулан хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан, хотын соёлыг төлөвшүүлж, нийгэм, олон нийтийн оролцоог дэмжих зорилгоор Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Боловсролын газартай хамтран хэрэгжүүлсэн. - Уг төсөлд НЭДТГ, НҮБ хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Жишиг сургууль” төслийн 8 сургуулийн 640 хүүхэд хамрагдаж, нийслэл Улаанбаатар хотын дэд бүтэц, урлаг соёл, төрийн үйлчилгээний 12 байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, мэргэжлийн чиг баримжаа олгох цахим контент бэлтгэн “Хайрын зуслан” пэйж хуудсанд байршуулж нийтэд түгээсэн. БЯ: Бага, суурь, бүрэн дүнд боловсролын сургалтын хөтөлбөрт орчны бохирдол, хог хаягдлыг ангилах, багасгах зэрэг агуулгыг тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал: бага ангийн Хүн орчин хичээлээр сургуулийн гадаад орчны аюулгүй байдлыг үнэлж цэгнэх, хүрээлэн буй орчинд нөлөөлж буй хүний үйл ажиллагаанаас жишээлэн тайлбарлах, орон нутаг, сургууль орчмын хог хаягдал, түүнийг багасгах арга замууд (хог хаягдлыг багасгахын тулд өөрийн оруулах хувь нэмрийг гаргах, хог хаях аргыг хэлэлцэх), Суурь боловсролын хөтөлбөрт-хүний үйл ажиллагаа хүрээлэн буй орчин (хөрсний бохирдол)-д хэрхэн нөлөөлдгийг тодорхойлох, Бүрэн дүнд боловсролын газарзүйн сургалтын хөтөлбөрт-хотын орчны бохирдол (дуу чимээ, хог, тоосжилт, хөрс г.м) ба амьдралын чанарын хамаарлыг дүгнэх, хотын цэвэрлэх байгууламж, хотын тулгамдсан асуудал, гэмт хэрэг, хүн амын бөөгнөрөл, ядууралд дүгнэлт хийх зэрэг суралцахуйн зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна.Нийслэлийн хэмжээнд 2024 онд “Улаанбаатар хотын гудамж талбай, түүхэн газруудтай танилцъя” сэдэвт 14 хоногийн аяныг 2024 оны 03 дугаар сарын 25-наас 04 дүгээр сарын 08-ны хооронд зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн нийт 38654 сурагчийг хамруулсан.Хотын соёлыг төлөвшүүлэх ажлын хүрээнд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 2 амьтны хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулж, нийслэлийн ерөнхий боловсролын 123 сургуулийн 8500 орчим суралцагчид амьтны хүрээлэнтэй танилцсан. Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 385 жилийн ойн өдрийг тохиолдуулан Улаанбаатар хотын түүхийг сургагчдад таниулах зорилгоор “Улаанбаатар хотын түүхэн замнал” сэдэвт ээлжит хичээлийн төлөвлөлт, гарын авлага боловсруулан нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 22453 сурагчид хүргэсэн. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа болон сурагчдын оролцооны байгууллага, эко клубээр дамжуулан хог хаягдлыг ангилан хаях, соёл хүмүүжилд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлуудыг нийт сургалтын байгууллагууд тогтмол зохион байгуулж хэвшсэн.	НЭДТГ 100 БЯ 100	100	90.0	Үр дүнтэй ажлууд хийгдэж байна.
					Зорилтын хэрэгжилтийн хувь			76.7	
Орчин төвтэй шийдэл									
Зорилт 9.2. Ирээдүйн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангаж, нөхөн сэргээх, харилцагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.									

226	9.2.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна.	2021-2025			НЗДТГ 2024 оны хүйтний улирлын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 2020 оны 12 дугаар сард 105 мкг/м3 байсан бол 2024 онд 44 мкг/м3 болсон нь 156 мкг/м3-ээр буюу 41.9%-иар буурсан байна. - PM10 тоосонцор 2020 оны 12 дугаар сард 132 мкг/м3 байсан бол 2024 онд 112 мкг/м3 болсон нь 20 мкг/м3-ээр буюу 84.8%-аар буурсан байна. - Хүхэрлэг хий SO2: Агаар бохирдуулах бодисын дундаж агууламж нь 2020 оны 12 дугаар сард 211 мкг/м2 байсан бөгөөд 2024 онд 55 мкг/м2 болсон нь 156 мкг/м3-ээр буюу 26%-аар буурсан байна. БОУАӨЯ: Монгол Улсын БОАЖЯ, БНСУ-ын Байгаль орчны яам хоорондын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд БНСУ-ын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгээр Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, БОАЖЯ-ны хашаанд агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах автомат суурин харуул шинээр байгуулан улсын нэгдсэн сүлжээнд холбосон. Улаанбаатар хотын агаарын чанарын хяналт шинжилгээний харуулуудыг PM10, PM2.5 тоосонцор хэмжих автомат багажаар тоноглох ажлыг хийж гүйцэтгэх тендерт “Эм Ай Эс Эс” ХХК шалгарч, багажийг эцсийн байдлаар Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэлийн тайлан гэрээ дүгнэсэн актыг хүлээн авч санхүүгийн бичиг баримтыг эцсийн байдлаар бүрдүүлэн Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүлээлгэн өгсөн. 2025 онд БНСУ-ын Засгийн Газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 21 аймгийн аймгуудын харуулын станцыг солихоор болсон. Агаарын чанарыг сайжруулах бүсэд байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дотоод орчны бохирдлыг бууруулах ажлын тендерт “Кей Би Эс Интернэйшнл” ХХК шалгарч, нийслэлийн 50 сургууль, 126 цэцэрлэг, 9 эмнэлэгт нийт 233973 шүүлтүүр суурилуулж хүлээлгэж өгсөн. 2024 оны 10 дугаар	НЗДТГ 90, БОУАӨЯ : 30	90, 30	50.0	Журмын 6.2.2.3-р үнэлэв.
227	9.2.2. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болгоно.	2021-2025	50.0, Нийслэлийн төсөв		НЗДТГ: 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан гарсан Зөвшөөрлийн тухай хуулийн зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтад орж, зөвшөөрөл олгох, сунгах журмаар зохицуулагдахаар тусгасан. Нийслэл Улаанбаатар хотын Эрх зүйн байдлыг тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд саналыг тусгасан бөгөөд 17.1-т Нийслэл нь ногоон хөгжлийг дэмжих сантай байна. 33.1.58-д -хог хаягдлын тухай хуулийн 40.4-т заасан иргэн аж ахуйн нэгжид олгох саналыг тусган тус заалтыг 2025 оны 06 дугаар сарын 01-нээс мөрдөж эхэлнэ. БОУАӨЯ: БОАЖЯ/20240203074 дугаартай “Хот суурин газрын төвлөрсөн хогийн цэгийг стандартын шаардлага нийцүүлэх нэг маягийн жишиг зураг төсөв боловсруулах” тендерт “Түмэн амгалан ордон” ХХК (РД:5694442) нь шалгарч, гэрээний дагуу ажлын барилга бүтээцийн зураг төслийг газар хөдлөлтийн 6,7,8,9 баллаар тооцож, түүнчлэн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт дэвсгэрт хийлгэсэн инженер, геологийн дүгнэлтэд үндэслэн нийт 5 хувилбараар, халаалт агаар сэлгэлтийн зураг төслийг -300С, -400С болон Говьсүмбэр аймгийн цаг уурын нөхцөлд тохируулан нийт 3 хувилбараар хийж гүйцэтгэсэн. 2024 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 165/2024 тоот албан бичгээр батлагдсан жишиг зураг, төсвийг 2024 оны 11 дүгээр сарын 20-нд гэрээ дүгнэсэн актыг үйлдэж хүлээн авсан. Хаягдал хэрэглээг дэмжих зорилгоор Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.Үүнд: 1/9 дүгээр зүйлийн 9.1.5-д “40.4, 40.9, 40.10-т заасан урамшууллыг олгох шалгуур үзүүлэлт, урамшууллын хэмжээ, түүнийг олгох, санхүүжүүлэх, зарцуулах журмыг батлах”, 40.4. Энэ хуулийн 40.5-д заасан үйлдвэрлэгч болон импортлогчоос бусад дараах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгоно” гэсэн заалтыг оруулж дараах үйл ажиллагаанд хамаарч байна. 40.4.1.хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхлэгч; 40.4.2.байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн; 40.4.3.цаас, лааз, шил, хуванцар зэрэг дахин боловсруулах боломжтой энгийн хог хаягдлыг ангилсан хог хаягдал худалдан авах цэгт хүлээлгэн өгсөн зэрэг нэмэлт өөрчлөлтүүд орсон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141118149821&showType=1	БОУАӨЯ 90, НЗДТГ 100,	100, 90	70.0	Эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
228	9.2.3. Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно.	2021-2025	0.0, Нийслэлийн төсөв		НЗДТГ: “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл-ийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд, Төслийн хүрээнд тогтвортой хөгжлийн 37 гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI) бүхий ногоон орон сууцны барилгын техникийн шаардлагыг хангасан, Олон улсын ногоон барилгын үнэлгээний EDGE системийн шалгуурын дагуу 800 айлын орон сууцны барилга болон ухаалаг удирдлагын СКАДА төвийн барилгын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд (Гал команд, эрүүл ахуй, Барилгын хөгжлийн төвийн мэргэжлийн экспертиз,) болон магадлалаар хянуулан батлуулсан ба Баянхошуу, Шархад дэд төвүүдэд айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажлыг гэр хорооллын Баянхошуу, Шархад дэд төвүүд дэх 18 блок, 598 айлын орон сууцны барилгын гүйцэтгэгчдийг төслийн санхүүжүүлэгч Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулж, барилгын ажлыг эхлүүлсэн Эдгээр барилгын ажлын явц дунджаар 37 хувийн хэрэгжилттэй байгаа ба барилгуудын зураг төслийн шатны EDGE сертификат авах ажлыг EDGE-ийн албан ёсны эрхтэй экспертүүдийг ажиллуулан хөндлөнгийн аудитаар хянуулж, эхний барилгын сертификат авах хүсэлтийг хүргүүлсэн. Ингэснээр гэр хорооллын дэд төвүүдэд баригдаж буй төслийн орон сууцнууд нь Монголын анхны олон улсын ногоон барилгын үнэлгээний гэрчилгээтэй орон сууц болох юм. Барилгын эрчим хүчний үр ашиг, Ногоон Барилгын Үнэлгээний Системийг олон нийтэд таниулах, барилгын салбарын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ын “Ногоон барилгын үнэлгээний Excellence in Design for Greater Efficiencies (EDGE) систем”-ийн дотоодын мэргэшсэн эксперт бэлтгэх хоёр дахь удаагийн сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус семинарыг албан ёсны сургалтын эрхтэй Sintali	НЗДТГ 100, ХББОСЯ 100	100	50.0	Аарга хэмжээний хүрээнд зохион байгуулалтын ажлыг авч хэрэгжүүлж байгаа. Гэвч стандарт тогтож, тогтолцоо хангалттай бүрдээгүй.
229	9.2.4. Олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.	2021-2025	.3, Нийслэлийн төсөв		ЗТЯ: Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дугаар тушаалаар “Унадаг дугуйн зорчих орчин ба хэрэглээг хөгжүүлэх дэд хөтөлбөр” баталсан. Нийслэлийн хэмжээнд унадаг дугуйн замын 8 байршлын зураг төсөл боловсруулах ажлыг 2020 онд Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ гүйцэтгэсэн. 2024 оны байдлаар 16 байршилд Авто зам, замын байгууламжийн 30.8 км трассд дугуйн замыг тусган батлуулсан. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд 2022 онд эхлүүлсэн Авто замын байгууламжийн нүхэн гарц, гүүрэн байгууламж, авто зам дагуух тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган хүний замын шинэчлэлтийн ажлын хүрээнд 2023 онд 3 байршилд 13.5 км дугуйн зам, 2024 онд Нийслэл хүрээ өргөн чөлөө, Элчингийн гудамж, Г.Чагдаржавын гудамжнуудад нийт 2.1 км дугуйн замыг барьсан. Улаанбаатар хотын явган хүний зам болон дугуйн замын сүлжээг хөгжүүлэх ажлын зураг төслийн зөвлөх үйлчилгээний зураг төслийг “Гео зураглал” ХХК боловсруулсан. Тухайн зураг төслийн дагуу Нийслэлийн засаг даргын А/1261 захирамжаар батлагдсан “Авто замын байгууламжийн нүхэн гарц, гүүрэн байгууламж, авто замын тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган зам” ажлын хүрээнд 12 байршилд нийт 17488 м2 явган замыг барьсан. - Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжүүлж байгаа дугуйн замын багц 1 ажлын хүрээнд 2 байршлын 33.5 км, багц 2 ажлын хүрээнд 22.54 км дугуйн замын ажил үргэлжилж байна. - Хөдөө орон нутагт: Нийт 9 аймагт 31.6 км унадаг дугуйн замын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын аймгуудын засаг дарга нартай байгуулсан гэрээнд унадаг дугуйн зам барих ажлыг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Орхон аймагт 2.7 км, Дорнод аймагт 5.5 км, Өвөрхангай аймагт 2.1 км, Завхан аймагт 6.7 км, Төв аймагт 5.6 км, Дархан-Уул аймагт 5 км, Өмнөговь аймагт 1.3 км, Дорноговь аймагт 2 км, Хэнтий аймагт 0.7 км унадаг дугуйн зам баригдаж дууссан. НЗДТГ:2024 онд Нийслэл Улаанбаатар хотын явган хүний замын сүлжээг хөгжүүлэх зорилтын хүрээнд нийт 11 байршилд 38630 м2 явган замын ажлыг гүйцэтгэсэн. 4 байршилд 100580 м2 явган замын боржин чулуун хавтан суурилуулах ажил он дамжин хийгдэж байна. 2024 онд Нийслэл Улаанбаатар хотын дугуйн замын сүлжээг хөгжүүлэх зорилтын хүрээнд нийт 8 байршилд 7.334 км дугуйн замын ажлыг гүйцэтгэсэн.	ЗТЯ/НЗДТГ	100	70.0	Тодорхой үр дүнтэй
					Зорилтын хэрэгжилтийн хувь			60.0	
Төлөвлөлт төвтэй хөгжил									
Зорилт 9.3. Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.									
230	9.3.1. Соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв баригдаж төвлөрлийг бууруулна.	2021-2025	1, Гадаад зээл, тусламж		Хөтөлбөрийн II үе шатны хүрээнд Баянхошуу дэд төвд зайлшгүй шаардлагатай нийгмийн барилга байгууламжуулын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд хэрэгжилтийн явц 82.5%-тай байна. Энэ үе шатны хүрээнд Дамбадаржаа дэд төвийн нийгмийн болон инженерийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж эхэлсэн байгаа бөгөөд хэрэгжилтийн явц 51.3%-тай байна. Санхүүжилтийн хэлэлцээрт заасан үүргийнхээ дагуу НЗДТГ-аас Дэнжийн мянга дэд төвүүдийн нийгмийн болон инженерийн бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх боловч НИТХ-ын чуулганаар 2023-2024 онуудад төсөв батлаагүй. Энэ үе шатны хэрэгжилтийн явц 56.4% Хөтөлбөрийн III үе шатны хүрээнд Толгойт дэд төвийн нийгмийн болон инженерийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж эхэлсэн байгаа бөгөөд хэрэгжилтийн явц 44.7%-тай байна. Санхүүжилтийн хэлэлцээрт заасан үүргийнхээ дагуу НЗДТГ-аас Шархад дэд төвүүдийн нийгмийн болон инженерийн бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх боловч НИТХ-ын чуулганаар 2023-2024 онуудад төсөв батлаагүй. Энэ үе шатны хэрэгжилтийн явц 34.2%	НЗДТГ	100	50.0	
231	9.3.2. Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	2021-2025	-		Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын дагуу Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн хүрээнд 2024 онд 3 байршилд 436 айлын үйлчилгээтэй орон сууц ашиглалтад орсон. Үүнд: - Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны “Хару констракшн” ХХК-ийн 13 дугаар байр буюу 94 айлын үйлчилгээтэй орон сууц, - Баянгол дүүргийн 2 дугаар хорооны “Грэйт роуд” ХХК-ийн 202 айлын үйлчилгээтэй орон сууц. - Сүхбаатар дүүргийн “Өү энд Би Эн” ХХК-ийн 140 айлын үйлчилгээтэй орон сууц	НЗДТГ	100	70.0	
232	9.3.3. Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлнэ.	2021-2025	5,967.7, Нийслэлийн төсөв, 15,000.0, Гадаад зээл		НЗДТГ: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 10, 16, 23, 24 дүгээр хороо, Яармаг орчмын нутаг дэвсгэрт баригдаж, ашиглалтад орсон хотхонуудад хэрэглэгдэж буй цэвэр усны 4.8 км шугамыг шинэчлэлтийн ажил хийгдэж байна. - Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй төслийн хүрээнд цэвэр усны Ф200-500мм хүртэлх диаметртэй 2.4км шугамыг доторлохоор төлөвлөж гүйцэтгэлээр CIPP=557 м Close-Fit 1220 метр доторлогоо хийж нийт 1777 метр урттай шугамд төсөл хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нийт 17.6 км шугам доторлосон. ХББОСЯ: “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд ус хангамжийн 9,2 км шугам сүлжээг суурилуулж, 4662 ш ухаалаг тоолуур суурилуулах ажлыг гүйцэтгэсэн. “Залуус-1” орон сууцны хорооллын төслийн цахилгаан хангамжийн ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ 2x630kBa-ын дэд өртөөний барилга 2-ыг барьж байгуулсан.	НЗДТГ, ХББОСЯ 100	100	50.0	Арга хэмжээний хүрээнд ажил эхэлсэн. Журмын 6.2.23-ын дагуу үнэлэв.
233	9.3.4. Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна.	2021-2025	100,800.0, Улсын төсөв		ЗТЯ: “Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЗЗҮ”, “Дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЗЗҮ”, “Дүүжин тээвэр төслийн Баянхошуу-Ханын материал Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа” боловсруулах ажлууд тус тус хийгдсэн. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах төслүүдийг хэрэгжүүлэхээр тусган ажиллаж байна. Үүнд: - Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөөний дагуу 17.7 км урт их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” төсөл - Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт “Агаарын дүүжин замын тээвэр” төсөл - “Шинэ тойрог зам” барих төсөл - “Туулын хурдны авто зам” барих төсөл Улаанбаатар хотын автобусны зогсоол, гудамж, зам, талбайн хаяг, тэмдэг тэмдэглэгээ, такси үйлчилгээнд мөрдөгдөж байгаа стандартуудад дүн шинжилгээ хийж олон улсын жишигт	ЗТЯ/НЗДТГ	70	30.0	Бэлтгэл ажил хийгдсэн.

234	9.3.5. Богд уулыг тойрсон "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан байна.	2021-2025	-		ЗТЯ: Богдхан төмөр зам төслийн ТЭЗҮ-ийг Зам, тээврийн хөгжлийн яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар 2022.01.11, Зам, тээврийн хөгжлийн яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дэргэдэх Төмөр зам, далайн тээврийн салбарын дэд зөвлөлийн хурлаар 2022.05.06-ны өдөр тус тус хэлэлцүүлсэн. Богдхан төмөр зам төслийн шинэчилсэн ТЭЗҮ-ийг 2022.05.12-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн төвд хүргүүлэн магадлуулж, 100/2022 дугаартай магадлалтын ерөнхий дүгнэлт гарсан. Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д Засгийн газрын 2021.08.04-ний өдрийн 230 дугаар тогтоолоор олгосон. Төслийн эхний 37.5 км төмөр замын барилгын ажлын газар шорооны ажил дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд: Үндсэн трассын газар шорооны ажил- 24%, Технологийн замын газар шорооны ажил- 98.8%, Ус хангамж, худгийн ажил- 90%. НЗДТГ:Засгийн газрын "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсан 203 дугаар тогтоолын 6.1.12-т тусгасны дагуу Үндсэн хариуцагчаар Зам, тээврийн хөгжлийн яам, хамтран хариуцагчаар Барилга, хот байгуулалтын яам ажилласан бөгөөд нийслэлийн зүгээс тухай бүрт холбогдох мэдээллийг өгч хамтран ажилласан.	ЗТЯ/НЗДТГ	100	100.0	
					Зорилтын хэрэгжилтийн хувь			60.0	
Хотын сайн засаглал									
Зорилт 9.4.Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ.									
235	9.4.1. Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод	2021-2025			НЗДТГ: Нийслэлийн 2024 оны төсвийн төслийг Ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулан иргэдийн саналыг авахын зэрэгцээ 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн Иргэний танхимд 9 дүүргийн 250 орчим иргэдийг хамруулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулахад иргэдээс нийт 637 санал ирүүлсэн. - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд иргэдийн саналыг цахим хэлбэрээр буюу гар утасны аппликейшн ашиглан авах ажлын хүрээнд 9 дүүргийн 204 хороонд “ОНХС” аппликейшн, “e-mongolia” аппликейшн болон цахим хуудсаар дамжуулан нийслэл даяар 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийн хооронд авсан санал асуулгад 916887 төсөл, арга хэмжээний санал ирүүлснээс Сангийн яамны ОНХС аппликейшн, “e-mongolia” аппликейшнаар 136306 санал, цаасан санал асуулгаар 780581 төсөл, арга хэмжээний санал өгсөн. Саналын эрхтэй 18-аас дээш насны 800,000 гаруй иргэн оролцох боломжтойгоос 337722 иргэн санал өгсөн нь саналын эрхтэй иргэдийн 42.2% нь байна. ХББОСЯ: Хот, тосгоны	НЗДТГ, ХББОСЯ 100	100	90.0	
236	9.4.2. Нийслэл эдийн засгийн хувьд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2021-2025	-		Нийслэл хоттой холбоотой харилцааны суурь зохицуулалтыг агуулсан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг 27 жилийн дараа буюу 2021 онд шинэчлэн батлуулснаар эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нийслэл Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, санхүүгийн бие даасан байдал хангагдах болон цаашдын хөгжлийг тодорхойлох шинэлэг зохицуулалтууд бий болсон. Тухайлбал: Нийслэлийг аймагтай, дүүргийг сумтай, хороог багтай адилтган зохицуулдаг байсныг өөрчилж, Нийслэл Улаанбаатар хот нь бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хотуудаас ялгаатай тусгай хот юм гэж үзэх хуулийн үндэслэлийг бүрдүүлж, цаашдын хууль тогтоомжийн өөрчлөлтийг хийхдээ Нийслэл хотын онцлогийг харгалзан үзэж, тусад нь зохицуулах боломжийг бүрдүүлэх эхний алхмууд хийгдсэн. Нийслэл Улаанбаатар хотын хариуцан гүйцэтгэх чиг үүрэг, хэрэгжүүлэх зарчмыг тогтоосноор аливаа асуудлыг шийдвэрлэх бүрэн эрх, санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг болж хариуцлагын механизмыг тодорхой болгосон. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Нийслэлийн Засаг дарга Сонгинохайхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 9000 га талбай	НЗДТГ	100	100.0	
237	9.4.3. Дархан, Эрдэнэт болон бусад том хотуудыг улсын зэрэглэлтэй болгож, хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.	2021-2025	-		Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг 2024.06.05-ны өдөр шинэчлэн баталсантай холбогдуулан “Хот байгуулах тухай” УИХ-ын 2024 оны 72 дугаар тогтоолоор Дархан, Эрдэнэт зэрэг хотуудыг улсын зэрэглэлтэй хот болгон тогтоосон.	ХББОСЯ	100	50.0	Хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн үү?
					Зорилтын хэрэгжилтийн хувь			80.0	
Дагуул хот									
Зорилт 9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ.									
238	9.5.1. Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн байна.	2021-2025	12,395.95, Улсын төсөв		НЗДТГ: Шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгчийг Засгийн газрын 2024 оны 59 дүгээр тогтоолоор томилсон. Шинэ Зуунмод хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн 2024 оны 09 сарын 04-ны өдрийн 67 дугаар тогтоолоор баталсан. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорац байгуулах тухай 114 дүгээр тогтоол батлагдсан. Корпорац нь Шинэ Зуунмод хотын газар хөгжүүлэлт, менежмент, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Шинэ Зуун мод хотын бүтээн байгуулалтын асуудлыг Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа хариуцаж, хөрөнгийн эх үүсвэрийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны саналаар Улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Зам тээврийн сайдын багцад Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хатуу хучилттай авто зам /Төв, Зуунмод сум/, “Хөшигийн хөндий туннель” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/ гэсэн төсөл арга хэмжээнийг хэрэгжүүлэх төсөв сүлжсэн. Монгол Улсын 2024 оны төсвийн	НЗДТГ ХББОСЯ	100	70.0	Төсөл арга хэмжээний төсөв батлагдсан ч үр дүнг тайлагнаагүй, Майдар хот талаар тусгаагүй, 6.2.2.2. тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал
239	9.5.2. Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулна.	2021-2025	430.0 , Улсын төсөв		ХББОСЯ: “Олон улсын нисэх онгоцны “Чингис Хаан” буудлыг түшиглэн бий болох Богд Хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн хангамжийн судалгаа, эх үүсвэр тодорхойлох” ажилд 2022.12.15-ны өдрийн 2701/2022 тоот магадлалын нэгдсэн дүгнэлт гарч,Төв аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн, ИТХ-ын 2023 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан. НЗДТГ: Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулах арга хэмжээ нь Нийслэлийн чиг үүрэгт хамаарахгүй.	ХББОСЯ/НЗДТГ	100	30.0	6.2.2.4. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь;
240	9.5.3. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлж эхэлсэн байна.	2021-2025	-		"Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-тай гэрээ байгуулсан 5 аж ахуйн нэгж; - “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-тай арьс ширний 4 үйлдвэр; - "Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк"-тай 1 аж ахуйн нэгж гэрээ байгуулан бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн.	НЗДТГ	100	50.0	Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй,
241	9.5.4. Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2021-2025	1.8, Нийслэлийн төсөв		НЗДТГ: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар: - "Багануур үйлдвэрлэл технологийн парк"-ийн ерөнхий цахилгаан хангамжийн ажилд 300.0 сая төгрөг; - “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн бүтээн байгуулалтын ажилд 3,111.8 сая төгрөг; - "Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажилд 7,166.6 сая төгрөг; - "Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажилд 492.8 сая төгрөг; - "Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн цахилгаан хангамжийн ажил, 35Кв-ын 2 хэлхээт ЦДАШ ажилд	НЗДТГ, ХББОСЯ	100	90.0	6.2.2.1. зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга
242	9.5.5. Хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төвийг нээн ажиллуулна.	2021-2025	20.0, Улсын төсөв		ЗТЯ: “Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай” Засгийн газрын 2024 оны 189-р тогтоолоор олон улсын болон улсын чанартай авто зам дагуу 21 байршилд газар олгох шийдвэр гаргуулсан. “АТУТ” ТӨҮГ дараах авто замын дагуух үйлчилгээ эрхлэгчидтэй гэрээ байгуулж ажиллаж байна. 1. Өвөрхангай аймаг Хархорин сумын нутаг дэвсгэрт байрлах “Гэр хорум” ХХК-ийн “Гэр комплекс” цогцолбор газар; 2. Завхан аймаг Сонгино сумын нутаг дэвгэрт байрлах “Титан мтс” ХХК-ийн “Нутаг ус” цогцолбор газар; 3. Булган аймгийн Рашант сумын нутаг дэвсгэрт байрлах “Деволопмент лорд” ХХК-ийн “Марс” цогцолбор газар; 4. Дорноговь аймаг Сүмбэр сумын нутаг дэвсгэрт байрлах “ДСБНТ” ХХК-ийн “Dream oasis” цогцолбор; 5. Булган аймгийн Рашант сумын нутаг дэвсгэрт байрлах “Сод хан трөвөл” ХХК-ийн “Хаан бууз” цогцолбор газар; 6. Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дэвсгэрт байрлах “Огуль хөгжил” ХХК-ийн “Элбэг” цогцолбор газар; 7. Дархан аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт байрлах “Даян амгалан” ХХК “Moms food” зоогийн газар; 8. Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд байрлах “Өгөөмөрланс” ХХК-ийн “Их хан центр” ХХК; 9. Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт байрлах “Хишиг арвин ашид” ХХК-ийн “Бумбат” зоогийн газар; 10. Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэрт байрлах “Хос уянга” зоогийн газар Өмнөх онуудад аймаг, сумдадс ашиглалтад оруулсан автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолборын жагсаалтыг хавсаргав. НЗДТГ: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/556 дугаар захирамжаар Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Плэйтайм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх 500,000 м.кв талбай бүхий газрын асуудлыг шийдвэрлэсэн. Төслийг “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай гэрээ байгуулан хэрэгжүүлж, цогцолборын байгууламжийн гадна талын 5000 м урт хашаа, 2500 м урт тусгаарлах хашаа барьж, цахилгаан, цэвэр усны эх	ЗТЯ/НЗДТГ	100	90.0	Тодорхой үр дүнтэй

243	9.5.6. Цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна.	2021-2025	-		НЗДТГ: Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор Нийслэлийн дагуул хотоор Багахангай хот, Агросити хот, Шарга морьт дагуул хотуудыг байгуулахаар шийдвэрлэсэн. - Улсын Их Хурлын 2024 оны 76 дугаар тогтоолоор Төв аймгийн нутаг дэвсгэрт нийслэлийн дагуул хот "Шинэ Зуунмод хот"-ыг байгуулсан. - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд цахим эдийн засаг үйлчилгээний салбарыг дэмжихэд чиглэсэн төлөвлөлтүүдийг тусгахаар төлөвлөөд байна. - Шинэ Зуунмод хотын цахилгаан хангамжийн 220,10,35 кВ-н 3 дэд станц, 102.3 км шугам, ус хангамжийн 2000м3-н 2 усан сан, 5 гүний худаг, мэдээлэл сүлжээний 96 болон 48 корын 39 км шилэн кабелийн угсралтын ажлыг холбогдох байгууллага ЭХЯ, ХББОСЯ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорац" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт хувьцааны 80 хувийг нийслэл Улаанбаатар хот эзэмшихээр заасны дагуу зарласан хувьцаа эзэмшигчид ногдох хувийг 2025 оны орон нутгийн төсөвт тусгасан. - "Ажлын хэсэг байгуулах тухай" Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/1349 захирамжаар ажлын хэсэг байгуулагдан, тус корпорацийн Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. Удирдах зөвлөлийн сонгон шалгаруулж, Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулна. Төлөөлөн упирдах зөвлөлийн гүйцэтгэх захирлыг томилсноор үйл ажиллагааг бүрэн эхлүүлнэ. ХББОСЯ: 1. АХБ-ны "Хөшигийн хөндийн дасан зохицох чадавхтай, ногоон, шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах төсөл"-ийн бүтээн байгуулалтын ажлыг 2025 оны эзэлийн ерөнхий хэлэлцээрт тусгуулах тухай саналыг тус яамны 2024 оны 01/892 тоот албан бичгээр ЭЗХЯ, СЯ-нд тус тус хүргүүлсэн. Төслийн зөвлөхөөр Японы "АЛМЕК Корпораци" компаниар ахлуулсан консорциум баг ажиллаж байгаа ба ТЭЗҮ-г холбогдох орон тооны бус мэргэжлийн зөвлөлүүдийн 2024.10.03-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн төслийн ТЭЗҮ-д Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэн БОУАӨЯ-ны 2024.10.03-ны өдрийн 2023/ОА-43 дугаар ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан. Уг техник туслалцааны хүрээнд төслийн зөвлөх багаас 8 тайлангуудыг боловсруулан тус яаманд ирүүлээд байна. 2. ЖАЙКА-ын техник туслалцааны "Шинэ Зуунмод хот болон эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих төсөл"-ийг 2023.12.08-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох санал боловсруулж, хуулийг дагалдаж гарах дүрэм, журмын төсөл боловсруулан хотын институцийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Уг төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурлыг 2024.12.13-ны өдөр зохион байгуулсан. 3. "Төрийн захиргааны байгууллагуудын нэгдсэн цогцолборын зураг төслийн техникийн тодорхойлолт боловсруулах ажлыг даалгавар"-ыг тус яам нь ЭЗХЯ-тай хамтран баталсны дагуу зөвлөх үйлчилгээний гэрээг зөвлөх багтай 2024.09.24 өдөр байгуулсан. Зөвлөх багаас боловсруулсан техникийн тодорхойлолтын төсөлтэй танилцаж, холбогдох саналыг 2024.10.28-ны өдөр ЭЗХЯ-нд хүргүүлэн ажлын хэсгийн 2024.10.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн.	НЗДТГ 70, ХББОСЯ 90	70	50.0	6.2.2.3. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;
					Зорилтын хэрэгжилтийн хувь			63.3	
					Зорилгын хэрэгжилтийн хувь			68.0	
					хэрэгжилтийн дундаж хувь			77.5	

"МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2024 ОНЫ ЯВЦЫН ТАЙЛАН

дд	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Суурь түвшин	Зорилтот түвшин 2025	Хүрэх түвшин 2024	Хүрсэн түвшин 2024	Хэрэгжилтийн хувь	ЭЗХЯ-ны үнэлгээ	Яамдаас ирүүлсэн /хэрэгжилт/ тайлбар
0	1	2	3	4	5		6	7		8
1	Шинэ бүтээл, патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг	тоо	Оюуны өмчийн газар	82	150	84	84		100.0	
2	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	хувь	Соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (СоЯ)	0.3	5	4.3	1.24	28.8	100.0	1.Номын сангийн нийт сан хөмрөгийн тоо-6.272.595 Цахим сан хөмрөгийн тоо-78213 Номын сангийн цахим сан хөмрөгийн тоо өмнөх онд 68.369 байсан бол энэ онд 78.213 болж 9.844-өөр нэмэгдсэн. Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь өмнөх онд 1.09 байсан бол энэ онд 1.24 болж 13.7%-иар өссөн хэдий ч 2025 оны хүрэх түвшнийг 5 гэж төлөвлөсөн учир буурсан үр дүн харагдаж байна.
3	1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	тоо		32	37	36.4	36.4	100	100.0	2.Урлагийн байгууллагын суудлын тоо-13.486 Соёлын төв /ордон/-ийн суудлын тоо-89.350 Номын сангийн суудлын тоо-10.708 Кино театрын суудлын тоо-10.265 Нийт соёл, урлагийн байгууллагын суудлын тоо-123.809 ҮСХ-ны даргын 2013 оны А/144 дүгээр тушаалаар баталсан "Соёлын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлалын дагуу 1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоог бодож гаргалаа. Нийт СУ-ын байгууллагын суудлын тоог суурин хүн амын дундаж тоонд харьцуулан 1000-аар үржүүлэн тооцсон.
4	Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж	хувь		47.1	56.0	55.5	57.4	100	100.0	3.Урлагийн байгууллагын үйлчлүүлэгчдийн тоо-1.014.276 Номын сангийн байнгын уншигчдын тоо-286.447 Соёлын төв/ордон/-ийн үйлчлүүлэгчдийн тоо-3.527.318 Кино театрын үйлчлүүлэгчдийн тоо-3.173.018 Жилийн дундаж хүн амын тоо-3.481.145 Соёлын үйлчилгээний байгууллагын төрөл бүрээр үйлчлүүлэгчдийн тоог хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлтүүдийн дунджаар тооцон бодож гаргасан.
5	Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо	хувь		21.6	23.9	23.6	33.2	100	100.0	4. "Музейн нээлттэй өдрүүд" арга хэмжээг 2022 оноос эхлэн улсын хэмжээнд зохион байгуулж тогтмолжсон, тус арга хэмжээг жил бүрийн 3 дугаар сарын эхний 7 хоногт зохион байгуулах Монгол Улсын Засгийн газрын 96 дугаар тогтоол гарсан. Монгол улсад орчин цагийн музейн байгууллага байгуулагдсаны 100 жилийн ойг угтан тус яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу "Музейн нээлттэй өдрүүд" арга хэмжээний хүрээнд музейн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдүүлсэн тусгай үзэсгэлэн, боловсролын хөтөлбөр, лекц, уулзалт зэрэг нийгэмд чиглэсэн олон үйл ажиллагааг зохион байгуулсан учраас үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн.
6	Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь	хувь		8.1	17.1	15.6	23.6	100	100.0	5. Соёлын эрхийн бичиг нэвтрүүлэх ажлын хүрээнд хүүхэд залуучуудад соёл, урлагийг түгээх, урлагийн боловсрол олгох боломжийг бий болгох, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг 16-18 насны иргэдэд олгохтой холбоотой соёлын эрхийн бичиг олгох ажлыг эхлүүлэх зорилгоор өсвөр насны 55 мянган хүүхдэд соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хамрагдах боломж олгосноор үйлчлүүлэгч хүүхдүүдийн тоо өссөн.
7	Хүний хөгжлийн үзүүлэлт	индекс	Үндэсний статистикийн хороо (ҮСХ)	0.74	0.77					2018 оны суурь түвшин 0.759 байна. АХ бодлогын хавсралт 3-д батлагдсан буруу байгааг засах шаардлагатай. Хүний хөгжлийн үзүүлэлтийг хэд хэдэн салбарын мэдээллээс тооцох учраас одоогоор гарах боломжгүй байна.
8	Жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлт (хэмжүүр)	индекс	Жендэрийн үндэсний хороо (ЖҮХ)	0.301	0.25	0.29				2018 оны суурь түвшин 0.288 байна. АХ бодлогын хавсралт 3-д 0.301 гэж батлагдсан буруу байгааг засах шаардлагатай. 2024 оны тооцоолол хийгдээгүй байгаа.

9	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БШУЯ)	81.5	89.4	88.9	91.8		100.0	
10	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	хувь		90.1	100.0	98.3	94.1		48.8	
11	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь		94.9	95.9	95.7	95.4		62.5	
12	7-14 насны хүүхдийн суурь чадвар (унших, тоо бодох)	хувь	ҮСХ	унших 61.6, тоо бодох	70					5 жилд нэг удаа учир 2024 онд гарахгүй.
13	Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	тоо	БШУЯ	34.1	25	26.6	28.7		72.0	
14	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо		31.1 хот-34.6, хөдөө-28.5	25 хот-30, хөдөө-25	26.1, хот-31.1 хөдөө-25.5	30.5, хот-32.7 хөдөө-28.8		70.0	
